



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ - 2014

ШУА-ИЙН АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2014 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр
- ШУА-ийн Нэгдсэн I байрны хурлын заал

Улаанбаатар
2015

DDC
930.1
M-695

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ - 2014 ОН

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2014 оны
хээрийн судалгааны үр дүн

Эрхэлсэн:	Ч.Ерөөл-Эрдэнэ
Хэвлэлд бэлтгэсэн:	Л.Ишцэрэн
Хэвлэлийн дизайнер:	Д.Сэрээтэр
Цаасны хэмжээ:	176 x 250
Хэвлэлийн хуудас:	11.3 хх

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-99973-2-374-3

ХӨТӨЛБӨР

Өмнөх үг

13⁰⁰-13¹⁰ Хурлын нээлт

*ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Гүнчинсүрэн*

13¹⁰-13²⁰ Төлбөр-16 хуучин чулуун зэвсгийн дурсгалт газар
хийсэн малтлага судалгаа

*Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Д.Огсүрэн,
Н.Звинс, Д.Флас.*

13²⁰-13³⁰ Рашаан хадны чулуун зэвсгийн суурингийн
малтлага судалгааны 2014 оны ажлын үр дүнгээс

*Д.Базаргүр, Б.Гүнчинсүрэн, Г.Эрэгзэн,
П.Алгармөнх, И Сон Бук, И Жон Өн*

13³⁰-13⁴⁰ Эгийн голын хөндийд хийсэн чулуун зэвсгийн
малтлага болон хайгуул судалгааны үр дүн

Г.Лхүндэв, Б.Гүнчинсүрэн, Д.Базаргүр, Г.Ангарагдөлгөөн

13⁴⁰-13⁵⁰ Харганы гол-5 хуучин чулуун зэвсгийн соёлт
давхарга бүхий дурсгалын малтлага судалгаа

*Б.Гүнчинсүрэн, Е.П.Рыбин, Ц.Болорбат,
С.А.Гладышев, Д.Огсүрэн, А.М.Хаценович*

13⁵⁰-14⁰⁰ Хүдрийн голын с ав нутагт хийсэн чулуун зэвсгийн судалгаа

*Б.Гүнчинсүрэн, Д.Огсүрэн, Ц.Болорбат,
М.Изүхо, Я.Бувит, Т.Үэки*

14⁰⁰-14¹⁰ Их нартын байгалийн нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэн
судлах Монгол-Америкийн хамтарсан экспедицийн 2014 оны
судалгааны ажлын товч үр дүн

Я.Цэрэндагва, С.Далантай, Ж.Шнейдер,

14¹⁰-14²⁰ 2014 онд Хотон нуурын Далантүрүүний хос толгойд хийсэн хадны
зургийн судалгаа

Я.Цэрэндагва, Р.Кортум, Б.Жаргалсайхан

14²⁰-14³⁰ Монгол-Монакогийн хамтарсан экспедицийн 2014 оны хээрийн
судалгааны ажлын товч үр дүн

Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга, Ж.Магай, К.Салисис

- 14³⁰-14⁴⁰ 2014 онд Булган аймгийн Тэшиг сумын нутаг Тарвагатайн голын хөндийд Монгол-Америкийн хамтарсан төслийн хээрийн шинжилгээний ангийн үр дүн
Б.Жаргалан, У.Гарднер
- 14⁴⁰-14⁵⁰ Монгол-Францын хамтарсан „Евразит” төслийн 2014 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн
Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү, Г.Энхбаяр
- 14⁵⁰-15⁰⁰ Монгол-Солонгосын хамтарсан „Соёлын өвийг судалж, хамгаалах” төслийн 2014 оны хээрийн шинжилгээний ажлын урьдчилсан үр дүн
*Д.Цэвээндорж, Н.Батболд, Б.Дашдорж
Бён Ён Хуан, Вүэ Мен Хуан.*
- 15⁰⁰-15¹⁰ 2014 оны Монгол-Америкийн хамтарсан „Дорнод Монгол: Археологийн хайгуул судалгаа” төслийн хээрийн шинжилгээний үр дүнгээс
Ч.Амартүвшин, Г.Галдан, У.Ханичёрч, Ж.Врайт
- 15¹⁰-15²⁰ Монгол-Францын хамтарсан „Тамирын голын Хүннүчүүд” төслийн 2014 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн
Ц.Төрбат, Д.Батсүх, Б.Эргэнэ
- 15²⁰-15³⁰ „Мон-Сол” төслийн 2014 оны хээрийн судалгааны үр дүнгээс
*Г.Эрэгзэн, М.Баярсайхан, Ц.Эгиймаа, П.Алгармөнх
Юн Хён-Вон, Ким Сан-мин*
- 15³⁰-15⁴⁰ Монгол-Японы хамтарсан „Эртний нүүдэлчдийн үйлдвэрлэлийн түүх” төслийн 2014 оны хээрийн шинжилгээний ажлын урьдчилсан үр дүн
*Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн,
Т.Сасага, И.Үсүки, К.Кияма, М.Сагава*
- 15⁴⁰-15⁵⁰ Монгол-Японы хамтарсан „Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ажлын үр дүнгээс
Г.Лхүндэв, Г.Ангарагдөлгөөн, Т.Осава, Ш.Сайто
- 15⁵⁰-16⁰⁰ Монгол-Германы Орхон экспедицийн 2014 оны хээрийн шинжилгээний ажлын тухай
У.Эргэнэбат, Т.Батбаяр, К.Франкен
- 16⁰⁰-16¹⁰ Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт орших Хэрлэн Барс 1 хотын суварганд хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүнт
*А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Г.Батболд,
Ц.Буянхишиг, Т.Хантөгс*

- 16¹⁰-16²⁰ Монгол-Японы хамтарсан „Археологийн дурсгалын 3 хэмжээст баримтжуулалт” төсөл
А.Энхтөр, Л.Мөнхбаяр
- 16²⁰-16³⁰ Монгол-Японы хамтарсан „Шинэ зуун” төслийн 2014 оны хээрийн шинжилгээний ажлын урьдчилсан үр дүн
Б.Цогтбаатар, Л.Ишцэрэн, Ц.Амгалантөгс, Н.Ширайши, Т.Мияке, Т.Сасага.
- 16³⁰-16⁴⁰ Монгол-Израйль-Германы хамтарсан „Хархорум-MIG” төсөл
Д.Цэвээндорж, А.Энхтөр, Б.Багма-Оюу, Г.Батболд, Т.Хантөгс, Ц.Буянхишиг
- 16⁴⁰-16⁵⁰ „Шинэ зуун” төслийн хүрээнд Хэрлэнбаян Улаан уулын Таван Хайлаастын аманд хийсэн маллага судалгаа
Б.Цогтбаатар, Н.Ширайши, Г.Батболд, Ц.Амгалантөгс, Л.Ишцэрэн,
- 16⁵⁰-17⁰⁰ Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг Эгийн голын хөндийд хийсэн археологийн дурсгалыг авран хамгаалах маллага судалгаа
Ч. Амартүвшин, Г.Эрэгзэн, Б.Багма-Оюу, Д.Базаргүр, Г.Лхүндэв, Г.Галдан, Б.Батгалай, Б.Ангарагдөлгөөн, Д.Мандах
- 17⁰⁰-17¹⁰ Төв, Умард Монголын нутагт хийсэн бэсрэг хайгуулын ангийн зарим үр дүн
Г.Эрэгзэн, Ч.Амартүвшин, А.Энхтөр, Г.Батболд, Б.Батгалай
- 17¹⁰-17²⁰ 2014 онд явуулсан археологийн авран хамгаалах хайгуул, маллага судалгааны товч үр дүн
Ч.Амартүвшин, Б.Батгалай, Д.Бөхчулуун
- 17²⁰-17⁵⁰ Асуулт хариулт
- 17⁵⁰-18⁰⁰ Хурлын хаалт

ӨМНӨХ ҮГ

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2014 оны хээрийн судалгаа нь бие даасан үндэсний хээрийн судалгаа, гадаадын судалгааны байгууллагуудтай хамтарсан судалгаа, авран хамгаалах судалгааны хүрээнд чулуун зэвсгийн үе, хүрэл ба түрүү төмрийн үе, хүннүгийн үе, дундад зууны үеийн судалгааны чиглэлээр хийгдсэн болно.

Үндэсний хээрийн шинжилгээ нь *„Монголын чулуун зэвсгийн судалгаа“, „Монголын хүрэл ба түрүү төмрийн үеийн археологийн судалгааны тулгамдсан асуудлууд ба шинэлэг шийдлүүд“, „Хүннүгийн археологийн судалгаа“* сэдэвт ажлын хүрээнд Булган, Сэлэнгэ, Хэнтий, Өмнөговь, Баянхонгор, Баян-Өлгий, Ховд, Увс, болон Завхан аймгийн нутагт явагджээ. Мөн тус хүрээлэнгээс зарим дурсгалыг газар дээр нь очиж шалгах, сэргээн засварлалтын өмнөх бэлтгэл ажлыг хангах зорилготой үндэсний хээрийн шинжилгээний хоёр анги ажилласан байна. Үүнд: Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг Худгийн халзан хэмээх Жужаны үед холбогдох боломжтой дурсгалт газар, Архангай, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл, Булган аймгийн нутагт орших зарим дурсгалт газарт хайгуул судалгаа, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг дахь Хэрлэн Барс хотын түрийн суваргыг сэргээн засахтай холбогдуулан хэсэгчилсэн маллагыг хийсэн юм. Эдгээр хээрийн шинжилгээний хугацааг нэгтгэн үзвэл нийт 61 өдрийн судалгаа болжээ.

Хамтарсан судалгааг ОХУ (1), ХБНГУ (2), ХБНГУ-Израил (1), БНСУ (3), Япон (6), Франц (2), АНУ (3), Монако (1) улсын судалгааны байгууллагуудтай хамтран явуулж нийт 19 судалгааны анги зохион байгуулсан нь Төв, Булган, Архангай, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Завхан, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай зэрэг 14 аймгийн, давхардсан тоогоор 35 сумын нутагт судалгаа хийжээ. Нийт хамтарсан судалгааны ангийн ажилласан хугацааг нэгтгэн тооцвол энэ онд 420 гаруй өдрийн хээрийн судалгааг гүйцэтгэжээ.

Тус хүрээлэнгийн судлаачид 2014 онд нийт 65 удаагийн авран хамгаалах хайгуул судалгаа хийсний үр дүнд 40 талбайгаас 1361 тооны археологийн дурсгал шинээр илрүүлэн олж баримтжуулснаас гадна уул уурхайн болон усан цахилгаан станцын талбай, өндөр хүчдэл дамжуулах шугам, хатуу хучилттай замын трассын дагууд таван газарт маллага судалгаа гүйцэтгэж нийт 93 дурсгалыг авран хамгаалсан байна.

Энэ оны хээрийн судалгааны үр дүнд соёлын өвийн дурсгалын мэдээллийн санг чамгүй нэмэгдүүлсний зэрэгцээ эх орны археологийн судалгааг шинэ эх хэрэглэгдэхүүнээр баяжуулав.

Толилуулан буй эмхтгэлд Археологийн хүрээлэнгийн 2014 оны хээрийн судалгааны үр дүнг тусгасан 25 илтгэлийг нийтлүүлж байна.

*Хүннүгийн археологийн судалгааны секторын
эрхлэгч, доктор Ч.Ерөөл-Эргэнэ*


ТӨЛБӨР-16 ХУУЧИН ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР ХИЙСЭН МАЛТЛАГА СУДАЛГАА

*Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Д.Огсүрэн,
Н.Звинс, Д.Флас.*

Монгол-Германы хамтарсан чулуун зэвсгийн судалгааны анги „Төлбөр-16 палеолитын дурсгалын малтлага: Монгол нутаг дахь дээд палеолитын эхлэл” төслийн хүрээнд 2012 оноос эхлэн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг, Төлбөрийн голын хөндийд орших олон соёлт давхарга бүхий 16-р дурсгалт газарт малтлага судалгааны ажил гүйцэтгэж байгаа билээ. Бид 2014 онд өмнөх жилүүдэд хийсэн малтлага судалгааны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэв.

2014 оны малтлага судалгаа


Энэ онд өмнөх буюу 2013 онд сорьц маягаар малтлага хийсэн (хойшид Pit 4 гэнэ) 1x4 м талбайг сунган малтлага судалгааг үргэлжлүүлсэн юм¹. Pit 4 маллагын талбай нь Pit 1 талбайн баруун хойд талд, хойноос урагш чиглэсэн гүн жалганы зүүн талын налуу ирмэгт байрлана. Уг маллагын талбай нь жалганы чиглэлийн дагуу буюу хойноос урагш сунасан хэлбэртэй. Бид өмнөх жилийн сул хөрсийг зөөж гаргасны дараа маллагын талбайг баруун тийш 8 м²-аар, урагш 3 м²-аар тус тус сунгаж, нийт 11 м² талбайд малтлага судалгаа хийж гүйцэтгэсэн.



Маллагыг 5 см-ийн зузаантайгаар явуулж, 2 болон 4 мм нүхтэй шигшүүр ашиглан цугларсан шороог шигших маягаар жижиг олдворуудыг илрүүлж байв. Мөн малтлагаас илэрч буй 2 см-ээс том хэмжээтэй олдворуудыг Total station багажийн тусламжтайгаар бүртгэн авч, газрын байршил болон маллагын явцыг фото зургаар баримтжуулан мэдээллийн санг бүрдүүлээ.

¹ Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Н.Звинс, Х.Пүрэвжал. Монгол-Гурманы хамтарсан чулуун зэвсгийн судалгааны ангийн 2013 онд хийсэн маллагын урьдчилсан үр дүн. Монголын Археологи-2013/ ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн 2013 оны хээрийн судалгааны үр дүн. УБ., 2013. Тал 6.

Хөрсний бүтцийг ажиглахад шууд бага зэрэг цайвар бор өнгө зонхилсон химэрлэг хөрс бүхий 3-р давхаргаас эхэлж байгаа ба 4-р давхарга нь бусдаас илүү зузаан байна. Харин 5, 6-р давхаргын хувьд хоорондын зааг ялгаа бараг мэдэгдэхгүй, зурвас үе мэт байдалтай. 7-р давхаргаас доош 30 см орчим гүнд хүртэл малтаж үзэхэд археологийн олдвор илэрч олдоогүй. Энэ нь уг дурсгал газарт хөрсний 7 давхаргад чулуун зэвсгийн олдвор, хэрэглэгдэхүүн агуулагдаж байгааг илэрхийлж байна.




T16 2014
Pit 4 Ortho

Малтлагаар нийт 5726 ш чулуун зэвсгийн олдвор малтаж гаргаснаас дийлэнх буюу 4165 олдвор (2 см-2 мм) нь шигшүүрээс илэрчээ. Харин 1561 ш олдвор (>2 см) малтлагаас илэрсний олонхийг цуулдасны үйлдвэрлэл эзэлнэ. Мөн гоёл чимэглэлийн зүйл 2 ш, амьтны ясны үлдэгдэл 106 ш илэрсний 31 ш нь малтлагаас, үлдсэн нь шигшүүрээс олдсон байна.

Үлдцүүдийн дотор хуучин чулуун зэвсгийн дээд үеийн эхэн шатны шинж төрхийг илэрхийлэх цохилтын нэг, хоёр талбайтай, цуулалтын нэг болон олон гадаргуутай, зэрэгцээ цуулалтын зарчимт уртлаг, гонзгой үлдцүүд хэд хэд илэрч олджээ. Эдгээр нь Төлбөр-4 дурсгалт газрын доод давхаргуудаас илэрсэн үлдцүүдтэй ижилсэж байна²

² А.Д.Деревянко, Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва, С.А.Гладышев, Ц.Болорбат, Е.П.Рыбин, Т.Т.Чаргынов. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Төлбөрийн голд Монгол-Оросын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн хийсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. УБ., 2006. АХГБСХ.



Багаж зэвсгийн дотор олон төрлийн хусуур, хатгуур, хянгар зэвсэг цөөн тоотой илэрч олджээ.

Эдгээрийн дотор сонирхолтой хоёр олдвор байгаа нь хоёр талыг засч хийсэн хурц үзүүртэй бариул бүхий хутга болон зүрх хэлбэрийн хоёр талт зэвсэг юм.



Мөн шигшүүрээс тэмээн хяруулын өндөгний хальсыг зүлгэж хийсэн хоёр зүүлт олдсон. Энэ хоёр зүүлт нь хэмжээний хувьд өмнө жил Pit 1 талбайгаас илэрсэн зүүлтүүдтэй³ ижил боловч, илүү нарийн үр хийцтэй байна.



Лабораторийн шинжилгээний үр дүнгээс

2011-2014 оны хооронд хийсэн хийсэн маллага судалгааны явцад илэрсэн ясны үлдэгдлүүдийн дээжийг лабораторийн шинжилгээнд өгсөн. Үүний үр дүнд Pit 1 маллагын талбайн хөрсний 4-р давхаргаас илэрсэн ясны үлдэгдлийн дээж 15.660 ± 60 BP (MAMS 14938) холбогдох бол, хөрсний 7-р давхаргаас илэрсэн ясны үлдэгдлүүдийн дээж 32.910 ± 160 BP (MAMS 20980), 33.520 ± 170 BP (MAMS 20979), 41.030 ± 350 BP (MAMS 20981) холбогдохыг тогтоожээ. Харин Pit 4 маллагын талбайн 7-р давхаргаас илэрсэн

³ Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Н.Звинс, Х.Пүрэвжал. Монгол-Германы хамтарсан чулуун зэвсгийн судалгааны ангийн 2013 онд хийсэн маллагын урьдчилсан үр дүн. Монголын Археологи-2013/ ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн 2013 оны хээрийн судалгааны үр дүн. УБ., 2013. Тал 8.

ясны үлдэгдлүүдийн дээж 39.570±290 BP (MAMS 20982), 40.480±320 BP (MAMS 20985), 40.910±340 BP (MAMS 20983), 41.720±160 BP (MAMS 20984) холбогдох нь тогтоогджээ.

2012 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Кембрижийн Их Сургууль болон ХБНГУ-ын Макс-Планкийн Хүрээлэнгийн лабораторийн мэргэжилтэнгүүд ирж хөрсний дээжийг зориулалтын багажаар үе бүрээс авсан бөгөөд уг дээжийг 2013 онд тус газруудад илгээсэн. Эдгээр дээжинд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээр уг дурсгалт газар орчмын тухайн үеийн байгаль, уур амьсгалын байдал, өвс ургамлын бүлгэмдлийн асуудал тодорхой болох юм.

РАШААН ХАДНЫ ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУУРИНГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ 2014 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС

Д.Базаргүр, Б.Гүнчинсүрэн, Г.Эрэгзэн, П.Алдармөнх, И Сон Бук, И Жон Ён

Өмнөтгөл.

Рашаан хадны дурсгалт газар ШУА-ийн Археологийн хүрээлэн, Сөүлийн Их сургуулийн Археологи, Эртний урлалын тэнхимтэй хамтран чулуун зэвсгийн үеийн судалгааг 2011, 2012 онуудад хийсэн юм. Энэ онуудад хийсэн судалгааны үр дүнд дурсгалын он цаг, чулуун зэвсэг үйлдвэрлэлийн аргын талаар гарган дэвшүүлсэн санал, дүгнэлтийг орчин үеийн түвшинд улам баталгаажуулан он цагийг 40,000 жилийн өмнө хамаарахыг батлан тогтоосны зэрэгцээ, илэрсэн чулуун зэвсгүүдийн дунд леваллуан аргаар хийгдсэн чулуун зэвсгүүд байгааг тодорхойлон гаргасан билээ. Мөн үүний зэрэгцээ малтлагын явцад илэрч олдсон эд хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан Рашаан хадны орчмын байгаль цаг уур, хүрээлэн буй орчинг нөхөн сэргээн үзэх зэрэг олон талын судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Малтлага судалгаа.

2014 онд D хэсгийн малтлагыг 2 м өргөнтэйгээр хойш сунган хойд талын цохионд тулган хөрсний давхарга хадны нөмөр хэсэгт ямар бүтэцтэй байх, хаданд хөмөг бий эсэх зэргийг шалган үзэхээс гадна хамгийн гол судалгаа соёлт давхаргын доод үеийн илрүүлэх, дахин соёлт давхарга байгаа эсэхийг нягтлан тэндээс илрэх олдвор хэрэглэгдэхүүнд анализ хийх, доод давхаргаас илрэх амьтны ясанд он цаг тогтоох шинжилгээг хийж өмнөх шинжилгээний үр дүнтэй харьцуулан үзэх зэрэг олон талын зорилгыг агуулсан юм.

Энэ онд өмнөх жилийн малтлагыг үргэлжлүүлэн хийхдээ нүхний баруун талын ханыг ашиглан хөрсний давхаргын бүтцийг тодорхойлох үүднээс энэ хэсэгт 2 м өргөн суваг татан доош үргэлжлүүлэн малтаж, үүнтэй залгуулан хойд тал руу хадан цохионд тулган малтсан(зураг 1). Маллагын явцад шинээр хүрэн давхаргыг улаан шаргал өнгийн буюу 4-р үеийн давхаргын доод талаас илрүүлсэн(зураг 2). Энэ хүрэн давхарга нь уулын энгэр хормойн хүрэн шороон бүтэцтэй, бичил нарийн хайрга чулуутай, давхаргын дунд хэсгээр зарим газраа 1 см зузаан нарийн элсэн судал ажиглагдана. Харин өмнөх жилүүдэд илэрч байсан кальци ихтэй 3-р үе болгон авч үзэж байсан давхарга энэ хэсгээс илрээгүй ба урд хэсгийн том бул чулуунаас эхлэн хойд тал руугаа намсан уусан алга болсон байдалтай байгаа юм. Энэ малтлагын явцад илэрсэн 4298 ш чулуун зэвсгүүдийг давхаргуудын аль хэсгээс илэрснээс шалтгаалуулан дараахь байдлаар ангилан үзсэн.

Хар давхаргаас илэрсэн чулуун зэвсгийн зүйлс. Энэ давхаргад өнгөн хөрс(1-р үе) болон хар шороон давхаргыг(2-р үе) хамруулсан.

Хар давхарга(1 ба 2-р үе), улаан шаргал давхарга(4-р үе) хоёрын зааг үеэс илэрсэн чулуун зэвсгийн зүйлс.

Улаан шаргал өнгийн давхаргаас(4-р үе) илэрсэн чулуун зэвсгийн зүйлс.

Хүрэн давхаргаас илэрсэн чулуун зэвсгийн зүйлс. Шинээр илэрсэн давхаргыг 5-р үе болгон авч үзсэн.

Мэрэгч амьтны нүхнээс илэрсэн чулуун зэвсгийн зүйлс. Энэ хэсэгт мэрэгч амьтны хөлөөр доод үед болон дээд үед байсан чулуун зэвсгийн зүйлс хоорондоо холилдсон байх үндэстэй учир тусад нь ялган үзлээ.

Ингэж хуваан авч үзэх нь дээрх давхаргууд өөр өөр цаг үед хамаарах төдийгүй чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга уламжлагдан ирсэн эсэхийг тодруулах боломжтой юм.

Малтлагын талбайн урд хэсгээс 2 м гүнээс элсэн давхарга илэрсэн ба энэ давхарга хадан цохионы хэсгээс 3,2 м гүнээс илэрсэн. Энэ давхарга голын эрэгт хуримтлагдан үүссэн давхарга байсан нь магадгүй Хурхын гол 40,000 жилийн өмнөх үед энэ хүртэл өргөн байсан байж болох юм.

Хөрсний давхаргын геологийн бүтцээс харахад хойд тал руугаа уруудсан байдалтай, хойд хэсэгтээ гүн бөгөөд уруудсан байдалтай тогтсон байна.

Элсэн давхаргаас доош сорилтын малтлага хийж үзэхэд 10-15 см гүнээс ул хадан хөрс илэрч байгаа учир малтлагыг дуусгасан юм.

Чулуун зэвсгийн ангилал. Чулуун зэвсгийн ангиллыг давхарга тус бүрээр ангилан бичлээ.

Хар давхарга буюу 1 ба 2-р үеэс нийт 1572 ш чулуун зэвсгийн зүйлс илэрч олдсоноос бэлдэц 9 ш, үлдэц 77 ш, зэвсгийн төрөл 55 ш, ялтас 154 ш, залтас 1057 ш, загасны торны хүндрүүлэгч 1 ш, түүхий эд 1 ш, техникийн цуулдас 6 ш, үйлдвэрлэлийн хаягдал/цуулдас 220 ш байна.

Үлдэц. 77 ш үлдцийг зориулалтаар нь ангилан үзвэл: левалмуан үлдэц 5 ш, ялтас цуулах зориулалт бүхий үлдэц 3 ш, бичил ялтас цуулахад зориулсан шаантаг үлдэц 15 ш, цохилтын олон талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдэц 38 ш, цохилтын нэг талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдэц 15 ш, 2 ба түүнээс дээш эмх цэгцгүй цуулалт хийгдсэн үлдэц 1 ш байна.

Зэвсгийн төрөл. 55 ш чулуун зэвсгийг төрөл зүйл, зориулалт хэрэглээгээр ангилан үзвэл: гилбэр хэлбэрийн зэвсэг 2 ш, зөв 1 ш, үзүүр мэсэн зэвсэг 1 ш, хусуур зэвсэг 15 ш, төгсгөл хусуур зэвсэг 10 ш, залтсыг шууд зэвсэг болгон ашигласан 18 ш, хэрэглээний зориулалт тодорхой бус эдлэл 6 ш, гоёл чимэглэлийн зүйл 1 ш байна.

Загасны торны хүндрүүлэгч эдлэл. Энэхүү эдлэл нь 1975, 1980, 1981 онуудад нийт 6ш олдсон ба тэдгээрийн зарим нь дундуураа хагарсан байдалтай олдсон байна. Тэгвэл энэ 1ш эдлэл нь харьцангуй том бүтэн олдсон юм.

Хар давхарга(1 ба 2-р үе), улаан шаргал давхарга(4-р үе) хоёрын зааг үеэс нийт 592 ш чулуун зэвсгийн зүйлс илэрч олдсоны бэлдэц 5 ш, үлдэц 30 ш, зэвсгийн төрөл 21 ш, хэрэглээний зориулалт тодорхой бус эдлэл 2 ш, ялтас 39 ш, залтас 405 ш, үйлдвэрлэлийн хаягдал/цуулдас 92 ш байна.

Үлдэц. 30 ш үлдцийг зориулалтаар нь ангилан үзвэл: левалмуан үлдэц 3 ш, ялтас цуулах зориулалт бүхий үлдэц 2 ш, бичил ялтас цуулахад зориулсан шаантаг үлдэц 8 ш, цохилтын олон талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдэц 10 ш, цохилтын нэг талбайтай цуулалтын олон гадаргуутай үлдэц 7 ш байна.

Зэвсгийн төрөл. 33 ш зэвсгийг зориулалт хэрэглээгээр нь ангилан үзвэл: хусуур 5 ш, төгсгөл хусуур 3 ш, шүдлэг иртэй зэвсэг 3 ш, хүнхэр иртэй зэвсэг 4 ш, сийлүүр 2 ш, дутуу боловсруулсан эдлэл 1 ш, зэвсгийн хагархай иртэй хэсэг 1 ш, залтсыг шууд зэвсэг болгон ашигласан залтас 9 ш, иртэй залтас 3 ш байна.

Улаан шаргал өнгийн давхарга буюу 4-р үеэс нийт 448 ш чулуун зэвсгийн зүйлс

илэрсэн ба үүнээс бэлдэц 10 ш, үлдэц 27 ш, зэвсгийн төрөл 41 ш, ялтас 26 ш, залтас 246 ш, үйлдвэрлэлийн хаягдал/цуулдас 98 ш байна.

Үлдэц. 27 ш үлдцийг зориулалтаар нь ангилан үзвэл: левалмуан үлдэц 9 ш, бичил ялтас цуулахад зориулсан шаантаг үлдэц 2 ш, цохилтын нэг талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдэц 7 ш, цохилтын олон талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдэц 4 ш, цохилтын хоёр талбайтай, цуулалтын хоёр гадаргуутай үлдэц 4 ш, говийн төрхийн үлдэц 1 ш байна.

Зэвсгийн төрөл. 41 ш зэвсгийг зориулалт хэрэглээгээр нь ангилан үзвэл: хусуур зэвсэг 10 ш, хүнхэр иртэй зэвсэг 4 ш, шүдлэг иртэй зэвсэг 1 ш, залтсыг шууд зэвсэг болгон ашигласан 21 ш, дутуу боловсруулсан эдлэл 2 ш, зориулалт тодорхой бус эдлэл 3 ш байна.

Хүрэн өнгийн давхарга буюу 5-р үеэс нийт 1305 ш чулуун зэвсгийн зүйлс илэрч олдсоны бэлдэц 1 ш, үлдэц 90 ш, зэвсгийн төрөл 103 ш, ялтас 63 ш, залтас 690 ш, үйлдвэрлэлийн хаягдал/цуулдас 317 ш байна.

Үлдэц. 90 ш үлдцийг зориулалтаар нь ангилан үзвэл: левалмуан үлдэц 17 ш, бичил ялтас цуулахад зориулсан шаантаг үлдэц 4 ш, ялтас цуулахад зориулсан үлдэц 4 ш, 2 ба түүнээс дээш эмх цэгцгүй цуулалт хийсэн үлдэц 19 ш, цохилтын олон талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдэц 10 ш, цохилтын нэг талбайтай цуулалтын олон гадаргуутай үлдэц 29 ш, цохилтын хоёр талбайтай, цуулалтын хоёр гадаргуутай үлдэц 7 ш байна(зураг 9. 4).

Зэвсгийн төрөл. 103 ш зэвсгийг зориулалт хэрэглээгээр нь ангилан үзвэл: хусуур 28 ш, төгсгөл хусуур 3 ш, шүдлэг иртэй зэвсэг 1 ш, хүнхэр иртэй зэвсэг 11 ш, левалмуан үзүүр мэс 3 ш, хутга хэлбэрийн зэвсэг 1 ш, залтсыг шууд зэвсэг болгон ашигласан залтас 41 ш, дутуу боловсруулсан эдлэл 1 ш, зэвсгийн хагархай иртэй хэсэг 12 ш, хэрэглээний зориулалт тодорхойгүй эдлэл 2 ш байна(зураг 9. 1-3, зураг 10. 1-12).

Мэрэгч амьтны нүхнээс илэрсэн чулуун зэвсгийн зүйлс. Эндээс нийт 414 ш олдсоноос бэлдэц 6 ш, үлдэц 22 ш, зэвсгийн төрөл 25 ш, ялтас 24 ш, залтас 281 ш, үйлдвэрлэлийн хаягдал/цуулдас 56 ш байна.

Үлдэц. 22 ш үлдцийг зориулалтаар нь ангилан үзвэл: бичил ялтас цуулахад зориулсан шаантаг үлдэц 3 ш, ялтас цуулахад зориулсан үлдэц 2 ш, цохилтын олон талбайтай, цуулалтын олон гадаргуутай үлдэц 10 ш, цохилтын нэг талбайтай цуулалтын олон гадаргуутай үлдэц 7 ш байна.

Зэвсгийн төрөл. 25 ш зэвсгийг зориулалт хэрэглээгээр нь ангилан үзвэл: хусуур 6 ш, төгсгөл хусуур 1 ш, хүнхэр иртэй зэвсэг 2 ш, үзүүр мэс 1 ш, залтсыг шууд зэвсэг болгон ашигласан залтас 15 ш байна.

Үүнээс гадна давхарга түс бүрээс илэрсэн залтас, ялтас, цуулдасыг хүснэгтээр гаргалаа. Энэхүү ангилал дээр тулгуурлан чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга, он цагийн асуудлыг тодруулахыг зорьсон юм.

Үйлдвэрлэлийн арга ба он цагийг тодруулах нь. Чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга нь хүн төрөлхтний хөгжлийн урт удаан хугацааны амьдралын туршлагаас үүдэн нилээд хэдэн арга байдаг ч одоогоор чулуун зэвсгийг хийх аргыг судлан түүнтэй адил чулуун зэвсэг хийх арга замаар үйлдвэрлэлийн аргыг сэргээх явцад тогтоогдсон аргууд байдаг байна. Эдгээр нь чулууг шууд цуулах, шууд бус цуулах, дарж цуулах гэсэн үндсэн аргууд юм¹.

A. Шууд цуулах арга (Direct percussion) нь чулууг цуулахдаа ямар нэг багаж

¹ John C. Whittaker. Flintknapping. 1997, A. Debenath, H.L. Dibble. Handbook of Paleolithic Typology. Paris. 1994

ашиглахгүйгээр бэлдэц чулуунаас залтас цуулж түүнийг шууд зэвсэг болгон ашиглах энгийн арга юм. Энэ шууд цуулах аргыг дотор нь А-1. Бэлдэц чулууг том чулуунд шидэж цуулах арга(hurling technique). Энэ нь хамгийн эртний хүний арга учраас нэг үгээр хэлбэл үлдэцийг дөш чулуун(anvil) дээр шидэж залтасыг цуулах арга юм. Залтасыг нэг нэгээр нь цуулахдаа тодорхой зорилгоор бус харин олон тооны залтас, цуулдас цуулж авахад байжээ. А-2. Бэлдэц чулууг гартаа барьж байгаад чулуунд цохиж залтасыг цуулах, А-3. Цохиур чулууг ашиглан бэлтгэсэн үлдэцнээс залтасыг цуулах аргуудаас бүрдэл болно. Бул чулуу болон дөш чулуу ашиглан цуулах арга(Anvil technique) ба суурилуулсан дөш чулуун дээр бэлдцийг байрлуулан цуулан авах залтасны цохилтын цэгийн байрлалыг тогтоогоод түүн дээрээ хүчтэй цохилтоор залтас цуулан авах арга юм. Энэ арга нь том залтасыг цуулан авахдаа элбэг хэрэглэдэг. Суурилуулж хөдөлгөөнгүй болгосон үлдэцнээс залтасыг цуулах арга нь палеолитын үеэс эхлэн неолитын үе хүртэл дамжин байнга хэрэглэж ирсэн ердийн арга гэж үзэж болох юм. Энэ аргад цохиур чулуу нь залтасыг хэрхэн цуулахад ихээхэн чухал үүрэгтэй байдаг. Цохиур чулуу нь үйлдвэрлэгчийн зорилгоос шалтгаалаад олон янзын хэлбэртэй байж болно. Энэ арга нь дотроо хатуу цохиураар хүчтэй цохиж цуулах, зөөлөн цохиураар цуулах гэж ангилагдана.

А-3-а. Хатуу цохиур чулуугаар цуулах арга (Hard Hammer Technique)нь хатуу цохиур чулуугаар үлдцийг цохиж залтасыг цуулах арга бөгөөд доод палеолитын үеэс эхлэн хамгийн ердийн байдлаар хэрэглэгдэж ирсэн арга юм.

А-3-б. Зөөлөн цохиураар цуулах арга (Soft Hammer Technique)нь үлдцийг бодвол зөөлөн материал үүнд; зөөлөн чулуу, мод, амьтны эвэр, яс зэргээр хийсэн цохиурыг ашиглаад залтасыг цуулах арга юм. Энэ аргаар цуулсан залтас нь ерөнхийдөө нимгэн цохилтын талбайтай, нүүрэн талын ихэнх нь тэгш хэлбэртэй цуурдаг онцлогтой юм.

Б. шууд бус цуулалтын арга (Indirect percussion) нь дээд палеолитын үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга юм. Энэ нь үлдэцнээс залтасыг цуулахдаа цохиур багаж болон үлдэц хоёрын хооронд цүүц багаж² ашиглан цуулалт хийх арга юм. Цүүц багажийг ашиглан залтас цуулахдаа чулуун цохиур зэвсэг хэрэглэхгүй ба харин мод, ясаар хийсэн цохиур зэвсгийг ашиглах нь илүү их тохиромжтой байсан байна. Цүүц багаж нь ерөнхийдөө эвэр болон түүнтэй адил шовх хэлбэрийн чулуу болон жижиг бөөрөнхий чулууг ч ашиглаж болно. Энэ арга нь палеолитын үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэх аргын өөрчлөлтийг харуулдагаараа онцлог юм³.

В. Дарж цуулах арга нь зориуд бэлтгэсэн багаж ашиглан даралт шахалтын аргыг ашиглан урт, өргөн залтас болон ялтас цуулан авч түүгээр төрөл бүрийн зэвсэг үйлдвэрлэх арга юм. Энэ арга нь дээд палеолитын эхэн үеэс эхэлсэн боловч дээд палеолитын дунд үеэс эхлэн ихэвчлэн урт ялтас цуулан авахад түлхүү ашиглах болсон нь ажиглагддаг байна.

Рашаан хадны чулуун зэвсгүүдийн дотор олон төрлийн хусуур, хутга, үзүүр мэс, ирлэсэн залтас, ялтас, говийн төрхийн үлдэц, шаантаг үлдэц, түүгээр ч барахгүй левалмуа маягийн болон хожуу үеийн үлдэц ч олдож байна. Хурх, Өглөгчийн голын хөндий, Биндэр уулын орчимд элбэг тархсан янз бүрийн өнгийн цахиур, хасын төрлийн чулуу нь үйлдвэрлэлийн үндсэн материал болж байжээ. Чулуун зэвсгүүдийн хийсэн аргыг үзэхэд дээрх аргуудаас А-3-р аргаар цуулалт хийгдсэн үлдэц ихэнх хувийг

² John C. Whittaker. Flintknapping. 1997, A. Debenath, H.L. Dibble. Handbook of Paleolithic Typology. Paris. 1994

³ Энэ зэвсэг нь амьтны эвэр, яс, зарим тохиолдолд нарийн зууван хурц үзүүр бүхий чулууг ашиглан хийсэн үлдэцний цуулах хэсэгт тулган барьж байгаад дээрээс нь цохиур багажаар цохиж залтас цуулахад хэрэглэгдэх багаж зэвсэг

эзлэх бөгөөд ийм үлдцийг цохилтын олон талбайтай, цуулалтын олон гадаргуутай, эмх цэгцгүй цуулалт хийгдсэн үлдэц хэмээх ангилалд оруулсан. Ийм төрлийн үлдэцний цуулалт хийсэн байдлаас үзэхэд А-3-а, б аргаар цуулагдсан ба гол нь хурц ирмэгтэй залтсыг цуулан авахыг зорилго болгож байсан байна. Мөн зэвсгүүдийн дунд ч гэсэн ийм цуулалтаар авсан залтас, цуулдасыг дахин боловсруулалт хийж ирлэн зэвсэг болгосон нь тодорхой мэдэгдэж байна.

Рашаан хадны суурингийн өнгөн хөрсний болон дээд давхаргаас олдсон говийн төрхийн үлдэц, төрөл бүрийн нимгэн ялтас, ялтсан залтас зэрэг эдлэлүүдийг неолитын үед холбогдуулан үзэж байна.

Рашаан хадны кальци ихтэй давхарга буюу 3-р үе, улаан шаргал давхарга буюу 4-р үеэс илэрсэн эдлэлүүд нь хийсэн арга барилын хувьд дээд палеолитын эхэн үеэс дунд үеийг хүртэл хугацааг хамрах бөгөөд энэ үеэс илэрсэн амьтны ясанд хийлгэсэн шинжилгээний үр дүн ч үүнийг нотлож байгаа юм⁴. 4-р үе буюу улаан шаргал өнгийн давхаргаас олдсон тал саран хэлбэртэй хусуур, гурвалжин мэс зэрэг нь Орхон голын хөндий Мойлтын амны палеолитын олон соёл давхарга бүхий суурингаас олддог зэвсгүүдтэй хэлбэр төрх, хэмжээ хийсэн арга барил бүхий л талаараа ижил байна.

Түүнчлэн дээрх ангилалын үр дүнгээс үзвэл, хусуур, хутга, хурц мэс зэвсэг, олон төрлийн үлдэц нь Монгол түүний хөрш Өмнөд Сибирь, Өвөр Байгалийн дээд палеолитын чулуун зэвсэгтэй адилсаж байна.

Рашаан хадны суурин нь мустьегийн дунд үеэс мезолитын сүүл үе хүртэл чулуун зэвсгийн дэвшингүй аажим хөгжлийг тодорхой харуулж байна. Тухайлбал, он цагийн хувьд хамгийн эрт үед холбогдох хүрэн давхаргаас илэрсэн зарим эдлэлийн үйлдвэрлэлийн арга, он цагийн асуудлыг авч үзвэл энэ давхаргаас илэрсэн эдлэлүүд бүгд мустьен үеийн левалуан хэв шинжийг агуулж байгаа нь маш чухал бөгөөд энэ нь дурсгалын он цагийг чулуун зэвсэг үйлдвэрлэлийн аргын хувьд цаашлуулан үзэх боломжтой болж байгаа юм. Үлдэцний хувьд бэлтгэл чулууны хажуу ирмэгийг эгц босоо шулуун зэрэгцээ цуулалтаар эргэн тойрон төв рүү чиглэсэн цуулалтыг хийж үүний дараа нэг хүчтэй цохилтоор нимгэн өргөн хоёр зах хажуу тэгш цуулагдсан залтас цуулсан, эсвэл бэлтгэл чулууны нэг талаас хэд хэдэн тууш цуулалт хийгээд түүний дараа мөн тэгш хэмт залтас цуулан авсан үлдэц нилээд тоотой байна. Ийм төрлийн үлдцийг левалуан үлдэц гэх ба аргыг мөн ингэж нэрлэдэг. Ийм аргаар хийгдсэн зэвсгүүд нь 4-р үеийн доод үеэс (40.000 жилийн өмнө холбогдох давхарга) буюу 5-р үеэс олдож байгаа юм. Эдгээр эдлэлүүдэд левалуан үлдэц (зураг 3. 4), левалуан үзүүр мэс (зураг 3. 1-3), левалуан залтас, олон төрлийн хусуур зэвсгүүд нь багтаж байна (зураг 4. 1-12). Үзүүр мэс, мустьен хусуур зэвсгүүдийг мустьен үеийн левалуан аргаар цуулан авсан залтас ашиглан хийжээ. Энэ үеийн олдворын он цагийн хамаарлыг Монгол орны нутгаас сүүлийн жилүүдэд илрүүлэн судалсан олон соёлт давхарга бүхий суурингуудын анхдагч болон хоёрдогч цуулалтын байдал, зэвсгийн цуглуулгатай харьцуулан үзэх нь илүү дөхөмтэй юм. Рашаан хадны 3, 4-р давхаргын олдворууд нь анхдагч цуулалтын байдлаараа Цагаан агуйн 3-5-р давхаргатай ижилсэх шинж байна.

Хүрэн давхаргын эдлэлүүд дотор он цагийн хувьд баттай тогтоогдсон Орхон 7 дурсгалын 10, 11-р давхарга⁵ болон Мойлтын амны доод давхаргаас илэрсэн үлдэц, залтас, хүнхэр болон шүдлэг иртэй зэвсгүүдтэй хийсэн аргын хувьд ижилсэж байгаа

⁴ M.Inizan, H.Roche, J.Tixier. Technology of Knapped Stone. 1992.

⁵ Б.Гүнчинсүрэн, Д.Базаргүр. Рашаан хадны малтлага судалгааны тайлан. (2011 он). АХГБСХ,д, 2012, Улаанбаатар.

учир палеолитын дунд үеэс дээд палеолитын үед шилжих шилжилтын үед хамруулан үзэж болох юм. Мөн энэ давхаргаас амьтны шилбэний ясыг тайрч засаж хийсэн цохиур багаж олдсон нь сонирхолтой юм.

Дүгнэлт

Рашаан хадны дурсгалт газрын маллага судалгаагаар Төв Азийн газар нутгийн нэг хэсэг болох энэ дурсгалт газрын газар зүйн өөрчлөлт, эрт үеийн хүний хэрэглэж байсан эдлэл хэрэглэгдэхүүнийг олж илрүүлэн түүний он цагийг системтэйгээр олж тогтоон цаг хугацааны явцад хадгалагдан үлдсэн палеолитын үеийн соёлт давхаргыг илрүүлэх, эндээс гарсан үр дүнд тулгуурлан олон талын судалгаа хийхээр зорьж байгаа билээ. Дурсгалын соёлт давхаргыг зааглан үзэхэд нэг бэрхшээлтэй зүйл байсан ба энэ нь мэрэгчдийн улмаас газрын хөрс маш их эвдэрч гэмтсэн ба хөрс нь холилдсон хэсгүүдээс соёлт давхаргыг олж тогтоох нь маш их бэрхшээлтэй зүйл юм.

Энд геологийн таван давхарга байгаагаас бүгд соёлт давхаргад хамаарч байна. Өнгөн хөрс, хар шороон давхарга буюу 1, 2-р үе неолитын үе, улсан шаргал давхарга буюу 3-р давхаргын доод үе, кальци ихтэй давхарга буюу 4-р үеийн дээд хэсгээс илэрсэн амьтны ясанд хийсэн он цаг тогтоох шинжилгээгээр 40,000 жилийн өмнө холбогдох болохыг тогтоож дээд палеолитын үе, хүрэн давхарга буюу 5-р үеийг дунд палеолитоос дээд палеолитод холбогдоно хэмээн үзэж байна.

Эндээс олж илрүүлсэн 4298 ш чулуун зэвсгийн зүйлсүүд нь хас, цахиур болон хайрга чулууг гол түүхий эдээ болгон хийсэн бөгөөд залтас, ялтсыг ирлэн хэрэглэж байснаас гадна гилбэр зэвсэг, том хэмжээний хусуур, хажуугийн болон төгсгөл хусуур, хүнхэр ирт болон шүдлэг ир бүхий зэвсэг, хатгах, огтлох, цоолох, зэрэг зориулалт бүхий олон төрлийн зэвсгийн зүйлсүүд байна.


2014 онд шинээр илрүүлсэн хүрэн давхаргын чулуун зэвсгүүд нь уг дурсгалын он цагийг урагшлуулан Рашаан хадны орчимд 50.000 жилийн өмнө эртний хүмүүс амьдарч байсныг нотлох боломж гарган өгч байгаа юм.



Зураг 1. Малтлагыг сунгаж малтсан байдал



Зураг 2. Давхаргуудын ерөнхий байдал



Зураг 3. Леваллуан үлдэц 4, үзүүр.мэс 1-3.




Зураг 4. 1-Мусьте хэлбэрийн хусуур, 2-5, 7-8-хусуур, 6,9,10-төгсгөл хусуур, 11, 12- гилбэр хэлбэрийн иртэй хусуур зэвсэг.

ЭГИЙН ГОЛЫН ХӨНДИЙД ХИЙСЭН ЧУЛУУН ЗЭВСГИЙН МАЛТЛАГА БОЛОН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Г.Лхүндэв, Б.Гүнчинсүрэн, Д.Базаргүр, Г.Ангарагдөлгөөн

2014 оноос Эгийн голд усан цахилгаан станц барих ажил дахин өрнөсөнтэй уялдан „Эгийн голын түүх, соёлын дурсгалуудыг авран хамгаалах археологийн судалгаа” төсөл хэрэгжиж, үүнд манай улсын түүх, археологийн салбарын мэргэжлийн байгууллагууд хамтран ажилласан билээ. Уг ажлын хүрээнд Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн талбайн усан сан үүсэх хэсэгт буй Баян гол, Улаан эрэг, Дөрөлжийн чулуун зэвсгийн дурсгалт газарт малтлага, Эмгэнт хошууны орчимд хайгуул судалгааны ажлыг хийсэн юм (зураг 1).



*Зураг 1. Судалгаа хийсэн газруудын байршил зүйн зураг
(1:100,000 масштабын газрын зургийн М48-88 дугаараас хэсэгчлэн авав)*


Дөрөлжийн чулуун зэвсгийн малтлага судалгаа

Өлийн давааны урд бие Эгийн гол руу түрж орсон гүнзгий гуу жалга, нугачаа ихтэй хошууг Дөрөлж гэх бөгөөд түүний зүүн биед баруун хойноос зүүн урагш чиглэлтэй цуварсан олон дэнжүүд байрлана. Энд 1999-2001 онд Монгол-Францын хамтарсан чулуун зэвсэг судлах анги Дөрөлж 1, Дөрөлж 2 сууринд малтлага судалгаа хийсэн¹ байдаг. Энэ удаа Дөрөлжийн зүүн биеийн олон дэнж дээр 4-н газар сонгон А, В, С, D хэмээн дугаарлан малтав. В хэсэг нь Дөрөлж-3 чулуун зэвсгийн сууринтай давхцаж байна.

¹ Ц.Төрбат, Ч.Амаргүвшин, У.Эрдэнэбат. Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд. Улаанбаатар, 2003. тал.10-12.

А хэсгийн малтлага судалгаа. Газар зүйн байршил: $N49^{\circ}26'09.1''$, $E103^{\circ}34'21.7''$, Alt 841 м. Дөрөлжийн зүүн урд хэсэгт 5 м² талбайд 150 см гүн малтлага хийсэн. Малтлагаас хөрсний 3-н давхарга илэрсэн боловч чулуун зэвсгийн дурсгал агуулсан соёлт давхарга илрээгүй.

В хэсэг буюу Дөрөлж 3 суурингийн малтлага судалгаа. Газар зүйн байршил: $N49^{\circ}26'14.6''$, $E103^{\circ}34'26.7''$, Alt 854 м. Баруун хойноос зүүн урагш сунасан жижиг дэнжийн хормой хэсгээс төв хэсгийг дайруулан 12х1.0 м талбайг А1-А12 өрөгт хуваан малтав. А1-А6 өргөөс чулуун зэвсгийн олдвор илрээгүй бол А7-А12 өргөөс чулуун зэвсгийн зүйлс илэрсэн бөгөөд уг талбайг хойш нь 200 см (В,С өргүүд), зүүн тийш А13-А14 өрөг нэмж сунган нийт 30 м² талбайд малтлага хийсэн. Малтлагын гүн 190 см. Малтлагаас хөрсний 4-н давхарга илэрч түүний 3, 4-р үе нь чулуун зэвсгийн олдвор агуулсан соёлт давхарга байв. Малтлагын талбайн В11, С11 өргийн 3, 4-р үеийн зааг хэсгээс галын ором, амьтны ясны жижиг хэлтэрхий илэрсэн (зураг 2).



Зураг 2. В хэсэг буюу Дөрөлж 3 суурингийн чулуун зэвсгийн тархалтын зураглал болон хөрсний давхаргын бүтцийн ерөнхий байдал

Чулуун зэвсгийн цуглуулга. В хэсэг буюу Дөрөлж 3 суурингаас нийт 161 ш чулуун зэвсгийн олдвор илэрсэн бөгөөд тэдгээрийг давхарга тус бүрээр ангилвал:

3-р давхарга: Үлдэц-1 ш, хусуур зэвсэг-1 ш, цохиур чулуу-1 ш, залтас-10 ш, ялтас-3 ш, цуулдас-6 ш байна (зураг 3).


4-р давхарга: Үлдэц-7 ш, сийлүүр-1 ш, шүдлэг иртэй зэвсэг-1 ш, хянгар-1 ш, төгсгөл хусуур-1 ш, залтас-51 ш, ялтас-46 ш, цуулдас-11 ш, техникийн цуулдас-3 ш, хагархай-17 ш байна.

Анхдагч цуулалт: Үлдэц-8, техникийн цуулдас-3 ш гэж ангилагдах бөгөөд нийт олдворын 6.8%-ийг эзэлнэ (зураг 4).


Зэвсгийн төрөл: Хусуур-2, сийлүүр, шүдлэг иртэй зэвсэг, хянгар, цохиур чулуу тус бүр 1 ш гэж ангилагдах бөгөөд нийт олдворын 3.7%-ийг эзэлнэ (зураг 5).

Цуулдасны үйлдвэрлэл: Залтас-61, ялтас-49, цуулдас-17, хагархай-17 ш гэж ангилагдах бөгөөд нийт олдворын 89.4%-ийг эзэлнэ (зураг 6).

С хэсгийн малтлага судалгаа. Газар зүйн байршил: $N49^{\circ}26'16.8''$, $E103^{\circ}34'27.8''$, Alt 864 м. Дэнжийн адаг хэсгийн тэгш газарт 2 м² талбайд 50 см гүн малтлага хийв. Өнгөн хөрс 20 см зузаан байсан бөгөөд түүний доороос том том чулуутай элсэрхэг хөрс 30 см хүртэл гүнд үргэлжилж, түүнээс доош хаданд тулсан. Энэ нь дэнж хэсгээс дээш өгсөх тусам шороон давхарга нимгэрч байгааг илтгэх бөгөөд эндээс чулуун зэвсгийн олдвор илрээгүй.




Зураг 3.3-р давхаргаас илэрсэн чулуун зэвсгүүд.
1-үлдэц, 2-хусуур, 3-цохиур чулуу, 4,5,6-ялтас




Зураг 4.4-р давхаргаас илэрсэн чулуун эдлэлүүд.
1-7-үлдэц

D хэсгийн малтлага судалгаа. Газар зүйн байршил: $N49^{\circ}26'18.3''$, $E103^{\circ}34'32.4''$, *Alt* 858 м. Уул руу алгуур өгссөн өргөн тэгш гадаргуутай дэнж дээр 4 м² талбайд 180 см гүнтэй малтлага хийв. Малтлагын 160 см гүнээс залтас-1, цуудас-1 ш илэрсэн. Энэ малтлагаар хөрсний 3-н давхарга илэрсэн.



Зураг 5. 4-р давхаргаас илэрсэн чулуун зэвсгүүд. 1-сийлүүр зэвсэг, 2-шүдлэг иртэй зэвсэг, 3-хянгар, 4-төгсгөл хусуур, 5-таргил залтас




Зураг 6. 4-р давхаргаас илэрсэн ялтаснууд.

Баян голын чулуун зэвсгийн маллага судалгаа

Уг дурсгалт газар нь Баян голын Эгийн голд цутгах цутгалын зүүн хойд талын өндөр дэнж дээр байрлана. *Газар зүйн байршил: N49°26'32.5", E103°38'40.6", Alt 862 м.* Энэ нь уулын энгэрийн хагас дугуйрсан хэсэг дэх хэд хэдэн өндөр дэнжийн баруун талаасаа хоёр дахь дэнж юм. Эхний дэнж дээр 1999 онд Монгол-Америк², 2010 онд Монгол-Японы хамтарсан чулуун зэвсэг судлах анги³ маллага судалгаа хийж байсан.

Энэ удаа хоёр дахь дэнж дээр А, В гэсэн хоёр талбайд маллага хийлээ.

А хэсгийн маллага. Дэнжийн баруун дээд ирмэг дагуу 56 м² талбайд маллага судалгаа хийв. Маллагын гүн газрын өндөр талд 180 см, нам талд 80 см болоход хайрган чулуутай давхарга гарч, чулуун зэвсгийн олдвор илрээгүй болно. Иймд Баян голын хөрсний давхаргыг тодорхойлох зорилгоор 420 см гүнд хүртэл малтаж үзэхэд уг газрын хөрс 12 давхаргаас бүрдэж байна (зураг 7). Энэхүү 12 давхаргын 3, 4-р үеэс чулуун зэвсгийн олдвор илэрсэн бөгөөд үүнээс доош илрээгүй болно. Хөрсний 2-р давхаргын доод болон 3-р давхаргын дээд хэсгээс амьтны ясны үлдэгдэл цөөн илэрсэн.




Зураг 7. Баян голын хөрсний давхаргын бүтцийн гар зураглал

Чулуун зэвсгийн цуглуулга. А хэсгээс 39 ш чулуун зэвсгийн олдвор илэрсэн бөгөөд тэдгээрийг давхарга тус бүрээр ангилвал:

3-р давхарга. Нийт 6 ш чулуун зэвсгийн зүйлс олдсон ба үлдэц-1, залтас-2, левалуа хэлбэрийн залтас-1, техникийн цуулдас-1, иртэй цуулдас-1 байна (зураг 8).

² Heater A. Price. "Lithic inventory and Preliminary Analysis 1999 Egiin Gol Survey and Excavation" Mongol-American joint expedition to Egiin Gol, Mongolia 1999 Survey Report. 2000. АХГБСХ. Section IV. p.1-2.

³ Т.Цүрүмару. Яагаад Монгол вэ? Монголд Японы чулуун зэвсгийн технологийн уламжлалыг хайх нь. "Монгол-Японы археологичдын хамтын ажиллагаа" сэдэвт үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурлын илтгэл. Гурван гол экспедиц. Улаанбаатар, 2013. тал.116-121.




Зураг 8. 3-р давхаргаас илэрсэн чулуун зэвсгүүд.
1-үлдэц, 2-леваллуа хэлбэрийн залтас, 3-техникийн цуулдас, 4-иртэй цуулдас

4-р давхарга. Нийт 33 ш чулуун зэвсгийн зүйлс олдсон ба үлдэц-1, үзүүр мäs-2, хусуур зэвсэг-2, залтас-14, ялтас-3, леваллуа хэлбэрийн залтас-2, үйлдвэрлэлийн хаягдал-1, цуулдас-7, иртэй цуулдас-1 байна (зураг 9).

Анхдагч цуулалт: Үлдэц 2, техникийн цуулдас 1 ш гэж ангилагдах бөгөөд нийт олдворын 7.7%-ийг эзэлнэ.

Зэвсгийн төрөл: Үзүүр мäs 2, хусуур 2, иртэй цуулдас 2 ш гэж ангилагдах бөгөөд нийт олдворын 15.3%-ийг эзэлнэ.

Цуулдасны үйлдвэрлэл: Ялтас 3, залтас 19, цуулдас 8 ш гэж ангилагдах бөгөөд нийт олдворын 76.9%-ийг эзэлнэ.



Зураг 9. 4-р давхаргаас илэрсэн чулуун зэвсгүүд.
1-үлдэц, 2,3-үзүүр мäs, 4,5-хусуур, 6,7-ялтас, 8,9-леваллуа хэлбэрийн залтас

В хэсгийн малтлага. А хэсгийн хойд булангаас зүүн тийш 400 см зайтай газарт 4 м² талбайд 160 см гүн малтлага хийв. Малтлагыг 50 см гүнтэйгээр шатлан гүйцэтгэсэн ба малтлагын талбайгаас чулуун зэвсгийн зүйлс 6 ширхэг олдсон нь залтас-3, бичил залтас-2, цуулдас-1 байна.

Улаан эрэгт хийсэн маллага судалгаа

Баян голын адаг болон Өлийн даваа хоёрын хоорондох уужим хөндийд хойноос урагш сунаж Эгийн гол руу шахаж тогтсон намхан дэнжийг Улаан эрэг гэнэ. Дэнжийн урд хэсгийн нэгэн намхан эргийг дайруулан 4,5 м² талбайд маллага хийсэн. Газар зүйн байршил: *N49°26'30,7", E103°36'22,5", Alt 847 м.* Өнгөн хэсгийн маллагын явцад залтас-2, цуулдас-3 олдсон. Маллагын гүн 140 см болоход хайрга чулуутай элсэн хөрс гарсан бөгөөд соёлт давхарга илрээгүй болно.

Эмгэнт хошуунд хийсэн чулуун зэвсгийн хайгуул судалгаа

Эмгэнт хошуу нь Баруун Бэлсэгийн амны адагт орших хадтай толгой юм. Газар зүйн байршил: *N49°27'25,2", E103°29'16,8", Alt 857 м.* Эмгэнт хошууны энгэр бэл орчмоор хайгуул хийж өнгөн хөрсөн дээрээс 11 ширхэг чулуун зэвсгийн олдвор түүвэрлэсэн. Чулуун зэвсгийн цуглуулганд хянгар-1, хүнхэр зэвсэг-1, иртэй залтас-1, залтас-5, ялтас-1, хагархай-2 ширхэг байна (зураг 10).



Зураг 10. Эмгэнт хошуунаас түүвэрлэсэн зарим чулуун зэвсгүүд.
1-давхар иртэй хянгар, 2-хүнхэр зэвсэг, 3-иртэй залтас, 4-залтас

Чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга барил, он цагийн хамаарлын асуудал

Эгийн голын хөндийд орших Дөрөлж, Баян гол, Улаан эрэг, Эмгэнт хошуунд хийсэн маллага, хайгуул судалгааны ажлын үр дүнд олж илрүүлсэн чулуун зэвсгийн олдвор, хэрэглэгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийж, чулуун зэвсгийн ангилал зүйн үүднээс бүх эдлэлүүдэд задлан шинжилгээ хийсэн бөгөөд эхлээд анхдагч цуулалтаар, дараа хоёрдогч боловсруулалтаар, эцэст нь эдлэлүүдийн хэв шинж болон багаж зэвсгүүдийн зориулалтаар нь ангилсан болно.

Энэ бүс нутагт амьдарч байсан эртний хүмүүс чулуун зэвсэг хийх түүхий эдээ голын эрэг, жалга дэнж, уул толгодын ёроол хэсгийн хурдсанд буй хар бараан өнгийн цахиурлаг занар, мөлгөр хайрган чулууг голчлон ашиглаж байжээ.

Анхдагч цуулалтын хувьд цохилтын нэг болон хоёр талбайт, цуулалтын нэг гадаргуут; цохилтын хоёр талбайт, цуулалтын хоёр гадаргуут хавтгай үлдэц; призм хэлбэрийн тайрдсан үлдэц; эмх цэгцгүй цуулалт хийгдсэн үлдцүүд зонхилж байна. Эдгээр үлдцээс тууш болон хөндлөн, мөн зэрэгцээ цуулалтаар залтас, ялтас цуулан авч байсан нь мэдэгдэнэ. Хавтгай болон гонзгой хэлбэртэй чулууны тэгш гадаргууг шууд цохилтын талбай болгон ашиглах, эсвэл цохилтын талбайг эхлэн бэлтгээд түүнээс цуулалт хийх аргыг голчлон хэрэглэж байжээ. Дээр дурдсан хэв шинжит үлдцүүд Монгол орны хангайн бүс нутагт орших Эг, Төлбөр, Орхон голын сав дагуух соёлт давхарга бүхий томоохон суурингуудаас илэрсэн нь дээрх дурсгалт газруудын он цагийн асуудлыг баримжсалах боломжийг олгож байна.

Тухайлбал: Он цагийг AMS (C^{14}) аргаар тогтоосон Дөрөлж-1 суурингийн дээд давхарга нь $22.030 \pm 180 \text{ BP}^4$, доод давхарга нь $31.880 \pm 800 \text{ BP}$ холбогдож байгаа бол Дөрөлж-2 суурингийн хувьд 27.000-25.000 жилийн өмнө⁵, Эгийн голд цутгах Баян голын суурин нь $27000 \pm 390 \text{ BP}^6$ жилийн өмнө холбогдож байна. Харин Сэлэнгэ мөрний дунд урсгал орчмын жижиг цутгал болох Төлбөрийн голын 15-р дурсгалт газрын 3-р давхарга 14.055 ± 80 (AA-84136) жилийн тэртээд, 4-р давхарга 14.680 ± 70 (Beta-263744) жилийн тэртээд⁷, 5-р давхарга 28.460 ± 310 (AA-84137) жилийн тэртээд тэртээд холбогдоно⁸. Мөн Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Орхон-1 дурсгалт газрын 1, 2-р маллагын 4-р үе (2-р соёлт давхарга) 29.465 ± 445 (COAN-2886) жилийн тэртээд, Орхон-7 дурсгалт газрын 1-р маллагын 5-р үе (3-4-р соёлт давхарга), Орхон-7 дурсгалт газрын 3-р маллагын 5-р үе (1-2-р соёлт давхарга) $23.595 \pm 459 \text{ BP}$ (АНУ) - $25.500 \pm 1400 \text{ BP}$ (АНУ) жилийн тэртээд холбогдохыг тогтоожээ⁹.

Чулуун зэвсгийн дотор дээд палеолитын хэв шинжийг агуулсан үзүүр мөс, хянгар, хусуур, сийлүүр, шүдлэг болон хүнхэр зэвсэг цөөн тоотой, уртлаг ялтас, залтас олон тоотой илэрсэн нь дурсгалт газруудын он цагийг тогтоох бас нэгэн үзүүлэлт болж байна.

Иймд бидний малтан судалсан дурсгалт газруудын чулуун зэвсгүүд нь дээр дурдсан суурингийн олдвор хэрэглэгдэхүүнтэй үйлдвэрлэлийн арга барил, хэв шинж, зэвсгийн төрөл зүйлийн хувьд адил байгаа нь дээд палеолитын дунд үед хамаарах боломжтойг харуулж байна.

Харин Улаан эрэгт хийсэн маллага судалгаагаар соёлт давхаргагүй болох нь тодорхой болсон бөгөөд дээд палеолитын төгсгөл болон шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгалыг агуулсан ил суурин бололтой.

⁴ J.Jaubert, P.Bertran, M.Fontugne, M.Jarry, S.Lacombe, Ch.Leroyer, E.Marmet, Y.Taborin, B.Tsogtbaatar. Le Paléolithique supérieur ancien de Mongolie: Dirulj 1 (Egiin gol) Analogies avec les données de l'Altai et de Sibirie. //Section 6. The Upper Paleolithic. General Sessions and Posters. Acts of the XIVth UISPP Congress, University of Liège, Belgium, 2-8 September 2001. BAR International Series-1240, 2004. p.230.

⁵ J.Jaubert, S.Lacombe, M.Jarry, M.Fontugne, B.Tsogtbaatar. Dirulj 1 et 2 (Egiin gol, region de Bulag, Mongolie) : Le Paléolithique supérieur ancien en Mongolie, rapport, 2001. АХГБСХ. p.4-7.

⁶ Heater A. Price. "Lithic inventory and Preliminary Analysis 1999 Egiin Gol Survey and Excavation" Mongol-American joint expedition to Egiin Gol, Mongolia 1999 Survey Report. 2000. АХГБСХ. Section IV. p.1-2.

⁷ С.А.Гладышев, Б.Гунчинсүрэн, Е.П.Рыбин, А.В.Табарев, Ц.Болорбат, Д.Одсүрэн, Д.Олсен. Итоги изучения многослойного палеолитического памятника Тулбэр-15 в 2010 году. Археологийн судлал. Том XXX. fasc.2. Улаанбаатар, 2011. т.39.

⁸ С.А.Гладышев, Б.Гунчинсүрэн, А.В.Табарев, Ц.Болорбат, Д.Одсүрэн, Д.Олсен. Заключительные работы на стоянке Тулбэр-15 в 2011 году. Археологийн судлал. Том XXXII. fasc.3. Улаанбаатар, 2012. т.58-59.

⁹ А.П.Деревянко, А.В.Кандыба, В.Т.Петрин. Палеолит Орхона. Новосибирск, 2010. стр.31-21, 249.

Эмгэнт хошуунаас түүвэрлэсэн цөөн тооны чулуун зэвсгийн цуглуулганд дээд палеолитын хэв шинжтэй эдлэлүүд байгаа боловч багаж зэвсгийн нэр төрөл хомс, ихэнх нь цуулдасны үйлдвэрлэлд хамаарах бөгөөд зарим нь хүчтэй элэгдэлд орсон, анхдагч цуулалттай холбоотой эдлэл олдоогүй зэрэг нь он цагийн асуудлыг дэвшүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Эгийн голын хөндийд хийсэн чулуун зэвсгийн судалгаагаар дурсгалт газрууд нь Сэлэнгэ, Орхон голын сав, түүний цутгал жижиг голуудын хөндийгөөр оршиж буй чулуун зэвсгийн дурсгалуудын нэгэн адил Эгийн гол, түүнд цутгах жижиг гол, горхи даган байр

ХАРГАНЫН ГОЛ-5 ХУУЧИН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СОЁЛТ ДАВХАРГА БҮХИЙ ДУРСГАЛЫН МАЛТЛАГА СУДАЛГАА

*Б.Гүнчинсүрэн, Е.П.Рыбин, Ц.Болорбат,
С.А.Гладышев, Д.Одсүрэн, А.М.Хаценович*

Хойд мөсөн далайн ай савд багтах Сэлэнгэ мөрний цутгал том, жижиг голуудын хөндийгөөр чулуун зэвсгийн үеийн баялаг дурсгалтай болох нь сүүлийн жилүүдэд хийгдэж буй хайгуул судалгааны дүнд тодорхой болоод байгаа юм.

Монгол-Оросын хамтарсан чулуун зэвсгийн дурсгал судлах хэсэг Сэлэнгэ мөрний дунд үрсгал орчимд, баруун гар талаас нь цутгах Их Төлбөрийн голын сав нутагт 2004 оноос суурин малтлага судалгааны ажлыг хийж байна. Уг төслийн судлаачид 2012 онд Сэлэнгэ мөрний баруун гар талын өөр нэг цутгал Алтайдын голын хөндийд шилжин ажигласан бөгөөд Харганын гол-5 хэмээн тэмдэглэгдсэн хуучин чулуун зэвсгийн соёлт давхарга бүхий дурсгалыг илрүүлсэн юм.

Энэ дурсгалт газар Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Чаптагын нуруунаас эх авч зүүн хойд зүгт урсан Алтайдын голд цутгах Харганын гол хэмээх цэнгэг уст уулын голын хойд эрэгт, үргэлжилсэн уулсын урагш намссан хамар дээр, голын хоёрдогч дэнжид оршино.

2012 онд энд дөрвөн газарт сорьц малтлага хийсэн бөгөөд 2 дугаар сорьц малтлагыг өргөтгөн 13 м² талбайд судалгааны ажлыг гүйцэтгэсэн¹ юм.



Харганын гол-5 (баруун талаас)



Харганын гол-5 (зүүн урд талаас)


Харганын гол-5 хэмээн тэмдэглэгдсэн энэхүү дурсгалын тухай илүү өргөн мэдээлэл олж авах зорилгын үүднээс хамтарсан төслийн 2014 оны хээрийн шинжилгээний ажлыг энд хийхээр төлөвлөсөн бөгөөд өмнөх малтлагын талбайг баруун болон урд тал руу нь сунгаж (малтлагын өргүүдийг баруун хойд талаас нь эхлэн баруунаас зүүн тийш чиглэлтэйгээр 19, 20, 21, 22-34 г.м) нийт 16 м² талбайд малтлага судалгааг гүйцэтгэв.

Малтлага судалгааны үр дүнд хөрний 6 давхаргад агуулагдсан археологийн эд өлөг бүхий 7 үеийг тодорхойлсон юм.

Тухайн газарт хөрсний давхарга бүрэлдэн бий болоход хормойн болон хагшмал хурдсын хуримтлал, салхины үйлчлэл гол нөлөөг үзүүлжээ. Харганын гол болон Их Төлбөрийн голын хөндийд малтан судалсан дурсгалуудын хөрсний 2 дугаар давхарга нийтлэг шинжтэй бөгөөд геологич В.А.Коломиец тухайн давхаргын тодорхойлолыг

¹ Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Д.Одсүрэн. Алтайд, Харганын голын савд хийсэн чулуун зэвсгийн судалганы урьдчилсан үр дүн. Монголын археологи-2012. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2012 оны хээрийн судалгааны үр дүн. УБ, 2012. т.5-12

хийсэн² юм. 3 болон 4 дүгээр давхарга 2014 оны маллагын баруун хэсэгт харьцангуй нимгэн байгаа нь ажиглагдсан. 4.1 дүгээр давхарга нь Умард Монголын бүс нутагт элбэг тохиолдох элсэрхэг хөрсөн давхарга³ юм. Энэ нь Төлбөр-4 (6-7-р давхарга), Төлбөр-16 (7а давхарга), Төлбөр-21 (5-р давхарга) дурсгалуудтай адил юм. Өмнөх судалгааны байдлаас үзэхэд энэ давхарга 45-37 мянган жилийн өмнөх үед холбогдох⁴ бөгөөд чулуун эдлэлүүдийн цуулалтын арга барил, хэв шинжээрээ энэхүү он цагийн хүрээлэлд хамаарах боломжтой.



Зураг 1. Харганын гол-5 дурсгалын өмнөд ханын зүсэлт

Маллага судалгааны дүнд илэрсэн олдворуудыг үе тус бүрээр нь доор ангилан боловсруулав.

7 дугаар давхарга. Эндээс нийт 29 ш олдвор илэрсэн бөгөөд анхдагч цуулалтын хэсэг нь *цуулдсууг*, янз бүрийн хэлбэртэй *хагархай хэлтэрхий* болон *цохилтын нэг талбайт*, *цуулалтын нэг гадаргуут үлдэц* хийхээр зассан ганц ширхэг бэлдцээр илэрхийлэгдэнэ. *Залтсууг* (20 ш) хэлбэрийн хувьд ялтсан залтас, богиновтор, тэгш өнцөгт маягийн хэлбэртэй хэмээн ангилагдана. Эдгээрээс бүтэн залтас 15 ш байх бөгөөд бусад нь суурь болон дунд хэсгийн хагархай юм.

Зэвсгийн төрөл зүйлд 6 ш эдлэл хамаарна. Тэдгээрийг залтас, хагархай ашиглан хийсэн байх ба дунд болон жижгээр холточсон захын хайрслал ир, зэрэгцээ ир, нэмэлт ажилбар хийгээгүй хүнхэр ирмэг гаргах замаар бэлтгэжээ. Эдгээр нь төрөл зүйлээрээ том хэмжээтэй залтасны нэг ирмэгийн дундаас доошхи хэсгийг ар талаас нь хагас налуу холточсон ирээр ирлэсэн *хянгар* (зураг 2-1), том хэмжээтэй залтас болон залтасны хагархай ашиглан хийсэн *хатгуур* (зураг 2-2, 3), ялтасны төгсгөл хөндлөн ирмэг болон түүнтэй нийлэх тууш ирмэгээс шулуун цуулалт хийх аргаар

²V.L.Kolomiets, S.A.Gladyshev, E.V.Bezrukova, E.P.Rybin, P.P.Letunova, A.A.Abzaeva. Environment and Human Behavior in Northern Mongolia during the Upper Pleistocene // Archaeology, Ethnology and Anthropology of Eurasia. – 2009. – №1 (37). – P. 2–14.

³T.G.Ryashchenko, V.V.Akulova, M.A.Erbaeva. Loessial soils of Priangaria, Transbaikalia, Mongolia, and northwestern China // Quaternary International. – 2008. – Vol. 179. – P. 90–95.

⁴А.П.Деревянко, Е.П.Рыбин, С.А.Гладышев, Б.Гунчинсүрэн, А.А.Цыбанков, Д.Олсен. Развитие технологических традиций изготовления орудий в каменных индустриях раннего этапа верхнего палеолита Северной Монголии (по материалам стоянок Толбор-4 и -15) // Археология, этнография и антропология Евразии. – 2013. – №4 (56). С. 21–37.



Зураг. 2. 7, 6 дугаар үеийн чулуун эдлэлүүд 1-хянгар; 2, 3-хатгуур зэвсэг; 4-сийлүүр; 5-хагачиж зассан зэвсэг; 6-ирлэсэн ялтас; 7-леваллуа хэлбэрийн үзүүр мэс; 8-хосолмол зэвсэг; 9-ялтасны хагархай

үзүүр мэс нь гурвалжиндуу хэлбэртэй бөгөөд ар талдаа гурвалжин хэлбэрийн цуулалт хийсэн ормыг хадгалжээ (зураг 2-7). Хосолмол зэвсгийг леваллуа хэлбэрийн залтас ашиглан бэлтгэжээ. Залтасны нэг хажуугийн гүдгэр ирмэгийг хагас босоо ирээр ирлэсэн нь хянгартай адил болжээ. Нөгөөх шулуун ирмэг нь хоорондоо зайтай жижиг ирээр ирлэгдсэн байна (зураг 2-8). Том залтасны хагархайгаар шүдлэг ирт эдлэлийг бэлтгэсэн байх ба түүний шулуун ирмэгийг ирлэн засчээ.

5 дугаар давхарга. Эндээс 612 ш олдвор илрүүлсэн. Олдворуудын анхдагч цуулалтыг зэрэгцээ, призм, цацарган, хавтгай гэх мэт арга барилуудаар гүйцэтгэж байжээ.

Цохилтын хоёр талбайт, цуулалтын хоёр галдаргуут зэрэгцээ цуулалтын зарчимт хавтгай үлдэц. Сегмент маягийн хэлбэртэй бөгөөд хөндлөн огтлол нь хоёр талаасаа гүдгэр юм. Нэг цуулалтын гадаргуу дээр хийгдсэн шулуун цуулалтын дүнд хэд хэдэн залтас цуулсан ормыг хадгалжээ. Түүний эсрэг орших өргөн гадаргуу дээр хоёр дахь цуулалтын гадаргууг бэлтгэсэн байх ба эдлэлийн хажуу талыг цохилтын талбай болгон ашиглаж залтас болон ялтсанцар салган авсан зэрэгцээ ормуудыг хадгалжээ (зураг 3-7).

бэлтгэсэн өнцгөн сийлүүр (зураг 2-4), гурвалжин хэлбэртэй залтасны нэг хажуу ирмэгийг нүүрэн талаас, нөгөө ирмэгийн доод хэсгийг нь хүнхэр ирээр ирлэсэн цавчих зэвсэг (зураг 2-5) юм.

6 дугаар давхаргаас 76 ш олдвор малтан гаргасан бөгөөд анхдагч цуулалтын тодорхойлох үлдэц, бэлдэц тэдгээрийн дунд байхгүй юм. Бүх олдворын дийлэнх олонх буюу 76% нь залтаснаас бүрдэнэ. Залтсууд нь ялтсан, тэгш өнцөгт, тарпец маягийн хэлбэрүүдтэй. Бүх залтасны 73% бүтэн, 27% хагархай хэлтэрхий бөгөөд цохилтын талбайн үлдэгдэл нь байгалийнхаараа, хоёр талтай, гөлгөр хэмээх гурван төрөлд ангилагдана. Ялтас 26 ш байгаагийн хоёроос бусад нь хагархай хэлтэрхий юм (зураг 2-9).

Зэвсгийн төрөл зүйлг 5 ш эдлэл хамаарна. Тэдгээр нь ирлэсэн залтас, ирлэсэн ялтас, леваллуа хэлбэрийн үзүүр мэс, хосолмол зэвсэг болон шүдлэг иртэй зэвсэг юм. Ялтас нь хоёр талтай бөгөөд төгсгөл ирмэгийг нүүрэн талаас нь холтчин ирлэжээ (зураг 2-6). Леваллуа хэлбэрийн



Зураг 3. 5 дугаар үеийн чулуун зэвсгүүд. 1-5-үлдэц; 6-төгсгөл хусуур; 7, 8-хатгуур зэвсэг; 9-ирлэсэн залтас; 10-холтослууур


Төв рүү чиглэсэн цуулалт бүхий үлдэц. Зууван хэлбэртэй, дундаж хэмжээтэй. Түүний бүх ирмэгийг цохилтын талбай болгон ашиглаж жижиг залтас цуулах ажиллагааг гүйцэтгэсэн үл мөр хоёр талын өргөн гадаргууд үлджээ (зураг 3-2).

Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут, призм хэлбэрийн зэрэгцээ цуулалтын зарчимт үлдэц 2 ш. Тэдгээрийг ялтсанцар цуулах зорилгоор бэлтгэжээ. Эдлэлүүдийн суурь хэсэг нарийн бөгөөд цохилтын талбай руугаа ялимгүй налсан цуулалтын гадаргуутай (зураг 3-3, 4).

Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут зэрэгцээ цуулалтын зарчимт хавтгай үлдцийг хайргаар хийжээ. Тэгш өнцөгт маягийн хэлбэртэй үг эдлэлийн ар тал нь гүдгэр бөгөөд ихэнх хэсэгтээ байгалийн өнгөн бүрхүүлээ хадгалсан байна. Цохилтын

талбайг том цуулалтуудаар бий болгосон байх ба цуулалтын гадаргуу нь ялтас болон тэгш өнцөгт маягийн залтас цуулсан үл мөрийг хадгалжээ.

Чулуун зэвсэг цуулалтын үйл ажиллагааны дүнд бий болсон хаягдалд залтас (199 ш), ялтас болон ялтасны хугархай (84 ш), хагархай, хэлтэрхий (49 ш), хайрс (112 ш) хамаарна. Залтсууд хэмжээгээр том, дундаж, жижиг хэмээн ангилагдана. Ялтсууд нь бүтэн (4 ш), дээд хэсгийн хугархай (34 ш), дунд хэсгийн хугархай (24 ш), үзүүр хэсгийн хугархай (22 ш)-наас бүрдэнэ. Бүтэн ялтсууд 60 мм хүртэл урттай бөгөөд бүх ялтас цохилтын талбайн үлдэгдлээрээ байгалийн, цэгэн, хоёр талтай, шүлүүн хэмээн ангилагдана. Мөн энэ давхаргаас 10 ш техникийн цуулдас илэрсэн нь үлдцийн хажуу ирмэгийг засах болон цохилтын талбайг дахин бэлтгэх явцад бий болжээ.



Багаж зэвсгийн төрөлд 24 олдвор хамаарна. 5 нь зэвсгийн хагархай юм.

Гадаргуу нь ялимгүй гүдгэр эдлэлийн хагархай 2012 онд мөн энэ давхаргаас илэрсэн өөр нэг хагархайн нөгөө тал бөгөөд түүнтэй хагарлын эвээрээ яв цав нийлсэн нь сонирхолтой юм (зураг 4). Мөн 13-15 мм өргөн ялтасны үзүүр хэсгийг бага зэргийн өөрчлөлттэй захын жижиг ирээр ирлэсэн ялтас (2 ш), ирлэсэн залтас (5 ш) (зураг 3-9), ирлэлтийн ажиллагааг тодорхойлох боломжгүй эдлэл (3 ш) бий.

Зураг 4. Хугарсан ормоороо нийлсэн эдлэл

Тогтсон хэв шинж бүхий зэвсгүүдэд хусуур (2 ш), хатгуур (6 ш), хүнхэр ирт эдлэл (1 ш), холтослууур (1

ш), харуул орно.

Хусуур. Эхний эдлэлийг зууван хэлбэртэй анхдагч залтсаар хийжээ. Түүний төгсгөлийн хөндлөн ирмэгийг ирлэж зассан байна (зураг 3-б). Хоёр дахь эдлэл нь урагш түрсэн хошуутай хусуурын төрөлд хамаарах бөгөөд залтасны хагархайг бэлдэц болгон ашиглажээ.

Хатгуур. Нэг эдлэлийг хагас анхдагч ялтасны үзүүр хэсгийн хугархай ашиглан бэлтгэжээ. Төгсгөл хөндлөн ирмэгийг жижиг хөндлөн цуулалтуудаар зассан байх ба шулуун болон хөндлөн ирмэгийн уулзах хэсэгт жижиг хатгуур гаргажээ. Гурван эдлэлийг залтас болон ялтсан залтсаар хийжээ. Хатгуур маягийн жижиг хошууг эдлэлийн хөндлөн болон шулуун ирмэгийн уулзах өнцөгт бэлтгэсэн байна (зураг 3-7, 8).

Хүнхэр ирт эдлэлийг хийхдээ залтсыг бэлдэц болгон ашигласан байна. Түүний хажуу ирмэгийн дээд хэсэгт хүнхэр ир гарган ирлэжээ.

Холтослуурыг үлдэц хэлбэрийн хагархай ашиглан бэлтгэсэн, тэгш өнцөгт маягийн хэлбэртэй. Ялимгүй гүдгэр ирэн хэсэг нь шаталсан ирээр бэлтгэгдсэн байна (зураг 3-10).

Харуулыг хийхдээ хайрга чулууг түүхий эдээр сонгожээ. Тэгш өнцөгт маягийн хэлбэртэй уг эдэлийг жижгээр холточсон хагас босоо ирээр ирлэж ялимгүй гүдгэр ирмэг гарган зассан байна.

4 дүгээр давхаргаас нийт 488 ш олдвор илрүүлжээ. Тэдгээр нь анхдагч цуулалтыг илэрхийлэх үлдэц болон хоёрдогч боловсруулалт хийгдсэн зэвсгийн төрөл зүйл, үйлдвэрлэлийн цуулдаснаас бүрдэл болно.



Зураг. 5.4 дүгээр үеийн үлдцүүд



Хавтгай үлдцийн хагархай 12 ш.

Бэлдэц 2 ш илэрсэн нь зууван хэлбэртэй. Цохилтын нэг талбайг, цуулалтын нэг гадаргуут дундаж хэмжээтэй үлдэц хийхээр төлөвлөж зассан байна.

Куба хэлбэрийн үлдэц тэгш өнцөгт маягийн хэлбэртэй агаад хайрга ашиглан бэлтгэжээ. Түүхий эдийн нэг тэгш захыг хөндлөн болон тууш цуулалтаар засч цохилтын талбайг гаргажээ. Энэ эдлэл нь залтас цуулах зориулалтаар бэлтгэгдсэн байна (зураг 5-1).

Төв рүү чиглэсэн цуулалт бүхий үлдцийг хайргаар хийсэн ба зууван хэлбэртэй юм. Түүнийг дунд болон жижгэвтэр залтас цуулах зориулалтаар бэлтгэсэн бөгөөд нэг гадаргуу нь хажуу ирмэгүүдээс төв рүү чиглэлтэй цуулалтууд хийсэн ул мөрийг хадгалжээ.

Цохилтын нэг талбайтай, цуулалтын нэг гадаргуутай хавтгай үлдэц 3 ш илэрснийг жижиг хагархайгаар хийсэн байна. Эдгээр эдлэлүүд тэгш өнцөгт маягийн хэлбэртэй бөгөөд хоёр нь хөндлөн огтлолоороо зууван, нэг нь дөрвөлжиндүү хэлбэртэй. Нэг эдлэлийн өргөн цохилтын талбай ар тал руугаа огцом налсан байхад нөгөө хоёр үлдцийн нарийвтар, ар тал руугаа ялимгүй налуу цохилтын талбайг жижгэвтэр цуулалтуудаар бий болгожээ. Хоёр эдлэлийн цуулалтын гадаргууг хөндлөн цуулалтуудаар нямбайлан бэлтгэсэн бөгөөд зарим хэсэгтээ чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Нэг эдлэлийг том хэмжээтэй залтас цуулах зорилгоор бэлтгэсэн байна. Дараагийнх нь жижиг ялтас болон ялтсан залтас цуулах зориулалтаар засч бэлтгээд сүүлийн шатанд нь хүртэл ашигласан дундаж хэмжээтэй эдлэл ажээ. Сүүлийн эдлэл нь Төлбөрийн голын хөндийгөөс илэрдэг нэг чиглэлд цуулалт хийж ялтас авах зориулалт бүхий хавтгай үлдцийн төрөлд хамаарна (зураг 5-3, 4).

Цохилтын хоёр талбайтай, цуулалтын нэг гадаргуутай хавтгай үлдэц гурвалжин хэлбэртэй бөгөөд хөндлөн огтлол нь чон хэлбэртэй. Цөөн цуулалтаар үндсэн цохилтын талбай бэлтгэгдсэн бөгөөд хоёр дахь цохилтын талбайг бүрэн бэлтгэлгүй орхижээ. Энэ эдлэлийг том хэмжээтэй залтас цуулах зориулалтаар бэлтгэсэн байна (зураг 5-6).

Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут тайрдаг үлдэц. Ялтас цуулах зорилгоор бэлтгэсэн энэхүү эдлэлийг том хэмжээтэй хагархай ашиглан хийжээ. Нэг хажуугийн нарийн тэгш талыг цуулалтын гадаргуу болгон ашигласан байна (зураг 5-7).

Бэлдэц. Баргил ялтасны дээд хэсгийн хугархайг бэлдэц болгон ашиглажээ. Түүнийг тайрдаг үлдэц хийх зорилгоор зассан байх ба цуулдасны нэг хажуу захыг зэрэгцээ хайрслал ирээр ирлэх явцад шаантаг хэлбэрийн хурц ирмэг бэлтгэгдсэн байна. Нөгөө хажууд нь цуулалтын гадаргууг бэлтгэг хэд хэдэн зэрэгцээ цуулалтын ул мөртэй (зураг 5-5).

Үлдсэн сийлүүр 2 ш. Эхнийх нь дөрвөлжин хэлбэртэй. Хажуу тал руугаа ялимгүй налсан хоёр цохилтын талбайг жижгэвтэр цуулалтуудаар засчээ. Бэлдцийн хажуу захаас хэд хэдэн ялтсанцар цуулсан бөгөөд цуулалтын гадаргуутай нийлэх хэсгийг нь хөндлөн цуулалтуудаар засчээ (зураг 6-1). Хоёр дахь эдлэлийг баргил ялтсаар хийсэн ба нэг талын хөндлөн ирмэг нь чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Хажуу талуудад ялтас цуулах ордлогууд хийгдсэн ул мөртэй (зураг 6-2).



Зураг 6. 4 дүгээр үеийн чулуун зэвсгүүд. 1, 2-үлдцэн сийлүүр; 3-6-Ялтсанцар цуулах зориулалт бүхий үлдэц; 7-харуул; 8-хатгуур зэвсэг

хэмжээтэй хагархайг бэлдэц болгон ашиглажээ. Гурвалжиндуу хэлбэртэй энэ эдлэлийн цохилтын талбайг жигэвтэр цувраа цуулалтуудаар боловсруулсан байх ба сүүрийг нь хөндлөн цуулалтаар засч хурцалжээ. Цуулалтын гадаргуу нь ялтас цуулсан зэрэгцээ ормуудыг хадгалсан байна (зураг 6-4).

Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут зэрэгцээ цуулалтын зарчимт торх хэлбэрийн үлдэц. Дундаж хэмжээтэй хагархайгаар хийсэн бөгөөд сүүлийн шатанд нь хүртэл ашиглажээ. Цохилтын талбай нь хэд хэдэн тууш болон хөндлөн цуулалтын дүнд бэлтгэгдсэн байна. Цуулалтын гадаргуу зэрэгцээ цуулалтын үл мөрийг хадгалжээ (зураг 6-5).

Цохилтын хоёр талбайт, цуулалтын нэг гадаргуут цилиндр хэлбэрийн үлдэц. Ялтсанцар цуулах зорилгоор бэлтгэгдсэн агаад ар тал руугаа огцом налсан цохилтын талбайг хөндлөн цуулалтуудаар гаргаад жижиг цуулалтаар нэмэлт засвар хийжээ. Эдлэлийн цуулалтын гадаргууг нэг талд нь бэлтгэсэн байх ба зэрэгцээ цуулалтуудын дүнд ялтас салган авсан үл мөрийг хадгалжээ (зураг 6-6)


Чулуун зэвсэг цуулалтын явцад бий болсон үйлдвэрлэлийн хаягдал энэ давхаргын олдворуудын ихэнх хувийг бүрдүүлэх бөгөөд тэдгээр нь залтас болон залтасны хагархай (313 ш), ялтас (60 ш), ялтсанцар (21 ш) болон хагархай хэлтэрхий (28 ш), хайрс (54 ш) техникийн цуулдас (36 ш) наас бүрдэнэ. Залтсуудын дүнд бүтэн (131 ш), дээд хэсгийн хугархай (32 ш), дунд хэсгийн хугархай (23 ш), үзүүрийн хугархай (60 ш), шулуун болон ташуу хагархай (12 ш) байна. Бүтэн 4 ш ялтас буй нь 60 мм

Цохилтын хоёр талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдцийг жижиг залтас, ялтсанцар цуулах зориулалтаар бэлтгэсэн байна. Зуувандуу хэлбэртэй энэ эдлэлийн тэгш өргөн гадаргуу нь ташуу цуулалтын аргаар цуулалт хийгдсэн үл мөртэй.

Ялтсанцар цуулах зориулалт бүхий цохилтын хоёр талбайт, цуулалтын нэг гадаргуут призм хэлбэрийн үлдэц (2 ш). Гурвалжин болон тэгш өнцөгт маягийн хэлбэртэй эдгээр үлдцүүдийг дундаж хэмжээтэй хагархай ашиглан бэлтгэсэн байна. Үлдцүүдийн цохилтын талбайг нэг хүчтэй цуулалтаар гаргаад дараа нь жижиг цуулалтуудаар нямбай засчээ. Цуулалтун гадаргуу нь цохилтын талбайгаас шулуун цуулалт хийх замаар ялтас, жижиг ялтсан залтас цуулсан үл мөрийг хадгалжээ (зураг 6-3).

Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут призм хэлбэрийн үлдцийг хийхдээ дундаж

хүртэл уртай. Мөн цохилтын талбайн үлдэгдэл бүхий дээд хэсгийн хугархай (23 ш) дунд хэсгийн хугархай (16 ш), үзүүр хэсгийн хугархай (16 ш) болон бусад хэлбэрийн хагархай хэлтэрхий хэмээн ангилдагдана. Цохилтын талбайн үлдэгдэл нь байгалийн, хоёр талт, шулуун байна.



Зураг. 7.4 дүгээр үеэс илэрсэн зэвсгийн төрөл зүйл. 1-хөндлөн иртэй ялтас; 2-үзүүр мэс; 3, 4-трапец хэлбэрийн эдлэл; 5-хянгар

Үзүүр мэсийг олон талтай ялтас ашиглан бэлтгэжээ. Үзүүр рүүгээ аажим налж нийлэх хажуугийн шулуун ирмэгүүдийг босоо зэрэгцээ ирээр ирлэсэн бөгөөд нэг хажууд нь хоёр хүнхэр ир гаргасан байна (зураг 7-2).

Хатгуур (8 ш). Эдгээр эдлэлүүдийг босоо хайрасласан жижиг холточсон ирээр ирлэж бэлтгэсэн бөгөөд бэлдэц чулуунуудын аль нэг талд нь хурц үзүүрүүдийг бэлтгэсэн байна (зураг 6-8).

Ялтасны үзүүр хэсгийн жижиг хагархай ашиглан хийсэн *баруултай ялтас* (1 ш). Түүнийг ар болон нүүрэн талаас нь хөндлөн чиглэлтэй хийсэн жижиг цуулалтуудаар боловсруулжээ. Мөн нэг талын шулуун ирмэг нь ирлэгдсэн байна. *Нүүрэн талаас нь хөндлөн хагачиж зассан эдлэл* (1 ш). Залтсаар хийсэн байх ба хөндлөн ирмэгийг нь нүүрэн талаас нь шаталсан ирээр боловсруулжээ. *Үзүүр хэсгийг нь хагачиж зассан зэвсэг*. Ялтасны үзүүр хэсгийн хугархайг бэлдэц болгон ашиглажээ. Түүний богино хөндлөн ирмэгийг түүш болон хөндлөн чиглэлд хийгдсэн жижгэвтэр цуулалтуудаар

Хоёрдогч боловсруулалт хийсэн *зэвсгийн төрөл*г хамаарах 26 ш эдлэл 4 дүгээр давхаргаас илрүүлжээ.

Харуул 3 ш. Уртавтар үлдэц, залтас болон хайрга чулууг бэлдэц болгон ашигласан байна. Дундаж хэмжээтэй хоёр эдлэлийн төгсгөлийн шулуун ирмэгт ирэн хэсгийг гаргажээ. Залтсаар хийсэн гурав дахь эдлэл нь бусдаасаа харьцангуй том хэмжээтэй. Түүнийг хэд хэдэн шатлалтайгаар нямбайлан зассан нь мэдэгдэнэ (зураг 6-7).

Хүнхэр ирт зэвсэг (2 ш). Эхний эдлэлийг хажуу талууд нь төгсгөл рүүгээ налж нийлэх уртавтар залтсаар хийжээ. Түүний хажуу ирмэгүүд захын жижиг ирээр ирлэгдсэн бөгөөд нэг түүш талд нь хоорондоо зайтай хэд хэдэн хүнхэр ирмэг бэлтгэжээ. Хоёр дахь эдлэлийг ялтас ашиглан хийсэн ба нэг шулуун ирмэгт нь нүүрэн талаас хийгдсэн цувраа цуулалтуудын дунд хүнхэр ир бэлтгэгдсэн байна.

Хянгар. Приметрийн 2/4 ирмэгийг нь ирлэсэн өндөр хэлбэрийн хянгар юм. Үзүүр рүүгээ нийлэх хажуу ирмэгүүдийг том болон жижиг холточсон ирээр ирлэж зассан байна (зураг 7-5).

боловсруулсан байна. *Ирлэсэн залтас* (5 ш). Ирлэсэн ялтас. Зэвсгийн төрөл зүйлд микролитын хэв шинжид хамаарах гурван эдлэл байх бөгөөд хоёр нь трапец хэлбэртэй (зураг 7-3, 4). Гурав дахь эдлэл хөндлөн богино ирмэгийг ар талаас нь ирлэсэн байна (зураг 7-1).

Харганын гол-5 суурингийн хамгийн доод үе 6, 7 дугаар давхарга нь он цагийн хувьд харьцангуй эрт үед холбогдох ажээ. Энэ давхаргаас гарсан сийлүүр, хатгуур зэвсэг, хянгар нь левалмуан арга барилд суурилсан хуучин чулуун зэвсгийн дээд шатны хэв шинжийг илэрхийлэх бөгөөд хуучин чулуун зэвсгийн дундаас дээд үед шилжих шилжилтийн үед хамруулан үзэх боломжтой юм. Олдворуудын цуулалтын арга төдийгүй он цагийн хувьд ч үндсэндээ хуучин чулуун зэвсгийн дээд үед хамаарах ба энэ үеийн чулуун зэвсэг цуулалтын хөгжлийг илэрхийлж байна. Дунд болон дээд палеолитын шилжилтийн үеийн чулуун зэвсэг цуулалтын аргыг илэрхийлэх эдлэлүүд Орхон-1 дурсгалт газрын 1, 2 дугаар малтлагын 3 дугаар үеэс илэрсэн бөгөөд бидний малтлага судалгаа хийсэн Харганын голын хөндийгөөс үйлдвэрлэлийн арга барилын хувьд адил олдворууд гарсан нь хөрш зэргэлдээ орших Их Төлбөрийн голын хөндийн дурсгалуудаас уг дурсгал нилээд ялгаатайг харуулсан төдийгүй цаашид Орхон голын хөндийн дурсгалуудтай харьцуулан судлахад сонирхолтой үр дүнд хүрэх боломжтой юм.

5 дугаар давхаргын анхдагч цуулалтын хэсэг нь нэг болон олон чиглэлд хийгдсэн зэрэгцээ цуулалтын зарчимт бичил үлдцээр, 4 дүгээр давхаргынх ялтсанцар цуулах зориулалтаар бэлтгэгдсэн янз бүрийн хэлбэр бүхий бичил үлдцээр илэрхийлэгдэнэ. Мөн үлдцэн сийлүүр, үзүүр мэс, төгсгөл хэсгийг нь хагачиж зассан зэвсгүүдийн хэв шинж, цуулалтын арга барилд үндэслэвэл хуучин чулуун зэвсгийн дээд үеийн эхэнд холбогдох нь тодорхой байна.

Өнөөгийн Монгол орны нутаг дэвсгэр Төв, Умар болон Зүүн Азийг нэгтгэсэн эртний хүний зам дайран өнгөрч буй хэсэгт байрлах тул хатгуур хэлбэрийн зэвсэг, харуул, сийлүүр зэрэг хуучин чулуун зэвсгийн дээд үеийн гол илэрхийлэл болсон олон төрөл зүйлийн эдлэлүүд илэрч байна.

ХҮДЭР ГОЛЫН САВ НУТАГТ ХИЙСЭН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУДАЛГАА

Б.Гүнчинсүрэн, Д.Одсүрэн, Ц.Болорбат,
М.Изүхо, Я.Бувит, Т.Үэки

Монгол орны умард захын байгалийн үзэсгэлэн цогцолсон, үржил шимт нутаг бол Хүдэр голын сав газар билээ. Энд Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн Японы Метрополитаны Их Сургуультай хамтран „Монголын палеолитын судалгаа” эрдэм шинжилгээний төслийг 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Хамтарсан төслийн судлаачид өмнөх жилд Хүдэр голын баруун эрэг Баян Цагаан уулын орчимд бага хэмжээний маллагын ажлыг зохион байгуулахын зэрэгцээ Уялга, Хүдэрийн адаг урсгалаар чулуун зэвсгийн хайгуул судалгаа хийсэн юм¹.

2014 оны хээрийн шинжилгээг 09 дүгээр сарын 11-нээс 09 дүгээр сарын 17-ныг хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн ба цөөн хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Хээрийн судалгааны ажлыг хайгуул, сорьц маллага гэсэн хоёр чиглэлээр хийв.

Сорьц маллага

Сорьц маллагыг өмнөх жилд бага хэмжээний маллага хийсэн Хүдэр голын баруун эрэг, Баян Цагаан ууланд хийсэн бөгөөд хуучин чулуун зэвсгийн соёл давхарга байгаа эсэхийг лавшруулан тодорхойлох зорилт тавьсан болно.


Сорьц маллага 1. Өмнөх жилийн маллагын талбайгаас хойд зүгт, голын эргийн дэнжийн тэгш дэвсэг дээр 1 x 1 м хэмжээтэй талбай сонгон маллагыг эхлүүлэв. Ургамлын үндэс агуулсан ширгэн хөрс нь 22-27 см зузаан юм. Газрын өнгөнөөс 17 см хүртэлх гүнээс дундаж болон жижиг хэмжээтэй ялтас, гурван талтай бичил ялтасны цохилтын талбайн үлдэгдэл бүхий дундаас дээш хэсгийн хугархай, жижиг хайрс болон хэлтэрхий (4 ш) тус тус илрэв. 17-22 см хүртэлх гүнээс ялтас (14 ш), залтас (10 ш), хагархай хэлтэрхий болон жижиг хайрс (19 ш) илэрчээ. Ялтсууд тэгш бус хэмтэй бүтэн (1 ш), цохилтын товгороо хадгалсан ялтасны дээд хэсгийн хугархай (10 ш), дунд хэсгийн хугархай (3 ш) хэмээн ангилагдана. Эдгээрийн ихэнх бичил ялтасны төрөлд хамаарах бөгөөд үлдцээс шахалтын арга хэрэглэн бэлтгэсэн байна. Мөн хээтэй болон хээгүй шавар ваарны жижиг хэлтэрхий (2 ш) олдсон байна.

Сорьц маллага 2. Өмнөх сорьц маллагыг хойш нь 1 x 1 м хэмжээтэй өргөтгөн малтахдаа сорьц маллага 2 хэмээн тэмдэглэсэн. Газрын өнгөнөөс доош 17 см хүртэлх гүнээс улбар шаргал өнгийн гадаргуутай, нарийн ширхэгтэй шавраар хийсэн ваарны хагархай (3 ш), жижиг залтас (2 ш), ялтасны үзүүр болон дунд хэсгийн хугархай тус бүр нэг, хагархай хэлтэрхий (8 ш) илрүүлэв. Маллагыг цааш нь 17-23 см гүнд хүртэл үргэлжлүүлэхэд нарийн ширхэгтэй шавраар хийсэн сайн шатаалтай ваарны нимгэн хагархай (4 ш), цуулалтын гадаргууг нь бүх приметрийн дагуу бэлтгэж бичил ялтас цуулах ажиллагааг тал бүрээс нь хийсэн харандаа хэлбэрийн үлдцийн дээд хэсгийн хугархай, ялтас (9 ш), ялтсанцар (2 ш), залтас (10 ш), хагархай хэлтэрхий болон хайрс (17 ш) тус тус илэрчээ. Энэ үеэс илэрсэн нэгэн сонирхолтой олдвор бол нэг нуруутай бичил ялтсаар хийсэн жижиг эдлэл юм. Түүнийг ялтасны дунд хэсгийн хугархай ашиглан хийсэн бөгөөд нэг хөндлөн ирмэгийг нүүрэн талаас нь дотогш нь холтчиж хүнхэр суурь хэсгийг бэлтгэжээ. Үзүүр рүүгээ ялимгүй налсан

¹ Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар, М.Изүхо, Г.Лхүндэв, Я.Бувит, Д.Одсүрэн, Л.Ишцэрэн. “Монголын палеолитын судалгаа” төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт хийсэн чулуун зэвсгийн судалгааны үр дүнгээс. Монголын археологи-2013. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2013 оны хээрийн судалгааны үр дүн. УБ, 2014. т.11-15

хажуугийн хоёр шулуун ирмэгийг босоо холточсон шүдлэг ирээр ирлэж засчээ. Энэ эдлэлийн үүрэг зориулалт төдий л тодорхойгүй агаад анх харахад хүнхэр суурьтай ялтсан зэвтэй ихэд адил сэтгэгдэл төрүүлнэ. Одоогоор бидэнд харьцуулах материал байхгүй бөгөөд түүний суурийг дотогш хүнхийлгэн зассан байдлаас үзэхэд иш модонд суулгах зориулалттай нь тодорхой юм. Бид энэ эдлэлийг ахуйн хэрэгцээний багаж хэмээн үзэж буй бөгөөд цоолтуурын үүргээр нүхлэх, цоолох үйлд хэрэглэж байсан бололтой. Маллагыг цааш үргэлжлүүлэхэд 33 см хүртэлх гүнээс бичил ялтас (4 ш), хагархай хэлтэрхий болон хайрс (6 ш) олдсон байна. Ширгэн хөрсний доороос шаргал өнгийн элсэрхэг давхарга гарах ба ямар нэг чулуун зэвсгийн олдвор хэрэглэгдэхүүн илрээгүй тул маллагыг зогсоов.

Сорьц малтлага 3, 4. Баян Цагаан уулын арагш намссан шил дээр 1 x 2 м хэмжээтэй талбай сонгон малтлага хийсэн. Ургамлын үндэстэй ширгэн хөрснөөс бичил ялтас 1 ш, цөөн тооны хагархай хэлтэрхий, шавар ваарны хагархай (8 ш) илрүүлсэн.



Зураг-1. Баян Цагаан уулын ялтсан зэвсэг, бичил ялтасны хугархай

Баян Цагаан ууланд хийсэн сорьц малтлагаас илэрсэн олдворуудыг цайвар, ногоон, шаргал өнгийн цахиурын төрлийн чулуугаар хийсэн байх ба энэ орчимд ийм төрлийн түүхий эд байхгүй тул эртний хүмүүс өөр газраас зөөвөрлөн авчирч багаж зэвсгээ үйлдэж байсан бололтой. Малтлагаас гарсан ялтсуудыг бичил ялтас цуулахаар засч бэлтгэсэн үлдцээс шахалтын арга хэрэглэн цуулан авсан нь тодорхой бөгөөд тухайн дурсгалт газарт

хийсэн өмнөх жилийн малтлагаас бичил ялтас цуулах зориулалтаар засч бэлтгэсэн хэд хэдэн үлдэц илэрснийг тэмдэглэх хэрэгтэй юм. Мөн бичил ялтас цуулсан ул мөрийг хадгалсан зэрэгцээ цуулалтын зарчимт харандаа хэлбэрийн үлдцийн хагархай нь Монгол орон болон хөрш зэргэлдээх Байгал нуурын бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн хөгжингүй шатны дурсгалуудтай адилсаж байгаа юм. Хоёрдогч боловсруулалт хийгдсэн багаж зэвсгийн төрлийн олдворууд тун цөөн байх ба бидний сонирхлыг ихэд татаж буй эдлэл бол дээр дурдсан ялтсаар хийсэн хүнхэр суурь бүхий зэвсэг билээ. Хэдийгээр үүнтэй яг адилсах эдлэл бидэнд буй материалд үгүй ч шинэ чулуун зэвсгийн хөгжингүй шатанд хамаарах боломжтой хэмээн үзэж байна.

Баян Цагаан уулын дурсгал нь хөрсний өнгөн хэсэг буюу ширгэн давхаргадаа олдворуудыг агуулсан шинэ чулуун зэвсгийн хөгжингүй шатанд холбогдох ил суурин юм.




Зураг-2. Рашааны амны адаг дахь чулуун зэвсгийн олдвор илэрсэн газар

Хайгуул судалгаа. Энэ оны хайгуул судалгааг Хүдэр голын хоёр эрэг даган гүйцэтгэсэн. Хайгуулын үр дүнд сумын төвөөс баруун хойд зүгт, үргэлжилсэн уулсын зүүн тийш харсан амны адагт, уулын хормойн налуу дагуулсан тариан талбайгаас цөөн тооны олдвор илрүүлсэн юм. Олдвор олдсон энэ газрыг нутгийн олон Рашааны ам хэмээн нэрлэх ажээ.

Хайгуулын явцад олдвор илрүүлсэн энэ хэсэгт нарийвчилсан хайгуул хийхэд цуулалтын үл мөр бүхий том хэмжээтэй хайрга, дундаж хэмжээтэй залтас (6 ш), анхдагч залтсаар хийсэн шаталсан ир бүхий хянгар болон хэд хэдэн хагархай хэлтэрхий илрүүлжээ.

Бид олдвор илэрсэн цэгт болон түүнээс зүүн, баруун, хойд, урагш чиглэлд хоорондоо 5 м зайтай 50 x 30 см хэмжээтэй талбайгаар 50 см гүнд хүртэл хүрзэн шалгалт хийхэд ямар нэг олдвор хэрэглэгдэхүүн илэрсэнгүй.

Тиймээс хөрсөн дээрээ цөөн тооны олдвор тархсан ил суурин хэмээн үзсэн бөгөөд эдгээр олдворуудын дунд цуулалтын аргыг тодорхойлох анхдагч цуулалтын ангиллын эдлэл, хоёрдогч боовсруулалт хийгдсэн багаж зэвсгийн зүйл бараг байхгүй тул он цагийн асуудлыг нарийн тодорхойлох боломжгүй юм. Гэвч олдворуудын ерөнхий хэв шинжид үндэслэн хуучин чулуун зэвсгийн дээд шатанд холбогдох боломжтой хэмээн таамаглаж байна.



Зураг-3. Рашааны амын чулуун эдлэлүүд: Цуулалт бүхий хагархай-1, хянгар-2, залтас-3-5

ИХ НАРТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛЫГ
БҮРТГЭН СУДЛАХ МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН ЭКСПЕДИЦИЙН 2014 ОНЫ
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮНГЭЭС

Я.Цэрэндагва, С.Далантай, Ж.Шнейгер,

Өмнөтгөл

Их Нартын байгалийн нөөц газар нь 1996 онд байгуулагдсан бөгөөд Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг сумдын нутгийн 43 000 га газрыг хамран байрладаг. Цөлөрхөг хээрийн дунд тогтсон сүрлэг хадан тогтоцоороо Их Нарт нь байгалийн өвөрмөц сонин содон шинжийг бүрдүүлсэн бөгөөд аргаль, янгир зэрэг ховор ан амьтад идээшин дассан нутаг юм.



Гэрэл зураг 1. Их Нартын Байгалийн Нөөц газар

Их нартын хадны археологийн дурсгалуудыг урьд өмнө тусгайлан, өргөн хүрээтэйгээр судалж байсангүй боловч хэд хэдэн удаа судалгааны ажил хийгдсэн байна.

1973 онд Их Нартын хадны урд талын өргөн хөндийд орших Цахиурт хэмээх газраас Д.Дорж палеолитын үед холбогдох хүрмэн чулуугаар хийсэн 11 залтас, 1 ялтас олж байв. Тэдгээр чулуун зэвсгүүдийн хийсэн арга барилд түшиглэн доод палеолитын үед холбогдуулан авч үзсэн байдаг.

2005 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Р.Мөнхтулга, С.Хүрэлсүх нар Их Нартын хадны баруун үзүүрийн хадан хясаанд байх нэгэн агуйгаас хадны оршуулга илэрсэн гэдэг мэдээллийн дагуу газар дээр нь очиж судалгаа хийж XII-XIV-р зууны үед холбогдох монгол эмэгтэйд хатмал шарил байгааг тогтоожээ. Уг хадны оршуулгаас илэрсэн эмэгтэйд даавуун тэрлэг, сайтар элдэж боловсруулсан илгэн дээл, арьсан гутал, торгон өмд сэлтийг өмсүүлэн, торгон тэрлэг дэрлүүлэн модон авсанд хийн нутаглуулсан байсан ба дагалдуулан богтог малгай, төмөр хутга, модон сам, модон аяга, хүрэл толь, сувдан ээмэг, чулуун зүүлт, сийлбэртэй модон эдлэл, өнгийн даавууны өөдөс зэргийг тавьсан байжээ. Дээрх судлаачид зам гудааст мөн 2-3 эртний бүлш бүхий газрыг үзэж танилцсанаа тайландаа дурдсан байдаг.

Их Нартын байгалийн нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэх, баримтжуулан судлах, хадгалж хамгаалах зорилготой археологийн хээрийн шинжилгээний ангийг ШУА-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, академич Т.Галбаатар, Денверийн

Зоологийн сангийн хамгаалын биологийн асуудал хариуцсан захирал Р.Рыдинг нарын хүчин чармайлт, дэмжлэгийн дүнд Монгол улсын ШУА, АНУ-ын Денверийн Зоологийн сан, Earthwatch хүрээлэнтэй хамтран 2010 оноос зохион байгуулж эхэлсэн юм.

Судалгаа эхэлснээс хойш 2010 онд 33 дурсгалт газар, 2011 онд 17 дурсгалт газар, 2012 онд 18 дурсгалт газар илрүүлэн олж бүртгэн баримтжуулсан билээ. Илэрч олдсон дурсгалууд нь Монголын археологийн судалгаанд тодорхой үр дүнгээ өгөхүйц эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм. Тус хээрийн шинжилгээний ангийг Монголын талаас ШУА-ийн Археологийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор, дэд профессор Я.Цэрэндагва, АНУ-ын талаас Калифорнийн үндэсний паркийн археологич, доктор Ж.Шнайдер нар удирдан ажиллаж байна.

Судалгаа эхэлснээс хойш 2010 онд 33 дурсгалт газар, 2011 онд 17 дурсгалт газар, 2012 онд 18 дурсгалт газар, 2013 онд 10 чулуун зэвсгийн суурин, 14 дөрвөлжин булш, 3 шоргоолжин булш, 1 хиргсиүүр, 29 хүннүгийн булш, 13 монгол булш, 3 хадны оршуулга, 1 зэл чулуут, том дөрвөлжин хэлбэрийн булш бүхий цогцолбор дурсгал, 8 чулуун байгууламж, 3 чулуун зэвсгийн түүхий эд олзворлодог байсан чулууны орд илрүүлэн олж бүртгэн баримтжуулмаа. Илэрч олдсон дурсгалууд нь Монголын археологийн судалгаанд тодорхой үр дүнгээ өгөхүйц эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм.

Судалгаа шинжилгээ

Хайгуулын хугацаа, бүрэлдэхүүн.

2014 оны хээрийн судалгааны ажил 6-р сарын 24-нөөс 07-р сарын 04-ний хооронд 10 хоногийн хугацаагаар ажилласан. Судалгааны багт Монголын талаас доктор, дэд профессор Я.Цэрэндагва, эрдэм шинжилгээний ажилтан С.Далантай, МУИС-ийн археологийн ангийн оюутан Г.Олзбаяр, Их нартын байгалийн нөөц газрын археологийн дурсгал хариуцсан байгаль хамгаалагч Д.Чойбалсан, АНУ-ын талаас Калифорнийн Их сургуулийн доктор Ж.Шнейдер (J.Schneider), судлаач доктрант Ж.Фаркухар (J.Farquhar), П.Хадел (P.Hadel) нар оролцон ажиллав.

Хайгуулын арга зүй.

Хайгуул судалгааны ажилд урьд өмнөх жилүүдэд хэрэглэж байсан шугаман хайгуулын аргыг хэрэглэн, урьдчилан газрын зурагт сонгон тэмдэглэсэн 2 х 2,5 км-ийн хэмжээтэй өргүүдээс 500 х 500 м шоо дөрвөлжин талбайнуудад явганаар нарийвчилсан шугаман хайгуул хийж гүйцэтгэв. Хайгуулыг тус бүр 6 хүний бүрэлдэхүүнтэй хоёр баг болгон хүн тус бүр хоорондоо 15 м-ийн зайтай алхах маягаар уртрагийн дагуу гүйцэтгэсэн бөгөөд эд өлгийн зүйлс олдсон тохиолдолд нарийвчилсан шалгалтыг тухайн газрын орчимд явуулж илэрсэн олдворын хажууд туг хатган бүртгэж байв. Энэхүү аргаар 6 хэсэг газарт хайгуул хийж олон тооны түүвэр олдворыг илрүүлэн, сонголтын зарчмаар зарим олдворыг түүвэрлэсэн юм.



Гэрэл зураг 2. Малтлага болон хайгуул судалгааны явц

Мөн энгийн самналт, автомашинаар тойрон хайх аргыг хэрэглэв. Илэрч олдсон булш, чулуун байгууламжуудын хэмжилтийг археологийн бүртгэлийн стандартын дагуу хийж гүйцэтгэв.

Илэрч олдсон дурсгалууд. Хайгуул судалгааны дүнд 3 чулуун зэвсгийн суурин, 3 хүннүгийн булш, олж илрүүлэн баримтжуулаа. Шугаман хайгуулыг нийт 6 талбайд хийснээс гуравт чулуун зэвсгийн дурсгалт газар, нэг газар 3 ш хүннү булш илэрч олов. Нэг хайгуулын талбайн 2 газарт археологийн дурсгал илэрсэнгүй. Энэ нь тухайн газрын байгаль, газар зүйн онцлогтой холбоотой байв. Их Нартын Байгалийн Нөөц газарт неолитын үеийн чулуун зэвсгийн дурсгал газрын хөрсөн дээр маш арвин тархсан байдаг онцлогтой. Тус газарт олон тооны чулуун зэвсгийн дурсгал, төмөр эдлэлийн хэсгүүд илэрч олдож байна.

Хайгуулын явцад 107 чулуун зэвсгийн зүйл, 1 самбар чулууны хагархай, 1 нүдүүр чулуу, 1 чулуун хүндрүүлэгч, 1 төмөр эдлэлийн хэсэг, 1 хүрэл зэв зэргийг тус тус түүвэрлэн цуглуулав.

Малтлага судалгаа. Хайгуулын ажлын зэрэгцээгээр 1 ширхэг хүннү булш малтан судалсан болно. Их нартын хаданд Улаанхад, Бургастай, Хуурай, Шинэ усны ам хэмээн 4 хөндий байдаг. Эдгээрээс Шинэ усны хөндийд Монгол-Америкийн хамтарсан экспедици 2013 оны хайгуул судалгааны явцдаа 29 булштай Хүннүгийн үед холбогдох жижиг оршуулгын газрыг олж илрүүлэн бүртгэн баримтжуулсан. 2014 онд хамтарсан экспедицийн бүрэлдэхүүн хэсэг тус газарт орших бүлэг оршуулгын он цагийн асуудлыг нарийвлан тогтоох зорилгоор нэг ширхэг оршуулгыг малтан судалсан юм.

Булшны ерөнхий байдал. Голын хуурай сайрын хойд хөвөөнд орших өндөр боржин хаднуудын баруун талын дэнжид булшнууд байрлана. Урд болон баруун талаараа хэсэг хайлаас мод ургасан. Эдгээр булшны төв хэсэгт байх бусдыгаа бодвол жижигэвтэр булшийг малтан судлахаар сонгосон юм. Зууван дугуй хэлбэртэй, намхан дараас чулуу мэдэгдэнэ. Гол хэсэгтээ дараас чулуугүй, тоногдсон бололтой хонхор юм. Дараас чулуунууд элсэнд дарагдан зах ирмэгүүд нь мэдэгдэхгүй болсон байна. 740 см хэмжээтэй.

Булшны дотоод зохион байгуулалт. Тус булш нь тоногдож сүйтгэгдсний улмаас оршуулгын зан үйл төдийлөн сайн мэдэгдэхгүй болсон хэдий ч дотоод зохион байгуулалт нь тодорхой байна.

Булшны нүх. Булшны толбо анх мэдэгдэхдээ хойд зүгт чиглэлтэй зууван дугуй хэлбэртэй чулуун хүрээ төдий байсан. 245 х 180 см хэмжээтэй. Бид үргэлжлүүлэн малтахад 20-30 см тутамд чигжээс чулуугаар дарж байсан бололтой чулуунууд гарч байсан. Малтлагын ажил доошлох тусам булшны нүхний хэлбэр өөрчлөгдөж толгойн хэсгээрээ өргөн, хөл хэсгээрээ хавчиг юм. 300 см гүнд хүрэхэд оршуулгын нүхний хэлбэр тодорхой мэдэгдэх болсон. Талийгаачийг хойд зүгт хандуулан банзан авсанд хийж оршуулсан нь мэдэгдэнэ. Оршуулгын нүхний доод хэсэг буюу хөл хэсгийн хөрс зөөлөн элсэрхэг учир том том хавтгай чулуугаар хашиж нуралтаас хамгаалсан байна. Оршуулгын нүхний дээд хэсэгт 75 см урт, 28 см өндөр тахилын хөмөг үйлдсэн ажээ.



Товч дүгнэлт

Их нартын тусгай хамгаалалтай бүс нутагт 2014 оны хээрийн судалгааны ажил 6-р сарын 24-нөөс 07-р сарын 04-ний хооронд 10 хоногийн хугацаанд ажиллаа. Судалгааны багийн хамт олон Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, судлах, хамгаалах зорилготой Монгол-Америкийн хамтарсан экспедици энэ жил өмнөө тавьсан зорилтоо биелүүлж, амжилт арвинтай ажилсан хэмээн үзэж байна.

Их Нартын Байгалийн Нөөц газрын нутаг дэвсгэр нь тогтоц, байгаль экологийн хувьд өвөрмөц төдийгүй эртний хүний үлдээсэн үе үеийн археологийн дурсгалаар баялаг болох нь сүүлийн 5 жил явуулсан судалгаагаар батлагдаад байна.

2014 оны хайгуул судалгааны ажлын үр дүнг дараах байдлаар товч дүгнэж байна. Үүнд:

- Бид тусгай хамгаалалтай бүс нутгийн археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах үүднээс зургаан газрыг сонгон авч нарийвчилсан хайгуулын ажил хийлээ. Эдгээр газруудын гуравт нь археологийн дурсгал байгааг илрүүлэн баримтжуулалт хийсэн болно.
- Дурсгал илэрсэн 3 газрын хоёрт нь чулуун зэвсгийн суурин илэрсэн юм. Энэ нь Их Нартын хад эрт үеэс эдүгээг хүртэл хүн амьдран суурьшсаар ирсэн өлгий нутгуудын нэг гэдгийг нотлон харуулж байна.
- Мөн неолитын үед тухайн нутагт амьдралын идэвхитэй үйл ажиллагаа явагдаж байсныг дахин шинээр илэрч олдсон чулуун зэвсгийн дурсгалууд нотлон харуулмаа.
- Нөөц газрын бүс нутгаас урьд өмнө илрээгүй археологийн дурсгалуудыг шинээр илрүүлэн олов. Үүнд палеолитын үеийн чулуун зэвсгийн томоохон суурин 1 газар илэрч олдсон нь энэ үеийн соёлын асуудлыг урагшлуулах бололцоог олгов. Мөн 3 ш хүннүгийн үеийн булш олж илрүүлэн бүртгэн баримтжуулмаа.
- Тус бүс нутгийн хүй нэгдлийн үеийн хүмүүс дан ганц гөрөөлөх аж ахуй эрхэлдэггүй ба газар тариалангийн аж ахуйг тодорхой хэмжээгээр давхар эрхэлдэг байсныг дахин нотлох самбар болон нүдүүр чулууны хагархайг олж илрүүлээ.
- Денверийн зоологийн сангийн дэмжлэгээр тусгай хамгаалалтай бүс нутагт байрлах археологийн дурсгалыг хамгаалах байгал хамгаалагчийг нутаг усаа сайн мэдэх, нутгийн малчин залуугаар тавьлаа. Байгал хамгаалагч бидэнд сар бүр бүс нутгийн археологийн дурсгалын бүрэн бүтэн байдлын талаар тайланг ирүүлж байна.

Талархал

Их Нартын Байгалийн нөөц газар дахь археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, судлах, хадгалан хамгаалах ажлыг санасчилсан ШУА-ийн дэд ерөнхийлөгч Т.Галбаатар, АНУ-ын Денверийн Зоологийн сангийн дэд ерөнхийлөгч Р.Рыдинг (R.Reading), 2013 оны археологийн экспедицийг зохион байгуулах ажлыг гардан гүйцэтгэсэн АНУ-ын Денверийн Зоологийн сангийн Монголын хөтөлбөрийн захирал В.Ганчимэг, Монголын ховор амьтныг хамгаалах эвслийн гүйцэтгэх захирал Т.Сэлэнгэ нарт гүн талархал илэрхийлж байна. Археологийн багийн бүрэлдэхүүнд оролцон ажилласан С.Далантай, П.Хадел (P.Hadel), Ж.Фаркухар (J.Farquhar) нарын археологичид, жолооч Ш.Энхтайван, Монголын үзэсгэлэнт байгалийг бахдан биширч,

археологийн дурсгалын бүртгэлийн ажилд чин сэтгэлээсээ оролцон тусалсан Их нартын байгалийн нөөц газрын залуу эрдэм шинжилгээний ажилчин нартаа талархлаа илэрхийлэхэд таатай байна. Хамтарсан хээрийн судалгааны ажлыг санхүүжүүлсэн Денверийн Зоологийн сан, Earthwatch хүрээлэнгийн хамт олон, ая тухтай ажиллах нөхцөлөөр хангаж байдаг Их Нартын Байгалийн Нөөц газрын эрдэм шинжилгээ судалгааны төвийн хамт олонд ажлын амжилт хүсэн ерөөе.



Дурсгалт газрын бүртгэл хийж байгаа явцаас



Чулуун зэвсэг олдож байгаа явцаас



Палеолитын олдвор



Неолитын нүдүүр чулууны хугархай



Хүннү булш



Гилбэр зэвсэг



Булины малтлага судалгаа



Хүннүгийн үеийн булинаас олдсон зоос



Хүннүгийн үеийн булинаас олдсон сувс



*Хүннүгийн үеийн булинаас олдсон авсны
төмөр чимэглэлүүд.*

2014 ОНД ХОТОН НУУРЫН ДАЛАНТҮРҮҮНИЙ ХОС ТОЛГОЙД ХИЙСЭН ХАДНЫ ЗУРГИЙН СУДАЛГАА

Я.Цэрэндагва, Р.Кортум, Б.Жаргалсайхан

Удиртгал

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт Хотон нуурын хойд хөвөөнд орших Далантүрүүний хос толгой, Арцат уулын хадны зургийн судалгааны ажил 2004 оноос эхэлсэн түүхтэй.

Далантүрүүний хос толгойн хадны зургийг 2004 онд Р.Кортум, МУИС-ийн Археологи, антропологи тэнхимийн багш З.Батсайхан, Баян-Өлгий аймаг дахь Нийгэм-эдийн засгийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан Х.Эдилхан нар анхлан судалж, хадны зургийн нийт дүрслэлүүдийн тоог урьдчилсан байдлаар гаргаж, зарим нэгэн зургийг хуулга хийн буулган авсан байна (1).

2005 онд Р.Кортум, Я.Цэрэндагва нараар удирдуулсан Монгол-Америкийн хамтарсан „Баян-Өлгийн экспедици 2“-ын судлаачид Далантүрүүний хос толгойн хадны зургийг дахин нарийвчлан бүртгэж, Арцат уулын хадны зургийн судалгааг эхэлж, зарим зургийн хуулбарыг хийж гүйцэтгэсэн байна (2).



Зураг 1. Далантүрүүний хос толгой (зүүн хойд талаас)

2007 онд Р.Кортум, Я.Цэрэндагва нараар удирдуулсан Монгол-Америкийн хамтарсан „Баян-Өлгийн экспедици 3“-ын судлаачид газарзүйн нарийвчилсан байршил тогтоох аппаратын тусламжтайгаар Далантүрүүний хос толгойн хоёр дахь уулын хадны зургийн дурсгал нэг бүрийн байршил зүйг тогтоон, геологийн тогтоцын судалгааг эхлүүлжээ (3; 4).

2010 онд Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва болон Баян-Өлгий аймаг дахь ШУА-ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны төвийн судлаачдын бүрэлдэхүүнтэй тусгай шинжилгээний анги Далантүрүүний хос толгойн хадны зургийн дурсгалт газарт судалгаа хийж, хуулбар хийсэн байна (5).

2011 онд Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедиц хадны зургийн бүртгэлийн ажлыг үргэлжлүүлэн хийсний зэрэгцээ хадны зураг бүхий газрын эргэн тойрон дахь археологийн бусад төрлийн дурсгалыг судлан хэд хэдэн булшийг малтан шинжилжээ (6).

2014 оны судалгааны ажил

Судалгааг 2014 оны 7-р сарын 8-23-ны хооронд 14 хоногийн хугацаагаар хийж гүйцэтгэв. Хамтарсан экспедицийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Я.Цэрэндагва, ШУА-ийн Нийгэм эдийн засгийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Жаргалсайхан, АНУ-ын Зүүн Теннессийн их сургуулийн (East Tennessee University) философи, хүмүүнлэгийн салбарын багш, доктор профессор Р.Кортум, тус сургуулийн судлаач В.Тайлор, тогооч Ирина нар оролцон ажиллав.

Өмнөх жилүүдэд Далантүрүүний хос толгойн эхний уулын урд энгэр болон оройн хэсэг, хоёр дахь уул бүхэлдээ, Арцат уул, Хүйтэн голын цутгалын хадны зургийн дурсгалыг бүртгэн баримтжуулж дууссан байсан бөгөөд энэ жилийн судалгааны ажлаар Хотон нуурын зүүн хойд биеийн уулсын хаднаа дүрслэгдсэн хадны зургийн судалгааг бүрэн дуусгах зорилт тавин ажигласан юм.

2014 оны судалгааны ажил Далантүрүүний хос толгойн эхний уулын зүүн хэсэгт төвлөрөн явагдсан. Эндхийн хадны зураг нэг бүрийг өндөр чадалтай байршил (GPS) тогтоогчоор байрлалыг тогтоон, хад бүрт дүрслэгдсэн дүрслэл бүрийг тоолон бүртгэх ажлыг амжилттай гүйцэтгэв. Бүртгэл хийхдээ тусгайлан бэлтгэсэн бүртгэлийн хуудас ашиглалаа.



Зураг 2. Өндөр нарийвчлалтай байршил тогтоох “Eshtech” багаж болон бүртгэлийн хуудас

Хадны зураг бүртгэх хуудсанд дараах үндсэн мэдээлмүүдийг багтаасан. Үүнд:

1. Зураг бүхий хадны байршил (уртраг, өргөрөг, өндөр)
2. Хадны хэмжээ
3. Дүр дүрслэл

4. Дүр дүрслэлийн хэмжээ
5. Үйлдэгдсэн арга (цоолборлосон, сараачмал, сийлсэн г.м.)
6. Дүрсийн хандсан зүг
7. Дүрсний гүн
8. Ямар арга барилаар зурагдсан (бүх талбайгаар хонхойлсон, хөвөөлсөн г.м)
9. Хадгалалтын байдал (хагаар хучигдсан эсэх, өнгөний байдал г.м.)
10. Хэдий үед холбогдох г.м.

Далантүрүүний хос толгойн эхний уулын зүүн талын хадны зургийг бүртгэн баримтжуулах ажлын дүнд 1114 дүрслэл байгааг нарийвчлан тогтоолоо. Тус бүртгэлд нэг хадны хавтгайд дүрслэгдсэн зураас, хонхорхойг хүртэл хамааруулсан юм. Энэхүү хэсэг газрын хадны зургийн бүртгэлийг хийж дуусгаснаар Далантүрүүний хос толгойн эхний уулын хадны зургийн бүртгэл цогц байдлаар хийгдэж дуусаж байгаа юм.

Энэ жилийн судалгааны үр дүнг өмнөх жилүүдийнхтэй хамтатган авч үзэхэд Далантүрүүний хос толгойн эхний уулын хаднаа 6019 дүр дүрслэл сийлэгдснээс 3414 нь биет (хүн, амьтан, шувуу г.м.) дүрслэлүүд байгаа нь тогтоогдов. Дүрслэгдсэн амьтдаас харахад янгир үнэмлэхүй олонхи байгаа бөгөөд буга, адуу, үхэр мөн олон тоогоор дүрслэгджээ. Тэдгээр хадны зургууд нь он цагийн өргөн хүрээлэлд хамаарах бөгөөд урьдчилсан байдлаар мезо-неолитын үеэс дундад эртний улсуудын үе хүртэлх үед холбогдоно.



Зураг 3. Судалгааны ангийн бүрэлдэхүүн



Зураг 4. Хадны зургийн бүртгэл хийж буй байдал



Зураг 5. Хадны зургийн хуулга хийж буй байдал



Зураг 6. Далантүрүүний хос толгойн эхний уул



Зураг 7. Морин тэрэгний дүрслэл

Судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу дараагийн шатны ажил болох Цуурхай уул болон Цуурхай уулын өмнөд бэлд байх хаваржааны арын хадны зургийг бүртгэх ажлыг эхлүүлсэн бөгөөд цаг агаарын хүнд нөхцөл байдал, цаг хугацааны давчуу байдлыг үл харгалзан ажиллаж дээрх газрын хадны зургийн бүртгэлийн ажлыг дуусгав.

Цуурхай уул нь Арцат уулын зүүн талд орших хүрэн элгэн асга хад бүхий уул бөгөөд түүний баруун хажуугийн толгой болон голын сайрын эрэг дагуух хад чулууд бүхий газарт хайгуул хийж цөөн тооны хадны зургийг илрүүлэн олов. Дээрх газраас нийтдээ 196 тооны хадны зургийг бүртгэн баримтжуулсан юм. Тэдгээрийн 135 нь биет дүрслэлүүд байлаа. Цуурхай уулын урд бэл дэх хаваржааны арын элгэн хаднаа 247 дүрслэл байгаагийн 152 нь биет дүрслэл байна.

Дүгнэлт

Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедицийн 2014 оны судалгаанаас дараах үр дүнд хүрэв.

1. Далантүрүүний хос толгойн эхний уулын хадны зургийг бүртгэх ажлыг дуусгав.
2. Цуурхай уулын зүүн талын толгой болон түүний бэлээс шинээр хадны зургийн дурсгал шинээр илрүүлэн олов.
3. Цуурхай уулын өмнөд бэлийн хаваржааны арын хадан дахь хадны зургийн бүртгэлийг хийж гүйцэтгэв.
4. Хадны зургийн дүр дүрслэлээр дамжуулан мезо-неолитын үеээс дундад эртний улсуудын үе хүртэл үргэлжилсэн түүхийн цаг үед амьдарч байсан эртний хүмүүсийн

аж байдал, зан суртахуун, оюуны соёл, ертөнцийг үзэх үзэл, байгаль дэлхийгээ танин мэдэх, шүтэн дээдлэх үзлийг тодруулах, сэргээн ойлгоход Хотон нуурын орчим дахь Далантүрүүний хос толгой, Арцат, Цуурхай уулын хадны зураг чухал үүрэг гүйцэтгэнэ.



Зураг 8. 73 дүрслэл бүхий хадны зураг



Зураг 9. Буга, янгир, морь, нохойн дүрслэл



Зураг 10. Анчдын дүрслэл



Зураг 11. Буга, үхэр адуу болон морьтой, явган дайчдын дүрслэл




Зураг 12. Цуурхай уул



Зураг 13. Цуурхай уулын хадны зураг



Зураг 14. Цуурхай уулын хадны зураг



Зураг 15. В.Тайлор хадны зургийг дүрсжүүлж байгаа нь

Ном зүй

R.Kortum, Z.Batsaikhan, K.Edelkhan, J.Cambrell. An another new petroglyph complex in the Altai mountains, Bayan-Ulgii aimag, Mongolia: Biluut 1, 2 and 3 // International newsletter on rock art.№41. 2005. pp. 7-14.

Я.Цэрэндагва, Р.Кортум. Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедицийн Баян-Өлгий аймгийн Толбо, Цэнгэл сумын нутагт хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан. АХГБС. УБ., 2006.

R.Kortum, J. Franklin, M. Whitelaw, J. Nave, Ya. Tserendagva. Archaeological Explorations of Biluut 1, 2, and 3: An Extensive Petroglyph and Burial Complex in the Altai Mountains of Mongolia // 73RD Annual Meeting of the Society for American Archaeology, March 26-30, 2008, Vancouver, BC, Canada.

Я.Цэрэндагва, Р.Кортум. Монгол-Америкийн хамтарсан археологийн экспедицийн Баян-Өлгий аймгийн Толбо, Цэнгэл сумын нутаг Билүүтэд хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан. АХГБС. УБ., 2008.

Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва. Далантүрүүний хос толгойд хийсэн хадны зургийн судалгааны ажлын тайлан // АХГБС. УБ., 2010.

Rock Art and Archaeology: Investigating Ritual Landscape in the Mongolian Altai. Field Report 2011. Edited by W.W.Fitzhugh, R.Kortum. Washington DC. Arctic Studies Center. 2012.

МОНГОЛ-МОНАКОГИЙН ХАМТАРСАН ЭКСПЕДИЦИЙН
2014 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

*Ч.Ерөөл-Эргэнэ, Ж.Гантулга,
Ж.Магай¹, К.Салисис²*

Монгол-Монакогийн хамтарсан археологийн экспедиц 2014 оны 06-р сарын 25-наас 08-р сарын 03-ныг хүртэл нийт 40 хоног Архангай аймгийн Их Тамир, Батцэнгэл сумдын нутаг Хойд Тамирын голын хойд эрэг, Хайрхан сумын Гол модны Хүннүгийн оршуулгын дурсгалт газарт ажиллав.

Энэ жилийн хээрийн судалгааны явцад Их Тамир сумын Баянцагааны хөндийн Бараан өвөр ам (Чулуун хороот) хэмээх газарт 3 дөрвөлжин булш, Батцэнгэл сумын Авдар хад хэмээх газарт сорилтын малтлага тус тус хийв. Хайгуул судалгааг Баянцагааны хөндий, Хойд Тамирын голын хойд эрэг орчимд явуулж нийт 11 буган хөшөөг шинээр илрүүлээ.

Хамтарсан экспедицийн судлаачид Хайрхан сумын Гол модны Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалт газарт ажиллаж дэвсгэр зургийг шинэчлэн хийсэн болно.

1. Малтлага судалгаа

1.1. Булшны малтлага

Баянцагааны хөндийн хойно орших Бараан өвөр уулын баруун урд энгэрт хойноос урагш цуварсан, хоорондоо 4.5-5.6 м зайтай 5 дөрвөлжин булш байсныг хойд талаас нь эхлэн дугаарласан болно. Тэдгээрээс 1, 2, 3-р дөрвөлжин булшинд нийт 7 буган хөшөөг булангийн хөшөө чулуу, хашлага болгон ашигласан байна. Бид гурван булш малтан шинжилсэн нь бүгд эрт цагт тоногдож сүйдсэний улмаас оршуулга илэрсэнгүй (*Зураг 1-7, Хүснэгт-1*).

1-р дөрвөлжин булшны зүүн талын хоёр буланд буган хөшөө (*100, 101-р буган хөшөө*) ашиглажээ. Малтлагын явцад дараас чулуун дундаас болон оршуулгын нүхнээс ваарны хагархай, хүний хавирганы хугархай, оюу сондор 1 ш гарсан болно (*Зураг 1-3*).

2-р дөрвөлжин булшны зүүн талын хашлага чулууг буган хөшөө (*102-р буган хөшөө*)-гөөр хийжээ. Булш мөн эрт цагт тоногдож сүйтгэгдсэн ч хүний ясны үлдэгдэл, ваарны хагархай, төмрийн басны үлдэгдэл зэрэг зүйлс эмх цэгцгүй байдалтай гарав. Тухайлбал, булшны нүхнээс хүний үүдэн шүд, шуу болон дунд чөмөгний ясны хугархай, мөн дараас чулуун дундаас хээтэй, хээгүй ваарны хагархай, төмрлөг боловсруулалтын хаягдал, ваарны хагархай зэрэг зүйлс илэрч олдсон (*Зураг 4, 5*).

3-р дөрвөлжин булшны хашлаганы гадна талаас төмрийн хаягдал, дотор талаас ваарны хагархай, бог, бод мал (?) -ын эрүү, шүд, далны ясны хэсэг, булшны нүхний зүүн урд хэсгээс бод малын шүд зэрэг зүйлс илэрч олдсон болно (*Зураг 6, 7*).

1.2. Сорилтын малтлага

Цац толгойгоос зүүн хойш 12.6 км зайд, уулын нарийн аманд баруун урдаас зүүн хойш 130 м орчим сүнаж тогтсон, 13 м өндөр боржин чулуун ханан хад бүхий тогтоц буйг Авдар хад хэмээн нэрлэдэг. Энэхүү тогтоц нь наран ээвэр, салхи шорооноос нөмөр газар ажээ.

Газар зүйн байршил: Умард өргөргийн 5301460, Дорнод уртрагийн 683205, далайн

¹ Монакогийн Нэн эртний хүн судлалын музейн судлаач, доктор (Ph)

² Альп-Газрын дундад тэнгис орчмын Археологи, нэн эртний судалгааны хүрээлэн

түвшнөөс дээш 1700 м (*Зураг 8*).

Авдар хадны өвөр бэлээс хуучин чулуун зэвсгийн зүйлс, ваар савны хагархай, төмрийн хаягдал зэрэг зүйлс түүвэр байдлаар олдсон тул 2011-2013 онд сорилтын малтлага хийж хуучин чулуун зэвсгийн дээд үед холбогдох хэдэн зуун олдвор илрүүлэн судалж үр дүнг нийтлүүлжээ.

Дурсгалт газрын баруун хойд талд 10-20 м зайд газрын хэвгийг чулуу өрж тэгшлэн зассан газрыг илрүүлсэн ба 2011 онд 1x2 м талбайд сорилтын малтлага хийж эртний бууц суурин байж болох магадлалтай хэмээн үзсэн юм. Улмаар дурсгалын хамрах хүрээг 240 м² болохыг тогтоож 2м² тутмыг дугаарлан А 6, А 6-8, В1, 2, С8, D 2-6, E 2-4 талбайг сонгон малтан шинжлэв (*Зураг 9*).

Малтан судалсан талбай бүрийн гүн харилцан адилгүй буюу 5-40 см байв. Малтлагаас чулуун зэвсгийн зүйлс, вааран савны хагархай, төмрийн хүдэр, хаягдал, ясны үлдэгдэл, модны нүүрс зэрэг хэдэн зуун олдвор хэрэглэгдэхүүн олдсоны зэрэгцээ галын ором илэрсэн болно (*Зураг 10*). Олдворууд нь түүхийн олон үед холбогдохыг урьдчилсан байдлаар тогтоогоод байна. Энэ нь Авдар хад орчимд хуучин чулуун зэвсгийн үеэс хүн суурьшиж багаж зэвсэг үйлдвэрлэж байсан төдийгүй эрт цагт төмөрлөг боловсруулж байсан газар болохыг илтгэнэ.

2. Хайгуул судалгаа

Энэ жилийн хайгуул судалгааг Хойд тамирын голын хойд эрэгт хийж 11 буган хөшөө илрүүлж бүртгэснийг өмнөх судалгааны дүнтэй нэгтгэвэл нийт 109 буган хөшөө болж байна.


Эдгээрээс 100-107-р хөшөөг дөрвөлжин булшны булангийн хөшөө чулуу болон хашлага чулуу, 109-р хөшөөг хиргисүүрийн дагуул байгууламжид ашигласан байв (*Зураг 11-14*).

3. Топографийн хэмжилт судалгаа

Монгол-Монакогийн хамтарсан археологийн экспедицийн судалаачид Гол модны дурсгалт газарт ажиллаж дэвсгэр зургийг шинэчлэн хийсэн юм.

Судалгааны явцад нийт 483 булш бүртгэсний 214 нь язгууртны булш, үлдсэн 269 нь дагуул болон жижиг булш байна (*Зураг 15*).

Ийнхүү Гол модны дурсгалт газрын хөрсийн онцлогоос шалтгаалж элсэнд дарагдаж мэдэгдэхгүй шахам болсон 63 булшийг шинээр бүртгэж дэвсгэр зурагт тэмдэглэсэн юм. Мөн оршуулгын газрын хойд зах хийгээд Мөнхийн толгойгоос зүүн талын уулс хүртэл үргэлжилсэн чулуун зураг илрүүлж баримтжуулаа. Жижиг чулууг тодорхой зайтай цувуулан босоогоор нь зоож хийсэн тэрхүү чулуун зураг оршуулгын газарт орших бүлэг булшийг заагласан шугам хэмээн урьдчилсан байдлаар үзэж байгаа билээ. Элсэн хөрсөнд дарагдсаны улмаас зарим чулуу нь газрын гадаргуу дээр мэдэгдэхгүй болсон тул цаашид сорилтын малтлага хийж чулуун зурааны үргэлжлэх урт, зориулалт зэргийг тодруулах шаардлагатай юм.




Зураг 1.1-р дөрвөлжин булины дэвсгэр ба хөндлөн огтлолын зураг



Зураг 2. 1-р дөрвөлжин булинаас олдсон хээтэй ваарны хагархай



Зураг 3. 1-р дөрвөлжин булинаас олдсон оюу сондор




Зураг 4.2-р дөрвөлжин булины дэвсгэр зураг



Зураг 5. 2-р дөрвөлжин були, малтлагын 2-р үеэс олдсон бодын шүд, ваарны хагархай



Зураг 6.3-р дөрвөлжин булины дэвсгэр зураг



Зураг 7.3-р дөрвөлжин булич, малтлагын 2-р үеэс олдсон төмөрлөг боловсруулалтын хаягдал, богийн эрүү, шүд, ваарны хагархай


Хүснэгт-1

Малтан шинжилсэн дөрвөлжин булшны товч мэдээллийн хүснэгт

№	Дурсгалын дугаар	Дурсгалын төрөл	Дараасны хэмжээ /см/	Хашлаганы хэмжээ /см/	Нүх			Хүний яс	Малын яс	Олдвор
					Хэмжээ /см/	Цнглээ	Гүн /см/			
1	1-р булш	Дөрвөлжин булш	700 x 840	330 x 405	50x76x190	60°	100	Хавирганы хугархай (?)	Бод малын эрүү, шүдний үлдэгдэл	Оюу зүүлт-1ш, ваарны хагархай, төмрийн баасны үлдэгдэл, чулуун зэвсгийн зүйлс-1ш
2	2-р булш	Дөрвөлжин булш	750 x 980	290 x 525	64x76x145	75°	87.5	Үүдэн шүд-1ш, бутала, ауна чөмөгний ясны хугархай (?)	Бод малын эрүү, шүдний үлдэгдэл	Ваарны хагархай, төмрийн баасны үлдэгдэл, модны нүүрсний үлдэгдэл
3	3-р булш	Дөрвөлжин булш	450 x 620	316 x 376	65x66x180	80°	92	-	Бөг, бод малын эрүү, шүдний үлдэгдэл	Ваарны хагархай-5ш, төмрийн баасны үлдэгдэл-2ш
4	1-р булшны чулуун байгууламж	Чулуун байгууламж	220 x 240	-	-	-	31	-	-	-
5	2-р булшны чулуун байгууламж	Чулуун байгууламж	185 x 245	-	-	-	34.5	-	-	Ваарны хагархай-1ш



Зураг 8. Авдар хадны ерөнхий байдал (урдаас)



Зураг 9. Авдар хадны орчимд хийж буй малтлагын талбай
(2014 оны малтлагыг тацгуу зураасаар тэмдэглэв)



Төмрийн хаягдал



Залтас



Шатсан яс



Чулуун зэвсгийн зүйлс



Хэтэй ваарны хагархай




Төмөр хутганы хугархай



Голын жижиг хайрга

Зураг 10. Авдар хадны суурингийн олдворын дээжис



Зураг 11. 2014 оны хайгуул судалгаагаар олдсон буган хөшөөдийн байршил



99-р буган хөшөө



100-р буган хөшөө



101-р буган хөшөө




102-р буган хөшөө

Зураг 12. Буган хөшөөний гар зураг



103-р буган хөшөө



104-р буган хөшөө



105-р буган хөшөө



106-р буган хөшөө

Зураг 13. Буган хөшөөний гар зураг




107-р буган хөшөө

109-р буган хөшөө



108-р буган хөшөө

Зураг 14. Буган хөшөөний гар зураг



Зураг 15. Гол модны дурсгалт газрын
2014 онд хийсэн дэвсгэр зураг

2014 ОНД БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ СУМЫН НУТАГ ТАРВАГАТАЙН ГОЛЫН
ХӨНДИЙД МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН ТӨСЛИЙН ХЭЭРИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ҮР ДҮН

Б.Жаргалан, У.Гарднер

Удиртгал

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн ба Америкийн Нэгдсэн Улсын Йелийн их сургуулийн хамтарсан археологийн төслийн хүрээнд Булган аймгийн Тэшиг сумын Тарвагатайн голын хөндийд 2014 оны 6 сарын 15-30 өдрүүдэд хээрийн шинжилгээний ажлыг зохион байгуулж амжилттай хэрэгжүүлээ. Судалгааны багийн бүрэлдэхүүнд Йелийн их сургуулийн докторант Б.Жаргалан, У.Гарднер нар, Уаёминг мужийн археологич Д.Гарднер, Б.Бунгер нар, Шинэ Зеландын Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Э.Бланшард, окутан А.Жонсон, А.Камерон, С.Румшлаг, Ч.Уугандаваа, О.Гүжирмэг нар, тогооч П.Байгальмаа, жолооч Н.Батмөнх, Д.Ганбат нар хамрагдсан болно¹.

Зорилго

Уг төслийн урдаа тавьсан ерөнхий зорилго бол Тарвагатайн голын хөндийд археологийн нарийвчилсан хайгуулыг гүйцэтгэн эртний дурсгалуудыг бүртгэн судалгааны эргэлтэнд оруулахаас гадна эртний хүн амын амьдралын хэв маяг, ахуй хэрхэн өөрчлөгдөж ирсэн болохыг судлах явдал юм. Ингэхдээ зөвхөн газрын хөрсөн дээр ил харагдах дурсгалуудыг хамруулахаас гадна Монголын археологид харьцангуй бага судлагдсан бууц суурингийн судалгааг түлхүү хэрэгжүүлж байна. Олон зууны турш хөрсөн давхаргуудад дарагдсан байдлаас болж эдгээр эртний бууц суурингууд нүдэнд үл харагдах учир төслийн анхан шатнаас эхлүүлэн хайгуул, дурсгал бүртгэх арга зүйнүүд дээр анхаарлаа хандуулсан юм.

2014 оны хээрийн шинжилгээний хүрээнд ерөнхий хоёр зорилгыг урдаа тавьсан. Нэгт, Тарвагатайн хөндийн салаа амнуудад буй бүртгэгдсэн хиргисүүрүүдээс сонгон нарийвчилсан он цагийг тогтоох. Хоёрт, нарийвчилсан хайгуулаар илэрсэн бууц суурингуудаас сонгон сорилтын маллага хийж он цаг болон тухайн дурсгалын байдлыг олж тогтоох болно.

Хүрэл зэвсгийн үед хамрагдах хиргисүүрүүдийн нарийвчилсан он цагийг тогтоох нь цаанаа Тарвагатайн хөндийд уг дурсгалыг босгох заншил хэдий үеэс ямар шатлалтайгаар эхэлсэн болохыг олох ач холбогдолтой юм. Ингэснээр зөвхөн хиргисүүрийн ерөнхий он цагийг тодорхой болгохоос гадна тэдгээрийг барих болсон нийгмийн шалтгаануудыг тогтоох ач холбогдолтой болно. Энэ төслийн урдаа тавиад байгаа судалгааны ерөнхий асуултуудын нэг нь Монгол ба Өвөр Байгалын газар нутгаар өргөн тархсан хиргисүүрүүдийг эртний хүмүүс ямар нийгэм, ахуй, соёлын үндсэн дээр барьсан болохыг тогтоох явдалтай холбоотой. Хэдийгээр тэдгээрийг оршуулгын болон тахилгын зориулалтаар барих болсон гэсэн онол зонхилоод байгаа хэдий ч уг хүн амын ахуйн амьдралын талаарх бидний ойлголт дутмаг байгаа тул дээрх ерөнхий ойлголтоос цааших судалгаа зогсонги байдалтай байна. Иймд эртний бууц суурингийн судалгааг түлхүү оруулж ирэх шаардлагатай болсон юм. Энэхүү төсөл эхэлснээс хойш нийт 74 км² талбайд нарийвчилсан хайгуул хийж 90 гаруй

¹ Б.Жаргалан. Булган аймгийн Тэшиг сумын Тарвагатайн голын хөндийд явуулсан археологийн судалгааны тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар, 2014.

бууц суурин бүртгээд байна. Харин эдгээрээс чухам аль нь хиргисүүртэй нэгэн он цагт хамрагдаж болохыг тогтоохын тулд хайгуулын үеэр олдсон хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан сорьцын малтлагуудыг хийж нарийвчилсан он цаг тогтоох шаардлагатай болсон юм. Ингэснээр цаашид өргөн хэмжээний малтаганд хамрагдах бууц сууринг олж тогтоож хиргисүүртэй нэгэн үеийн хүн амын өдөр тутмын амьдралын талаарх ойлголтыг баяжуулж судалгааны олон асуултын хариултыг олж болох ач холбогдолтой.

Судалгааны арга зүй

Хиргисүүрийн малтлага. Тарвагатайн хөндийд хэд хэдэн газарт том хэмжээний хиргисүүрийн төвлөрөл бүртгэгдсэн. Эдгээр нь голдуу 5-6 хиргисүүрээс бүрдэнэ. Тус бүртээ дөрвөлжин хашлагатай, 8-24 ширхэг дагуулуудтай болно. Хиргисүүрийн он цагийг тогтооход бүрэн хэмжээний малтлага шаардагддаг боловч олон тохиолдолд он цаг тогтооход хэрэгтэй органик дээж олддоггүй. Дээрээс нь Тарвагатайн хөндийд бүртгэгдсэн хиргисүүрүүдийн голын овгор чулуунууд тоногдолтын үл мөртэй байлаа. Хэдийгээр дагуул байгууламжуудаас тахилд өргөсөн амьтадын яс зэрэг зүйлс олддог боловч эдгээр дагуул байгууламжууд гол чулуун овгортой нэгэн цаг үед боссон эсэх асуудал шийдэгдээгүй байна. Иймээс энэ төслийн хүрээнд хиргисүүрийн гол вогор чулуунаас гадна бусад хэсгүүдийн (хашлага чулуу, дагуул байгууламж) он цагийг тогтоох арга зүйн дагуу малтлагуудыг явуулсан болно. Уг арга зүй нь чулуун дор буй хөрс хамгийн сүүлд хэдэн жилийн өмнө наранд ил гарсан байсан эсэхийг тогтооход чиглэсэн байдаг тул хиргисүүрийн хэсэг болгоны чулууг хэдэн жилийн өмнө тавьсан болохыг мэдэж болно. Энэ арга зүй цаанаа олон дагуул байгууламжтай том хэмжээний хиргисүүрүүдийг удаан хугацааны турш эртний хүмүүс босгож уу, эсвэл олон хүний хүч хөдөлмөрийг төвлөрүүлэн нэг удаагийн аянаар барьсан уу гэсэн асуудлыг шийдэхэд чиглэсэн.

Тарвагатайн аманд энэ зун ажигласан цөөн хоногт нийт 4 хиргисүүрээс он цагийн дээж авахаар төлөвлөв. Ингэхдээ тус бүрийг нь тодорхой судалгааны зарчмын дагуу сонгов. Хамгийн эхэнд малтлага судалгаанд хамрагдсан хиргисүүр буюу TVP 2 дурсгал нь Тарвагатайн голын хамгийн өргөн салаа амны эхэнд байрлахас гадна нийт бүртгэгдсэн хиргисүүрүүдээс хэмжээгээр хамгийн том нь болно. Дараагийн хиргисүүр буюу TVP 172 дурсгал нь эхний хиргисүүрээс хойш өндөр энгэр дээр байрлана. Энэхүү дурсгалыг сонгох болсон шалтгаан нь эхний дурсгалаас холгүй зайнд байрлахас гадна газар зүйн байршлын хувьд тэс ондоо байсантай холбоотой. Үүнээс гадна хэмжээгээр бага, арай цөөн тооны дагуул байгууламжтай байв. Ингэснээр энэхүү хоёр өөр төрлийн хэв шинжтэй, хоёр өөр төрлийн газар зүйн байршилтай дурсгалуудыг харьцуулах боломж бүрдэж байгаа юм. Гурав дахь хиргисүүр нь эдгээр хоёр дурсгалаас чанх зүүн тийш байрлах бөгөөд харьцангуй бага тоногдолтын үл мөртэй байв. Газар зүйн байршлын хувьд харьцангуй задгай уулын энгэр дээр байрлана. Хамгийн сүүлд малтаганд хамрагдсан хиргисүүр нь Улиатайн голын эрэг байрлана. Энд хэдийгээр том хэмжээний хиргисүүрүүд байрлах боловч өөр хоорондоо хол зайнд байгаа нь сонирхол татна. Үүнээс гадна уг хөндийн хамгийн том хиргисүүрийн төвлөрлөөс тэс ондоо зохион байгуулалттай байна.



ТVP2 дурсгалын нэгдүгээр дагуул байгууламж

Маллаганд хамрагдах хиргисүүрийн дагуул байгууламжийг сонгохдоо юуны өмнө тоногдолтонд хэр ихээр өртсөн болохыг анхааралдаа авав. Бүртгэлд хамрагдсан хиргисүүрүүд болон тэдгээрийн дагуул байгууламжууд Тарвагатайн хөндийн хэмжээгээр тоногдолтонд ихээр өртсөн болох нь ажиглагдсан. Дараагийн нэг шалгуур нь дагуул байгууламжийн байршил юм. Бидний сонгосон хиргисүүрүүд гадна дөрвөлжин хашлаганыхаа дөрвөн талд дагуултай байсан бөгөөд урд талдаа хамгийн ихээр төвлөрч байв. Чулуун хашлаганы өөр талд буй дагуул сонгон он цагийг нь тогтоосноор уг хиргисүүр хэр их хугацааны туршид баригдсан болохыг тогтоох боломжтой болно. Дагуул байгууламж болгоны гадна талаар хүрээ татаж бүрэн талбайгаар нь цэвэрлэн маллагыг гүйцэтгэв. Маллагын үе болгон дээр гар ба фото зураг, нарийн тодорхойлолтыг гүйцэтгэв.



Хиргисүүрээс OSL дээж авч буй үйл явц

Шинээр хэрэгжүүлж буй он цаг тогтоох арга зүйн дээжийг авахдаа аль болох хөндөгдөж хөдлөөгүй чулуу сонгож байлаа. Сонгосон чулууны нэг талд хүн багтахаар хангалттай том хэмжээтэй нүхийг чулууны ёроол нэг талаас ил гартал ухав. Үүний дараагаар 8 см голчтой төмөр хоолойг чулууны хажуу талаас ёроол доогуур алхаар нүдэн оруулж шорооны дээж авав. Хоолойг гаргахдаа гэрэлд цохиулахгүйн тулд дээжийг авч байгаа хүнтэй хамт бүрэн хучиж байв. Он цагийн дээж авсан нүхний хажуунаас мөн хөрсний чийгшилт, сансрын цацраг идэвхийн дээжийг мөн авав. Эдгээр нь он цагийн нарийвчлалыг бататгах нэмэлт дээжнүүд болно.

Бууц суурингийн сорьц малтлага. Өмнө нь хэлсэнчлэн эдгээр сорьц малтлагууд нь хайгуул судалгааны үр дүнд илэрсэн бууц суурингуудын нарийвчилсан он цагийг тогтоох, тухайн дурсгалын байдлыг тогтоох зорилготой болно. Ингэснээр цаашид өргөн хэмжээний малтлага явуулах бууц сууринг олж хүрэл зэвсгийн үеийн хүн ам

ямар аж ахуй хэрэглэдэг байсан, хөдөлмөрийн ямар багаж зэвсэг хэрэглэдэг байсан, ямар ахуйн эд хэрэглэл ашигладаг байсан зэргийг өдөр тутмын амьдралын үйл ажиллагааны үр дүнд үлдсэн олдвороос тогтоож болох юм.

Аливаа бууц суурингийн дурсгалын он цаг, онцлогийг тогтоохын тулд хоёр төрлийн шатны сорьцын малтлага явуулав. Юуны өмнө газрын хөрсөн дээр болон дороос олдсон олдворын төвлөрөл ихтэй газарт 30х30 м талбай татаж 3 м болгонд өрмөн шалгалтыг хийж гарсан шороог бүрэн шигшинэ. Ингэснээр тухайн дурсгалын олдворын тархалтыг улам нарийсгаж байгаа юм. Ваарны хагархай, малын яс болон чулуун зэвсэг зэрэг олдвор гарсан сорьц болгон дэр туг зоосноор энэхүү нарийвчилсан тархалтыг ажиглаж болно. Үүний дараагаар олдворын хамгийн их төвлөрөлтэй хэсэгт тугны тархалтын байдлаас хамаараад 1х1 м юмуу бусад хэмжээний талбайг татан сорьцын малтлагыг гүйцэтгэв. Энэ нь зөвхөн тухайн газарт эртний хүмүүс оршин сууж байсан эсэхийг тогтоохоос гадна он цаг тогтоох найдвартай дээжийг олоход чиглэсэн алхам болно. Малтлагын үр дүнд гарсан бүх шороог шигшиж олдсон олдворуудыг бүртгэлийн дугаарын дагуу савлан хадгалав.

Урьдчилсан үр дүн

2014 оны зуны хээрийн шинжилгээний судалгаагаар нийт 4 хиргисүүр ба 3 эртний бууцыг малтлага судалгаанд хамруулав. Хиргисүүр болгонос хоёр дагуул байгууламж малтаж радиокарбон ба OSL он цагийн дээж авав. Эдгээрэс гадна хиргисүүрийн хашлага чулуунаас мөн OSL дээжийг дангаар авав. Ингэснээр эдгээр он цаг тогтоох арга зүйнүүдийг хооронд нь харьцуулж тухайн дурсгалын он цагийг илүү нарийвчлалтай тогтоож болох юм. Гарсан он цагийн дээжүүдийг шинжилгээний газруудад явуулсан байгаа. Дагуул байгууламжуудаас илэрсэн адууны яснуудыг изотопын судалгаанд хамруулахаар төлөвлөж байгаа.

Малтлаганд хамрагдсан эртний бууцнуудын хувьд TVP 141, 187, 232 дурсгалууд хамрагдсан. Эдгээр нь газар зүйн байрлалын хувьд орчин үеийн намаржаа, өвөлжөөтэй давхацаж байснаас гадна эдгээр байршлаас хайгуулын явцад олон тооны ваарны хагархай, чулуун зэвсгүүд илэрсэн болно. Дурсгал болгон дээр 1х1м ба 2х2м хэмжээтэй сорьцын малтлагын талбайг олдворын нягтрал ихтэй хэсэгт байршуулж малтлагыг гүйцэтгэв. Эдгээр хэмжээтэй малтлагууд нь цаашид өргөн хэмжээний малтлага судалгааг чиглүүлж өгөхөөс гадна нарийвчилсан он цаг тогтоох дээж олох ач холбогдолтой. Үүнээс гадна эдгээр хэмжээнүүд нь нягтрал багатай бууц суурингийн судалгаанд аливаа соёлт давхарга, байгууламж зэргийг олж тогтоохоо хамгийн бага хэмжээний хүлээн зөвшөөрөгдсөн талбайнууд юм. TVP 141 ба 187 дурсгалуудын малтлагын явцад эртний багана байршуулж байсан үл мөр ба галын ором тус бүр илэрсэн. Он цагийн дээж болгон ашиглагдах малын яс (зарим нь их хэмжээгээр түлэгдсэн) бүх дурсгалуудаас илэрсэн.

МОНГОЛ-ФРАНЦЫН ХАМТАРСАН „ЕВРАЗИАТ” ТӨСЛИЙН
2014 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү, Г.Энхбаяр

Монгол-Францын хамтарсан „Евразиад” төслийн хээрийн шинжилгээний анги 2004 оноос хойш Баян-Өлгий аймгийн нутагт эртний ба дундад зууны үеийн нүүдэлчдийн соёлыг малтан судлаж байгаа билээ. 2014 онд тус төслийн хоёр бие даасан судалгааны баг тус аймгийн нутагт ажиллав. Эхний баг нь тус аймгийн Ногооннуур сумын нутагт эртний Түрэгийн оршуулгын дурсгалыг судлах зорилготой ажилласан бол Хоёрдугаар баг нь тус аймгийн Сагсай сумын нутагт хүрэл зэвсгийн үеийн нүүдэлчдийн оршуулга ба тахилгын дурсгалыг малтан судлах зорилготой ажиллав.

Судалгааны 1-р баг. Ногооннуур сум.

Монгол-Францын хамтарсан археологийн „Евразиад” төслийн 2014 оны хээрийн шинжилгээний ангийн эхний баг Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт байх Их хатуугийн голын хөндийд 2014 оны 06-р сарын 18-наас 07-р сарын 12-ны хооронд хийж гүйцэтгэсэн болно.

Уг судалгааны багт Монголын талаас ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүрэл ба түрүү төмрийн үеийн судалгааны секторын доктор, дэд профессор Ц.Төрбат, тус секторын эрдэм шинжилгээний ажилтан Н.Баярхүү, Г.Энхбаяр нар, Францын талаас Байгалийн түүхийн Үндэсний музейн ажилтан, доктор Л.Себестьян, В.Бернард нар оролцон ажиллав.

Их хатуугийн дурсгалт газар буй уулын голын хавчиг дэнж Монгол Алтайн нурууны нэгэн томоохон салбар, Сийлхэмийн нурууны салбар уулсын дундуур урсах Их Хатуугийн голын баруун гар талд байрлана. Уг дурсгалт газар Ногооннуур сумын төвөөс 30 км-т орших бөгөөд анх 2006 онд Н.Баярхүү, Т.Идэрхангай нар „Монгол Алтайн түүх археологийн дурсгалууд” төслийн явцад илрүүлж баримтжуулжээ. Бид энэ жилийн хээрийн судалгааны явцад Их Хатуугийн голын баруун талын дэнж болон түүний урд талд орших нэгэн жижиг цутгалын эрэг дагуу байрласан 100 гаруй дурсгалын тархалтыг тогтоон гэрэл зургаар баримтжуулсан болно (Зураг 1).


Бидний малтлага судалгаа хийсэн талбайд нэлээд олон дурсгал өөр хоорондоо тийм ч холгүй зайтай оршино. Тухайлбал, Түрэгийн үеийн тахилын онгон 5, хүн чулуун хөшөө 2, булш 5, тахилын хашлага бүхий хүрлийн үеийн хөшөө чулуу 3 бий. Бид энэ жилийн тухайд дээрх талбайд буй таван булшийг малтан судлах зорилт тавин ажиллав.

Гэвч малтлагын явцад дээрх таван булшны зөвхөн нэг нь түрэг булш, хоёр нь хүннүгийн үеийн тахилгын байгууламж, хоёр нь тодорхойгүй чулуун байгууламж болох нь илэрхий болов. Эдгээр дурсгалууд гадаад зохион байгуулалт болон хэлбэр, хэмжээ зэргээрээ бидний дугаарласанаар 5-р булшнаас бусад нь түрэг булшны хэлбэртэй нэлээд ойролцоо байсан юм. Гэтэл малтлага хийж үзэхэд 1-р дурсгал түрэг булш, 2 болон 5-р дурсгал Хүннүгийн үеийн тахилгын байгууламж, 3 болон 4-р дурсгалын тухайд малтлагын явцад он цагийг баттай тогтоох ямар нэг зүйл гараагүй, харин өнгөн хөрсний цэвэрлээгээний явцад малын хэдэн ширхэг ясны хугархай хэлтэрхий төдий гарсан тул он цаг, үүрэг зориулалт тодорхойгүй.

Түрэг булшы тухайд оршуулга нь эрт цагт тоногдсон шинжтэй бөгөөд үүний дээр мэрэгч амьтад ихээр үүрлэсний улмаас хүн болон адууны яснууд холилдож

эмх замбраагүй болсон байна. Хэдий холилдсон боловч хүн болон адууг толгойгоор нь эсрэг зүгт хандуулсан нь анхны байралдаа байгаа хүний шилбэний яс, адууны толгой болон цээжин биеийн хэсгээс тодорхой мэдэгдсэн юм. Хүнээ толгойгоор нь хойд зүгт чиглүүлж дээш харуулан хэвтүүлсэн байсан бол адууг толгойгоор нь урд зүгт чиглүүлэн хоньчилон тавьсан байжээ. Хүний гавал болон зарим яснууд нь илрээгүй болно. Хүн морь хоёрыг заагалж нарийн хавтгай чулуугаар хашлага хийсэн нь хүний хөл талд эвдэгдээгүй хэвээр илэрсэн (Зураг 2). Булнаас хадгалалтын хувьд нэлээд муудсан боловч дотроо хэдэн ширхэг төмөр зэвтэй сум бүхий үйсэн саадаг олдсон бөгөөд сумны модонд хийсэн судалгаагаар 6 ширхэг сум нь бүгд нэг модноос гаргаж авсан болохыг тогтоосон юм (Зураг 3).


Их Хатуугийн хүн чулуун хөшөө бүхий тахилын онгоноос он цаг тогтоох дээж авч бидний малтсан 1-р булштай харьцуулах зорилгоор малтлага хийсэн боловч тэндээс ямар нэг эд зүйл, тахилгын шинж тэмдэг зэрэг он цаг тогтоох зүйл илрээгүй болно. Мөн эдгээр дурсгалаас зүүн тийш нэлээд зайтай орших хүрлийн үеийн зэрэгцээ 3 хөшөө чулууг тахилын хашлага чулуун дотор босгосон байгаа бөгөөд зүүн талдаа ганц жижиг цагариг хэлбэрийн дагуул байгууламжтай. Эдгээр хөшөөдийн он цагийг тогтоох дээж авах зорилгоор нэгэн цагарган чулуун байгууламжийг 20x50 см хэмжээтэй малтаж үзсэн боловч дээжинд авч болох ямар зүйл илрээгүй тул буцааж нөхөн сэргээсэн болно.



Зураг 1. Дурсгалуудын тархалтыг он цаг болон хэлбэрээр ангилсан тойм зураг.
Үйлдсэн © В.Бернард (2014).



Зураг 2. Түрэгийн морьтой оршуулгын фотограмметрийн дүрс.



Зураг 3. Сумны модонд хийсэн судалгаа


Судалгааны 2-р баг. Сагсай сум.

Уг судалгааны багт Монголын талаас ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүрэл ба түрүү төмрийн үеийн судалгааны секторын доктор, дэд профессор Ц.Төрбат, тус секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Батсүх, Н.Баярхүү, Г.Энхбаяр нар, Францын талаас Францын Цөлийн ба Хээр талын хүрээлэнгийн захирал доктор, профессор П.Х.Жискар оролцон ажиллав. Хээрийн судалгаа 2014 оны 08 сарын 02-ноос 09 сарын 01 хүртэл хугацаанд Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Цагаан Асгад явагдаж нийт хүрлийн үеийн 18 булш, 2 тахилгын байгууламж, 1 ширхэг түршилтын шуудууг тус тус малтан судалжээ. Бидний малтан судалсан эдгээр булшны ихэнх нь 4 талдаа хөшөө чулуутай, дөрвөлжин болон дугуй хүрээтэй байдаг Сагсай хэлбэрийн булшнууд болно.

Манай төслийн баг Цагаан Асгын дурсгалт газрын баруун урд хэсэгт орших хиргисүүр ба Сагсай хэлбэрийн булш бүхий энэхүү оршуулгын цогцолбор газрын нийт 24 булшийг 2007 оноос эхлэн дөрвөн жилийн хугацаанд малтан судалсаар энэ жил дуусгав. Сагсай хэлбэрийн булшинд оршуулсан хүндээ ямарваа нэгэн эд өлгийн зүйл дагалдуулдаггүй боловч хүний ясны хадгалалт маш сайн байдаг билээ. Ийм учраас бид тус бүлэг оршуулгын газрын хүний ясны бүтцэд генетик болон патологийн судалгаа хийж тэдгээрийн аж байдал, бодгалуудын хоорондын холбоо хамаарал, өвчлөл зэргийг тогтоохоос гадна тэдний амьдарч асан он цагийг нарийвчлан тогтоох зорилт тавьж байгаа билээ. Эдгээр дурсгалт газраас зүүн тийш орших Цэнгэл хэлбэрийн дурсгалаас 2 ширхэгийг малтан шинжилж он цаг тогтоох зорилгоор зарим нэг дээж авсан. Мөн Хар чулуутын голын гүүрнээс баруун хойд зүгт орших Цагаан Асга-II дурсгалт газраас түрүү хүрлийн үед холбогдож болзошгүй 2 булш илрүүлэн малтав. Үүнээс гадна Цагаан Асгын баруун хэсгийн дурсгалт газрын хойд талд найман чулуут тахилгын жижиг байгууламжууд хагас дугуйрсан байдалтай орших хэсэгт сорьцын сүвгийг 20 см гүнтэйгээр малтсан боловч ямар нэгэн эртний байгууламж илрээгүй болно.

Эдгээр булшнуудад хүнээ голчлон баруунаас баруун хойш чигт толгойг нь хандуулан оршуулсан байна. Үүнээс гадна 4 булш хоосон байв. Ялангуяа 24-р булш хэдийгээр 9,9 м голчтой овгор, битүү чулуун дараастай байсан боловч хоосон байсан билээ. Түүнчлэн 7-р, 22-р, 24-р ба TsA-2-2-р булшнууд хоосон байв.

Энэ жилийн малтлагын явцад хэд хэдэн булшнаас дараасны түвшинд шавар савын хагархай гарсан болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Мөн хүний араг ясны цээжин хэсгээс илэрсэн 1 ширхэг ясан зорх одоогоор энэхүү соёлын булшнаас гарч буй анхны эд өлгийн зүйл болно. Хэдийгээр ихэнх булшнаас илэрсэн хүний ясны хадгалалт сайн боловч цөөн зарим булш, түүний дотор эртний газрын өнгөн хөрсөн дээр тавьж чулуугаар даруулан оршуулсан хүний ясны хадгалалт харьцангуй муу байлаа. Мөн хэд хэдэн булшнаас илэрсэн хүний ясанд патологийн асар их өөрчлөлтэй байсан болохыг дурдая. Үүний дотор 2 ба 5-р булшийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.



Зураг 1. Цагаан Асгын дурсгалт газрын дэвсгэр зураг

ДУРСГАЛ №2014-1. Цагаан Асгын төв хэсэгт орших хэсэг чулуун байгууламжийн баруун захад орших Цэнгэл хэлбэрийн тэгш өнцөгт хүрээтэй байгууламжийн баруун талд урдаас хойш цувраагаар байрлах 5 чулуун байгууламжийн голынх нь буюу урд, хойно аль ч талаасаа 3 дахь нь юм. Хэлбэрийн хувьд зүүн урдаас баруун хойш чигтэй сунасан тэгш өнцөгт хэлбэртэй байна. Дараасны баруун талаар чулуу бага бөгөөд голын хайрган чулуугаар дараасыг хийсэн. Дараасны урд захаар хавтгай чулууг босгон хийсэн хашлага цухуйна. Цэнгэл хэлбэрийн тахилгын байгууламжийн баруун талд байх иймэрхүү чулуун дараастай, тэгш өнцөгт болон тодорхой хэлбэргүй чулуун дараасуудыг бид 2011 оноос цөөн тоогоор малтан судласан болно.

Маллагын 1-р үеийг гүйцэтгэхэд тэгш өнцөгт хэлбэртэйгээр хавтгай чулуудыг босоогоор нь хавиргалан зоож хашлага хийн доторхи талбайг голын хайрган чулуугаар битүү дүүргэсэн байв. Зүүн талын хашлагын төв хэсэг бага зэрэг нурсан байв. Хэмжээ: өргөн 4,1-4,5 м, урт 7,6 м.

Зүүн урдаас баруун хойш чигтэй хөндлөн тэнхлэгийг чулуун байгууламжийн дагуу хагаслан татаж тэнхлэгийн зүүн хагасын дараасыг хуулж хөндлөн огтлолыг гаргахад төв хэсгээс бодын далны толгойн хэсэг гарав. Баримтжуулалтын дараа үлдсэн баруун талын дараасыг хуулж маллагын 2-р үеийг гүйцэтгэхэд хүрээний төвөөс жижиг хайрган чулуу бүхий элсэн үе гарсан ба хашлагын дагуу уртааш зурвас хүрэн бор толбо илрэв.

Гэрэл зургаар баримтжуулан 3-р үеийн маллагыг өмнө илэрсэн толбоны дагуу үргэлжлүүлэхэд тус бүр хайрган чулуун чигжээстэй 5 ш зууван дугуй нүх бүхий зохион байгуулалт илэрч №4-р нүхний амсрын орчмоос бог малын сүүжний хугархай гарав. Бид уг нүхнүүдийг ертөнцийн зүгээр урдаас хойш чигтэй дугаарлав. Эдгээр нүхнүүд

бараг нэг эгнээнд бөгөөд 340 хэмийн чигт хандсан. Үүнийг хөндлөн огтлолын зурагт оруулахын тулд нэмэлт тэнхлэгийг А1 цэгээс баруун тийш 85 см зайд В цэгийг үүсгэн шилжүүлж хүхнүүдийн төв хэсгээр дайран гарсан тэнхлэгийг татан гар зургийг хийв.

Малтлагын 4-р үед тус 5 ширхэг хүхний доторх чулуудыг авч малтлагыг үргэлжлүүлэхэд №1 дугаартай хүхнээс хэсэг модны үлдэгдэл төв дундаас нь илрэв. Харьцангуй дөрвөлжиндүү хэлбэртэй, гүехэн. Хэмжээ: 110x80x80 см. №2-оос 1 ш богийн асуух нурууны яс, жижиг модны үлдэгдэл гарав. Жижгэвтэр, дугуй хэлбэртэй. Хэмжээ: 85x85x88см. №3-аас мөн адил жижиг модны үлдэгдэл. Уртлаг, зууван дугуй ба гүехэн. Хэмжээ: 94x75x86 см. №4 Хоосон. Зууван дугуй хэлбэртэй. Хэмжээ: 100x95x78 см. №5-ын баруун ханаас бага зэрэг нүүрс гарсан боловч мөн адил хоосон. Дугуйвтар хэлбэртэй. Хэмжээ: 106x80x78 см.

ДУРСГАЛ №2014-2. Дээрх дурсгалаас баруун урагш орших Цэнгэл хэлбэрийн дугуй хүрээтэй байгууламж бөгөөд зүүн талдаа 85 см зайд хөшөө чулуутай юм. Хүрээний хойд хэсэгт байх зууван дугуй хэлбэрийн байгууламжийг хавтгай, голын хайрган чулуудыг уртааш нь босгон газарт зоож хийсэн бөгөөд үүний баруун хойд талд нэгэн бусдаасаа арай томхон хөшөө бололтой чулуунд №2 гэсэн дугаар өгөв. Дугуй хүрээний баруун урд талд бас нэг хөшөө бололтой тусдаа чулуу буйд №3 гэсэн дугаар өгөв. Хүрээний чулууд нэлээд хөрсжиж зарим хэсэг тодорхой сайн мэдэгдэхгүй байв.

Малтлагын 1-р үед тахилын байгууламжийн зохион байгуулалт маш тодорхой гарч ирлээ. Ерөнхийдөө Цэнгэл хэлбэрийн дурсгал баруун, зүүн талаараа тасалдсан байдаг бөгөөд тус хүрээн дотор буй зууван дугуй байгууламжийн өмнө талд гол тэнхлэгийн дагуу гал түлсэн ором байдаг. Дугуй хүрээний хойд хагаст орших зууван дугуй байгууламжийн хүрээг мөн хавтгай саарал чулуудаар босгож хийсэн бол хойд талд нь 5 ш хавтгай (хүрээг хийсэн чулуудыг бодвол том) чулууг уртааш нь буюу гонзгой талаар дээш босгон зоожээ. Эдгээрийн голд том цагаан хайрган чулууг буюу хөшөө чулуу №2 бий. Дугуй байгууламжийн зүүн талд буюу хаалганы харалдаа 85 см зайд №1 дугаартай хөшөө байх бөгөөд хугарсан байдалтай илрэв. Мөн баруун урд талд нь 1 ш хайрган чулуу хүрээний гадна талд байх нь хөшөө чулуу №3 юм. Тус хайрган чулууны нэг тал хагарсан бөгөөд хагарсан талыг доош харуулан тавьжээ.

Хойд талын зууван дугуй байгууламжийн өмнө 57-68x115 см хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэртэй талбайд 5 см гүнтэй шалгаж үзэхэд 60x80 см хэмжээтэй толбонд 3 см зузаан галын ором илэрсэн болно. Эндээс шатсан модны хэсгүүдээс он цаг тогтоох дээж авав. Хойд талын зууван дугуй байгууламжийн дотор талд шалгалт хийхэд юу ч илэрсэнгүй боловч №2 дугаартай хөшөө чулууны өндөр 57 см болох нь тодорхой болов.

Чулуун байгууламжийг хавтгай, нарийн, жижгэвтэр чулуудаар хийсэн. Хэмжээ: хойноос урагш 5,5 м, баруунаас зүүн тийш 4,4 м. Дугуй хүрээний төвийн хойд хэсэгт зууван дугуй хэлбэртэй байгууламж байх бөгөөд 1,7 м урт, 1,5 м өргөн. Хүрээний зүүн талын тасархайн урт 65 см, баруун талынх 55 см. Хөшөөний хэмжээ: №1. Өргөн 22 см, зузаан 20 см, өндөр 23 см, №2. Өргөн 27 см, зузаан 16 см, өндөр 35 см, №3. Урт 28 см, өргөн 32 см, зузаан 16 см.

СОРЬЦЫН СУВАГ. Баруун, зүүн чигтэй 6x2 м талбайд 20 см гүнтэй шуудуу малтан шалгахад ямарч нүх толбоны зүйл мэдэгдсэнгүй. Тус шуудуунаас баруун тийш 3 м зайд хагас дугуйрсан байдлаар хиргисүүрийн тахилгын дагуул болох 8 чулуут жижиг дугуй байгууламж бөгөөд зэрэг булшны дараас байж болзошгүй хэсэг хавтгай чулууд байсан тул шалгалт хийсэн болно.

ЦАГААН АСГА-2. Хар чулуутын голын баруун эрэг, ертөнцийн зүгээр голын хойд талын өргөн дэнж дээр Хар чулуутын голын бетонон гүүрнээс баруун хойш зүгт 2 км

зайд энэхүү дурсгалт газар оршино. Энд нийт 3 булш бий. Эдгээрийг бид зүүн урд талаас нь дугаарлаж 1-р ба 3-р булшийг малтан судлав.

1-р булш. Дугуй хэлбэртэй, хавтгай чулуун дараастай булш байсан бололтой. Харамсалтай нь зэргэлдээ байх орчин үеийн казах иргэдийн булшнуудад их хэмжээгээр чулууг нь авч хэрэглэсэн тул анхны хэлбэр төрх нь алдагдсан байна. Дараасын зах ба төв хэсгээр илүү овгор, харин баруун талаараа дараас нимгэн, чулуу цөөтэй юм. Хэмжээ: баруунаас зүүн тийш 7,3 м, хойноос урагш 7 м. Дараасын төвд 3 ш хавтгай чулууг гурвалжлан өрж хийсэн нь ажиглагдав. Маллагын 1-р үеийг гүйцэтгэхэд дараасын баруун талаар бага зэрэг хөрс нь цайвар болоод чулуугүй байв. Мөн дараасын баруун зах орчимд хавтгай чулууг урдаас хойш чигтэй уртааш нь хавиргалан зоосон байна. Дараасын төв хэсгийн зүүн талаас 1 ш шавар савын хагархай /№1/, бог малын далны ясны хагарсан хэсэг 1 ш тус тус гарав. Түүний баруун талаас шавар савын ёроолын хэсэг, төв хэсгээс хэд хэдэн хагархай гарав. Дээрх шавар савны хагархайнуудад нэгдсэн нэг дугаар /№1/ өгөв. Дараасын баруун захад дахин хавтгай чулуудаар гурвалжлан өрсөн байсны зүүн хойд талын хавтгай чулууг нь урьд дараас чулууг тонох явцдаа авч хаясан бололтой. Хөндлөн огтлолыг хойноос урагш чигтэйгээр гаргасан бөгөөд дараасын төв хэсэгт хавтгай, том чулуудыг уртааш нь зүүн урдаас баруун хойш чигтэй зууван дугуй хэлбэр гарган тойруулан тавьж хүрээ гарган, төв хэсгийг нь хөндлөөш нь тагласан байгууламж илрэв. Түүний дээр тус байгууламжийн зүүн урд хэсэгт өмнөх гурвалжин байгууламж бий. Чулуун дараасыг нэг үе голын хайрган болон хавтгай чулуудыг ашиглан хийсэн байна.


Маллагын 2-р үед тэнхлэгийн баруун хэсгийн буюу үлдсэн дараасыг хуулж хүрээг үлдээхэд дараасын төвд зүүн урдаас баруун хойш чигтэй хавтгай чулуун дараас бүрэн гарав. Дугуй хүрээг хайрган чулуугаар тойруулан хийсэн нь үе үе тасалдсан байдалтай болжээ. Булшны төвийн чулуун байгууламжийн хэмжээ: 3,8x1,8 м. Маллагын 3-р үеийг гүйцэтгэн чулуун дараасыг хуулахад зүүн урдаас баруун хойш маягтай хайрган чулуун чигжээстэй оршуулгын нүх илрэв. Нүхний дотор хойд талд уртааш нь нимгэн хавтгай, урт чулууг хийн урд талаар нь хайрган чулуугаар битүү чигжсэн байв. Маллагын 4-р үеийг гүйцэтгэн хайрган чулуудыг хуулж оршуулгын нүхний хэлбэрийг хөөн малтаж хойд талын хавтгай чулууны суурийг гаргав. Энэ үед тус чулууны хойд талд оршуулгын нүхний үргэлжлэл бололтой толбо байна. Тус хавтгай чулууны баруун талын суурийг арай жижгэвтэр хавтгай чулуугаар хашиж тулган тавьсан байх бөгөөд хойд хэсгийг тусгаарлан хамгаалсан мэт сэтгэгдэлийг төрүүлнэ. Маллагын 5-р үед тус хавтгай чулууг хуулан үргэлжлүүлэхэд дахин 2 ширхэг хавтгай чулууг давхарласан байдлаар тавьсан байх нь илэрсэн бөгөөд энэ түвшинд эх газрын хөрс гарав. Мөн оршуулгын нүхний хойд талын гадна зах үл ялиг хойш тэлсэн ба чулуун дараасын баруун захын хөрсөн дотроос хүний гавлын яс цухуйв. Энэхүү оршуулгын нүхийг хойш чигтэй ташуудан хавсан байдлаар буюу хөмөглөн ухаж оршуулгаа хийсэн байна. Маллагын 6-р үеийг үргэлжлүүлэн чулуудыг хуулан авахад нарийн жижиг нүхэнд хүнийг толгойгоор нь баруун хойш хандуулан тэнэгэр байдлаар оршуулсан оршуулга илрэв. Нүүрээр зүүн хойш харуулжээ. Гавал, зүүн гарын шуу, 3 ширхэг нуруу, хөлийн яс буюу бөгсөн биеийн хэсэг анхны байрдалаараа гарсан бол баруун гарын (?) бугалга, 1 ширхэг нуруу байх нь хөдөлж анхны байрлалаа алдсан байна. Цээжний орчмын яс байхгүй. Хоёр хөлийн тавхайн орчим хүний хавирга нэг, хоёр хөлийн гуяны дотор талд хэсэг нурууны (?) яс бий. Мэрэгч эдгээр яснуудыг хөдөлгөсөн бололтой. Нүхний хэмжээ: 300x180 см. Дотор жижиг нүхний хэмжээ: 205x50 см. Үеийн гүн: 110 см.



Зураг 2. 2-р булшны малтлагын үеүдийн зураг



Зураг 3. 2-р булшны оршуулга илэрсэн байдал



Зураг 4. 6-р булшны чулуун дараасны дэвсгэр зураг ба хөндлөн огтлол



Зураг 5. Дурсгал №1.




Зураг 6. Дурсгал №2



Зураг 7. Цагаан Асга-II дурсгалын 1-р булш



Зураг 8. Цагаан Асга-II дурсгалын 1-р булшны оршуулга



Зураг 9. Цагаан Асга-I дурсгалын 15-булшны дараас чулууны фотограмметрийн дүрслэл

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН „СОЁЛЫН ӨВИЙГ СУДАЛЖ,
ХАМГААЛАХ“ ТӨСЛИЙН 2014 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
АЖЛЫН УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

*Д.Цэвээндорж, Н.Батболд, Б.Дашдорж
Бён Ён Хуан, Вүэ Мен Хуан.*

Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн БНСУ-ын Соёлын Өвийн Үндэсний хүрээлэнтэй хамтран „Соёлын өвийг судалж хамгаалах нь” эрдэм шинжилгээний төслийг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд 2009-2013 онд Говь-Алтай аймгийн Чандмань, Бигэр, Халиун, Баян-Уул, Төгрөг, Бугат, Тонхил, Дарви, Есөнбулаг, Эрдэнэ, Цогт, Алтай, Шарга, Цээл, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Дэлгэр зэрэг сумдын нутгаар археологийн хайгуул судалгааг явуулж тухайн бүс нутагт буй археологийн дурсгалуудыг илрүүлэн бүртгэж баримтжуулах ажил хийсэн. Археологийн хайгуул судалгааны явцад Говь-Алтай аймгийн 18 сумын нутгаас нийт 4327 дурсгал олж илрүүлж улмаар „Монголын соёлын өв” 4 боть цуврал тайланг хэвлүүлээд байна.

2014 онд Монгол-Солонгосын хамтарсан төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутаг Зүрх ууланд буй хүрэл зэвсгийн болон хүннүгийн үед холбогдох оршуулгын дурсгалт газар маллага судалгаа, Жаргалан сумын нутагт археологийн хайгуул судалгааг үргэлжлүүлэн хийлээ.

Монгол-Солонгосын хамтарсан хээрийн шинжилгээний анги Зүрх ууланд буй эртний булш оршуулгын дурсгалыг археологийн арга зүйн дагуу малтан шинжилж, түүх соёлын дурсгалыг судлах зорилгоор 2014 оны 6-р сарын 08-наас 6-р сарын 22-ны өдрийг дуустал 15 хоногийн хугацаатай ажиллав.

МАЛЛАГА СУДАЛГАА

Говь-Алтай аймгийн нутаг Жаргалан сумын төвөөс зүүн хойш 5 орчим км зайд „Зүрх” хэмээх бараантан харагдах намхавтар уул бий. Энэхүү ууланд Монгол нутагт амьдарч байсан эртний нүүдэлчдийн үлдээсэн олон үеийн дурсгал ихтэй бөгөөд түүнийг тойроод нийт 320 орчим хүрлийн үеийн булш, хиргисүүр, Хүннүгийн үед холбогдох 58 жижиг булш бүхий оршуулгын газар байдаг.

Монгол-Солонгосын хамтарсан хээрийн шинжилгээний анги Зүрх уулын орчимд эртний нүүдэлчдийн таван булшийг малтан судлав. Эдгээр нэг нь хүрлийн үеийн булш байсан бол бусад нь Хүннү улсын (НТӨ III-МЭ I зуун) үед холбогдоно.

Хүрлийн үеийн дурсгал.

1-р булш. Зүрх уулын дунд орших Дэл-Улаан уулын өвөрт тархан байрласан Хүрэл зэвсгийн үед холбогдох (НТӨ 3000 жил орчим) бүлэг дурсгалаас дугуй хэлбэрийн чулуун хүрээтэй, төв хэсэгтээ зууван дугуй хэлбэрийн жижиг хашлагатай булшийг сонгон малтав. Голч хэмжээ: 400 см. Булшны дараас нь багавтар чулуудаар дүүргэж, гадуур нь том чулуудыг цагариглуулан өрж үйлдсэн хүрээтэй болох нь мэдэгдэв (Зураг-1). Дараасны голд баруунаас зүүн тийш чиглэлтэй зууван дугуй хэлбэрээр эгнүүлэн өрсөн жижиг хашлага гарав. Газрын өнгөн хөрсний түвшнээс доош 30 см

гүнд толгойг нь баруун тийш хандуулан, нүүрийг нь хойд зүгт харуулж хажуу талаар нь хоёр хөлийг нь нугалж тавьсан хүний оршуулга илрэв (Зураг-2). Ясны хадгалалтын байдал сайн. Оршуулганд дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл гарсангүй.



Зураг-1. Өнгөн хөрсийг цэвэрлэсний дараа.




Зураг 2. Оршуулга

Хүннүгийн үеийн дурсгал.

Зүрх уулын баруун урд талын намхавтар уулыг Элст толгой гэх бөгөөд энэ толгойн хойд тал болон баруун энгэрт Хүннү улсын (НТӨ III - НТ I зуун) үед холбогдох нийт 58 жижиг булш бүхий оршуулгын газар бий. Тус шинжилгээний анги эдгээр дурсгалаас баруун энгэрт гурав, хойд талд нэг булшийг сонгон малтлага судалгаа хийлээ.



Зураг 3. Зүрх уулын Элст толгойн Хүннүгийн дурсгалууд.



Зураг 4. Зүрх уулын Элст толгойн Хүннүгийн дурсгалуудын дэвсгэр зураг.

1-р булш. Зүрх уулын баруун салаа болох Элст толгой хэмээх өндөрлөг хадан уулаас баруун хойд зүг рүү намсаж тогтсон дэл хадтай довцогийн ар шил дээр, хойд уулаас уруудаж буусан нар ээвэр налуу энгэрт бусад дурсгалаас ганцаар өндөрлөгт сондгой орших хүрэн болон саарал өнгийн том боржин чулуугаар үйлдсэн дугуй хэлбэрийн том цагариган хүрээтэй, голдоо хонхортой булш юм. (Зураг-5). Үг дурсгалын голч 9 м. Хадгалалтын байдал дунд зэрэг. Малтлагын явцад чигжээс чулуудын завсраас 2 төрлийн ваарны их бие, амсар, ёроолын хагархай хэсгүүд гарч байв. (Зураг-6).



Зураг-5. Өнгөн хөрсний цэвэрлэгээний дараах байдал.



Зураг-6. Оршуулгын нүхний чигжээс чулууд

Малтлагыг үргэлжлүүлэн газрын өнгөн хөрсний түвшнээс доош 360 см гүнд хүрэхэд зүүн хойд зүгт 30° чиглэлтэй авсны дээд хэсэг буюу банзан тагны орой илэрсэн (Зураг-7) ба түүнийг оршуулгын нүхний голд байрлуулж хажуу талын хөндий

зайг улаан хүрэн өнгийн жижиг хад чулуудаар завсаргүй чигжиж хамгаалсан нь модон авс хэвээ алдалгүй хадгалагдаж үлдэх нөхцөл болжээ. Оршуулгын нүхний хойд хана дагуух хөмөгнөөс хонины толгой болон богийн бусад ясууд олон тоогоор гарч байв. Хашлагыг тагласан хөндлөн банз нь дунд болон хойд хэсэгтээ цөмөрч хугарсан нь тонуулчдын ул мөр бололтой.



Зураг-7. Бунханы таг илэрч буй байдал



Зураг-8. Гадна талын бунхан

Цөмөрч орсон тагны завсраар дотор нь жижиг модон авставьсан нь харагдаж байв. Гадны талын бунханыг дүнз модыг засч тэгшлэн, үзүүр хооронд нь эр, эм углуурга гарган холбож хийсэн байна (Зураг-8).

Доторх жижиг авсны тагийг авч оршуулгыг цэвэрлэн нээх явцад тоногдсоны улмаас хүний яс энд тэндгүй гарч байв. Дотор талын авсны зохион байгуулалт, хийц нь тун нарийн, үр дүйтэй хүний гараар бүтсэн нь илэрхий харагдана (Зураг-9). Авсны банзыг зүйж тогтоохдоо төмөр хадаас хэрэглэлгүйгээр хоёр талдаа их талтай эрвээхэй дүрст углуурга гарган холбож (Зураг-10, 11), үзүүрийг нь мөн гадна хашлаганы адил эр, эм углуурга гарган бэхэлжээ (Зураг-12). Авсны таг, хана, шал бүгдийг эрвээхэй хэлбэрт углуургаар холбосон байна.



Зураг-9. Давхар авс



Зураг-10. Эрвээхэй хэлбэрийн углуурга



Зураг-11. Эрвээхэй хэлбэрийн углуурга



Зураг-12. Углуургыг бэхэлсэн шаантаг

Булшны гадна бунханы дотроос 3 талт хүрэл зэв, ясан булцуу бүхий их биенд нь гурван нүх гаргасан дуут сүмны зэв, авсны дотор талаас торгон хувцасны тасархай, хувцас хэрэглэлийн бүч бүслүүр байсан бололтой даавуу эдлэл, нимгэн модон эдлэл, даавуунд ороосон зэвэрч муудсан төмөр эдлэл, төмөр хошуутай, модон иштэй ооль гарав. Уг оолины ишийг нь бургас модоор хийж хар будгаар буджээ (Зураг-13). Оолины толгойг нь хуш (?) модоор үйлдэн доод үзүүрт нь хөндлөн төмөр ир зуулган бэхэлжээ (Зураг-14).

Энэхүү модон иштэй, төмөр иртэй ооль нь Монгол дахь Хүннүгийн үеийн булш оршуулганаас илэрч буй анхны тохиолдол юм. Урьд өмнө зөвхөн хиргисүүрийн өнгөн хөрсний цэвэрлэгээнээс л хүрэл ооль илэрч байв. Уг олдвор нь Хүннү нарын мод боловсруулах, үйлдвэрлэх, модон эдлэлийн үйлдвэрлэлийн хөгжил, онцлогийг харуулах анхны олдвор болж буйгаараа онцлог юм.



Зураг-13. Авсан дотроос гарсан ооль



Зураг-14. Ооль

Маллагын явцад гадна бунханы толгойн хэсэг дэх хөмөгнөөс хонины толгой 10 гаруй (хонины толгой бүгд эвэртэй байсан), чий будагтай модон аяганы тал хэсэг, ясан хямсаа 2 ширхэг, нумны ясан наалт, үйсэн саадагны үлдэгдэл, үйсэн савны дугуй ёроол, хүрэл бүсний арал, хүрэл цагариг, эвдэрч зориулалт нь мэдэгдэхгүй болсон төмөр эдлэлийн хугархай хэсгүүд, нум сүмны мөс модны хугархай хэсгүүд, гурван дэлбээт төмөр зэвнэг ширхэг, нарийн хавтгай зүссэн модон эдлэл гарсан ба үжирч бутарсан хүний ясны үйрмэгүүд авсан дотор тархжээ.

Тонуулчид хүний шарилыг жижиг авсны толгойн талын зайд чирж гаргаад тэр чигт нь орхижээ. Гадна бунхан болон авсны аль алинийг нь будаж, чимэглээгүй ажээ.

Урьд өмнө нь үүнтэй төстэй авс бүхий хүннү булшийг манай орны судлаачид дангаар болон гадны эрдэмтэдтэй хамтарсан судалгааны экспедицийн хүрээнд малтан судалж байжээ.

1986 онд археологич Д.Цэвээндорж тэргүүтэй ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн „Хүннүгийн дурсгал судлах” хээрийн шинжилгээний анги Говь-Алтай аймгийн Цогт сумын төвөөс зүүн хойш 3 км-т Хиргист хоолой хэмээх газарт нийт 97 Хүннү булштай дурсгалт газар шинээр нээн илрүүлсэн бөгөөд эндээс нийт 5 булш малтан судалжээ. Тус оршуулгын газрын 4-р булшнаас гарсан авсны урт талыг 4-5 см зузаантай, 60 см хүртэлх өргөнтэй ганц ганц өргөн банзны буланг углуургадан хийжээ. Харин хөл ба толгой талыг тус бүр хоёр банзыг хооронд нь дамар /эрвээхэй/ хэлбэрийн модон холбоогоор холбосон байна. Авсны хажуугийн хоёр хананы ирмэгт тус бүр 2 углуурга гарган, түүнтэй харалдаа таганд мөн 4 нэвт углуурга гарган модон шаантаг хийж таг авс хоёроо бэхэлсэн байна [Цэвээндорж, 2003: 213].

Мөн ийм хэлбэрийн австай Хүннүгийн дурсгалыг 2008, 2010 онд Монголын Үндэсний Музей, АНУ-ын Пенсильваний Их Сургуультай хамтарсан хээрийн шинжилгээний анги Ховд аймгийн Шомбуузын бэлчир буюу Дээд хөх заагийн аманд буй 15 хүннү булш малтан судалснаас 2010 онд малтсан 8-р болон 2008 онд малтсан 15-р булшнаас илэрсэн авсны банзыг эрвээхэй буюу дамран дүрстэй углуургаар тогтоон бэхэлсэн байжээ [Миллер нар, 2011: 156-161].

Эндээс үзэхэд авсны банзыг тогтоосон эрвээхэй хэлбэрт углуурга Монгол Алтай орчмын Хүннүгийн дурсгалд тааралдаж буй нь анхаарал татаж байна. Бидний малтан судалсан давхар австай булш нь Зүрх уулын Элст толгойд буй бусад дурсгалаас зайдуу өндөрлөг газарт сондгой орших хийгээд малтлагаар илэрсэн олдвор хэрэглэгдэхүүний байдлаас үзэхэд тухайн орон нутгийнхаа бүлэг иргэдийн дунд нэр нөлөөтэй, зонхилоч ноёлох давхаргын нэгэн байсан бололтой.

21-р булш. Элст толгойн баруун өвөрт орших бүлэг булшны хойд хэсэгт орших хүрэн улаан өнгийн дунд зэргийн чулуугаар үйлдсэн дугуй хэлбэрийн цагариган хүрээтэй, голдоо хонхор дараастай булш юм. Булшны голч хэмжээ: 550 см (Зураг-15).



Зураг-15. Өнгөн хөрсний цэвэрлэгээний дараах байдал.



Зураг-16. Оршуулга илэрсэн байдал.

Газрын өнгөн хөрсний түвшнээс доош 50 см гүнд зүүн хойд зүгт чиглэл бүхий 190x80 см хэмжээтэй толбоны ормоор маллагыг үргэжлүүлэхэд 200 см гүнд нүхний төв хэсгээс их биенээсээ салж хөндөгдсөн нүүрэн талыг нь урагш хандуулан орхисон хүний гавлын яс илэрсэн. Гавлын ясны байдлыг үзэхэд хадгалалт сайн, эрүүний яс залгаатай хэвээр, төрх байдлыг ажихад монголжуу төрхийн эмэгтэй хүн бололтой. Хажуу талаас нь хүний далны яс, ваарны хагархай хэсгүүд гарч байв. Эдгээр олдворын доороос оршуулгын нүхний дагуу тавьсан модон авсны дээд хэсэг гарсан. Хүний бодгаль нь толгой, гарын яснаас бусад нь хөндөгдөөгүй, тэнэгэр байдалтай илрэв. Авсны дунд хэсэгт шатаалт сайтай, тортог болсон вааран аяга, хонины толгой,

эрүүний ясны хамтаар илрэв (Зураг 16). Мөн зориулалт нь мэдэгдэхгүй болтлоо зэвэрч исэлдсэн хавтгай төмөр эдлэлийн хугархай хэсгүүд гарав. Маллагын гүн-267 см. 52-р булш. Зүрх уулын Элст толгойн баруун бэлд буй бүлэг дурсгалын баруун захад орших хоорондоо дараас чулуудын зах хөвөөгөөр залгагдсан хойноос урагш цувраа байдалтай харагдах дугуй хэлбэрийн том жижиг хоёр булшийг сонгон авч малтсан бөгөөдурд талын буюу багавтар булшийг 52, хойд талын арай том булшийг нь 53 хэмээн дугаарлав. 52-р булшны голч: 400 см (Зураг-17). Ойролцоогоор 80 см гүнээс оршуулгын нүхний 200х90 см хэмжээтэй толбо мэдэгдсэн бөгөөд 100 см гүн дэх чигжээс чулуудын доороос оршуулгын дээд хэсэг илэрч эхлэв. Оршуулгын зүүн талаар жижгэвтэр чулуудыг давхарлан хашлага үйлдсэн нь үлдсэн байх бөгөөд бусад талын хашлага чулууд нь хөндөгдөн таржээ. Хашлаганы дотор талаас тоногдож хоцорсон хүний яснууд эмх замбараагүй байдалтай илрэв (Зураг-18).



Зураг-17. Өнгөн хөрсний цэвэрлэгээний дараах байдал



Зураг-18. Оршуулга илэрсэн байдал.

Гавал болон биеийн яс, аарцагны ясны бэхжээгүй байдлаас үзэхэд 10-12 орчим насны хүүхэд ажээ. Оршуулгын хамт амсар, их биеийн тал хэсэг нь хагарсан жижгэвтэр шавар сав, төмөр эдлэлийн хэсгүүд илрэв. Өөр дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл илэрсэнгүй.

53-р булш. Өмнө малтсан 52-р дурсгалын хойд талд залган орших хүрэн улаан өнгийн чулуугаар үйлдсэн цагариг хэлбэрийн дараастай булш юм. Голч хэмжээ: 620 см (Зураг-19). Цэвэрлэгээний явцад булшны дараасны дундаас улаан өнгийн шавар ваарны амсар, эргэх хүрдний оромтой ёроол, их биеийн хагархай хэсгүүд гарч байв.



Зураг-19. Өнгөн хөрсний цэвэрлэгээний дараах байдал.



Зураг-20. Оршуулга илэрсэн байдал.

Булшны нүхэн дэх чигжээс чулуудыг авч малтахад 170 см гүнд хүний оршуулганд хүрэв. Нүхний хэмжээ: 240x80 см. Чанх хойд зүгт хандуулан тавьсан модон авсан дахь хүний оршуулгыг тонож ясыг нь эмх замбараагүй орхижээ (Зураг-20). Хүний толгой, гар, их биеийн яс хөндөгдсөнөөс бус аарцаг, хөлийн ясууд анатомийн байрлалаа хадгалж үлджээ. Нас барагчийн хоёр хөлний завсар зориулалт нь төдий л тодорхой бус хавтгай ясан эдлэл тавьсан нь сонирхолтой байв. Мөн хүний баруун ташааны дагуу тавьсан төмөр зэвтэй сүмны хугархай, ууцны орчмоос бүсний төмөр арал, дөрвөн дэлбээт авсны төмөр чимэглэлүүд гарсан. Харин авсны толгойн хэсэгт адууны зүлд хойлоглон тавьсан нь бага зэрэг хөндөгджээ. Адууны толгойг хоншоор талыг нь зүүн тийш хандуулан хөндлөн тавьсан байх ба шанаа орчмоос хазаарын төмөр цагариган хоёр зуузай, амгайн хамт олдов. Авсны банз мод өмхөрч муудсан хүрэх төдийд бутарч байсан ба гадна талаар нь багавтар чулуудыг хоёр давхарлан өрж хашлага хийсэн ажээ.

ХАЙГУУЛ СУДАЛГАА

Монгол-Солонгосын хамтарсан „Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн судалгааны баг 2013 онд хийсэн ажлаа үргэлжлүүлэн Жаргалан сумын нутагт археологийн хайгуул судалгаа хийж нийт 23 газрын дурсгалыг бүртгэн баримтжуулаа.

Судалгааны баг Жаргалан сумын нутаг дахь Тээг толгой, Хүнхэрийн амны урд боомын Улаан чулуут, Хонгор, Хүнхэрийн ам, Улаан булаг, Долоон тогооны агуй, Цахирын овоо, Цагдуултайн гол, Зайвар, Цахир уул, Дөрөө уул, Дөрөөний хөтөл, Нар уул, Бударгана, Хаяа, Бүрэн хайрхан зэрэг газруудад буй эртний нүүдэлчдийн түүхэнд холбогдох булш, хиргисүүр, хөшөө чулуу, хийдийн түүрх зэрэг олон дурсгалыг бүртгэн баримтжуулав.



Зураг 21. Цахирын овооны хиргисүүр



Зураг 22. Хонгорын хүрээний хийдийн туурь



Зураг 23. Улаан булагийн дурсгал



Зураг 24. Дөрөөний хөтөл



Зураг 25. Нар уулын хиргисүүр



Зураг 26. Бударгана уулын булш



Зураг 27. Хаяагийн хөшөө чулуу



Зураг 28. Бүрэн хайрханы хиргисүүр

Дүгнэлт

Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, БНСУ-ын Соёлын Өвийн Үндэсний хүрээлэнтэй хамтарсан „Соёлын өвийг хадгалж хамгаалах” эрдэм шинжилгээний төслийн хүрээнд судалгааны багийн хамт олон 2014 оны зун Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутаг Зүрх ууланд Хүрэл зэвсгийн үеийн булш нэг, Хүннүгийн үеийн булш дөрвийг малтан шинжлэв. Энэ удаагийн малтлага судалгааны дүнд 1-р булшнаас модон иштэй, төмөр ир бүхий ооль илэрсэн нь эртний Хүннү нарын мод боловсруулах, үйлдвэрлэх, модон эдлэлийн үйлдвэрлэлийн хөгжил, онцлогийг харуулах анхны олдвор болж буйгаараа онцлог болсон юм. Уг булшин дахь өөд болоочийг оршоосон давхар модон бунхантай авс, дагалдуулсан эд өлгийн зүйл зэргээс үзэхэд тухайн орон нутагтаа нөлөө бүхий зонхилоч нэгэн байжээ гэж үзэж болохоор байна.

Элст толгойн баруун өвөрт малтсан Хүннүгийн үед холбогдох эдгээр дөрвөн булш бүгд тоногдсон байсан хэдий ч оршуулгын дотоод зохион байгуулалтын хувьд бүгд өөр, тухайлбал, давхар модон бунхантай австай, дан модон австай, чулуун хашлагатай, гадуураа чулуун хашлагатай модон австай болно. Булшнаас илэрсэн хүний яс, дагалдуулсан эд өлгийн зүйлс, оршуулгын зан үйлийн онцлог нь Хүннүгийн археологийн судалгаанд бас нэгэн шинэ материал болон нэмэгдэж байна.

Мөн Жаргалан сумын нутагт археологийн хайгуул судалгаа хийж нийт 23 газрын дурсгалыг өмнө хийсэн судалгаанд нэмж бүртгэн баримтжуулаа.

Тус төслийн хүрээнд генетикийн судалгааны баг¹ 2014 оны 06 дугаар сарын 23-наас 07 дугаар сарын 04-ны хооронд Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Жаргалтхаан, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Баянхутаг, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Онгон, Асгат, Баяндэлгэр, Түвшинширээ, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумдын нийт 245 ард иргэдээс шүлсний дээж авч лабораторийн судалгаа шинжилгээнд явуулсан. Энэ бүхний үр дүнг тусад нь нийтлэх болно.

НОМ ЗҮЙ

- Миллер нар, 2011 - Браян Миллер, Ж.Баярсайхан, Ц.Эгиймаа, П.Б.Коновалов, Жохенсон Эрик, Мишел Махичек, Жүди Логан, Клейр Нейли. Шомбуузын бэлчир дэх Хүннүгийн дурсгал. // Нүүдэлчдийн өв судлал. Улаанбаатар, 2011, тал 156-183.
- Цэвээндорж, 2003 - Д.Цэвээндорж. Хиргист хоолой, Онъольтын хүннү булш. // Монголын археологийн судалгаа (эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл. 1983-1992). Боть II. Улаанбаатар, 2003, тал 209-228.

¹ Судалгааны багт монголын талаас Археологийн хүрээлэнгийн ЭША Ц.Амгалантөгс, Л.Дэлгэрмаа нар, Солонгосын талаас доктор Со Мин Сог нарын 3 судлаач оролцон ажилласан.

2014 ОНЫ МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН
 „ДОРНОД МОНГОЛ: АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА“
 ТӨСЛИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГЭЭС

Ч.Амартүвшин, Г.Галган, У.Ханичёрч, Ж.Врайт

Монгол-Америкийн хамтарсан „Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа“ төсөл нь 1997-2000 онуудад Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын хөндийд ажигласан „Умард Монгол“ төсөл, 2003-2008 онуудад Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулуунд ажигласан „Өмнөд говийн бүсийн археологийн судалгаа“ төслийн үргэлжлэл мөн билээ. Уг хамтарсан төслийн багийнхны гол зорилго бол эртний нүүдэлчдийн төрт улсын нийгэм, эдийн засгийн зохион байгуулалтыг археологийн хэрэглэгдэхүүнээр тодруулах явдал юм. Энэхүү зорилгот хүрэхийн тулд Монголын газар зүйн хувьд ялгамжтай бүс нутгуудад үе шаттайгаар археологийн хайгуулын арга зүйг шинээр боловсруулж эртний нүүдэлчдийн бууц суурин, булш оршуулга, хөшөө дурсгалыг шинээр илрүүлэн олж мэдээллийн санг бүрдүүлэх, шинжлэх ухааны олон талт нягт судалгааг гүйцэтгэдэг билээ.

Хамтарсан төслийн хүрээнд Дорнод Монголын нутагт буй археологийн цогцолбор дурсгалт газар болох Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань Хар уулыг сонгон авсан нь *нээгдүгээрт*, Дорнод Монголын бүс нутаг нь эртний нүүдэлчдийн дурсгалаар арвин баялаг, тухайн чиглэлээр судалгааны ажил тодорхой хэмжээнд хийгдсэн нь хайгуулын арга зүйг шинээр боловсруулахад таатай нөхцлийг бүрдүүлнэ. *Хоёдугаарт*, тухайн сонгосон газрууд нь Дорнод Монголын бүс нутгийн олон үед хамаарагдах дурсгалт газрын сайн жишээ болохуйц газар мөн бөгөөд ялангуяа Хүннүгийн үед холбогдох булш оршуулгын дурсгалт газрын хамгийн зүүн талын хязгаар хэмээн одоогоор тодорхойлогдоод байгаа билээ. *Гуравдугаарт*, тус төслийн багийнхан умард болон өмнөд бүс нутаг дахь хүннүгийн бууц суурин, булш оршуулгын дурсгалын судалгааг олон жилийн хугацаанд хийж гүйцэтгэж тодорхой хэмжээний туршлага хуримтлуулсан. Энэ удаад дорнод талын хүннү нарийн аж ахуй, нийгмийн байдлын талаар шинэ хэрэглэгдэхүүнийг цуглуулан бүс нутгийн харьцуулсан судалгаа хийх таатай боломж нээгдэнэ хэмээн үзэв. *Дөрөвдүгээрт*, өмнөх төслүүдэд тодорхой хязгаарлагдмал хүрээнд нэг газрыг сонгон авч нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэж байсан бол энэ удаад газар зүйн байдал, дурсгалт газрын байршлаас хамааран 100 гаруй км зайтай орших Дэлгэрхаан уул (DKU), Чандмань Хар уул (СКУ) гэсэн хоёр дурсгалт газрыг оруулан 160х80 км хэмжээтэй талбайг сонгон авав. Урьдчилсан байдлаар тухайн сонгосон талбайд орсон хоёр том цогцолбор дурсгал гадна тэднээс тодорхой зайтай өөр жижиг хэмжээтэй дурсгалт газрууд байгаа болохыг харж болно. Эдгээр том хэмжээтэй цогцолбор дурсгал, жижиг хэмжээтэй дурсгалт газруудын хоорондын холбоо, том хэмжээтэй дурсгалт газруудын хооронд холбоо зэргийг тодруулахад чиглэгдэнэ. *Тавдугаарт*, бүс нутгийн онцлогт тохирсон хайгуулын арга зүйг шинээр боловсруулах, үр дүнг нэгтгэсэн мэдээллийн санг бий болгосноор Монголын археологийн судалгааны арга зүйд шинэ зүйл болно хэмээн үзэж байна.

Хамтарсан төслийн баг 2013 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан ууланд хайгуул судалгаагаар нийт 10 км² талбайг хамарсан нарийвчилсан

хайгуулыг хийж 14 тооны олон үед хамаарагдах түүвэр олдворт дурсгалуудыг нээн илрүүлсэн юм. Мөн Дэлгэрхаан уулаас харьцангуй зайтай орших Зараа уул, Мөнххайрхан уул, Молцог элс зэрэг бусад газруудад хялбаршуулсан (Recon) арга зүйг ашиглан хайгуулын ажлыг хийж палеолит, неолитын бууц сууринг шинээр олсон билээ¹. Харин энэ жил (2014 он) Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Чандмань Хар уул болон түүний орчны бүсэд хайгуулын ажлыг зохион байгуулснаас гадна Сэрүүн цагаан, Хөх хад гэсэн хоёр газарт булш оршуулгын малтлагын ажлыг гүйцэтгэв.

Хамтарсан төсөлд Монголын талаас тус хүрээлэнгийн Археологийн дурсгалыг авран хамгаалах секторын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Археологийн музей-лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Галдан, Хүннүгийн археологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Д.Молор, МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхимийн багш, доктор, дэд профессор З.Батсайхан, магистр Ч.Амарбилэг нар болон АНУ-ын талаас Ийелийн Их сургуулийн профессор, доктор У.Ханичёрч, Оберлин Коллежийн судлаач, доктор Ж.Врайт нар оролцон ажиллав.

Малтлага судалгаа

Малтлага судалгааны баг Чандмань Хар уулаас баруун хойд зүгт байх Сэрүүн цагаан хэмээх газарт 5 орчим хүннүгийн үед холбогдох бүлэг булшнаас 1, хайгуулын багийнхны Хөх хад гэх газраас шинээр илрүүлсэн хүннүгийн үед холбогдох оршуулгын дурсгалт газар 2 булш, 1 шороон байгууламж, 2 чулуун байгууламж малтан судалсан.

Эдгээрээс Сэрүүн цагааны 1-р булшнаас эмэгтэй хүний түрүүлгэ харуулсан оршуулга гарсан нь ихээхэн сонирхол татахуйц баримт болсон билээ. Учир нь 2004, 2012 болон 2013 онуудад Чандмань Хар ууланд малтсан хүрэл зэвсгийн үед холбогдох булш оршуулгын дурсгалуудаас гол төлөв түрүүлгэ нь харуулж оршуулсан өвөрмөц зан үйл бүхий дурсгалуудыг малтан судалсан байдаг. Энэхүү сонирхолтой баримтыг бид дараа дараагийн жилүүдэд явуулах малтлага судалгааны ажлаараа илүү тодорхой болгох үүднээс тэрхүү газарт дахин малтлага судалгааны ажил хийх болно.

Хүснэгт 1: Нийт малтан шинжилсэн дурсгалын товч мэдээлэл

№	Газрын нэр	Булш дугаар	Малтлага дугаар	Дурсгалын төрөл	Солбицол
1	Сэрүүн цагаан	1	Ех.14.01	Хүннү булш	N45° 42' 38.2" E111° 03' 35.9"
2	Хөх хад	1	Ех.14.02	Хүннү булш	N45° 47' 18.3" E111° 10' 18.9"
3	Хөх хад	2	Ех.14.03	Шороон байгууламж	N45° 47' 18.3" E111° 10' 20.0"
4	Хөх хад	3	Ех.14.04	Хүннү булш	N45° 47' 14.5" E111° 10' 13.0"
5	Хөх хад	4	Ех.14.05	Чулуун байгууламж	N45° 47' 14.5" E111° 10' 13.0"
6	Хөх хад	5	Ех.14.06	Чулуун байгууламж	N45° 47' 15.7" E111° 10' 17.1"
7	Хөх хад	6	Ех.14.06	Чулуун байгууламж	N45° 47' 13.3" E111° 10' 13.6"

¹ Ч.Амартүвшин, Г.Галдан, Д.Одсүрэн, Д.Бөхчулуун. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уул: Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: Археологийн хайгуул судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. Улаанбаатар, 2013. ШУА-ийн АХГБСХ.

Хүснэгт 2: Хүннү булшны товч мэдээлэл

Газрын нэр	Дараасны хэмжээ	Оршуулгын нүхний хэмжээ	Оршуулгын гүн	Оршуулгын хэлбэр	Оршуулгын чиглэл	Олдвор
Сэрүүн цагааны 1-р булш (Ех.14.01)	6.5 м	2.4х1.3 м	1.65 м	Модон авс	Баруун хойд	Ваарны хагархай, бог малын яс, төмөр эдлэл
Хөх хадны 1-р булш (Ех.14.02)	7.5 м	2.5х1.1 м	1.5 м	Чулуун хашлага, модон авс	Зүүн хойд	Ваарны хагархай, төмөр зэв, чулуун зэвсэг, бод малын яс, чулуун эдлэл
Хөх хадны 3-р булш (Ех.14.04)	4 м	2.5х1.0 м	1.3 м	Чулуун хашлага	Зүүн хойд	Хүрэл чимэглэл

Маллага судалгаанд хамрагдсан булш оршуулгын дурсгалууд бүгд эрт цагт тонуулчдын гарт өртөн эвдэн сүйтгэгдсэн байсан хэдий ч Дорнод Монголын хүннү судлалд үнэтэй хувь нэмэр болохуйц антропологийн эх хэрэглэгдэхүүн, тухайн бүс нутагт амьдарч байсан нүүдэлдийн эдийн соёлын талаар бага боловч ойлголт өгөх эд өлгийн зүйлс илрүүлэн олсон. Малтан шинжилсэн Сэрүүн цагааны 1-р, Хөх хадны 1-р болон 3-р булшнаас гарсан антропологийн эх хэрэглэгдэхүүнээс дээж аван АНУ руу лабораторийн нарийн шинжилгээнд явуулаад байна.



Зураг 1. Сэрүүн цагааны 1-р булш

Зураг 2. Хөх хадны 1-р булш



Зураг 3. Хөх хадны 3-р булш




Зураг 4. Малтлага судалгаагаар илэрсэн олдворууд

Хайгуул судалгаа

2013 онд тус хээрийн судалгааны багийнхан Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул болон ойролцоо байх бүс нутагт нарийвчлалтай арга зүйгээр хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд дээр дурдсанчлан нүдэнд ил үзэгдэх овор хэмжээ томтой дурсгалуудыг илрүүлэхээс гадна энгийн үед хүний нүдэнд төдийлөн анзаарагддаггүй чулуун зэвсэг, шавар ваарны хагархай болон бусад жижиг олдвор хэрэглэгдэхүүнийг цуглуулав.

Харин энэ жил (2014 он) бид хайгуул судалгааны ажлыг Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Чандмань Хар уул болон ойролцоох Аврага уул, Боть уул, Үүдийн хад зэрэг газруудад археологийн нарийвчлалтай хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Хайгуул судалгаагаар нийт 15 км² талбайг хамруулж нийт 100 тооны дурсгал илрүүлэв. Хайгуулаар илэрсэн дурсгалуудыг өмнөх жилийн хайгуулын дугаарын араас залгуулан дугаарласан болно.



Зураг 5. Хайгуул судалгаагаар илэрсэн дурсгалуудын байрлал

Нийт илрүүлэн бүртгэгдсэн дурсгалуудад бууц суурин, булш оршуулга, чулуун байгууламж, хадны зураг, бичээс, сүм хийдийн туурь зэрэг хуучин чулуун зэвсгийн үеэс XIX зуун хүртлэх түүхийн олон үед хамаарах судалгааны өндөр ач холбогдол бүхий дурсгалуудыг бүртгэн баримтжуулсан.

Эртний хүмүүсийн амьдарч байсны шууд үл мөр болох чулуун зэвсгийн үеийн дарханы газар, явуулын анчдын түр сууринг олон тоотойгоор нээн илрүүсэн. Үүнд, хуучин чулуун зэвсгийн үед хамаарах задгай бууц суурин 2, шинэ чулуун зэвсгийн үед хамаарах бууц 20 газарт байна. Хүрэл зэвсгийн үед хамаарах дурсгалд бууц суурин 4, булш оршуулгын дурсгал 52 ширхэгийг бүртгэсэн. Тодруулбал, Чандмань Хар уулын хэв шинжит булш 24, дөрвөлжин булш 23, хиргисүүр 2, Улаан зуухын хэв шинжит булш 2, шоргоолжин булш 1 байна.

Нарийвчилсан хайгуул судалгаанд хамрагдсан талбайгаас бид хүннү нарт холбогдох бууц суурин 5, оршуулгын газар 2-ыг нээн илрүүлсэн. Түрэгчүүд холбогдогдох чулуун байгууламжийн цогцолбор 1, дугуй хэлбэрийн чулуун дараастай булш 2, ваарны хагархай бүхий бууц суурин 2-ыг нээн илрүүсэн бол хятан нарт холбогдох хятан ваарны хагархайтай задгай суурин 18, дундад зууны үед хамаарах дугуй хэлбэрийн чулуун дараастай булш 6 ширхэгийг бүртгэн баримтжуулсан байна.

Энэ жил манай судалгааны ангийн хайгуулын багийнхан археологийн дурсгалт газрын байршлыг урьдчилан тодорхойлох загварын дагуу хуучны сүм хийдийн мэдээг ашиглан тухайн газруудад хайгуулын ажлыг хийхийг түлхүү зорьсон ба энэ нь үр дүнгээ тодорхой хэмжээнд өгсөн билээ. Тодруулбал, хуучны сүм хийд байх газарт эртний хүмүүсийн амьдарч байсан үл мөр давхцах тохиолдол 80%-тай байгаа нь цаашид археологийн шинжлэх ухаанд энэхүү газрын байршлыг урьдчилан тодорхойлох загвар нь бүрэн ашиглагдах боломжтой харуулж буй хэрэг юм.

МОНГОЛ-ФРАНЦЫН ХАМТАРСАН
„ТАМИРЫН ГОЛЫН ХҮННҮЧҮҮД” ТӨСЛИЙН 2014 ОНЫ
ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Ц.Төрбат, Д.Батсүх, Б.Эрдэнэ

Монгол-Францын хамтарсан „Тамирын голын хүннүчүүд” төслийн хээрийн шинжилгээний анги 2014 оны 06 сарын 21-нээс 07 сарын 26-ныг дуустал Архангай аймгийн Өгийнуур сумын нутаг Тамирын Улаан хошуунд орших хүннүгийн оршуулгын газарт ажиллав. Тус төслийн хоёр дахь жилийн хээрийн шинжилгээний багт Монголын талаас доктор, дэд профессор Ц.Төрбат, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Д.Батсүх, Б.Эрдэнэ, Францын талаас доктор С.Дюшен, докторант Д.Николаева нар ба сэргээн засварлагч, зураач, палеозоологч, гэрэл зурагчин 5 мэргэжилтэн оролцон ажилласан билээ.

2014 оны хээрийн шинжилгээний багийн үндсэн зорилт бол оршуулгын газрын зүүн дэнжийн булшнуудын малтлагыг үргэлжлүүлэх, мөн хэсгийн дэвсгэр зургийг хийх, малтлагын арга зүйг сайжруулах зэрэг байсан болно. Бид тавьсан зорилтоо зохих хэмжээнд биелүүлж Хүннүгийн 9 булш, эртний Түрэгийн үеийн 1 булш малтан судлав. Зарим булшны нүхний гүн ба талбайн хэмжээ асар том байсан тул үүнээс илүү олон тооны дурсгалыг малтан судлах боломжгүй байсан юм. Зүүн дэнжийн булшнуудын дэвсгэр зургийг шинэчлэн хийсэн бөгөөд доктор, профессор З.Батсайхан нарын хийсэн зургаас зарим талаар нэлээд ялгаатай болж, судалгааны явцад шинэ булш илэрч байгаа тул дугаарлалтыг шинэчлэхээс өөр аргагүй байдалд хүрсэн байна. Хэд хэдэн булшны хөндлөн огтлолыг өнгөн хөрснөөс оршуулгын түвшин хүртэл хийж, тухайн дурсгалын бичил түүхийг тайлан унших боломжтой болсныг энд дурдах нь зүйтэй. Ийм бүтэн хөндлөн огтлолоос уг дурсгалыг тоносон нүх ба уг нүх эргэж дүүрсэн үйл явцыг нарийн тодорхой ажиглаж болно.

Булш №3. Дугуй, цагирган дараастай ба дараасын голч 6,8-7,3 м, өндөр 0,2 м. Малтлагын явцад бод малын нурууны яс 2 ширхэг, чөмөгний хугархай, дараасын хойд захаас шавар савын хагархай зэрэг зүйлс тус тус илэрсэн. Малтлагын явцад 235 см гүнээс давхар модон авс илэрсэн бөгөөд модны хадгалалт харьцангуй муу байв. Эрт цагт тоногдсоны улмаас хүний яс нь анатомын байрлалаа алдаж холилдсон байдалтай илэрсэн. Мөн авсны хойд талаас шавар ваар хагарсан байдалтай гарав. Оршуулгын түвшинд тодорхойгүй төмөр эдлэл, чий будагтай савын хэсэг, шавар савын хагархай зэрэг эд зүйлс илэрсэн болно.

Булш №13. Дараасын голч 14, м, өндөр 0,5 м. Малтлагын 3-р үед буюу 145 см гүнээс оруулмал булш илрэв. Энэхүү булшийг хожим эртний Түрэгийн үед хийсэн байх боломжтой хэмээн таамаглаж байгаа бөгөөд тухайн үед ийм оруулмал булш хийсэн тохиолдол олон байдаг билээ. Оруулмал булшны хүний ясыг урьдчилсан байдлаар антропологич Б.Эрдэнэ 50-55 орчим настай монгол төрхтөн боловч хятад хүн байх магадлалтай хэмээн дүгнэсэн байна. Малтлагын 4,3 м гүнээс булшны жинхэнэ эзний оршуулга илэрсэн нь ихэд тоногдсон байв. Оршуулгын түвшингээс нийт 59 тооны олдвор илэрсэний ихэнх нь шавар ваарны хагархай болно. Мөн онцлон дурдууштай цөөнгүй олдвор илэрсний дотор хүрэл толины 2 хэсэг хагархай, төмөр эдлэлүүд болон авсны дөрвөн дэлбээт цэцгэн хэлбэртэй төмөр чимэглэлүүд, чулуун ба ясан сувс, 5 ш хэлхээтэй хүрэл у-шу зоос, алтан ээмэг, хуудас мөнгөн эдлэл, жижиг хуудас алтны өөдөс зэрэг зүйлс илэрч гарав. Оршуулгын эзний ясны хадгалалт муу бөгөөд бүрэн бус юм.

Булш №14. Дугуй, цагариган дараастай ба дараасын голч 7,15 м, өндөр 0,3 м болно. Маллагын 117 см гүнээс 2 хүнд 2 адууг дагалдуулсан оршуулга илрэв. Хоёр адууг хоньчилон хэвтүүлж дагалдуулсан байх бөгөөд баруун, зүүн талд нь 2 хүнийг дээш харуулан баруун хойш толгойгоор нь хандуулан, тэнэгэр байдлаар оршуулсан ажээ. Хойд талын хүний ясыг бүсэлхийнээс дээш самарч тоносон. Адууны тоног бололтой 2 ширхэг төмөр арал, 1 ширхэг хүрэл толины хагархай, шавар савын хагархай зэрэг зүйлсийг илрүүлэв. Ертөнцийн зүгээр урд талын хүнийг А, хойд талынхыг В гэж тэмдэглэсэн бөгөөд А залуу эрэгтэй хүн, В эмэгтэй хүн байжээ. Сонирхолтой нь эдгээрийн толгойн талд шагайт чөмөг дагалдуулсан байв. Зан үйлийн хувьд уг булшийг Эртний Түрэгийн үед хамааруулж болох хэдий ч шагайт чөмөг дагалдуулсан өвөрмөц заншлыг баримтлан эртний монголчуудын соёлын хүрээнд хамааруулж болох юм.

Булш №15. Дугуй, цагирган дараастай ба дараасын голч 15 м, өндөр 0,2 м. Маллагын 2,25 м гүнээс хүний гавлын ясны оройн хэсэг илэрч гарсан ба тоногдсон ажээ. Маллагын 4,5 м гүнд битүү банзаар хийсэн модон хайрцаг илэрсэн нь муу хадгалалттай юм. Авсны хэмжээ 3,241,96 см ба дотроо тасалгаатай юм. Тус булшинд чулуун нухуур, төмөр эдлэл, сувс, алтадсан хүрэл товруу зэрэг зүйлс дагалдуулсан байв. Хүний ясны хадгалалт маш муу ба уг газар нь их чийгтэй газар байсан тул хадгалалтын нөхцөл муутай байжээ.

Булш №16. Дугуй, цагирган дараастай. Дараасын голч 8 м, өндөр 0,2 м. Маллагын 305 см гүнээс давхар модон авс илэрсэн ба хүний сүүж, ахар сүүл, дунд чөмөг, хавирга зэрэг яснууд овоорсон байдалтай гарав. Маллагын 329 см гүнд 200 см урт, 88 см өргөн, 40 см өндөр модон авс илэрч гарсан юм. Мөн өмнөх дурсгалын адил тоногдсон ба ээрүүлийн дунгүй, том шавар сав, сувс, төмөр эдлэл, чий будагтай аяга, таваг зэрэг зүйлс гарсан боловч бэхжүүлэн биетээр авах боломжгүй байв. Мөн ширмэн тогооны бөөрцгийн хагархай, шавар сав зэрэг эд зүйлийг дагалдуулжээ. Хүний ясны хадгалалт харьцангуй сайн боловч дутуу.

Булш №17. Дугуй, цагирган дараастай. Дараасын голч 8 м, өндөр 0,2 м. Маллагын 315 см гүнээс оршуулга буюу хүний яс илрэв. Тоногдсоны улмаас эмх замбараагүй хаялсан байв. Давхар банзан австай байжээ. Тонуулчид уг булшийг эрт цагт тоносон хэдий ч авсны гадна талд хойлгын хэсэгт нямбайлан тавьсан эд өлгийн баялаг цуглуулгад хүрч чадаагүй байна. Эндээс гарсан олон сонирхолтой олдворын дотроос бидний эмээл хэмээн үзэж буй эдлэл судалгааны онцгой ач холбогдолтой юм. Бүхний мэдэж байгаагаар энэ бол Хүннүгийн булшнаас олдож буй анхны металл хийцтэй эмээл болох төдийгүй дэлхий дээрх анхны хатуу материалаар хийсэн бүүрэгтэй эмээл байх бүрэн боломжтой. Мөн хоёр ширхэг амгай, зүүзай, чий будагтай сав, төмөр зэв, хутга, илдний ир гэх мэт эд өлгийн зүйлсийг дагалдуулсан байжээ. Мөн хүрэл жижиг сав, ясан савх зэрэг аж ахуйн зориулалттай зүйлс ч гарав.


Булш №18. Дугуй, цагирган дараастай ба дараасын голч 8,8 м, өндөр 0,1 м. Бод малын сүүж, хавирганы хугархай зэрэг зүйлс гарч байв. Маллагын гүн 2,5 м болоход модон авс илэрч эмх замбараагүй болсон хүний яс, бог малын асуух нуруу, хавирга зэрэг гарав. Хэдийгээр тонуулчид сүйтгэсэн байсан боловч уг оршуулгын эзэнд нумын ясан наалт, гичир, шавар ваар, төмөр арал, цагираг зэрэг эдлэлүүдийг дагалдуулсан байв. Мөн ариутгасан галын ором, шавар савын дотроос илэрч гарлаа.

Булш №19. Дугуй, цагирган дараастай ба дараасын голч 8 м, өндөр 0,1-0,3 м ба гадна талаас нь харахад тоногдсон шинжтэй. Маллагын 270 см гүнд давхар модон авсанд оршуулсан настай эмэгтэй хүний оршуулга илрэв. Мод болон хүний ясны

хадгалалт маш муу. Оршуулгын эзэнд том босоо шавар саванд хонины асуух нуруу болон ууцны ясыг тэр чигээр нь чанаж төмөр шанага дүрсэн хэвээр нь дагалдуулсан байжээ. Энэхүү булшны оршуулгын нүхэнд урд болон баруун талд нь хөмөг гарган хөндийлөн ухаж эд өлгийн зүйлсийг тавьсан байсан нь тодорхой ажиглагдав.

Булш №20. Дугуй, цагирган дараастай ба дараасын голч 5,9 м, өндөр 0,1 м. 235 см гүнээс мөн адил давхар модон авс илэрч хүний яс замбараагүй байдалтай илрэв. Залуу эрэгтэй хүүхдийн оршуулга бөгөөд хөл талын авсны тасалгаа болон өөр бусад газраас нийт 104 ширхэг богийн шагай илэрсэний 16 ширхэг нь дээрээ нэвт нүхтэй байв. Үүний 1 нь 2 нүхтэй, 1 нь 3 нүхтэй, 2 нь төмрөөр битүү тойруулан ороож бэхэлсэн байв. Мөн 1 ширхэг сүүжин хэлбэрийн алтан ээмэг, нүхтэй ясан эдлэл, төмөр эдлэлийн хэсгүүд зэрэг эд хэрэглэлийг дагалдуулан оршуулсан байлаа.

Булш №21. Дугуй, цагирган дараастай ба дараасын голч 6 м, өндөр 0,1 м. Маллагын 170 см гүнээс авсны мод илэрч бод, бог малын зарим яс гарч байв. Мөн шавар савын хагархай гарч байна. Давхар банзан авсанд байсан хүний яс мөн л эмх замбараагүй болжээ. Оршуулгын эзэнд сүвс, төмөр хутга, дэгээ, шавар сав, ээмэг зэрэг эд зүйлсийг дагалдуулсан бөгөөд хүний яс нь бүрэн биш, хадгалалт нь дунд зэрэг байв.



Зураг 1. Тамирын Улаан хошууны зүүн дэнж дээрхи бүлэг булшны дэвсгэр зураг.

Үйлдсэн © Ц.Төрбат (2014).



Зураг 2. 13-р булшны 3-р үед илэрсэн оруулмал оршуулга



Зураг 3. 13-р булшнаас илэрсэн алтан ээмэг



Зураг 4. 14-р булшны оршуулгын түвшин



Зураг 5. 15-р булшны малтлагын 10-р үе



Зураг 6. 17-р булшны 6-р үед эмээлийн төмөр бүүрэг илэрч буй байдал



Зураг 7. 19-р булшнаас шавар ваар болон төмөр шанага илэрч буй байдал

„МОН-СОЛ” ТӨСЛИЙН 2014 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

*Г.Эрэгзэн, М.Баярсайхан, Ц.Эгиймаа, П.Алдармөнх
Юн Хён-Вон, Ким Сан-мин*


ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Солонгосын Үндэсний музей хамтран хэрэгжүүлж буй Мон-Сол төсөл нь 1997 онд анх эхэлж байснаас хойш 18 жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус төслийн хүрээнд олон ажлууд хийгдэж судалгааны ажлын үр дүн, олдвор хэрэглэгдэхүүн нь „Өглөгчийн голын дурсгал” (1999), „Морин толгойн Хүннүгийн үеийн бүлш” (2001), „Худгийн толгойн Хүннү бүлш” (2003), „Мон-Сол төслийн 2002-2004 оны судалгааны үр дүн” (2005), „Дуурлиг нарсны Хүннү бүлш-I, II” (2012, 2014) зэрэг тайланд орж нийтлэгдээд байна.

Төслийн судлаачид Морин толгой, Худгийн толгой, Дуурлиг нарс зэрэг Хүннүгийн хэд хэдэн оршуулгын дурсгалт газарт язгууртны болон жирийн жижиг булшны судалгааг хийж, тухайн үеийн оршуулгын зан үйл, булшны бүтэц зохион байгуулалтын талаар тодорхой хэмжээний ойлголттой болсон хэмээн хэлэлцээд цаашид харьцангуй судалгаа бага хийгдсэн Хүннүгийн хот суурин, үйлдвэрлэлийн холбогдолтой дурсгалыг судлах нь зүйтэй хэмээн үзсэн юм. Энэ үүднээс 2013 оноос эхлэн Төв аймгийн Баянжаргалан сумын нутаг, Хэрлэн голын баруун эрэгт байрлах „Гуа дов” хэмээх Хүннүгийн үеийн хотын турьд малтлага судалгааны ажлыг эхлүүлсэн билээ.

Эхний жилийн хувьд (2013 он) Гуа довын хэрмийн өмнөд хаалга хэмээн таамагласан хэсэгт 33х12.5 м хэмжээтэй талбайд малтлага судалгаа хийж 16 багана бүхий том хэмжээтэй барилгын түрийг ил гарган цэвэрлэсэн. Гэвч цаг хугацааны боломжоос шалтгаалан барилгын өмнө хэсгийг бүрэн ил гаргаж амьжаагүй ба барилгын зориулалт, бүтэц зохион байгуулалтын онцлог зэрэг олон асуудлыг ч хөндөж чадалгүй судалгааны ажлыг түр зогсоосон юм.

2014 онд дээр өгүүлсэн дутуу орхигдсон ажлыг үргэлжлүүлэн хийсэн ба барилгын зориулалт, зохион байгуулалтыг илүү тодруулахыг хичээж ажиллав. Мөн уг барилгатай залгагдаж буй хэрмийн бүтцийг мэдэх зорилгоор барилгаас зүүн тийш 50 м зайд хэрмийг хөндлөн зүссэн малтлагыг ч хийсэн юм. Малтлагын ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нь тайланд орсон болохоор энд зөвхөн барилгын ерөнхий хэлбэр, бүтэц, зохион байгуулалтын талаар товчхон өгүүлье.

Бидний малтлага хийж буй барилга нь 33 м урт, 14.5 м өргөн хэмжээтэй юм. Барилгын төв хэсэгт зүүнээс баруун тийш (ертөнцийн зүгээр баруун хойноос зүүн өмнө тийш) цуварч байрлах тус бүр 10х5 м хэмжээтэй 2 хэсэг дагтаршуулсан шавар суурь илэрсэн. Энэхүү тэгш өнцөгт хэлбэрийн дагтаршуулсан шавар суурийн 4 буланд тус бүр 1, төв хэсгийн 2 захад хоорондоо 1.5 м зайтай хос гэх мэтээр 1 суурьт 8 баганын чулуун суурь мэдэгдсэн бөгөөд 2 хэсгийн баганын суурийг нэгтгэн үзвэл уг барилга 16 баганатай болох юм. Уг 2 дагтаршуулсан хэсэг нь хоорондоо 5 м зайтай байна. Дагтаршуулсан 2 шавар суурийн гадна талаар 2-3 м талбайд дээврийн ваарнууд битүү дэвссэн мэт илэрсэн. Мөн 2 дагтаршуулсан шавар суурийн зүүн баруун талаас залган хэрмийн үлдэгдэл хэмээн таамагласан 1.4 м өргөн шавар зурвас 2 тийш үргэлжлэх бөгөөд дагтаршуулсан шавар суурь болон хэрмийн залгагдах хэсэгт улаан өнгийн тоосго ашиглан барьсан тасалгаа байв. Ийм тасалгааны үл мөр дагтаршуулсан шавар суурийн 2 захад тус бүр 2 мэдэгдсэн (Дэвсгэр зургийг үзнэ үү).



Гуа довын хэрмийн хаалганы хэсгийн малтлагын дэвсгэр зураг




Хэрмийн хаалганы хэсгийн хөндлөн зүсэлтийн зураг

Малтлага судалгааны явцад хийсэн ажиглалтаар энэхүү барилга нь хэрмийн нэгэн хаалга болох нь мэдэгдэж байна. Хаалганы ерөнхий төрх нь тус бүр 8 баганатай тэгш өнцөгт хэлбэрийн хос байгууламж, орж гарах хэсэг нь түүний дундуур байжээ. Хос байгууламжийн 2 захад буюу хаалганы зүүн, баруун жигүүрт хэрмийн хананд тулган дотор, гадна талд нь улаан тоосгоор барьсан жижиг тасалгааг байгуулсан байна. Энэ жилийн хувьд бид зөвхөн барилгын дээврийн ваарны хэсгийг бүрэн цэвэрлэж дууссан бөгөөд одоогоор дээврийн ваарыг бүрэн зайлуулаагүй болохоор барилгын бүтэц, зохион байгуулалтын талаар үүнээс илүү нарийн мэдээлэл авах боломжгүй байна. Дээврийн ваарыг цэвэрлэх явцад хаалганы баруун урд булангийн хэсэгт 3 үе дээврийн нүүр ваар илэрсэн нь сонирхол татсан. Энэ байдал нь уг хаалга 2-3 давхар үелэсэн дээвэртэй болохыг харуулж буй юм.

Малтлагын хэрэглэгдэхүүнд тулгуурлан төсөөлөхөд Гуа довын хэрэмний хаалга нь хэлбэрийн хувьд Чойжин ламын сүм музейн гол хаалга зэрэг орчин үед уламжлан ирсэн зарим нэг эртний барилга байгууламжийнхтай төстэй байх магадлал өндөр байна.

Энэ жил хаалганы хэсгээс гадна хэрэмний хэсэгт зүсэлтийн маллага хийсэн. Маллага хийж буй хаалганы хэсгээс зүүн тийш 50 м зайд хэрмийг хөндлөн зүсч малтахад газрын өнгөн хөрснөөс доош 0.15 м гүнд хаалганы хэсэгт илэрсэнтэй төстэй 1.4 м өргөн дагтаршуулсан шавар (хэрэмний суурь хэсэг) илэрсэн. Энэ нь хэрэмний суурь хэсэг хаалганаас буланг чиглэн жигд үргэлжлэж буйг харуулж байв. Хэрмийн шавар суурын 2 талаас дээврийн ваарнууд илэрсэн бөгөөд энэ байдал нь хэрэмний орой хэсэг ч вааран өнгөлгөөтэй байсныг харуулж буй юм. Түүнээс гадна хэрмийн суурь болох дагтаршуулсан шаврын зүүн талд буюу хэрмийн дотор талаас баганын суурь болох нүхний ором мэдэгдсэн. Энэ бүхнээс үзэхэд Гуа довын хэрэм нь дотуураа давхар модон байгууламжтай нилээд ярвигтай бүтэцтэй байсан бололтой байна. Мон-Сол төслийн хувьд 2015 онд Гуа довын дурсгалт газарт хийж буй маллагын ажлыг нилээд өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэ судалгааны дараа дурсгалын зориулалт, бүтэц, зохион байгуулалтын талаар илүү нарийн мэдээлэл өгөх боломжтой болно хэмээн найдаж байна.



Гуа довын хэрэмний хаалганы хэсгийн маллагын агаарын зураг



*Хэрэмний хэсгийн маллагын зураг
(гадна талаас)*



*Хэрэмний хэсгийн маллагын зураг
(дотор талаас)*

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН „ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮҮХ”
ТӨСЛИЙН 2014 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН
УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

*Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн,
Т.Сагада, И.Үсүки, К.Кияма, М.Сагава*

Тус төсөл нь Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Зүүн Байдлагийн голын савд дөрөв дэх жилдээ амжилттай ажиллаа.

Хоёр талын хамтарсан төслийн 2011-2013 он хүртэл байгуулсан хамтран ажиллах гэрээний хугацаа дууссан тул 2014-2018 он хүртэл дахин таван жилийн хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулж төслийн нэрийг „Эртний нүүдэлчдийн үйлдвэрлэлийн түүх” хэмээн нэрлэсэн. Хамтарсан төсөл нь Монгол нутаг дахь эртний хүрэл, төмөр, ваар сав шатаах үйлдвэрлэлийн дурсгалуудыг илрүүлэн олж малтлага судалгаа хийж, эртний нүүдэлчдийн үйлдвэрлэлийн түүхийг сэргээн тодруулах зорилготой билээ. Энэ жил судалгааны багийнхан үндсэн гурван хэсэгт хуваагдан ажиллав. Нэгдүгээр хэсэг Хустын булагийн төмрийн хүдэр хайлуулах зуухны малтлагыг үргэлжлүүлж, хоёрдугаар хэсэг булш оршуулгын малтлага судалгааг үргэлжлүүлэн хийсэн. Харин энэ жилээс эхлэн гуравдугаар хэсгийг шинээр зохион байгуулж шавар ваар сав шатаах зуухны малтлагыг эхлүүлэв.

2012 онд ваар сав шатаах үйлдвэрлэлийн дурсгалаас авсан модны нүүрсний дээжний C14 радио-карбонь задлан шинжилгээний дүнд НТӨ I зуунаас НТ I зуунд хамаарах нь тодорхой болсон юм ¹. Энэ нь төмрийн хүдэр хайлуулах зуухны он цагтай давхцаж байгаа бөгөөд ваар сав шатаах үйлдвэрлэлийн газар нарийвчилсан судалааг хийснээр хүннүгийн үйлдвэрлэлийн системийн талаар цогц ойлголтыг авах боломж бүрдэх юм.

1. Төмрийн хүдэр хайлуулах зуухны малтлага судалгаа

Хустын булагийн төмрийн хүдэр хайлуулах дурсгалт газарт 2013 оны 08-р сарын 30-ны өдрөөс 09-р сарын 13-ны өдөр хүртэл нийт 4 талбайд малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

Өмнөх жил малтсан Ex.13.01, Ex.13.02 талбайгаас хойш 5x5 м хэмжээтэй хоёр талбайг шинээр нээж баруун талаас Ex.14.01, Ex.14.02 хэмээн дугаарлав .



¹ Ч.Амартүвшин, Т.Сагада, Г.Эрэгзэн, И.Үсүки, Л.Ишцэрэн. Хустын булагийн дурсгалт газарт илэрсэн төмрийн хүдэр хайлуулах болон ваар шатаах зуухны он цагийн асуудалд //Studia Archaeologica. Tom. XXXII. Fasc. 13. Tal 213-228. Улаанбаатар, 2012.

1.1. Ex.14.01, Ex.14.02 талбайн малтлага

Энэ жил малтлага хийсэн хоёр талбайн урд болон баруун ханын зүсэлтийн зургийг үйлдэх зорилготой 0.5 м өргөнтэй ханыг үлдээв. Мөн өмнөх жил Ex.13.02 талбайгаас илэрсэн төмрийн хүдэр хайлуулах 4-р зуухны суурь хэсгийн бүтцийг судлах зорилгоор талбайг бүхлээр нь цэвэрлэн гаргасан.

1.2. Ex.14.01 талбайн малтлага судалгаа

Тус талбайн 5х5 м бөгөөд өнгөн хөрсийг хуулсны дараа 2-р хөрсөн үеэс галд түлэгдэж шатсан зууван дугуй хэлбэрийн ором хоёр ширхэг илэрсэн. Тус хоёр нүхийг Pit-5, Pit-6 хэмээн нэрлэсэн.



EX.14.01 талбай. Pit-5



EX.14.01 талбай. Pit-6

Pit-5 нүх нь талбайн баруун хэсгээс илэрсэн. Нүх нь 120х140 см зууван хэлбэртэй, бөөн төмрийн хаягдал, зуухны ханын хэсэг, хөөрөгний хошуу агуулсан бөгөөд үүнийг хаягдал хийх зориулалттай нүх хэмээн үзэж байна. Олдворуудыг цэвэрлэн гаргаж гэрэл зураг авч дэвсгэр зураг үйлдэж баримтжуулалт хийсний дараа урд хэсгийн олдворуудыг авч зүсэлтийн малтлага хийв. Тус нүхний гүн 15 см.

Pit-6 нүх нь талбайн зүүн хэсгээс илэрсэн. Нүх нь 120х160 см зуйван хэлбэртэй бөгөөд төмрийн хаягдал, зуухны ханын хэсэг, модны нүүрс, чулуу зэрэг зүйлс агуулсан байна. Тус нүхнийг цэвэрлэн олдворуудыг гарган гэрэл зураг авч, дэвсгэр зураг үйлдэн баримтжуулалт хийсний дараа баруун хэсгийн олдворуудыг авч зүсэлтийн малтлагыг хийв. Тус нүхний гүн 15 см байна. Зүсэлтийн гар зургийг хийж баримтжуулалт хийн малталгыг дуусгав.

Талбайн урд хэсэгт 50 см өргөнтэй сорьц малтлагыг хийсэн бөгөөд өнгөн хөрснөөс доош 60 см гүнд мөн хагас дугуй хэлбэрийн шатсан нүхний ором илэрч үргэлжлүүлэн малтахад зуухнаас гарсан төмрийн хаягдал агуулсан нүх болох нь тодорхой болов.



EX.14.01 талбайн урд ханын хэсгээс илэрсэн нүх

Тус нүхний урд хагас хэсэг нь хана нь тулсан тул энэ хүргээд малтлагыг дуусгасан. Илэрсэн нүхний хэмжээ 140 см урт, 40 см өргөнтэй байна. Энэ нүхнээс хойш чиглэсэн 80 см орчим өргөнтэй хүрэн бор өнгийн нарийн зурвас үргэлжилсэн тул бид талбайн урд талын 2 м хэсгийг нийтээр нь доош нь малтсан. Өмнөх нүхнээс хойш 1 м орчим зайд өнгөн хөрснөөс доош 40 см гүнд галд түлэгдсэн 100х60 см зуйван дугуй хэлбэрийн нүх илэрч Pit-8 хэмээн нэрлэв .



EX.14.01 талбай. Pit-8



EX.14.01 талбай. Pit-8

Pit-8 нүхний захын хэсэг галд их ертөн хатуурсан бөгөөд түүний дотор талын төв хэсэгт 40х60 см хэмжээтэй нүхэнд бөөн төмрийн хаягдал илэрсэн. Тус хоёр нүх нь ойролцоо бөгөөд хоорондоо хүрэн бор хөрсөөр холбогдсон нь ямар нэг хамаарал бүхий хэмээх таамагт хүргэв. Тус хоёр нүхний түвшинд талбайн бусад газрууд нь хатуу цагаан хөрстэй байна. Урд ханын хэсэгт илэрсэн нүх нь зуухны суурь хэмээн үзвэл түүнээс гарсан төмрийн хаягдалыг хойд талын Pit-8 нүхэнд хаясан байх магадлалтай юм.

1.3. Ex.14.02 талбайн малтлага судалгаа.

Тус талбай нь 5х5 хэмжээтэй. Өнгөн хөрсийг авсны дараа 2-р хөрсний үеээс галд түлэгдсэн хүрэн бор дугуй хэлбэрийн нүх илэрсэн. Тус нүхийг Pit-7 хэмээн нэрлэв (*гэрэл зураг 5*).

Pit-7 нүх нь 100 см голчтой бөгөөд доош малтахад төмрийн хаягдал их хэмжээтэй илэрсэн. Тус нүхийг цэвэрлэн гэрэл зураг авч, дэвсгэр зураг үйлдэв (*гэрэл зураг 6*).

Үүний дараа баруун хэсгийн олдворуудыг авч зүсэлтийн малтлага үйлдэн зүсэлтийн гар зургийг хийж баримтжуулав. Тус нүхнээс урагш 60 орчим см зайд том чулуу байх бөгөөд түүнийг урд талд залгаад хөөрөгний шавар хошуу олон тоогоор агуулсан 40x20 см хэмжээтэй нэг жижиг нүхийг малтсан (гэрэл зураг 6-1). Энэ талбайн баруун талд 2 м, урд талд 1 м өргөнтэй сорьц малтлагыг хийсэн боловч ямар нэгэн эд өлгийн зүйл гаралгүй байгалийн хөрсөнд хүрсэн тул талбайн баруун болон урд ханын зүсэлтийн гар зургийг хийснээр малтлагыг зогсоов.



EX.14.02 талбай. Pit-7




EX.14.02 талбай.
Хөөрөгний шавар хошуу илэрсэн нүх

1.4. Ex.13.01 талбай дахь 4-р төмрийн хүдэр хайлуулах зуухны малтлага

Тус талбайгаас өмнөх жил илрүүлэн олж малтсан төмрийн хүдэр хайлуулах зуухыг энэ жил үргэлжлүүлэн малтаж цэвэрлэн дэвсгэр зургийг үйлдэв (гар зураг 5). Зуухны суурь хэсгийн бүтэц зохион байгуулалтыг тодорхой болгох үүднээс зуухны төв хэсгийг дайруулан 20 см өргөнтэй малтлагыг хийв.



Ex.13.01 талбай. 4-р зуухны малтлага



Ex.13.01 талбай. 4-р зуухны зүсэлтийн зураг

Тус зуухны суурь хэсэг нь 50 см орчим дөрвөлжин суурьтай (гэрэл зураг 7, гар зураг 5) бөгөөд 30 см орчим гүнд ёроол хэсэг байгаа нь тодорхой болсон (гэрэл зураг 7-1, гар зураг 6). Мөн зуухны ханын хэсэг болон төмрийн хаягдал агуулсан нүхний гүн 50 см бөгөөд өндөр температурт халсан зуухны хана, төмрийн хаягдал зэргийг хийж байснаас түлэгдэж шатсан ул мөр тодорхой харагдана.

Энэ жилийн малтлага судалгаагаар төмрийн хаягдал, зуухны ханын хэсэг,

хөөрөгний шавар хошуу агуулсан нүх 4 нүхийг илрүүлэн олсон. Мөн төмрийн хүдэр хайлуулах 4-р зуухыг бүрэн малтан дууссан бөгөөд зуухны суурь болон, үйлдвэрлэл дууссаны дараа зуухыг нурааж хаясан нүхний бүтцийн талаар тодорхой мэдээллийг авч чадсан.

Ирэх жилийн судалгааг энэ удаад малтсан талбайгаас баруун тийш үргэлжлүүлэн талбайг сунгахаар төлөвлөсөн болно. Ингэснээр шинээр төмрийн хүдэр хайлуулах зуух илрэх магадлалтай бөгөөд, тус дурсгалт газрын нийт ажлын талбайг бүрэн гаргаж эртний төмрийн үйлдвэрлэлийн газрын тухай бүрэн хэмжээний ойлголт авахыг зорьж байгаа болно.

Мөн өмнөх 3 жилийн үр дүнг нэгтгэн Хустын булагийн дурсгалаас илэрсэн төмрийн хүдэр хайлуулах зуухыг Бага нарийны ам, Байгал нуурын баруун эргийн Барун Хал, Минусинскийн Трошкина дурсгалуудаас олдсон нэг цаг үеийн ижил зуухнуудтай харьцуулан судалж „Хүннүгийн төмрийн хүдэр хайлуулах зуухны зарим асуудалд” эрдэм шинжилгээний өгүүлэлийг нийтлүүлсэн ².

2. Ваар сав шатаах зуухны малтлага судалгаа

Хустын булагийн ваар сав шатаах зуухны дурсгалыг анх 1990 онд „Гурван гол” төслийн судалгааны багийнхан илрүүлэн олж, үүний дараа 2001 онд „Мон-Сол” төслийн судалгааны багийнхан малтлага судалгааг гүйцэтгэсэн байна ³.



KBS 2.К-1 талбай



KBS 2.К-1 талбайн малтлагын явц

Манай судалгааны багийнхан тус дурсгалт газрын он цагийг дахин нягтлах үүднээс 2012 онд модны нүүрсний дээж аван он цагийг нарийвчлан гаргаж энэ тухай эрдэм шинжилгээний өгүүлэл нийтэлсэн болно ⁴.


Судалгааны багийнхан 2014 оны 08-р сарын 30-наас 09-р сарын 05 хүртэл ваар сав шатаах үйлдвэрлэлийн газар судалгааг хийсэн юм. Энэ жил судалгааны багийнхан

² Л.Иицэрэн, Т.Сасада. Хүннүгийн төмрийн хүдэр хайлуулах зуухны зарим асуудалд //Studia Archaeologica. Том. XXXIV. Fasc.20. Тал 253-263. Улаанбаатар, 2014.

³ Д.Цэвээндорж, Д.Баяр, Г.Мэнэс, Л.Билэгт, З.Батсайхан. 1990 онд Чингис хааны булшийг хайх “Гурван гол” Монгол, Японы хамтарсан төслийн хүрээнд явуулсан археологийн хайгуулын тайлан. ШУА-ийн АХГБСХ. №56. //Д.Баяр, Л.Билэгт, Ширази, Курия. Монгол-Японы хамтарсан “Гурван гол” шинжилгээний ангийн Хэрлэн голын эхний баруун хэсэгт хийсэн эртний судлалын хайгуулын ажлын тайлан. 48-50-р тал.

⁴ Ч.Амартүвшин, Т.Сасада, Г.Эрэгзэн, И.Усүки, Л.Иицэрэн. Хустын булагийн дурсгалт газарт илэрсэн төмрийн хүдэр хайлуулах болон ваар шатаах зуухны он цагийн асуудалд //Studia Archaeologica. Том. XXXII. Fasc. 13. Тал 213-228. Улаанбаатар, 2012.

тус дурсгалт газар өмнөх жилүүдэд хийгдсэн хайгуул судалгааны мэдээллийн үндсэн дээр Зүүн Байдлагийн голын зүүн дэнжийн төгсгөл орчимд модны нүүрс болон галд шатаж хар хүрэн өнгөтэй болсон ваар болон дээврийн ваарны бөөгнөрөл бүхий таван газрыг илрүүлж, түүнээс К1 хэмээн нэрлэсэн талбайд малтлага хийхээр товлов



КBS 2.К-1 дэвсгэр зураг

Эдгээр таван газрыг бүгдийг нь ваар сав шатаах зуух хэмээн таамаглаж байсан бөгөөд, энэ жил малтлага судалгааны хугацаа, мөн малтах талбай зэргээс шалтгаалан К1 талбайд баруунаас зүүн тийш 4 м, хойноос урагш 8 м талбайд судалгааг хийхээр төлөвлөв. Малтлагын явцад энэ талбайд ваар сав шатаах зуух байхгүй түүхий тоосгоор барьсан „□” хэлбэрийн „нүхэн сууц” хэлбэрийн ором гарсан. Тус талбайгаас бүрэн мэдээлэл авахын тулд дээд хэсэгт нь зүүнээс баруун тийш 3 м, хойноос урагш 3.5 м нэмэж малтлагыг үргэлжлүүлсэн.

Малтлагын явцад 2-р үеэс хар хүрэн дугуй хэлбэрийн толбо илэрсэн бөгөөд хойноос урагш 4 м, зүүнээс баруун тийш 3.8 м хэмжээтэй байна. Уг толбоны булангууд нь дугуйрсан бөгөөд баруун хойд ханын өндөр нь хэсэг нь 60-70см, зүүн өмнөд хана нь 10 орчим см, баруун талынх (төв хэсгээс өмнө тийш) 30 см орчим байгаа нь тодорхой болсон. Байгалын хөрсийг ашиглаж хийсэн шал нь уртрагийн дагуу чиглэж дэнжийн урд талруугаа налуу боловч өмнөд талын хагас хэсэг нь бараг тэгш хэмтэй ба өргөргийн дагуу ерөнхийдөө тэгш хэмтэй байгаа нь тодорхой болсон. Энэхүү шалыг цагаан өнгийн нимгэн дагтаршуулсан шавраар бүржээ. Ханыг харин цагаан шавраар өнгөлөөгүй байна. Хагас нүхэн сууцны үлдэгдлийн өмнөд хэсэгт түүхий тоосго илэрсэн ба урт 70 см, өргөн 1.3 м хэмжээтэй байна. Түүний баруун зах болон өмнөд захад нь түүхий тоосгогыг уртааш нь дэвсжээ. Тус түүхий тоосгоор хийсэн шалны өргөн 70-110 см, өргөн 2 м орчим ба ихэнх хэсгүүд нь хөрсний үс зэрэг гадны нөлөөнөөс болж нэлэнхүйдээ хатуурсан байдалтай байна.

„□” хэлбэрийн хагас нүхэн сууц доторх түүхий тоосгоны баруун талын хойд хэсэгт 10 см өргөн одоо үлдсэн өндөр 10 см шатсан шавар ханын хэсэг байх бөгөөд, өмнө талруу 70 см зайд баруун тийш эргэсэн булан нь аажмаар мэдэгдэхгүй болжээ.

Ойр хавьд нь галд шатсан зүйлийн үлдэгдэл тийм ч их байхгүй байгааг одоогоор тайлбарлах боломжгүй байна. Түүнчлэн түүхий тоосго дэвссэн зүүн талын хагас хэсгийн доод үед мөн түүхий тоосго дэвссэн хэсэг гарсан нь дээд үеэс ялгаатай байна. Энэ нь тус сууцны шалыг хийх үед доод талд нь таарсан газрын нүхийг битүүлэх зорилготой хийсэн хэмээн таамаглаж байна.


Бидний сонгон малтсан К1 дурсгалаас ахуйн зориулалтын ваар сав шатаах зуух болон барилгын дээврийн ваар шатаах зуух илэрсэнгүй. Тус дурсгалын ойр орчинд Хүннүгийн үеийн ваар болон дээвэр ваарны хагархай багагүй тархсан байгаа нь бидний таамаглаж буй хагас нүхэн сууц нь ваар сав шатаах үйлдвэртэй ямар нэгэн хамаарал бүхий дурсгал хэмээн таамаглаж байна. Ирэх жилийн малтлагыг зүүн тийш тэлж тус нүхэн сууцыг бүхлээр нь гаргах зорилготой байна.

3. Булш оршуулгын дурсгалын малтлага судалгаа

Төслийн хүрээнд энэ жил Хүннүгийн үед холбогдох 1 булш, он цаг нь тодорхойгүй 1 тахилын чулуун байгууламж малтан шинжлэв.

Малтлага судалгаа хийсэн 2 дурсгал нь Намрсайн ухаа хэмээх урагш Хэрлэн гол руу шахаж, хойш Баруун Бүрхийн голын дунд урсгал хүртэл үргэлжилсэн өндөрлөгийн өмнө болон хойд хөтөл дээр байрлана.

Малтлага хийсэн эхний дурсгал нь Намрсайн ухаагийн өмнө талд, урагш сунаж тогтсон намхан хошууны араар дайрах хөтөл, авто замын хойхно байрлана. Ерөнхийдөө уулын өмнө талын судаглан тогтсон хотгорын баруун хажуугийн наран ээвэр налуу дэвсэг юм. Энд голдоо чулуугүй хүрээлсэн маягтай тавьсан чулуун байгууламжтай 8 булш байх ба өнгөрсөн жил уг оршуулгын дурсгалт газрыг шинээр илрүүлж, нэгэн булшийг сонгон малтлага хийсэн билээ. Энэ жилийн хувьд оршуулгын газрын тархацын дэвсгэр зургийг үйлдэж, хамгийн хойд талд байрлах нэгэн булшийг малтан судласан.



Намрсайн ухаагийн Хүннүгийн оршуулгын дурсгалт газрын тархацын зураг


Хоёр дахь дурсгал нь Намсрайн ухаагийн арын хөтлөөр дайрч гарах авто замын өмнө талын тэгш дэвсэг дээр байрлана. Энд зүүнээс баруун тийш 1 эгнээнд цувруулан байгуулсан 18 чулуун байгууламж байв. Бидний малтлага хийсэн тахилын байгууламж нь зүүн талаас 3 дахь нь юм.



Намсрайн ухаагийн 2-р хүннү булш

Намсрайн ухаагийн өмнө талд байрлах бэсрэг оршуулгын дурсгалт газарт нийтдээ 8 булш байх ба эдгээр булш нь зүүнээс баруун тийш цуварсан байдалтай, 2 эгнээгээр тавигдсан байна. Өнгөрсөн жил болон энэ жил малтлага хийсэн булшнууд нь хойд талын эгнээнд байрлана. 2013 онд малтлага хийсэн булш нь харьцангуй жижиг хэмжээтэй гадаад чулуун байгууламжтай байсан бөгөөд газрын гүнд оршуулгын нүхний толбо мэдэгдсэн ч оршуулга болон ямар нэгэн эд өлгийн зүйл олдоогүй билээ. Харин энэ жил малтлага хийсэн булш (2-р булш) нь газрын өнгөн хөрсөн дээр ил цухуйн харагдах цагариг хэлбэрийн чулуун байгууламжтай, 2 м гүнд хүнээ модон авсанд хийж оршуулсан дурсгал юм. Энэ булшны гадаад чулуун байгууламжийн голч 5 м хэмжээтэй бөгөөд өнгөн хөрсний цэвэрлэгээний дараа гадаад чулуун байгууламжийн төв хэсэгт ялимгүй баруун хойш чиглэлтэй гонзгой хэлбэрийн чулуугүй талбайтай болох нь тодорхой болсон. Малтлагыг уг чулуугүй талбайг хамруулан хийхэд өнгөн хөрснөөс доош 0.2 м гүнд оршуулгын нүхний толбо

тодорч мэдэгдсэн юм. Оршуулгын нүх нь баруун хойноос зүүн өмнө тийш чиглэлтэй урт гонзгой хэлбэртэй, 2.8x1.3 м хэмжээтэй байсан бөгөөд 0.8 м гүнд багавтархан догол гаргаж шатласан зааг мэдэгдсэн. Уг заагаас доош нүхний хэлбэр илүү тодорхой мэдэгдсэн ба нүхний чиглэл чанх хойд зүгт хандсан байдалтай болж өөрчлөгдсөн. Мөн энэ түвшинд нүхний хэмжээ 2.5x1.1 м болж жижгэрсэн. Доош малтахад нүхний төв хэсгээс эмх замбараагүй болсон чулууд гарч байсан бол өмнө хагасаас битүү чулуун чигжээс гарч байсан. Нүхний өмнөд хагасаас гарсан чулуун чигжээс нь өнгөн хөрснөөс доош оршуулгын хэсэгт хүртэл үргэлжилсэн. Харин нүхний хойд хагасаас тонуулчдын нүхний ором болох бараан өнгийн хөрс ялгарч мэдэгдэж байв. Тонуулчдын нүхний ором 1.8 м гүнд оршуулгын хэсгийн дээр хүрэхэд илүү тодорхой мэдэгдсэн бөгөөд энэ түвшинд тонуулчдын нүхний оромны хэсэгт хар өнгийн элсэрхэг хөрс ялгарч байлаа. Оршуулгын хэсэгт модон авсны ором тод мэдэгдэж байсан бөгөөд доторх хүний ясыг ихэд бусниулж сүйтгэсэн байв. Хүний ихэнх яс авсны төв хэсэгт бөөгнөрөн овоорчээ.



*Намсрайн ухаагийн 2-р хүннү бушинаас илэрсэн олдвор, эд өлгийн зүйлс
1-4 Нумын ясан наалт; 5-6 хазаарын төмөр цагариг; 7-15 төмөр эдлэлийн үлдэгдэл;
16-21 төмөр зэвний үлдэгдэл; 22 төмөр амгай, зуузай.*

Хөлийн мөчний яснууд авсны өмнөд хагаст байгаагаас үзэхэд хүнийг толгойгоор нь хойд зүгт харуулан оршуулсан болохыг таамаглаж болохоор байв. Авсны төв хэсэгт овоорсон хүний яснууд дундаас сумын төмөр зэв, нумын ясан наалтны хугархай

зэрэг зэр зэвсгийн зүйлс олдсон. Авсны толгой талын баруун хойд булангийн шалны хэсэгт шавар ваарны ёроолын ором мэдэгдснээс үзэхэд энэ хэсэгт тахилын идээ ундааны зүйлс хийсэн шавар ваар тавьсан байсан бололтой. Мөн авсны толгой талын хананы гадна талаас төмөр амгай, хос төмөр зуузаг, 2 ш төмөр цагариг зэрэг адуу малын тоног хэрэглэлийн зүйлсийн үлдэгдэл илэрсэн юм. Оршуулгын хэсгийг цэвэрлэж авсны дараа шалгаж үзэхэд авсны баруун зүүн талын ханын гадна талаар хавтгай чулуудыг эгнүүлэн тавьж хашлага үйлдсэн нь мэдэгдсэн.

Намсрайн ухаад малтан шинжилсэн булш нь бүтэц, зохион байгуулалт, илэрсэн олдвор эд өлгийн зүйлсийн хэлбэр, хийц зэргээр Хүннүгийн жижиг булштай ижил байна. Бид авсны модноос дээж авч он цаг тогтоолгохоор илгээсэн бөгөөд уг шинжилгээний үр дүнд булшны он цагийг илүү нарийвчлан тогтоох боломжтой болох юм.

Өнгөрсөн жилийн хайгуул судалгааны явцад Намсрайн хөтөл дээрээс зүүнээс баруун тийш 1 эгнээгээр цувруулан байрлуулсан 18 ш тахилын чулуун байгууламжийг илрүүлсэн билээ. Эдгээр тахилын чулуун байгууламж нь 3-4 м голчтой, дугуй хэлбэртэй харагдах өндөр биш чулуун овоолго юм. Тахилын байгууламжийн байршил, 1 эгнээгээр цувруулан тавьсан байдал зэрэг нь сонирхол татсан тул 1-ийг сонгон малтаж, бүтэц зохион байгуулалт, холбогдох он цагийг нь тогтоох шаардлагатай хэмээн үзсэн. Маллага хийх дурсгалыг сонгохдоо гадаад чулуун дараас нь харьцангуй бага хөндөгдсөн, хэмжээгээр их томгүй зэрэг байдлыг харгалзан зүүн захаас 3 дахь байгууламжийг сонгон авсан. Энэхүү чулуун байгууламж нь 3 м голчтой дугуй хэлбэртэй, төв хэсгээр бага зэрэг овгор чулуун овоолго юм. Өнгөн хөрсний цэвэрлэгээг хийсний дараа хэлбэр нь дугуй бус тэг дөрвөлжин хэлбэртэй болох нь тодорхой болсон. Харин уг дөрвөлжингийн 4 буланг ертөнцийн 4 зүг рүү харуулан байгуулсан бололтой байв. Дээр нь овоолсон сул чулуудыг авч үзэхэд газрын өнгөн хөрсөн дээр чулуудыг эгнүүлэн тавьж дөрвөлжин хүрээ хийгээд дотор талыг чулуугаар дүүргэсэн болох нь тодорхой ажиглагдсан. Бид өнгөн хөрсөн дээр ил мэдэгдэж байсан чулуун дараасыг бүгдийг зайлуулан цэвэрлэсэн ба өнгөн хөрснөөс доош 0.5 м гүнд хүртэл малтаж үзсэн боловч ямар нэгэн эд өлгийн зүйлс, тахил тайллагын үл мөр илэрсэнгүй. Эдгээр тахилын байгууламжууд нь байрлал болон зохион байгуулалтын хувьд сонирхол татах хэдий ч маллага хийсэн дурсгалаас он цаг тогтоох ямар нэгэн эд зүйл олоогүй тул холбогдох цаг үеийг тогтоох боломжгүй байв.

**МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН „ДОРНОД МОНГОЛЫН ЭРТНИЙ
ТҮРЭГИЙН ҮЕИЙН ТҮҮХ АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС**

Г.Лхүндэв, Г.Ангарагдөлгөөн, Т.Осава, Ш.Сайто

Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Япон улсын Осака Их сургуультай хамтран Монголын зүүн бүс нутгийн эртний Түрэгийн үеийн археологийн дурсгалуудыг бүртгэн баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, зарим дурсгалыг малтан судлах зорилготой „Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх археологийн судалгаа” төслийг 2014 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус төслийн хээрийн судалгааны анги Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт буй Түрэгийн үед хамаарах зарим хүн чулуу, тахилын онгон, хад чулуунаа сийлэгдсэн бичээс зэргийг үзэж судалсан юм. Судалгааны ажлын хүрээнд дээрх дурсгалуудыг үзэх явцын далимд зам дагуу тааралдсан Монголын археологийн зарим дурсгалуудыг мөн бүртгэн баримтжуулсан. Ингэхдээ тухайн дурсгалын тодорхойлолтыг үйлдэн гэрэл зургаар баримтжуулж, байрлалыг GPS багажаар тогтоон тэмдэглэсэн болно. Эдгээр дурсгалуудын ихэнх нь судалгааны эргэлтэнд орж байсан тул дэлгэрэнгүй өгүүлэхээс зайлсхийж, аймаг тус бүрээр ялган хүснэгтлэн үзүүлэхийг зорьсон юм.

Хэнтий аймгийн долоон сумын нутгаас хүрэл зэвсгийн үеийн буган хөшөө, дөрвөлжин булш, хиргисүүр зэрэг 20 гаруй дурсгал, Түрэгийн үед холбогдох тахилын онгон, хүн чулуу, хөшөө чулуу зэрэг 46 дурсгал, руни бичээс 1, хятан бичээс 1, он цаг тодорхойгүй булш 5, тахилын байгууламж 1 зэрэг дурсгалыг бүртгэн баримтжуулсан (хүснэгт-1). Хээрийн судалгааны явцад үзэж судалсан дурсгалуудын холбогдох он цагийг тодорхойлоход хялбар байсан хэдий ч шууд тодорхойлох боломжгүй дурсгалууд байна. Ийм дурсгалууд нь зүүн талдаа зэл чулуутай, дүгрэг хэлбэрийн намхан дарааст булш, гонзгой дөрвөлжин хэлбэрийн намхан хашлагатай тахилын байгууламж зэрэг болно.

Судалгаанд хамрагдсан дурсгалуудын дотроос тамганы дүрслэлтэй Түрэг хүн чулуу, онцлог хэлбэртэй тахилын онгоны талаар цухас дурдвал:

Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг Худагтын хүн чулуу. Цайвар саарал өнгийн боржин чулуугаар босоо хүний болхи дүрстэй урлажээ. Хүн чулууг зүүн зүгт 90 хэмд хандуулан босгосон ба нүүр нь ихэд элэгдэж мөлийжээ. Толгойн орой хэсгийг шовгор хэлбэртэй дүрсэлсэн нь дуулга (малгай) байж болох талтай. Их биед гар, хөл болон бусад эд хэрэглэлийн зүйлс дүрслээгүй. Өндөр нь 174 см, мөрний өргөн 47 см, зузаан нь 18 см. Хүн чулууны цээжин хэсэгт (эрүүнээс доош 35 см-т) янгирын дүрстэй тамга, түүний дор 10 см зайд **Ф** хэлбэрийн, зүүн доод буланд өргөстэй саран тамга (буруу тийш харсан)-ыг тус тус дүрсэлжээ. Янгирын дүрст тамгыг 18x20 см, **Ф** хэлбэрийн тамгыг 13x16 см, өргөстэй саран тамгыг 15x10 см талбайд ерөнхий тэгийг 1-2 см өргөнтэй хонхойлгон цохиж сийлжээ. Хүн чулууны ард тахилын онгон байсныг илтгэх хавтант хашлаганы үлдэгдэл бий.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Агуйт уулын тахилын онгон. Агуйт уулын баруун талын тэгш газарт хагас саран хэлбэртэй үйлдсэн 14 тахилын онгон байна. Хавтан чулуудыг залгаж дөрвөлжлөн хайрцаглаж суулгаад дотор нь чулуу дүүргэсэн хашлагатай. Зарим тахилын онгоны дараас чулуу гадагш тарж анхны хэлбэр төрхөө алджээ. Бүтэн хашлаганы хэмжээ нь 3.6x3.6 м. Ихэнх хашлаганы зүүн талаас зүүн урагш хандуулан босгосон зэл чулуутай. Нэг эгнээндээ олон

тоотой үйлдсэн ийм тахилын онгон Монгол нутаг дахь Түрэгийн үеийн дурсгалуудад хоёрхон тохиолдоод байна. Нөгөө нь Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутагт байх нумарсан хэлбэртэй 13 тахилын онгон¹ бөгөөд дээрх дурсгалтай хэлбэр төрх, зохион байгуулалтын хувьд ижилсэж байна.

Хэнтий аймаг (Хүснэгт-1)

№	Дурсгалын төрөл	Сумын нэр	Газрын нэр	Гадаад байдал	Тоо
1	Буган хөшөө	Өмнөдэлгэр	Дунд Жаргалантын гол	Дөрвөлжин булшны буланд босгожээ	5
2	Дөрвөлжин булш	Өмнөдэлгэр	Дунд Жаргалантын гол	Он цагийн эрхэнд эвдэрч нурсан	7
3		Батширээт	Биндэр уул	Он цагийн эрхэнд эвдэрч нурсан	10+
4	Булш	Өмнөдэлгэр	Дунд Жаргалантын гол	Зэл чулуутай (зарим нь тоногдсон)	5
5	Хиргисүүр	Өмнөдэлгэр	Дунд Жаргалантын гол	Дагуул байгууламжтай	1
6		Дэлгэрхаан	Агуйт	Дагуул байгууламжгүй	1
7	Түрэг хүн чулуу	Өмнөдэлгэр	Баруун Баян гол	Налсан байдалтай, хашлагатай	1
8		Батширээт	Улаан Үзүүр	Босоо байдалтай, хашлагатай	1
9		Батширээт	Бархын Баян гол	Толгойн хугархай, унасан	1
10		Батширээт	Живхээстэйн ам	Босоо байдалтай, хашлагатай	5
11		Баянхутаг	Соно уул	Босоо байдалтай, хашлагагүй	1
12		Баянхутаг	Хулгар ухаа	Босоо байдалтай, чулуун байгууламжтай	1
13		Мөрөн	Зүүн хэрэм	Босоо-1, тойм дүрслэлтэй-1, хашлагагүй	2
14	Мөрөн	Худагтын ам	Босоо байдалтай, овгийн тамга тэмдэгтэй, хашлагатай	1	
15	Тахилын онгон	Батширээт	Улаан үзүүр	Баруун талд нь хүн чулууг хожим босгожээ	4
16		Батширээт	Живхээстэйн ам	Зүүн талдаа хүн чулуутай	5
17		Цэнхэрмандал	Таван толгой	Цэцгэн хээтэй	1
18		Дэлгэрхаан	Агуйт	Тал саран хэлбэртэй мөн дангаар болон хосоор байрлана	17
19	Бичээс	Батширээт	Рашаан хад	Руни бичээс 2 мөр	1
20		Хэрлэн	Эрдэнэ уул	Хятан бичээс 6 хэсэг газарт олон мөр	1
21	Хөшөө	Мөрөн	Зүүн хэрэм	Хашлаганы үлдэгдэл бий	2
22	чулуу	Мөрөн	Зүүн хэрэм	Чингисийн тулганы чулуу гэдэг	4
23	Тахилын байгууламж	Баян-Адарга	Газрын нэр тодорхойгүй	Эвдэрч сүйдсэн, он цаг тодорхойгүй	1

Дорнод аймгийн хоёр сумын нутгаас хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш 2, Түрэгийн үед холбогдох тахилын хашлага 9, хүн чулуу 1-ийг бүртгэн баримтжуулсан (хүснэгт-2).

¹ Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, Д.Х.Жискар. Монгол Алтайн археологийн дурсгалууд-1. Баян-Өлгий аймаг. Улаанбаатар, 2009. тал. 156.

Дорнод аймаг (Хүснэгт-2)

№	Дурсгалын төрөл	Сумын нэр	Газрын нэр	Хадгалалт	Тоо
1	Дөрвөлжин булш	Баян Уул	Жанчивын адаг	Дөрвөн буландаа босоо чулуутай, нэг нь тоногдсон	2
2	Тахилын хашлага	Баян Уул	Жанчивын энгэр	Зарим нь зэл чулуутай, зарим нь тоногдсон	9
3	Хүн чулуу	Хөлөнбуйр	Баян-Өлзийт	Босоо байдалтай, хашлагагүй	1

Сүхбаатар аймгийн таван сумын нутгаас хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш 3, Түрэгийн үед холбогдох хүн чулуу зэрэг 3, тахилын онгон 1, Монголын үед холбогдох хүн чулуу 14, тахилын байгууламж 5-ыг бүртгэн баримтжуулсан (хүснэгт-3).

Сүхбаатар аймаг (Хүснэгт-3)

№	Дурсгалын төрөл	Сумын нэр	Газрын нэр	Хадгалалт	Тоо
1	Түрэг хүн чулуу	Асгат	Алаг Морьт (Зүүн Ар булаг)	Босоо байдалтай, тамгатай, чулуун байгууламжтай	1
2		Эрдэнэцагаан	Жаргалантын ширээ	Босоо байдалтай, хашлагатай	1
3		Дарьганга	Хөөвөр	Босоо байдалтай, хашлагатай	1
4	Монголын үеийн хүн чулуу	Эрдэнэцагаан	Хонгор овоо	Унасан, хугарсан	2
5		Дарьгана	Хөргийн хөндий	Босоо, хугарсан, унасан	5
6		Дарьганга	Алтан овоо	Босоо байдалтай	4
7		Онгон	Шартын хад	Босоо байдалтай	1
8		Онгон	Таван толгой	Хугарч гэмтсэн	2
9	Тахилын байгууламж	Эрдэнэцагаан	Хонгор овоо	Хүн чулууны ойр орчимд байрлана	5
10	Тахилын онгон	Түвшинширээ	Донгойн ширээ	Унасан байдалтай гэрэлт хөшөөд	?
11	Дөрвөлжин булш	Асгат	Газрын нэр тодорхойгүй	Дагуул байгууламжтай	3


Тус хамтарсан төслийн хээрийн судалгааны ажлын явцад баримтжуулсан олон үеийн дурсгалуудаас Түрэгийн үед холбогдох хүн чулуу, тахилын онгоныг Монголын төв болон баруун бүс нутгийн ижил төрлийн дурсгалуудтай харьцуулахад зарим онцлог ялгаа байна. Хүн чулуу нь тооны хувьд харьцангуй цөөн байгаа нь газар нутгийн хувьд Зүүн Түрэгийн хаант улсын зүүн хязгаар нутаг байсантай холбоотойгоор хүн амын суурьшил бага байсан бололтой. Хийц загварын хувьд ихэнх нь болхи, заримдаг дүрслэлтэй. Хэдийгээр заримдаг дүрслэлтэй боловч зарим хүн чулуунд овгийн тамга тэмдгээ сийлсэн байгаа нь сонирхолтой байна. Тухайлбал: Алаг Морьт (Зүүн Ар булаг)-ын хүн чулуунд **Т** хэлбэрийн тамга, Худагын амны хүн чулуунд янгир, **Ф** хэлбэрийн, өргөстэй саран тамга (буруу тийш харсан)-ыг тус тус сийлжээ.

Газар зүйн байршил нь төдий л ялгаагүй боловч цөөн тохиолдолд намхавтар гүвээ толгодын онь хөтөл, тэгш ширээн дээр байрлана. Түрэг хүн чулууны чанд тогтсон дэг жаяг болох дөрвөлжлөн үйлдсэн хавтант хашлагын зүүн талд нүүрээр нь зүүн зүг хандуулан босгосон хүн чулуу, түүний өмнөөс наран мандах зүгийг чиглүүлэн олон зэл чулууг цувуулан босгосон дурсгал Живхээстэйн амны хүн чулуунд цогц байдлаар илэрч байна. Бусад хүн чулуунд тахилын хавтант хашлаганы үлдэгдэл байх боловч зэл чулуу огт байхгүй байна. Мөн цөөн тохиолдолд дүгрэг дарааст чулуун байгууламжийн голд эсвэл хажуу талд нь өмнө зүгт хандуулан босгожээ. Ийм хүн чулууд нь анх байсан газартаа байгаа бус хаа нэгтгээгээс зөөгдсний шинж тэмдэг байж болох юм.



Тахилын онгоны хувьд хавтан чулуудыг дөрвөлжлөн суулгаж нэг эгнээнд үйлдэж зүүн талд нь наран мандах зүгт цувуулан босгосон зэл чулуутай эгэл жирийн гэгдэх нийтлэг хэлбэртэй хашлага, гадна талыг хээ угалзаар чимсэн том хавтант чулууг хайрцаглан хийсэн, эртний Түрэг бичээстэй олон хөшөө бүхий тахилын онгон аль алин байна. Хээ угалзаар чимэглэсэн том хавтант тахилын онгон нь дэргэдээ хүн чулуутай байсан эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

Тус хамтарсан төслийн хээрийн судалгааны цаашдын ажлын үр дүнд Монгол орны зүүн хэсгийн эртний Түрэгийн үеийн археологийн дурсгалуудыг нэгтгэн баримтжуулах, хадгалж хамгаалах шаардлагатай дурсгалын талаар төсөл боловсруулах, он цагийн асуудлыг нэг мөр болгон шийдвэрлэх зарим дурсгалыг малтан судлах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.



Хэнтий аймаг Мөрөн сум. Худагтын ам. Хүн чулуу



Хэнтий аймаг Өмнөдэлгэр сум. Зэл чулуут булш



Хэнтий аймаг Дэлгэрхаан сум. Тахилын онгон



Хэнтий аймаг Цэнхэрмандал сум.
Тахилын онгон



Хэнтий аймаг Мөрөн сум. Хөшөө чулуу



Хэнтий аймаг Батширээт сум.
Улаан үзүүр. Хүн чулуу



Хэнтий аймаг Мөрөн сум.
Зүүн хэрэм. Хүн чулуу



Дорнод аймаг Хөлөнбуйр сум.
Баян-Өлзийт. Хүн чулуу



Сүхбаатар аймаг. Эрдэнэцагаан сум.
Жаргалантын ширээ. Хүн чулуу



Сүхбаатар аймаг Дарьганга сум.
Хөөвөр. Хүн чулуу



Сүхбаатар аймаг Асгат сум.
Алаг Морьт (Зүүн Ар булаг). Хүн чулуу

МОНГОЛ-ГЕРМАНЫ „ОРХОН“ ЭКСПЕДИЦИЙН 2014 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТУХАЙ

У.Эрдэнэбат, Т.Батбаяр, К.Франкен

Монгол-Германы „Орхон“ экспедици 2014 оны 7-р сарын 8-наас 8-р сарын 15-ны хооронд Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших эртний Уйгурын нийслэл Хар Балгас болон Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Монголын эртний нийслэл Хархорум хотын бүрханы шашны „Их сүм“-ийн туурь зэрэг газарт өмнөх жилүүдэд явуулсан маллага судалгааны ажлаа үргэлжлүүлэн хийж гүйцэтгэлээ. Хээрийн шинжилгээний багт Монголын талаас, төслийн удирдагч, доктор, профессор У.Эрдэнэбат, эрдэм шинжилгээний ажилтан Т.Батбаяр, МУИС-ийн ШУС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн магистрант, оюутнууд болон Хархорин сумын ажилчид, Германы талаас, ХБНГУ-ын Археологийн хүрээлэнгийн Европын бүс Соёлын Археологийн Комиссийн археологич, доктор К.Франкен тэргүүтэй 7 судлаач оролцон ажиллав.

1. Хар Балгаст хийсэн маллага судалгаа

Тус шинжилгээний анги 2009 оноос хойш Хар Балгасын дэвсгэр талбайн хэд хэдэн газарт маллага судалгаа гүйцэтгэсэн бөгөөд эдгээрээс илэрч олдсон олон зуун хэрэглэгдэхүүнтэй харьцуулах эд өлгийн баримт олж авах хийгээд өвөрмөц сонин байдлаар төлөвлөгдсөн хотын их хэрмийн зүүн урд булан дахь байгууламжийн бүтэц зохион байгуулалтыг судлан шинжлэх, үүрэг зориулалтыг тодруулах зэрэг зорилгын үүднээс тус цитадель дээр өмнөх жилүүдэд үүсгэсэн талбайгаа өргөтгөж, маллагыг шинээр нийт 250 орчим ам дөрвөлжин талбайд үргэлжлүүлэв.

2011 онд хийсэн сорилтын маллагад тулгуурлан явуулсан дараа дараагийн жилүүдийн маллага судалгааны үр дүнд цитадель гэж нэрлэдэг хотын энэхүү хэсгийн архитектурыг судлах цоо шинэ эх хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж байна. Цитадель нь НВ2 буюу сүм/ордон хотын яг зүүн урд буланд шавар, хайрга, элс шороо үелүүлэн дэлдэж хийсэн бараг 7 м өндөр 60х70 м орчим аварга том тавцан дээр байрлах бөгөөд зүүн болон урд талаасаа дор хаяж 12 м өндөр хадгалагдсан ордон хотын хэрмээр хамгаалагджээ.

Одоогийн байдлаар цитадель дээрхи байгууламж нь баруун болон хойд талдаа хаалга үүдтэй байсан нь мэдэгдэх бөгөөд үүгээр үзэхэд зөвхөн ордон хотын хэрмийн дотор талаас л орж гарах боломжтой байсан аж. 2013-2014 онд уг байгууламжийн баруун талын ханын зохион байгуулалтыг дайруулан малтаж хаалганы байгууламжийг илрүүлэн олсон юм. Энэ маллагын явцад уг байгууламж руу орж гарах хаалга үүдний ор үлдэгдэл илэрч мэдэгдсэн төдийгүй элс, шавар үелүүлэн дэлдэж хийгээд шургааг модоор бэхлэн гадуур нь тоосго өрж гадарласан 5 м өргөн ханатай байсан нь илрэн гарч байна. Эндээс газар суулгасан хаалганы самбарын бэхэлгээ ба хаалга руу очдог замын хэсгийг модон банзаар шалласны үлдэгдэл ч олдсон билээ. Харин хаалганы байгууламжийн дотор талыг шатаасан тоосго дэвсэн шалласан бөгөөд бороо, цасны ус тогтохгүй урсаж гарахаар тооцоолж гадаргууг нь хийсэн ажээ.

Хаалга үүдний эдгээр зохион байгуулалтаас гадна эндээс өгсөж гарах тусгай шат бүхий тоосгоор өнгөлсөн тавцанг малтаж гаргав. Энд илэрсэн олдворын цогц байдлаас үзэхэд, хэрмийн баруун хаалгаар ороод цааш тусгай тоосгон замаар

явж 0,7 м өндөр тавцан дээр байрлуулсан гурван гишгүүртэй жижгэвтэр шатанд тулж улмаар түүгээр дээш өгсөж цитадель хэмээх энэхүү байгууламж руу нэвтрэн орж гардаг байсан бололтой. Эдгээр олдворын цогц байдал түүнийг хүрээлж байгаад дээрээс нь нурж унасан асар том шавар ханын нурангин дор байлаа. Эндээс модон банзаар шаласан шатны гишгүүр, модон жаазан хүрээнд ердийн шатаасан тоосгыг дээр дээрээс нь давхарлан өрөх маягаар хатавчийг нь өнгөлсөн хаалганы үлдэгдэл, бороо цасны ус зайлуулах суваг бүхий тоосгон зам зэрэг үг байгууламжийн зохион байгуулалтыг судлахад чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүн олдсон юм.

Хаалганы зохион байгуулалтаас гадна цитаделийн зүүн өмнөд хэсэгт явуулсан малтлагаас монументаль архитектурын олон тооны үлдэгдэл илрэн гарлаа. Энэхүү барилгын зарим хэсгийг бүр XX зууны эхээр Оросын археологичид малтсан байлаа. Хүрээлэн буй хэрмийн зузаан ба үүрэг харьцааны тухай асуудлыг судлах зорилгоор оросуудын малтлагын хуучин нүхийг зүүн тийш нь өргөтгөн тэлж малтлагыг үргэлжлүүлэв. Хүчтэй галд шатсан тоосго, дээврийн ваар голдуу бараг 4 м зузсан үнс нурангийг зайлуулан малтсаны дараа барилгын өрөө тасалгааны хэсгүүд илрэн гарч эхэлсэн. Одоохондоо энэхүү барилгын тасалгааны зөвхөн баруун болон зүүн ханыг баримтжуулсан бөгөөд хойд ба урд хэсэг нь хэр үргэлжилж байгааг ирэх жил тогтоох болно. Өрөөний дотор талыг барилгын дээврийг тулж байсан гурван эгнээ баганын суурь чулуу зааглан хувааж байна. Эдгээрийн онцлог байдал гэвэл, төвийн хэсэгт байрласан бөгөөд дээвэр нурууны хамгийн их даралтыг тулах хүнд даацын баганын сууриудыг маш зузаан бат бөх чулуугаар ихээхэн үр гарган хийж, харин зах хөвөөгөөр байрлах баганын сууриудыг нимгэвтэр чулуугаар хийсэн нь цөм анхны байрандаа хадгалагдаж үлдсэн байлаа. Баганы суурь бүрийг тусгайлан зассан байх бөгөөд үндсэндээ хоёр янзын хийц загвар голоно. Тухайлбал, хоёр зах болон дунд эгнээнний нэг нийт арван нэгэн суурь (65 x 70 см x 25 см) нь ямар нэгэн хээ чимэг үгүй, тэг дөрвөлжин хэлбэрийн энгийн хийцтэй бол дунд эгнээнд буй баганын дөрвөн суурь (115 x 118 x 28 см) нь дөрвөн тал бүхий хавтгай оройтой, дөрвөлжин суурьтай, орой дээрээ баганын мод суулгах тусгай ховил гаргаж зассан уран хийцтэй байна.

Баганы суурь чулууны хооронд илэрсэн шалны төвшинд хөх саарал өнгийн шавар зуурмаг мэдэгдэх бөгөөд барилгын дотор талын өрөө тасалгаануудыг шатаасан хөх тоосгоор хоёр давхарлаж шаласан байжээ. Барилгын шавар ханыг хоёр талаас нь хашсан дүнзэн баганын үлдэгдэл малтлагын үед биет байдлаар цөөн тоотой гарсан ч гэсэн, модон багана нь шатахад үлдэж хоцорсон хоосон ормууд нь шавар ханан дээр тун сайн хадгалагдаж үлдсэн байв. Энд хадгалагдсан олдворын цогц байдлыг үзэхэд, шавар ханыг бэхэлсэн багануудыг гурав болон таваар нь хэсэгчлэн эгнүүлж хооронд нь тодорхой зайнд нарийн эрэмбэ дараатай байрлуулсан байжээ. Барилгын хана барих энэхүү өвөрмөц технологи нь Хар Балгасын энэ хэсгийн барилга байгууламж хэдий үеийн, аль газрын уран барилгын хийц төлөвлөлтөөр баригдсан асуудлыг тодруулахад ихээхэн чухал хэрэглэгдэхүүн болох нь эргэлзээгүй. Барилгын өрөөг заагласан ханын зохион байгуулалтаас 1-3 м өндөр хадгалагдсан бөгөөд хийсэн байдлаараа өөр хоорондоо ялгаатай байна. Шавар үелүүлэн дэлдэж хийсэн зузаан ханын дотор ба гадна талыг модон баганаар бэхлэж дээрээс нь шавраар шавж чимэглэл зурж байсан ором мэдэгдэж байв. Ханыг ингэж хосолмол байдлаар хийснээр томоохон барилгын дээвэр нурууны эд ангиудыг холбож тогтоох ба нүсэр хүнд дээврийг тулах даацыг сайжруулахад чухал нөлөөтэй болжээ. Энэхүү барилгын ханын зузаан, хадгалагдаж үлдсэн өндөр, баганы суурийг хийж урласан байдал, өрөө тасалгааны хэмжээ зэрэг уран барилгын бүрдэл хэсгүүд нь бүхэлдээ

Хар Балгаст одоо хүртэл мэдэгдсэн барилгуудынхаас нэн онцлог юм. Ялангуяа сүрлэг том байдал, барилгын бүрдэл хэсгүүдийн өвөрмөц байдал нь энэ барилга ямар нэгэн онцгой үүрэгтэй байсныг илтгэн харуулна. Тэрчлэн эндээс гарсан цөөн тооны олдворууд ч гэсэн иймэрхүү сэтгэгдэл төрүүлж байна.

Хар Балгасын цитадельд хийсэн маллагын явцад хүчтэй гал түймэрт эрсдэн шатаж устсан сүрлэг том барилга болоод шороо дэлдэж хийсэн хүчирхэг их хэрмийн бүтэц зохион байгуулалтыг хадгалсан зузаан үе давхрагууд, харьцангуй өндөр бөгөөд сайн хадгалагдсан барилгын зузаан хана туургын үлдэц, барилгын дээвэр нурууг тулж байсан баганын чулуун сууриуд, шавар ба тоосгон шалны үлдэгдэл зэрэг VIII-IX зууны Уйгурын нийслэл хотын барилга архитектурын бүтэц зохион байгуулалтыг судлах шинэ эх хэрэглэгдэхүүнийг илрүүлэн олсон билээ. Үүний хамт барилгын хэрэглэгдэхүүн болох шатаасан болон түүхий тоосго, модон хийцийн үлдэгдэл, янз бүрийн төмөр хадаас, дээврийн нөмрөг ба тосгуур ваар, шавар сав суулганы хагархай, дээврийн чимэглэл болох хэдэн төрлийн хээтэй нүүр ваар, нэн ялангуяа байшин барилгын нуруу, дээврийн хэсэгт муу муухай бүхнээс хамгаалахыг бэлгэдэн байрлуулдаг домгийн амьтны шавар баримал дүрсийн үлдэгдэл, өнгийн будаг бүхий ханын шаваас, сийлбэртэй ясан чимэглэлийн хугархай, төмөр сөргөө, харвуулын сүмны зэв, гантиг чулуун самбар дээр алт суулган сийлж бичсэн хятад бичээстэй сүмийн сүнсэн тахилын үлдэгдэл, элдэв янзын тамга тэмдэгтэй дээврийн ваарны хагархай, цэцгэн толгой бүхий алтан шармал зэс хадаас, цэцгэн зэс чимэглэл, маш гоёмсог хээ чимэгтэй жижигхэн чулуун тулгуур зэрэг онцлох эд өлгийн зүйлс олдсон юм. Хар Балгасаас олдсон эдгээр олдвор хэрэглэгдэхүүн ба уран барилгын зарим бүрдэл хэсгүүд нь БНХАУ-ын нутагт буй Тан улсын нийслэл Чан'ань хотын маллага, ОХУ-ын Тувад байдаг Уйгурын Пор-Бажын болон Монголын төв нутаг Орхоны хөндийд малтан судалсан Уйгурын бунхант булшны олдворуудтай ижил төстэй, харьцуулан үзэж болохоор байна.

2013-2014 оны зун Монгол-Германы Орхон экспедици Хар Балгасын их хэрмийн цитадель дээр ийнхүү гол судалгаагаа төвлөрүүлэн явуулсны зэрэгцээ мөн энэхүү байгууламжийн чанх урд харалдаа, цайзат их хэрмийн гадуур тойрсон шуудууг судалгааны хүрээнд хамруулан хөрсний дээж авах, бүтэц зохион байгуулалтыг тодруулан судлах зорилгоор зүсэлт хийж малтав. Сорилтын маллагын үр дүнд, уг шуудуу 4 м орчим өргөн, 2 м-ээс илүү гүнтэй, сүвгийг нь банзан хашлагаар хүрээлж хамгаалсан байсныг урьдчилсан байдлаар тогтоогоод байна. Модон хашлагын үлдэгдэл бүхэлдээ шатсанаас үзэхэд сүвгаар ус урсахаа больж нэгэнт хуурайшсаны дараа хотын энэ хэсэг гал түймэрт автан сөнөсөн бололтой.

2. Хархорумын „Их танхим”-ын маллага шинжилгээ

1948-1949 онд Хархорум хотын талбайд өргөн хэмжээний маллагын ажил анх гүйцэтгэсэн С.Киселев ахлагчтай Монгол-Зөвлөлтийн хамтарсан судалгааны ангийн судлаачид энэ хотын их хэрмийн дотор, баруун өмнөд өнцөгт нь орших тусгай хэрэмт цогцолборын төв дундах том барилгын үлдэгдлийг хэсэгчилсэн байдлаар малтан судалж, уг барилгыг Өгэдэй хааны „Түмэн амгалант орд” хэмээн тодорхойлсон нь олон жилийн турш монгол судлалын хүрээнд нийтээр хөдөлбөргүй дагаж мөрдөх цорын ганц үзэл баримтлал болж ирсэн билээ.

Гэвч энэ барилга нь хааны орд харш бус, харин 1235/36 онд суурийг нь тавьж, 1256 онд барьж дуусган 1346 онд эзэн хааны зарлигаар „Юань улсыг мандуулах асар” буюу „Цогт их сүмийн гэр” хэмээх нэр хайрлаж дурсгалын хөшөө босгосон

бурхан шашны аварга том сүмийн үлдэгдэл болох нь Монгол-Германы хамтарсан археологийн экспедицийн үйл ажиллагааны үр дүнд олон баримтаар нотлогдоод байна.

2014 онд ёслол тэмдэглэж байгаа ХБНГУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн хүрээнд хийж буй олон ажлын нэг нь Хархорум дахь бурханы шашны их сүмийн археологийн үлдэцийг хамгаалах, өргөн олон түмэнд үзүүлэх ил музей болгон эзэмшиж ашиглах бүтээн байгуулалтын төсөл юм.

Энэхүү төслийн ач холбогдлыг өндөр үнэлж ХБНГУ-ын Гадаад Хэргийн Яам, Герда-Хенкель сан, Германы Археологийн Хүрээлэнгээс санхүүжүүлж байгаа бөгөөд Монгол Улсын ССАЖЯ-наас зохих хөрөнгийн эх үүсвэрийг гаргаж хоёр орны мэргэжлийн археологич, архитекторуудын удирдлагаар Монголын „Ордгео“ ХХК бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна.

Монголын эртний нийслэл Хархорум хотод монгол, герман археологичид хамтран 15 дахь жилдээ маллага судалгаа хийж байгаа бөгөөд маллагаар илэрсэн үл хөдлөх дурсгалуудын анхны дүр төрхийг нь алдагдуулалгүй, хүрээлэн буй байгаль орчинд нь зохицуулан бэхжүүлэн хадгалж олон нийтэд зориулсан эртний түүхийн биет музей болгохоор төлөвлөж байгаа нь энэ чиглэлээр манай оронд хийгдэж буй анхны ажил болох юм.

Хархорумын Цогт их сүмийн археологийн маллагын ил музей байгуулах төсөл нь хоёр үе шаттай хэрэгжих бөгөөд эхний үе шатанд их сүмийн барилгын суурийн нүүрэн талыг хүрээлж байсан ханын хэсгийг цэвэрлэх маллага хийж 1948 оноос хойшхи хуучин маллагаас гаргасан дагтаршсан шороог эндээс археологичдын хяналтан дор техникийн хүчээр зайлуулах явдал байв.

Бид хуучин сүмийн турь буюу Халхын Өндөр гэгээн Занабазарын эх Ханджамц хатны суваргын дэргэд овоолж орхисон хуучин маллагуудаас хуримтлагдсан дагтаршсан шороог Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг даргын Тамгын газартай зөвшилцсөний дагуу орон нутагт байгаа хүнд даацын машин механизмыг хөлслөн 2014 оны 4 сарын 15-24-ний хугацаанд зөөж зайлуулав. Хуучин маллагын шороог зөөж хотын төв хэсэг дэх 1948/49 оны Монгол-Зөвлөлтийн, 2000-2005 оны Германы Бонны Их Сургуулийн малтсан том нүхийг дарлаа.

Ийнхүү техникийн хүчээр шороо зайлуулах ажлын явцад Эрдэнэ зуу хийдийн хойд талд, эртний Хархорумын дэвсгэрт, Ханджамц хатны суваргаас зүүн тийш 450 м зайтай хэсэг газар цөмөрч 120x100 см хэмжээтэй, амсар нь зууван дугуй хэлбэртэй гүнзгий нүх санамсаргүй байдлаар илэрч мэдэгдсэн юм. Уг нүхэн дотор доош цөмөрсөн шороо орж дарагдсан боловч одоо мэдэгдэж байгаа гүн 300 см орчим байв. Дотогш цөмөрч орсон хөрсний зузааныг хэмжиж үзэхэд 140 см хүрч байлаа. Иймээс уг нүхний гүн дор хаяж 440 см-ээс багагүй байгаа бололтой гэж үзлээ. Нүхний дотор талын ханыг шалгаж үзэхэд усанд идэгдэж хужир урган цайрсан шинжтэй. Одоогийн өнгөн хөрснөөс доош 140 см төвшинд нүхний амсрыг тойруулан хавтгай чулуугаар өрж хашсан мэт бөгөөд дээр нь хуучин модны үлдэгдэл мэдэгдэж байв.

Хархорумын дэвсгэрт санамсаргүй байдлаар илэрсэн энэхүү цооног нүх бол эртний худаг юмуу ямар нэгэн усжуулалтын системтэй холбоотой байгууламж байж болох юм. Дурсгалын координат: N47°12'32.5, E102°50'46.6, далайн төвшнөөс дээш 1458 м өндөрт оршино. Нүхэн дотор орж шалгаж үзэхэд зүүн хойд ханын хэсэгт булангийн дагуу 30 см орчим урт модны үлдэгдэл мэдэгдэж байгаа нь уг цооногийг модоор доторлож байсны үлдэц бололтой. Нүхэн дотор ямар нэг эд өлгийн олдвор


мэдэгдээгүй. Энэхүү сохор худаг бололтой цооног нүх нь эртний Хархорум хотын төвд буй хойд-урд чиглэлтэй их гудамжны баруун талын нэгэн барилгын баруун захад, хэсэг дэрс ургасан жижиг овгорын баруун талд, 1948/49 онд С.Киселевын экспедицийн малтсан „Гудамжны уулзварын барилгын” том нүхнээс баруун тийш 100 м орчим зайтай орших бөгөөд газрын өнгөн хөрсөн дээр ямар нэг барилга байгууламж байсан гэж мэдэгдэх шинж тэмдэг үгүй, тэгш гадаргуутай газар байгаа юм.

Бид шороо зөөх ажлын явцад илэрсэн эртний худаг бололтой нүхийг банзаар таглан, шороо чулуугаар далдан битүүмжилж, хүн мал, машин тэрэг дайрахаас сэргийлэн улаан тоосгоор алсуур тойруулан хашсан тэмдэг тавьж орхиод 2015 оны зун Орхоны хөндийд ажиллахдаа сорилтын малтлага хийж үзэхээр шийдвэрлэж, шинээр илэрсэн дурсгалын тухай Өвөрхангай аймгийн Хархорин сумын Засаг даргын Тамгын газар, Орхоны хөндийн тусгай хамгаалалтай газрын Хамгаалалтын захиргаа, Хархорум музейн удирдлагуудад албан ёсоор мэдэгдэж, орон нутгийн хамгаалалтанд үлдээсэн болно.

Хархорум дахь бурханы шашны их сүмийн түрийг хамгаалах, олон нийтэд үзүүлэх археологийн ил музей болгох зорилгын үүднээс 2013-2014 оны судалгааны хүрээнд уг сүмийн түрийн гол барилгын шороон довжооны дөрвөн талыг тойруулан нийтдээ 1600 м² орчим талбайд хөрс шороог цэвэрлэж малтах ажлыг гүйцэтгэж барилгын суурийг бүрэн хэмжээгээр малтаж ил гаргасан болно. Малтлага судалгааны явцад, барилгын дээврийн чимэглэл болох хэдэн янзын хээ бүхий ногоон паалантай чимэглэлийн хэсгүүд, нүүр ваарны хагархай, шавар баримал дүрсийн үлдэгдэл, хэд хэдэн төрлийн шаазан савны хагархай, хятад бичээстэй хүрэл зоос, хаадын овгийн тамга бүхий тоосго зэрэг сонирхолтой олдвор хэрэглэгдэхүүнийг илрүүлсэн юм.

2014 онд явуулсан судалгаагаар, дээрх онцлог олдворуудаас гадна тухайн газрын үүрэг зориулалтыг тайлбарлахад үлэмж ач холбогдолтой шинэ мэдлэг олгосон олдворын цогц байдал уг сүмийн суурийн дөрвөн булангийн дороос тус бүр суурийг дэлдэх үед тэнд аравнайж тавьсан шүншиг олдсон нь онцгой ач холбогдолтой. Сүмийн шүншигт тариа будаа, төрөл бүрийн жимс, алтан утастай торгонд боодолтой „есөн эрдэнэ” (үүнд: Монгол гүрний их хаадын алтан зоос 2 ш, мөнгөн зоос 3 ш, шүр, сүвд, оюу) орсон бөгөөд эдгээрийг том вааран саванд хийж амсрыг нь шавар тагаар таглаж тавьжээ. Есөн төрлийн материалаас бүрдсэн эд юмс нь бүтээн цогцолсон суварга шүтээнийг амилуулан тэтгэх нарийн нандин бэлгэдэлтэй бөгөөд Хархорум хотод монгол, герман археологичдын малтан судалсан энэхүү байгууламж XIII-XIV зууны бурханы шашны сүм байсныг бүрэн дүүрэн нотолж өглөө.

Монгол-Германы хамтарсан экспедицийн 2014 оны малтлага судалгаагаар Язгуурын таван бурханы ивээл дор Их Монгол Улс үүрд мөнх мандан бадарч байхын бэлгэдэл болсон энэхүү сүмийн довжоо суурин дороос XIII зууны үед их хаадын аравнайж хийсэн шүншигийг ийнхүү илрүүлэн олсон нь Монголын эртний түүхийн судалгаа, археологийн шинжлэх ухаанд гарсан нэгэн шинэ нээлт боллоо.



Зураг 1: Архангай, Хотонт, Хар Балгас. Монгол-Германы Орхон Экспедицийн малтлага судалгаа явуулж буй газрыг тэмдэглэсэн нь



Зураг 2: Архангай, Хотонт, Хар Балгас. Цитадель дээрх малтлага судалгааны явц



***Зураг 3:** Архангай, Хотонт, Хар Балгас. Цитадель дээрх байгууламжийн баруун талын хаалганы хэсэг*




***Зураг 4:** Архангай, Хотонт, Хар Балгас. Сөргөө*



Зураг 5: Архангай, Хотонт, Хар Балгас. Цитадель дээрх барилгын ханын өрлөг, баганын чулуун сууриуд, тоосгон шалны үлдэгдэл



Зураг 6: Архангай, Хотонт, Хар Балгас. Гантиг чулуун самбар дээр алт суулган сийлж бичсэн хятад бичээстэй сүмийн сүнсэн тахилын үлдэгдэл



Зураг 7: Өвөрхангай, Хархорин, Хархорум. “Их танхим” буюу Юань улсыг мандуулах асрын суурийн малтлагаас илэрсэн олдворын цогц байдлын дэвсгэр зураг



Зураг 8: Өвөрхангай, Хархорин, Хархорум. “Их танхим” буюу Юань улсыг мандуулах асрын суурь довжоог малтаж гаргасны дараа хамгаалалтын хана барьсан байдал.



Зураг 9: Өвөрхангай, Хархорин. Монголын эртний нийслэл Хархорум. Юань улсыг мандуулах асрын сууринд 2014 онд явуулсан малтлагаар илэрсэн шүнишиг



Зураг 10: Өвөрхангай, Хархорин. Монголын эртний нийслэл Хархорум. Юань улсыг мандуулах асрын шүнишигээс илэрсэн есөн эрдэнийн бэлгэдэл



Зураг 11: Өвөрхангай, Хархорин. Монголын эртний нийслэл Хархорум. Юань улсыг мандуулах асрын шүнишигээс илэрсэн Монголын их хаадын алт, мөнгөн зоос



Зураг 12: Өвөрхангай, Хархорин. Монголын эртний нийслэл Хархорум. Юань улсыг мандуулах асрын сууринд хийсэн малтлагаар илэрсэн шавар барималын толгой

**ДОРНОД АЙМГИЙН ЦАГААН-ОВОО СУМЫН НУТАГТ ОРШИХ
ХЭРЛЭН БАРС 1 ХОТЫН СУВАРГАНД ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН
МАЛТЛАГА СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮН**

*А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Г.Батболд,
Ц.Буянхишиг, Т.Хантөгс*

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутагт орших Хэрлэн Барс 1 хотын суваргыг сэргээн засварлах ажлын хүрээнд „Соёлын Өвийн Төв”-ийн хүсэлтийн дагуу ШУА-ийн Археологийн Хүрээлэн суваргын дотоод болон гадаад зохион байгуулалтыг нарийвчлан тодруулах малтлага судалгаа хийсэн юм.

Суварганы дотор хэсэгт ихээхэн хэмжээний хурдас хуримтлагдсан бөгөөд зүүн өмнө талын хаалганы доод хэсэг нурж онгорхой болсон нь 1 болон 2-р давхарыг дамнасан өндөр хаалга мэт харагдаж байна. Мөн суваргын дээвэр болон хаалганы доод нуранхай нь дотор талын хурдас хойноос урагш налуу болоход нөлөөлсөн бололтой (зураг 1). Хойд хана хэсгээр ихээхэн хэмжээний малын бууц, өтөг, шувууны сангас хуралдсан байна.

Ингээд нурж цөмөрсөн ханыг голмуулан хойноос урагш тэнхлэг татсан бөгөөд дотор хэсгийн диаметр 5,2 м байсан тул хойд ханаас урагш 260 см дээр төвийн цэгийг авч хөндлөн огтолын тэнхлэг татаж А, Б, В, Г хэмээн 4 хэсэгт хуваасан ба эхний ээлжинд А талбайг сонгон малтлаа. Энэ нь суваргын дотор хэсэгт хадгалагдан буй соёлт давхаргын бүтцийг тодруулах хамгийн өндөр хэсэг юм.

Малтлагын товч тодорхойлолт

Малтлагын эхний гурван үеийн хөрсний бүтэц ерөнхийдөө хоорондоо төстэй боловч 2-р үе нь хатууран дагтаршсан хөрсөн мэт үе байсан бөгөөд суварганы ханыг дагаад сулавтар зөөлөн байлаа. Энэ нь бороонд норж мөн мал амьтан ихээр орж хэвтсэнийх бололтой. Эдгээр үеүдэд цаасан номын тасархай, даавууны тасархай, шагай, малын яс, шавар цац, бурханы шавар баримал, даавуун дээр зурсан бурхны хөрөг (танка), тоосгоны хагархай зэрэг эд өлгийн зүйлс илэрч байлаа. 3-р үеэс тоосгоны хагархай холилдож эхэлсэн бөгөөд малтлагаас илэрсэн номын тасархайн ихэнх нь энэ үеэс илэрч байлаа. Дараагийн үеэс барилгын нуранги багасаж эхэлсэн бөгөөд түүний доор шувууны сангас мэрэгчийн яснууд ихэвчлэн байгаагаас үзвэл энэ үед суваргын зүүн өмнө талын хана нураагүй буюу мал орж ирэх боломжгүй байсан бололтой. Энэ үеийн малтлагаас өмнөхтэй адил дээврийн ваарын хагархай, тоосгоны хэлтэрхий, цаасан номын хуудас, баруун урд ханын орчмоос хүрэл цөгц зэрэг илэрсэн.

5, 6, 7-р үеүдэд хөрс бага зэрэг хатуу болж ирсэн бөгөөд дээврийн ваарын хэлтэрхий ихсэж тоосгоны хагархай багасаж эхэлсэн. Мөн суварганы төв хэсгээс „тонуулын нүхний ором” тодорхой мэдэгдэх болсон нь хөрсний байдал өөрчлөгдөж шороон үе эхэлсэнтэй холбоотой. Улмаар 144 см гүнээс буюу малтлагын 7-р үеэс нүүр ваарын цөөн тооны хэлтэрхий болон дээврийн дусал ваар илэрсэн. 8-р үед суваргын доод шал буюу дагтаршуулсан шороо гарснаар малтлагыг зогсоолоо (зураг 2).

Суваргын төв хэсэгт буюу малтлагын талбайн зүүн урд булан хавьд байсан „тонуулын нүх” үргэлжилсээр байсан бөгөөд энэ нь 1м-ээс гүн байгаа бололтой.

Мөн энэхүү нүх нь тонуулчид орохоос өмнө „шонгийн нүх”, эсвэл „шүншгийн нүх” байсан байх магадлалтай юм (зураг 3).

Малтлагын талбайн урд хананд өнгөн хөрснөөс доош 30 см гүнд ойролцоо 3 ш даавууны өөдөс цухуйж байсан тул бид В талбайн баруун хананд тулган 1 м өргөнтэй 35 см гүнтэй нэмэлт малтлага хийв. Эндээс 460 x 15 см хэмжээтэй, төвд үсгээр бичсэн унжлага даавуу илэрсэн.

Хэрлэн Барсын суваргын суурь чухам ямар байсан талаар тодруулах зорилготойгоор гадна талд 1x5 м хэмжээтэй сорилын сувгийг суваргын баруун хойд талд уг суурийн булангийн чиглэл дагуу татаж эхлүүлэв. Суварга ойролцоогоор 300 тонн орчим жинтэй гэж үзвэл энэхүү нүсэр байгууламжийг олон зуун жилийн турш хадгалан өнөөг хүргэсэн гол зүйл бол суурь юм. Тиймээс одоо өнгөн хөрсөнд ил харагдаж буй ойролцоогоор 12,4x12,4 м хэмжээтэй тэгш өнцөгт дөрвөлжин чулуун өрлөг байгаа бөгөөд түүний гадна талаар ахин шатласан байж болзошгүй чулуун байгууламж байгаа учир энэхүү суурийг тодруулах зорилготойгоор дээрх сорилын малтлагыг хийсэн юм (зураг 4).

Суварганы гадна талд баруун талд болон өмнө, зүүн өмнө талд хүний гараар бүтээсэн бололтой гурван хонхор байна. Энэ хонхорыг бид бороо, цасанд автуулахгүй байлгах, усыг хуримтлуулах цөөрөм байсан байж болох юм хэмээн таамаглаж байна. Учир нь энэхүү байгууламжийн суурь усанд автах л юм бол нуралт үүсэх нь хялбар тул энэхүү тойрсон суваг болон „цөөрмийн” тусламжтайгаар усаа хурдан шавхдаг байсан байж болох талтай байна. Зүүн талын цөөрмийн одоо байгаа гүн, дагтаршуулсан шалнаас доош 180-186 см гүнтэй байгаа нь уг суварганы сууриас харьцангуй доош энэхүү „цөөрөм” оршиж байгааг баталж буй мэт. Өмнө талын „цөөрмийн гүн” нь 156 см байхад баруун талынх нь 89 см гүнтэй байна.

Мөн баруун талаар явсан машин замаар нэгэн дурсгал ил гарсан нь уг суваргыг байгуулж байхад, эсвэл хожим засварлаж байхад үйлдсэн байж болох 190x190 см хэмжээтэй тэгш дөрвөлжин, 1 үе тоосгыг хажуу талаар нь хавиргалан босгож газарт суулган дотор талд нь шохой зуурч байсан шохойн оромтой тогоо илэрсэн нь цаашид өргөн хүрээтэй малтлага хийх шаардлагатайг харуулж байна.

Шашны холбогдолтой эд өлгийн зүйлс

Малтлагаар илэрсэн шашны холбогдолтой олдворуудыг дотор нь хэд хэд ангилж болохоор харагдаж байна. Цаас болон үйсэн дээр бичсэн ном, судрын тасархай 82, эдгээрээс монгол бичгийн 64, түвдээр бичсэн 15 тасархай илэрлээ. Мөн даавуун дээр урласан бичиг болон бүрхны хөрөг 4 илэрсэн бөгөөд үүнээс дээрээ бичиг бүхий даавуу /түвд бичигтэй унжлага 4м урт, 5м урттай/ 2, бүрханы хөрөг 2 байна (зураг 5, 6).

Эдгээрээс гадна төмөрлөг, шавар, модоор хийсэн эдлэлүүд нилээд илэрсэн бөгөөд үүнд: төмөрлөг эдлэлүүд нь хүрд, тахилын аяга, гүнгэрваа зэрэг байна. Шавар эдлэлүүд нь шавар барималын хэлтэрхий, бүрхны хөрөг, бумба, цац зэрэг болно. Модон эдлэлүүд нь гүнгэрваа, сийлбэртэй модон чимэглэлийн хэсгүүд илэрч байлаа (зураг 7, 8).

Ахуйн зориулалттай эд өлгийн зүйлс

Малтлагаас ихээр илэрсэн зүйлсийн нэг нь даавууны тасархайнууд юм. Эдгээрийн ихэнх нь сэмэрч муудсан бөгөөд материал, хэлбэрийн хувьд өөр өөр ба

нийт 21 даавуу байна. Мөн сувс, сурны тасархай, дээсний тасархай, бүсний арал, хадаас, төмөр гархи, төмөр эдлэлийн хэлтэрхийнүүд, паалантай ваарны хагархай 1 ширхгийг тус тус олж илрүүлсэн. Эдгээрээс гадна маллагын талбайн бүх үеэс хээтэй, хээгүй шагайнууд илэрч байв. Үүнд хээтэй шагай 9 ширхэг, зассан шагай 1 ширхэг, хээгүй шагай 119 байна (зураг 9, 10).

Барилгын материал

Маллагын талбайгаас хамгийн ихээр илэрсэн олдвор нь тоосгоны хагархай бөгөөд зарим үед цөөн боловч маллагын үе бүрээс илэрч байлаа. Илэрсэн тоосгоноос цөөн тооны бүтэн тоосго илэрсэн бөгөөд энэ нь нэг талыг нь гурвалжлан зассан, дөрвөлжин гэсэн хоёр төрлийн тоосго байна. Дөрвөлжин тоосгоны урт 28.5 см, өргөн 14 см, зузаан 6.7-5.9 см бол нэг талыг нь гурвалжлан зассан тоосгоны урт 27.5 см, өргөн 19.5 см, зузаан 5.9 см байна. Маллагын талбайд дээврийн ваар цөөнгүй илэрсэн бөгөөд эдгээр нь хэмжээ, хийц, найрлагын хувьд ерөнхийдөө 2 төрөл байна. Гэвч хэмжээ авах бүтэн ваар илрээгүй байна. Мөн маллагын талбайгаас дээврийн дусал ваар 1 ш, нүүр ваарын хэлтэрхий 2 ш, ханын шохойн жижиг хугархай зэрэг илэрсэн билээ (зураг 11, 12).

Эдгээрээс гадна маллагаас малын яс ихээр илэрсэн нь махчин шувуу, махчин амьтны авчирч хураасан яс бололтой. Эдгээрийн дотроос хүний эрүүний яс 2 ширхэг илэрсэн нь ил тавьсан шарилын үлдэгдэлийг амьтан зөөсний баримт болов уу.

Дүгнэлт

Бидний маллагын өөр нэгэн зорилго нь 1770-аад оны сурвалжид суварган дотор ханын зураг байсан хэмээн тэмдэглэснээс хожим ахин сэргээсэн зураг байсан юм биш биз хэмээн таамаглаж байсан боловч маллага судалгааны үеэр ямар нэгэн ахин засварлаж байсан гэх үл мөр илрээгүй юм. Тиймээс бидний 4-р үе хэмээн дугаарласан үе соёлт давхаргын бараг 80 см орчимоос эхлэсэн бөгөөд энэ үед малын өтөг бууц байхгүй байгаагаас үзэхэд XVIII зууны үед мал амьтан орох боломжгүй, шувуу үүрээ засдаг байсан бололтой. Гэвч энэ үед нурж эхэлсэн байсныг тоосгоны нуранхай илтгэж байна. Гэвч бидний үзэж байгаагаар нурж байсан ч дээвэр болон бусад хэсгээр ус орох нь харьцангуй бага байсан тул ханын зураг XVIII зуун хүртэл хадгалалт сайн байжээ хэмээн үзэж байна.

Суваргын гаднах маллагын үр дүнд гадна талын чулуу гадагш өргөсгөн өрсөн өрлөг бус, энэхүү чулуун өрлөгийн хаяаг манасан шинжтэй суваргийн суурь байгууламж байж болох юм гэсэн урьдчилсан дүгнэлтэнд хүрсэн юм.

Олон жилийн турш суваргын дотор хуримтлагдсан хурдаст өнөөг хүртэл олон соёлт давхаргыг үүсчээ. Маллагын эхний үеүдэд малын бууц, үнс, шороо холилдсон үе байсан бөгөөд энд шарын шашны холбогдолтой нилээд хожуу үеийн эдлэл хэрэглэл, даавууны тасархай, шавар цац, цаасан номын тасархай, даавуун дээр бичсэн төвд болон соёмбо үсгээр бичсэн унжлага зэрэг зүйлс илэрсэн байна. Энэ нь уг суваргыг сүүл үе хүртэл шүтэж ирсний илрэл болж байна.

ХАВСРАЛТ



Зураг 1. Суваргын дотор тал.



Зураг 2. "А" талбай. Дагтаршуулсан шал.



Зураг 3. "А" талбай. Тоннуулчид орсон нүх



Зураг 4. Суварганы зүүн хойд булан.



Зураг 5. Давуун дээр зурсан бурхны хөрөг



Зураг 6. Түвд бичигтэй унжлага



Зураг 7. Тахилын аяга



Зураг 8. Шавар бумба



Зураг 9. Даавууны тасархай



зураг 10. Хээтэй шагай



Зураг 11. Тосго



зураг 12. Дусал ваар

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН
 „АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛЫН 3 ХЭМЖЭЭСТ БАРИМТЖУУЛАЛТ “ ТӨСӨЛ

*А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Т.Шожи,
 Ё.Сэндай, И.Үсүки, К.Кияма*

Монгол Японы хамтарсан шинжилгээний анги Монгол нутагт орших үл хөдлөх дурсгалуудыг бүртгэн баримтжуулах ажлынхаа хүрээнд шинжлэх ухааны шинэ ололт амжилтуудыг археологийн шинжилгээний нэгэн чиглэл дижитал архивын сан бүрдүүлэхэд оршино.

Энэ төрлийн судалгаа нь Монгол улсын нутагт харьцангуй бага хийгдсэн бөгөөд төслийн хүрээнд монголын хот суурин тэр дундаа дундад эртний Уйгур, Хятан улсуудын үеийн дурсгалуудыг баримтжуулахад чиглэгдэв.

Монгол нутагт орших соёлын үл хөдлөх биет өвийн дурсгалууд нь хадгалалт хамгаалалт, хараа хяналт султай бөгөөд жил ирэх тусам нар, салхи, бороо зэрэг байгалийн сөрөг нөлөө болон хүний үйл ажиллагааны нөлөөнд бага багаар сүйдэж утсаар байгаа билээ.

Тус төсөл нь 2012 оноос хойш нийт 3 жил үргэлжилж байгаа бөгөөд энэ хугацаанд Монголын дундад зууны үеийн хот суурины хэрэм болон барилга байгууламжийг баримтжуулах ажлыг хийж багагүй үр дүнд хүрээд байна. Үүнд,

2012 онд Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших эртний Уйгурын нийслэл Харбалгас хотын өндөр шавар суварга, хэрмийг 3 хэмжээст оруулан баримтжуулав.

2013 онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших Харбухын балгасанд сүүл үед буюу XVI -XVII зууны үед байгуулсан сүмийн чулуун барилга байгуулалж, Улаан хэрэм, Чин толгой зэрэг дурсгалт газруудад баримтжуулалт хийв. Энэхүү дурсгалуудыг 3 хэмжээст хэмжилт судалгаа бүрэн хийгдэж дууссан бөгөөд тусгай компьютерийн тусламжтайгаар дэлгэн үзүүлэхэд бэлэн болсон. (Одоо ШУА-ийн Археологийн хүрээлэнд дижитал хэмжилтийн үр дүнг 3 хэмжээст орчинд үзэх боломжтой)

2014 ОНЫ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хятан улсын үед холбогдох монгол нутагт орших цорын ганц дурсгал болох Хэрлэн барс хотын суваргад энэ удаагийн хэмжилт судалгааг хийсэн юм. Монгол нутагт орших Хятаны археологийн дурсгалыг судлах хүрээнд 1950 онд Х.Пэрлээ Суварганы орчимд багахан хэмжээний маллага судалгаа хийснээс хойш өдийг хүртэл Хэрлэн Барс-1 хотын суварганы орчимд маллага судалгааг хийгээгүй юм. Иймд суваргыг нарийвчлан судлах шаардлагатай байлаа. Хятаны үеийн суварганы дотоод хэсэгт болон гадар орчинд түүхэн дурсгалын дотоод зохион байгуулалт, гадаад хэлбэр хийц, байгууламжыг барьсан арга хэлбэрийг судлан тодруулахад оршино. Энэхүү судалгааны үр дүнд Хэрлэн Барсыг сэргээн засах төслийн өмнө археологийн соёлт давхрага эвдэн сүйдэхээс сэргийлэх ач холбогдолтой.

Энэхүү судалгааг хийснээр дурсгалуудын одоогийн бодит хэмжээ болон тэдгээрийн жижиг ширхэг бүрийн хэмжээг компьютер технологийн тусламжтай нарийн гаргах бөгөөд дуурайлган хийсэн жижиг загварыг ч гаргаж болох юм.

„FARO“ 3D төхөөрөмж болон D-GPS -багажийн тусламжтайгаар зураглалын бүх

үйл ажиллагааг хийв.


Энэхүү „FARO“ 3D төхөөрөмж нь 10 минутанд сууриа бүрэн эргэх буюу 360 хэмд байх бүхий л биетийн зургийг авах хүчин чадалтай бөгөөд бид Хэрлэн барсын суварганы 8 талаас нь буюу бүх талаас нь баримтжуулаа.

Суварганы хамгаалалтын хашааг ашиглан 60 ширхэг хөдөлгөөнгүй цэг (shooting point) суурилуулан мөн суварганы үүд буюу онгорхой хэсэгт 2 хөдөлгөөнгүй цэг байрлуулж тус бүрийг Total station-ы тусламжтайгаар хэмжиж газарзүй мэдээлэлийн системд холбох юм.

Судалгааны үр дүнд X зууны үед холбогдох Хэрлэн барс хотын энэхүү суварга ихэд нурсаар одоогийн байдлаар 16.5 метр өндөр болох нь тогтоогдов. Диаметр хамгийн их хэсэг буюу суурь хэсэгтээ 9 метр болох буюу дотор хэсэгтээ 5.6 метр, ханын зузаан 1.8 метр байсан юм. Мөн дотор хэсгийн зургийн ул мөр хадгалагдаж байна гэж үзэв.




А.




Б.

Зураг 1. а) Хэрлэн барс хотын суварга, б) Суваргын зүсэлтийн зураг².

² Х.Пэрлээ. К истории древних городов и поселений в монголии. Советская археология. М.,1959. Рис 8. 49 тал




(a) Digitized pagoda



(b) Outline of pagoda

Fig.4 Structure of this pagoda between outside and inside

Зураг 2. Пародижитал аттаратын хэмжилтийн зураг.



Зураг 3. Пародижитал аппаратын хэмжилтийн зураг.



Зураг 2. Дижитал баримтжуулалтын ажлын явц.

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН „ШИНЭ ЗУУН” ТӨСЛИЙН 2014 ОНЫ
ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ҮР ДҮН.

*Б.Цогтбаатар, Л.Ишцэрэн, Ц.Амгалантөгс,
Н.Шурайши, Т.Мяке, Т.Сасага.*

Монгол-Японы хамтарсан „Шинэ зуун” төслийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших „Аваргын балгас” буюу Чингис хааны „Их Орд” туурь бүхий дурсгалт газарт 2001 оноос эхлэн маллага судалгааны ажлыг гүйцэтгэж буй билээ.

Дээрх судалгааны баг тус дурсгалт газарт жил бүр хээрийн шинжилгээний ажил хийж, тус тууринд нурж үлдсэн барилгын ормууд, од өргөө, тахил тайлга, үйлдвэрлэлтэй холбоотой газруудыг нарийвчлан судалж бүтэц зохион байгуулалт, үүрэг зорилалт, холбогдох он цагийг нарийвчлан тогтоосоор ирсэн юм.

2014 оны маллагаар Лос.10-2 талбай хэмээн бидний нэрлэсэн талбайд орших барилгын үлдэгдлийг бүтэн хэмжээгээр малтан судалсан болно. Тус талбай нь „Аваргын балгас”-ын дурсгалт газрын баруун урд хэсэгт орших бөгөөд цувраа арав гаруй барилгын үлдэгдлийн зүүн захад оршино (зураг 1). Өмнөх жилийн маллага судалгааны Е-4, Е-5 талбайгаас барилгын ханын хэсэг шат мэт дагтаршуулсан довжоо зэрэг¹ (зураг 2) зүйлс илэрсэн талбайгаас хойш барилга байх магадлалтай хэмээн таамаглаж маллагын талбайг 4x4 м хэмжээтэй 16 өрөгт хуваасан бөгөөд нийт 256 м² талбайд судалгааг хийсэн юм (зураг 3).

Өнгөн хөрсийг хуулж авсаны дараа талбайн D-2,3,4, E-2,3,4 талбайгаас барилгын үлдэц хэсэг мэдэгдэж D-2, E-2 табайн урд хэсэгт 20 см гүнд 7,6 м өргөнтэй дагтаршуулсан улаан хөрсний хэсэг илэрсэн. Тус улаан хөрсөн үе нь D-3, 4, E-3, 4 талбайн зах хэсгээс илэрсэн бөгөөд бид барилгын гадна талын ханын хэсэг хэмээн тодорхойлсон ба зүүнээс баруун тийш 7,56 м, хойноос урагш 8,38 м хэмжээтэй „П” хэлбэртэй байв. Түүнээс дотогш D-3, 4, E-3, 4 талбайн төв хэсэг рүү маллагыг үргэлжлүүлэхэд цагаан түүхий тоосго гарч байсан ба төв хэсэг рүүгээ хонхойсон буюу барилгын хана дотор тал руугаа нурсан байдалтай илэрсэн (зураг 4). Хөрсний бүтэцийн мэдээлэл, зүсэлтийн зураг хийхэд зориулж өрөг тус бүрийн зүүн болон урд талд 50 см өргөнтэй хамар үлдээж маллагыг хийсэн болно. Ханын нурсан байдлын гэрэл зураг авч баримтжуулалт хийсний дараа гар зураг үйлдэн маллага судалгааг үргэлжлүүлсэн болно. Улаан ханын үлдэгдлийн дотор тал руу нурсан түүхий тоосгоны үлдэц бүхий даврхагыг хусан маллагыг үргэлжлүүлэх явцад D-3, E-3 талбайн хойд хэсэгт 1,36 м өргөн, D-3,4-ийн зүүн тал E-3,4-ийн баруун талын зах хэсгийг дайрч дотогшоо 1,18 м өргөнтэй дартаршуулсан цагаан өнгөтэй шороон үе илэрсэн. Үүнийг үргэлжлүүлэн маллаж үзхэд мөн „П” хэлбэртэй байв. Улмаар талбайн төв хэсэгрүү маллагыг үргэлжлүүлэхэд цагаан шороогоор дагтаршуулж хийсэн үе нь 90° шулуунаар 50 см доошилж барилгын шалны хэсэг гарсан (зураг 5).

Мөн барилгын улаан ханын үлдэгдлийн зүүн булангийн баганы суурьнаас баруун тийш 1,70 м зайд нэг шугамд баганын суурь нүх, түүнээс баруун тийш 2,8 м зайд нэг, түүнээс баруун тийш баруун буланд нэг нийт 4 ширхэг баганы нүх байгааг тогтоосон бөгөөд эдгээр нь 14 см голчтой ба нүхний ёроолд чулуун сууртай байна. Урд талын

¹ Б.Цогтбаатар нар., 2013. Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн 2013 оны хээрийн шинжилгээний ангийн тайлан. II хэсэг: “Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Аваргын балгас” АХГБСХ. УБ., 2013, 2-33 тал.

хэсэгт ч мөн дээрхтэй ижил хэмжээтэй 4 ширхэг баганын суурь илэрсэн бөгөөд. Барилгын үлдэгдлийн төв хэсэгт хоорондоо 2,6 м зайтай 2 ширхэг баганын суурь илэрсэн (зураг 6).

D-4, E-4 өргийн урд хэсэгт хаалга байсан бололтой ханын улаан үлдэгдэл тасарсан байна. Энэ хэсэг барилгын үүд болох нь тодорхой байна. Маллага судалгааны явцад барилгын ерөнхий бүтцийг тодруулан дэвсгэр зурагт буулган үзвэл дараах дүр зургийг харж болно.

Уг барилгын үүд нь урагш харсан, гадуураа улаан дагтаршуулсан шороон ханын суурьтай, түүний дээр түүхий тоосгоор ханыг өндөрлөн босгосон, баруун ханын гадна захаас зүүн гадна зах хүртэл 7,56 м, хойноос урагш 8,38 м хэмжээтэй байна. Ханын дотор талд дагуулж „П” хэлбэрийн 1,18 м өргөнтэй төв хэсгийн шалнаас дээш 50 см өндөртэй суудалтай маягийн тавцан байна. Түүний дотор талд 4,80 м өргөн, 4,92 м урт бүхий өрөөний төв хэсэг байна. Нэг өрөө бүхий ийм хэлбэрийн барилгын үлдэгдэл 2009 онд малтсан Лос.9 талбайн өмнөд талын барилгатай төстэй байна².


Тус талбайгаас илэрсэн олдворуудын тухайд барилгын төв хэсгийн баруун урд талаас ширмэн тавга хэлбэрийн тогооны хэсэг илэрсэн бөгөөд эх биеэс дээш залгагдсан сэнж бүхий бариултай, ёроол хэсэгтээ „六” (зургаа) ханз үсэгтэй байна.

Барилгын үүдний хэсгээс харьцангуй том зургаан талт тэрэгний цөн, Хойд сүн улсын үеийн зоос 2 ширхэг (大定通宝 Da Ten Tong Bao), (元祐通宝 Yuan You Tong Bao), мөн нэг талдаа зааны дүрстэй, нөгөө талдаа ханзаар (象) заан гэж бичсэн дугуй хэлбэрийн Хятад шатрын хясаа нэг ширхэг, төмөр хадаас, үйс, ваар шаазангийн хагархай, бог малын яс зэрэг олон тооны эх хэрэглэгдэхүүнүүд илэрсэн юм. Мөн барилгын дотор талын зүүн хойд хэсгээс нарийн бургасыг сүлжиж хийсэн зориулалт нь тодорхой бус зүйл гарсан болно (зураг 8).

Тус барилга нь нийт 10 баганы суурьтай, түүхий тоосгон ханатай, нийт 64 м² эзэлхүүнтэй байсан нь тодорхой болов. Харин барилгын дээврийн тухайд холбогдох материал илрээгүй тодорхойлох боломжгүй байна. Өмнөх жил малтсан E-8,9, G-9 талбайгаас илэрсэн дугуй тогоо хэлбэрийн нүхний ормууд нь барилгын өмнө талд 10 орчим метр зайд байрлах борооны усыг хуримтлуулах зориулалттай болов уу хэмээн урьдчилан таамаглаж байна. Түүнчлэн маллагаас гарсан ваар шаазангийн хэсгүүд, Хойд сүн улсын үеийн зоос зэрэг олдвор эх хэрэглэгдэхүүнд тулгуурдан үзвэл 13-р зууны эхэн хагаст хамаарах магадлалтай юм. Маллагаас гарсан модны нүүрсний дээжид он цагийг тогтоолгохоор Япон улсад илгээсэн болно.

2014 онд маллага судалгааны дээрх ажилаас гадна Аваргын балгас болон Чингис хаантай холбоотой түүхийн дурсгалт газруудыг олон нийтэд сурталчилан таниулах ажлын хүрээнд Японы NHK телевизтэй хамтран „Дэлхийн түүхийн алдарт хүн Чингис Хаан” нэвтрүүлэгийг бэлтгэхэд тус төслийнхэн оролцож 2014 оны 11-р сарын 29-нд NHK телевизийн түүхийн цуврал нэвтрүүлгээр олон нийтийн хүртээл болгов.


² Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн 2009-2010 оны хээрийн шинжилгээний ангийн тайлан. Нийгата. 2010.



Зураг 1. Аваргын Балгасны дэвсгэр зураг



Зураг 2. 2013 онд Лос 2-10 талбайд малтлага хийсэн талбайн дэвсгэр зураг




Зураг 3. Лос 2-10 талбайг өргүүдэд хуваасан байдал




Зураг 4. D-3А, E-3А талбайн матлага. Барилгын нурсан хана.



Зураг 5. Барилгын үлдэгдлийн ерөнхий зураг.



Зураг 5. Барилгын үлдэгдлийн дэвсгэр зураг.



Зураг 6. Барилгын үлдэгдлийн дэвсгэр зураг.

МОНГОЛ-ИЗРАИЛЬ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН
„ХАРХОРУМ-МИГ” ТӨСӨЛ

*Д.Цэвээндорж, А.Энхтөр, Б.Бадма-Оюу,
Г.Батболд, Т.Хантөгс, Ц.Буянхишиг,
Я.Бэмман, Р.Сузана, Э.Пүүл, М.Биран, Т.Да-Агли*

Монголын эртний нийслэл Хархорум хотод археологийн судалгаа шинжилгээ хийдэг Монгол-Германы хамтарсан „Хархорум” төсөл 2014 оноос хамтын ажиллагааны хүрээгээ тэлж Монгол-Израиль-Герман гурван улс хамтарсан төсөл хэрэгжүүлж эхэлсэн билээ. 2014 оны малтлага судалгаанд Монгол талаас ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал доктор, профессор Д.Цэвээндорж, Дундад зууны археологийн судалгааны секторын эрхлэгч доктор А.Энхтөр, Б.Бадма-Оюу, магистр Г.Батболд, Т.Хантөгс, Ц.Буянхишиг нар, Израиль улсаас Hebrew их сургуулийн түүхч, доктор Михал Биран, археологич Тавфик Диидл нарын археологичид, Герман улсаас Боннын их сургуулийн доктор, профессор Ян Бемман, доктор Эрнст Пол нарын 17 хүний бүрэлдэхүүнтэй баг Хархорум хотын турьд 2014 оны 7 сарын 30-наас 8 сарын 25 хүртэл 26 хоногийн хугацаатай ажиллав.

Малтлагын талбайг хамтарч хэлэлцэж төлөвлөсний дагуу топографийн зурагнаас сонгосон талбайд хийсэн ба тэрхүү талбайд тэгш өнцөгт хэлбэрийн хэрэмтэй, дотроо хэд хэдэн өрөөтэй сууцны үлдэгдэл байсан юм /зураг 1/. Уг сууц нь Эрдэнэ зуу хийдийн хашаанаас чанх хойш 1.5 км орших ба малтлагын нийт 4 талбай нээж, түүнээс хойд зүгт 300 м зайд Хархорум хотын хойд хэрэмд зүсэлт хийх нэг талбайг сонгон авснаар 2014 оны малтлагын ажил эхэлсэн билээ. Талбай тус бүрийн малтлагын товч явцаас танилцуулья.

Талбай 1

Уг талбай нь 6x7 м харьцаатай тэгш өнцөгт хэлбэртэй бөгөөд өргөргийн дагууд дунд нь 1 метр хамар үлдээж 3x6 м хэмжээтэй 2 хувааж хойд талын 3x6 м талбайг 1-А, урд талын ижил хэмжээтэй талбайг 1-Б талбай хэмээн дугаарлаж малтлагыг эхлэв.

Эхний шатны малтлагаар сонгосон талбайн дотор талд өнгөн хөрсийг 5-10 см гүн хуулахад малын яс, ваар, шаазан эдлэлийн жижиг хагархайнууд илэрч гарч байв.

Дараагийн шатанд эхний түвшний гүний хэмжээг нэмж 10-18 см доошлуулж үзэхэд үл мэдэг толбонууд, 1-Б талбайн зүүн хойд буланд уртрагын дагууд өрсөн хэдэн ширхэг тоосго, мөн талбайн дунд уртрагийн дагуу байрлалтай ханын тоосгон өрлөг, талбайн баруун урд хэсэгт цайвар саарал өнгийн уртрагийн дагууд 35 см өргөнтэй зурвас мэдэгдэж эхэллээ. 1-А талбайн баруун талаас төмөр хадаас, шаазан болон ваарны хагархайнууд, бог малын яс илэрч байв.

1-р үеэс ваар савны жижиг хагархай болон малын яс цөөн тоотой илэрснээс гадна энэ үед хөрсний байдал өөрчлөгдөж малтлагын төв хэсгээс хайрган үе илрэв. Хайрган үеийг дагуулан малтахад цөөн тооны дээврийн ваарны хагархай болон шатсан модны жижиг хэсгүүд, малын ясны хэсгүүд илэрч байв. Малтлагыг бүх талбайгаар доош үргэлжлүүлэхэд 1-А талбайн 12 см гүнд, талбайн зүүн хэсгээс түүхий тоосгон өрлөг мэдэгдэж эхэлсэн юм. Энэ нь барилгын баруун хойд булан бөгөөд булан хэсгийн гадна тал голын хамар доор үргэлжлэх боломжтой юм. Ханыг

хийхдээ түүхий тоосгыг хажуугаар нь босгож нэг үе өрсөн байна. Энэ үед талбайн зүүн хана орчимд барилгын дотор хэсгээс хөх тоосгоны хагархайнууд, мөн зүүн хойд булан орчимд хойд хананаас 23 см зайд барилгын ханатай нийлсэн байдалтай хагас дугуй хэлбэртэй шатсан толбо илэрсэн. Энэ барилгын хананы дотор талд 10 см, гадна талд 20 см гүнтэй малтлагыг үргэлжлүүлэхэд барилгын дотор хэсгээс дахин түүхий тоосгоны 2 жижиг өрлөг илрэв. Дээр илрээд байсан хөх тоосгонуудын зарим нь босоо байдалтай байна. Эдгээр тоосгонууд пийшэнгийн яндангийн хэсэг байж болох юм. 1-А талбайгаас илэрсэн барилгын баруун талын хананы нийт өргөн 70 см орчим байна.

1-Б талбайд 63 см гүнд талбайн зүүн хананаас 190 см, өмнө талын ханаас 105 см зайд цагаан саарал өнгийн толбо илэрсэн ч энэ хэсгийг тойроод хайрагтай үе илэрсэн бөгөөд баруун талын хананаас чулуу багатай саарал өнгийн шороон зурвас огтолсон байдалтай гарч ирэв.

Ийнхүү 1-р талбайн малтлагын 3-р түвшин хүртэл малтаж үзэхэд дээрх илэрцүүд улам тодрон байгалын хөрснөөс ялгарч харагдаж байв. 1-А талбайн зүүн урд өнцөг доош 57см гүнд талбайн бусад хэсэгтэй тэнцүүлэхэд цагаан саарал толбо илэрч эхлэж байна. Мөн уг талбайн баруун зүүн талуудын хөрсний өнгө, бүтэц өөр болох нь энэ үеэс ажиглагдаж эхэлсэн ба 1-Б талбайн зүүн талын хананд илрээд байсан тоосгонууд илүү сайн мэдэгдэж зүүн хойд хананд зуухны дээд талын түүхий тоосгон өрлөг байгаа нь тодорхой боллоо. Эдгээр тоосгонууд нь өнгөн хөрснөөс доош 30 см-т байв. Уг талбайн баруун болон зүүн талд илрээд буй толбонуудыг 85 см гүнээс байшингийн гадна хананы баруун талд байх жижиг суваг байж болох 35-38 см өргөн зурвас илэрлээ. Уг талбайн дунд илрээд байсан хананы өрлөгийг улам тодруулж үзэхэд 1-А болон 1-Б талбайн дунд үлдээсэн хамрын дагууд байшингийн хойд хана байгаа нь тодорхой болсон юм. Таамгаа батлах үүднээс дээрх 2 талбайн голын хамрын зүүн хэсгийг 1-Б талбайд илэрсэн ханыг дагуулан 12 см гүн хуулахад дээрх таамаг зөв болох нь батлагдсан юм. Уг хана нь 3-5 давхар түүхий тоосгоор баригдсан 50 см зузаан хана байна. Булангийн дотор талд шатаасан тоосго болон түүхий тоосго илэрсэн. Мөн дотор талын зүүн хананаас түүхий тоосгоор хийсэн халаалтын системийн доор саарал үнсэн давхрага хуримтлагджээ. Энэхүү шатсан халаалтын системийн доор нэг үе буюу 30см зузаан элсэн давхрага байна. Уг элс шатаж өнгө нь улаан болж хувирсан байсныг доош нэг үе шалгаж үзэхэд өмнөх соёлт давхаргын зуухны ором мэдэгдэж эхэлсэн билээ /зураг 2/.

Талбай 2

Бид уг тусгай хэрэм бүхий энэхүү байгууламжийн Талбай 1-ээс хойш нэг шулуунд хоорондоо хана нь давхцахаар тайлбайг сонгож, хойд хэрэм болон хойд хэрэмд тулган барьсан байгууламжийн зохион байгуулалт, хөрсний соёлт давхаргыг тодруулах зорилгоор 1:20 м урттай сорилын суваг татсан болно /зураг 3/.

Дээрх талбайд малтлага судалгааг 20 см зузаантайгаар зохиомол үе үүсгэн малтсан юм. Өнгөн хөрсийг хуулсаны дараа 11,7-15,7 м уг байгууламжийн хойд хэрэм байж магадгүй 4 м орчим хайрга голдуу хөрс илэрсэнээс бусад талбайд хөрсний өнгө хувирсангүй. Үе-2 малтлагын дараа дээрх 4 м орчим хайрган зурвас хумигдаж 14-14,8 м хооронд хайрга, шар шавар холин дэлдсэн хэрэм байгаа нь тодорхой болсон юм. 14,8 м хойш 20 м хүртлэх зайд үнс, ваар шазангийн хагархай, малын яс зэрэг ахуйн хаягдал хуримтлагдсан хэсэг байв. Уг хэрмээс урагш 10,4-11,8 м хооронд тус барилгын ханзан халаалтын булан илэрсэн ба 12,40-13,1 м хооронд барилгын

зүүн хана бидний сонгосон чиглэлээс үл ялиг жишүү илэрсэн юм. Уг байгууламж нь хойд талаараа хэрэм бүхий байгууламж болох нь тодорхой болсон бөгөөд хэрмийн ар талаар ус зайлуулах сувагтай байсан нь тогтоогдсон юм. Барилгыг хойд хэрмэнд шахаж барьсан бөгөөд түүхий тоосго (шороонд)-р утаа гүйх хоолойг үйлдэсэн ханзан халаалтай /зураг 4/.

Энэ удаагийн сорилын сувгийн зүсэлтэнд уг барилгын зүүн ханын 2 суурь чулуу хамран орж ирсэн бөгөөд барилгын хана үл ялиг жишин орж ирсэн учир барилгын өргөнийг шууд тодорхойлох боломжгүй ч ойролцоогоор хойд ханаас өмнө хана хүртэл 8 м орчим өргөнтэй болох нь мэдэгдэв. Энэхүү талбайгаас дундад зууны үеийн ваар шаазан, бусад ахуйн хаягдал илэрч байсан бөгөөд жижиг хэмжээний боронз бүхий шилэн эдлэлийн хагархай, даалуу мэт нэг талд нь таван цэг дүрсэлсэн хавтгай дөрвөлжин ясан эдлэл, бүсний чимэг бололтой хүрэл эдлэл зэрэг зүйлс илэрсэн юм.

Талбай 3

Хотыг тойрох гадна хэрмийн хойд хаалгыг 1960-1980 хооронд аж ахуйн зориулалтаар ашиглах байшингууд барихдаа ихэд эвдсэн байна. Энэ газарт хэрмийн сайн мэдэгдэж байгаа хэсэгт 20х5м хэмжээтэй газар зүсэлт хийлээ /зураг 5/.

Малтлага хийж байсан талбайд 1.3 м өргөн, 1.5м өргөн чулуу болон шавраар өрсөн хана илэрлээ. Энэ хана нь 2 талаасаа нуржээ. Хэрмийн гадна талд 20 см зузаантай шатаж, үйрсэн ваарны хагархайнууд олдсон. Энэ ваарнууд 13-р зуунд холбогдож болох бөгөөд Орхоны хөндийгөөс олддог.

Талбай 4

Гадуураа дөрвөлжин хэрэмтэй голдоо овгор барилгын үлдэцийг сонгон малтахаар болж барилгын баруун хойд буланг сонгон 6х7м хэмжээтэй транш нээж голдоо 1м өргөнтэй хамар үлдээв. Мөн эндээс баруун тийш 50м татаж 30м зайд 20м урттай, 1м өргөнтэй 2-р траншийг нээсэн нь баруун талын хэрмийг дайруулсан юм. Транш 1-ийн хамрын хоёр талын өмнөөс хойш А, В хэмээн дугаарлаж 3х6м хэсжээтэй хоёр талбайд малтлагыг эхлүүлсэн болно.

Овгор барилгын зүүн урд буланд дахин 6х7м хэмжээтэй транш татаж голд нь 1 м өргөнтэй хамар үлдээж малтаж эхлэхэд 16см гүнээс барилгын зүүн урд булан 4-А талбайгаас илэрсэн бөгөөд 4-В талбайгаас барилгын зүүн талын ханын үргэлжлэл илэрсэн ингээд барилгын гадна хэсгийг доош малтаж эхэлсэн юм. 4-А талбайн баруун хойд хэсэгт илрээд байсан барилгын зүүн урд булан болон халаалтын системийн хэсгийг дахин доош 5 см гүнтэй малтахад барилгын хана болон зуухны тоосгоны өрлөг илүү тодорхой харагдаж эхэлсэн ба уг халаалтын систем нь 2 үе тоосгон өрлөг мэдэгдсэн бөгөөд гадна талын өрлөгийг хийхдээ түүхий тоосгыг хажуугаар нь босгож цацраг мэт дугуйруулан өрсөн бол дотор талын өрлөгт жижиг богинохон (тал) түүхий тоосгийг хэвтээгээр нь эгнүүлж өрсөн байлаа. Энэ 2 өрлөгийн хооронд 35-45 см зайтай мөн баруун ханаас 6ш босоо байдалтай түүхий тоосго илэрсэн. Энэ хэсгийн булангийн өнцөг төдий л сайн мэдэгдэхгүй бөгөөд өмнө талын ханыг түүхий тоосгоор хажуугаар нь босгож хөндлөн өржээ. Уг барилгын зүүн талын хан нь бусад ханаа бодвол илүү зузаан бөгөөд өвөрмөц байдлаар өржээ. Энэ хэсгийн булан маллагын талбайн баруун ханаас 140 см хойд ханаас 205 см хэмжээтэй байна. Энэхүү талбайн маллагын 2-р үед, 17 см гүнд баруун ханаас 3,2

м зайд түүхий тоосгоор өрсөн өөр нэгэн жижиг халаалтын систем илэрсэн юм.

4-В талбайгаас барилгын зүүн ханын үргэлжлэл илэрсэн ба мөн халаалтын системийн үргэлжлэл баруун тийш эргэсэн байдалтай илэрч харагдав. Ингээд малтлагыг барилгын дотор хэсэгт халаалтын системийн хоёр талаар доош малтахад 41 см гүнээс ханзны хойд талын ёроолоор уртаашаа бага зэрэг сунасан галын ором илэрсэн нь бидний таамгаар зуухны ам бололой. Үүний эсрэг талд 36 см гүнээс зууван дугуй хэлбэрийн бүрэн шатаалттай хөх тоосгон зуух илэрсэн бөгөөд өмнө мэдэгдээд байсан баруун зүг эргэсэн халаалтын системийн доороос илэрсэн. Мөн барилгын ханаас зүүн тийш 77 см зайд малтлагын талбайн хойд хананаас 7 см зайд 14 см голчтой модны (шон) ором илэрсэн. Энэ үед хатуу шар шавран үе илэрсэн бөгөөд малтлагын талбайн баруун хойд булангаас буюу зүүн ханаас 120 см хойд ханаас 100 см хэмжээтэй 20 см өргөнтэй цагиргалсан хайрган үеийн тал хэсэг илэрсэн. Барилгын дотор хэсэгт малтлагын талбайн баруун хойд хэсэгт илрээд байсан хатуу шавран үеийг доош 5 см гүн малтахад хатуу үе дууссан байна. Барилгын дотор талд илрээд байгаа зуухыг үргэлжлүүлэн эндээс 4 үе өөр өнгийн шороо илэрч байлаа. Ингээд нийт 75 см гүн малтахад зуухны дотор хэсгийн ёроол гарсан бөгөөд энд дагтаршуулсан шавар нилээд шатсан байдалтай илэрсэн. Зуухыг үйлдэхдээ хамгийн доор түүхий тоосгыг босоогоор өрж дээр нь хэвтээгээр тоосго орж, түүний дээр дахин босоогоор өрөөд дээрээс нь 3 давхар хэвтээгээр тоосго өрж хийжээ. Зуухны ам нь хойд талдаа бөгөөд дөрвөлжлөн хийсэн бөгөөд шатаасан тоосгоор өрсөн байв /зураг 6/.

Энэ талбай дээр өмнөх болон баруун хана нь энэхүү байшингийн буланг үүсгэж байна. /зураг 5/ уг талбайн зүүн хагаст нь пийшин олдсон /зураг 6/ ба пийшингийн дотор талыг тоосго ба чулуугаар хийжээ. Пийшингийн ханыг тоосгоор өрөхдөө хэвтээ болон босоо байдалтай хэдэн давхар өрсөн байна. Пийшин дотроос 13-р зууны сүүл үед Хятадад хэрэглэж байсан *longquan kiln* шаазан илэрсэн.

Нэг халаалтын суваг нь пийшингийн баруун талаар гараад баруун өмнөд зүгрүү эргэж хойшоо үргэлжилж явсан байна. Энэ хоолойн урагшаа гарсан хэсэгт тоосгийг босоогоор нь өрсөн, дотор талын хойш чиглэсэн шугам нь 4-5 давхар хэвтээ тоосгоор баригджээ. Уг сувгийг хавтгай чулуугаар хагас бүржээ. 2-р суваг нь эхнийхтэй зэрэгцээ илэрсэн боловч хойд хэсгээрээ илүү давхрага тоосго бас мэдэгдэж байна. 4-р талбайн Б хэсэгт нурсан түүхий тоосгон хана илэрлээ /зураг 7/. Энэ нурсан хананы доор 1 см зузаантай цагаан давхрага илэрсэн нь хананы гадна талд хүрсэн байна. Энэ нь магадгүй хананы гадна талын давхарга байсан байж болно эсвэл энэ шалны давхрага байсан байж болно.

Түүний доор хойд ханатай паралелл зэрэгцээ 50 см-ийн зайтай голын чулуунууд байна. Энэ голын хайрга хана хоёрын дундах зайд байх элсэрхүү материал байна. Энэ элсний ором нь өмнөд хананы суурины нүх байсан байж болох юм. Хэрэв нүх бол өмнөх үеийн шавсан шал юм. 4-А талбайн гадна талд шатсан тоосгоор бүрсэн шал байна /зураг 8/. Энэ давхрага нь гадна талын хана, түүний гадна талтай яаж холбогдох нь тодорхойгүй. Энэ газрын баруун урд талын халаалтын шугам тэгш өнцөгт хэлбэртэй 3 хэсэгт хуваагдсан ягаандуу тоосгоор зааглагдаж харагдана. Зориулалт болон түүнтэй холбоотой суваг нь тодорхойгүй /зураг 7/.

Талбай 5

Бид барилгын баруун хэсгийг үзэх зорилгоор 4-р талбайн эсрэг талд 7х6 м хэмжээтэй 5-р талбайг нээж өмнөхтэй адил дунд нь 1м өргөнтэй хамар үлдээж 3х6 м хэмжээтэй 5-А, 5-В талбайг нээж малтлагыг эхлүүлсэн юм.

5-А талбайн өнгөн хөрсний малтлагаар 4-А талбайгаас илэрсэн ханзны үргэлжлэл шатсан тортог бүхий шороон хэсгүүд, шавар түүхий тоосгоны хэсгүүд үргэлжилж байгаа нь илэрлээ. Талбайн төв хэсгээс баганын суурь байж болзошгүй хавтгай чулуу илрэв. Мөн барилгын баруун хойд булан байж болзошгүй хавтгай чулуу илэрсэн нь цаашдын судалгаагаар тодорхой болох боломжтой юм. Мөн 4-А талбайн ханзны утаа гүйх сүвгийн үргэлжлэл нь өнгөн хөрстэй ойролцоо шатсан хар хүрэн өнгөөр талбайн баруун хойд буланд зурваслан ялгарч гарч ирлээ. Талбайн баруун урд талаар хайргатай хөрс ил гарч мөн бага хэмжээний ханын шохой илэрлээ.

Яндангийн үргэлжлэлийн хэмжээ хойд хананаас 110 см, зүүн хананаас 151 см бөгөөд барилгын баруун урд талын булан хойд хананаас 142 см, зүүн хананаас 254 см хэмжээтэй тодорч эхлэв. Нэгдүгээр үеийн өнгөн хөрс хуулалтаас цөөн тооны шаазан ваарны хагархай, малын яс олдсон ба ханын шохойн хэсгээс дээж авлаа.

Мөн 5Б талбайд илэрсэн барилгын хоёрдугаар ханын үргэлжлэл болох түүхийн тоосгон өрлөг ил гарч ирсэн ба өрлөгийн урт 68 см, өргөн нь 17 см байв.


Гуравдугаар үеийн малтлага судалгааны явцад цөөн тооны малын яс, ваарны хагархай 5ш, шаазангийн хагархай, 3 ш цэнхэр өнгийн сүвс, ханын шохой зэрэг зүйлс олдсон болно. Түүнчлэн барилгын бүтэц зохион байгуулалтад холбогдох баганын суурь болон барилгын дээврийн ваар зэрэг зүйлс цөөн тоотой тохиолдож байсан юм.

5-Б хэсгийн нэгдүгээр үеийн малтлагаар гол барилгын баруун талын хана болон зуухны үргэлжлэл ерөнхийдөө тодорч гарав. Уг баруун талын ханаас баруун тийш 1 м орчим зайд түүхий тоосгон хана мөн илэрсэн юм /зураг 8/.

Дүгнэлт

Малтлагын явцыг товч танилцуулахад ийм байна. Бидний сонгож авсан энэхүү байшин төв гудамжны баруун хойд талд орших бөгөөд 81х75 м хэмжээтэй гадуураа шороон хэрэмтэй, дотроо төв барилгаас гадна 8 барилгатай байгаа бололтой. Хойшдын малтлагаар нэмж барилга илрэх боломжтой юм. Хэрэм төв гудамруу харсан нэг том хаалгатай бөгөөд энэхүү хаалга нь жижиг хэрмийн зүүн урд талд ажээ. Нөгөө хаалга нь чанх хойд зүгт харуулан барьсан 2-3 м хэмжээтэй. Төв барилгаас тусдаа баригдсан жижиг барилгуудыг хэрмийн хананд тулгаж барьсан байдалтай. Харин хэрмийн төв барилгыг голд нь тусгай өндөрлөгт барьсан нь ажиглагдаж байна.

Энэ жилийн малтлагаар хэрэмийн дотор талд 6х13м хэмжээтэй түүхий тоосгоор өрсөн барилгын гурван өнцөг илэрсэн /зураг 9/ ба уг барилга сайн хадгалагдсан шинжтэй, хананы барьсан хэлбэр нь хойд талдаа буюу талбай 5-д тоосгоо босоо өрж огтолцуулсан байна. Уг босоо огтолцол нь 50 см өргөнтэй аж. Хананы дотор талд тоосгыг диагналдуулан өрсөн нь энэ ханыг бэхжүүлэхийн тулд хийсэн байж болох юм. Энэхүү малтлагын ажил нь Хархорум хотын доторх тусгай хэрэмтэй байгууламжыг бүрэн малтаж судлах зорилготой юм.



Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.



Зураг 4.



Зураг 5.




Зураг 6.



Зураг 7.



Зураг 8.



Зураг 9.



„ШИНЭ ЗУУН” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЛЭНБАЯН УЛААН УУЛЫН
ТАВАН ХАЙЛААСТЫН АМАНД ХИЙСЭН МАЛТЛАГА СУДАЛГАА

*Б.Цогтбаатар, Н.Шираши, Г.Батболд
Ц.Амгалантөгс, Л.Ишцэрэн,*

Монгол-Японы хамтарсан „Шинэ зуун” төслийн хүрээнд „Аураг” ордын туурь, Хөдөө Арал орчимд буй эртний нүүдэлчдийн үлдээсэн түүх, соёлын дурсгалуудыг олж бүртгэх, малтан судлах, хадгалж хамгаалах ажлуудыг хийж ирсэн билээ. Тус төслийн судлаачид дундад эртний үеийн Монголчуудын хот суурингийн түүрийг судлан тухайн үеийн хүн амын нүүдэл суурьшилт, хот балгад байгуулалт, төмөр боловсруулалт, үйлдвэрлэх болон эрхлэх аж ахуй, шүтлэг бишрэл зэрэг эдийн болон оюуны соёлын олон асуудлыг шийдвэрлэх цогц судалгааг шинжлэх ухаан, технологийн шинэ ололт, дэвшлийг ашиглан нарийн тогтоох ажлуудыг явуулж байна. Тус төслийн хийж буй судалгааны талаар жил бүр танилцуулж урьдчилсан үр дүн бүхий судалгааны бүтээлүүд хэд хэд хэвлэгдэн олны хүртээл болсон билээ. Тиймээс энэхүү тайланд дахин нуршин давтахаас зайлс хийж, өнгөрсөн 2013 онд эхлүүлсэн судалгааны үргэлжлэлийг танилцуулж байна.

2014 онд бидний судалгааны баг Таван хайлаастын ТХ¹-4 болон ТХ-5 хэмээн нэрлэсэн бүлэг булш бүхий бэсрэг оршуулгын газар малтлага судалгааг 2014 оны 5 сарын 21-нээс 6-р сарын 05-ны хооронд 14 хоногын хугацаатай үргэлжлүүлэн малтсан болно. Энэхүү ТХ-4, ТХ-5 хэмээх бүлэг булш бүхий бага хэмжээний оршуулгын газар нь хоорондоо 30 м зайтай оршино. ТХ-4 нь нийт зургаан булштай бөгөөд өнгөрсөн жил №1, 2 гэж дугаарласан булшийг малтсан болон энэ онд үлдсэн №3-6 хэмээн дугаарласан үлдсэн дөрвөн булшийг малтан судлав. Энэ нь тус цөөн тоотой бүлэг булш нь хоорондоо чухам ямар хамааралтай болох уг удамын харилцаа холбоо байна уу гэх зэрэг генийн сангийн холбоо хэлхээг торлуулах сан бүрдүүлэх болон энэхүү булшнуудыг хэдий хугацаанд үйлдэгдсэн зэргийг тодруулах зорилготой байв.

ТХ-5 хэмээх дурсгал нь нийт найман булштай бөгөөд өнгөрсөн жил №1, 8 хэмээн дугаарласан булшуудыг малтан судласан бол энэ удаад №5, 6 хэмээн дугаарласан булшуудыг малтан судалсан юм. Энэ онд нийт зургаан булш малтан судалж холбогдох он цагийг тогтоосон юм.

Булшны гадаад болон дотоод зохион байгуулалт: Малтлага судалгааг явуулсан дурсгалт газрууд нь өндөр уулын дунд биеэс дээшхи хэсэгт тэгшивтэр ирмэг, дэвсэг дээр эсвэл уулын орой хэсгийн багахан хонд мэт мухар ам бүхий газарт байрлах учраас газрын дээд талын зарим дараас чулууд төдийлөн сайн мэдэгдэхгүй байна. Энэ нь бороо, цас зэрэг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр шороо, чулуу уулын уруу гулсаж булшны дараасны дээд хэсгийг дарж мэдэгдэхгүй шахам болгожээ. Үүнээс гадны булшны дараас чулуун дээр Буйлс, Хайлс ургац дараас мэдэгдэхгүй шахуу болсон байдалтай. Дурсгалуудын гадаад зохион байгуулалтыг авч ТХ-4 №1-6 болон ТХ-5 №1 болон №5-р булш нь дугуй цагирган дараастай байхад ТХ-5 №7, 8-р булш зууван хэлбэрийн овгор дараас чулуутай. Энэ бүгдээс харахад энэхүү булшнууд анх үйлдэгдэхдээ ТХ-5 №7,8 булштай адил зууван хэрбэрийн овгор дараастай байсан бөгөөд тоногдох явцад голын овгор дараасыг гадна тийш тараан шидсэнээр дугуй цагирган хэлбэр үүссэн бололтой. Учир нь ТХ-5 №7, 8 булш

¹ ТХ - Хэрлэнбаян улаан уулын зүүн урд биенийн зүүн урагш харсан богино амыг Таван Хайлааст гэх бөгөөд түүнийг товчлон ТХ гэж бичсэн.

дараас нь огт хөндөгдөөгүй ямар нэгэн тонууд өртсөн шинжгүй байсан боловч оршуулгын хэсэгт мэрэгч үүрлэн хүний яс, эд өлгийн зүйлс зөөгдсөн шинжтэй байсан юм. Дараасыг үйлдэхдээ бахим зууван гозгой чулууг оршуулгын нүхний ирмэгийг дагуулан зууван хэлбэр үүсгэж, нүхний болон их газрын хөрс хоёрын уулзвар дээр хавж тавиад голын хөндий зайнд дундаж чулуугаар битүү овоолго үүсгэн дарсан байна. Дараас чулууны дор ТХ-4 №1-6 болон ТХ-5 №1, 5, 7, 8-р булш нь уртрагийн дагуу зууван хэлбэрийн дараас чулуутай, түүний дор төв хэсэгт өмнөөс хойш эсвэл үл ялиг зүүн урдаас баруун хойш, баруун урдаас зүүн хойш чиглэлтэй оршуулгын нүхний толбо илэрч байв. Оршуулгын нүхний толбоны дагуу 1-4 үе чигжээс чулуу гарч дунджаар 1.5-2.2 м-ийн гүнд оршуулганд хүрч байна. Хамгийн гүн нь ТХ-5 №5 булш байсан бөгөөд 220 см-ийн гүнээс оршуулга илрэв.

Оршуулгын зан үйл: Энэхүү ТХ-4, ТХ-5 нийт малтсан арван булшны найм нь ямар нэгэн байдлаар тоногдсон шинжтэй тоногдоогүй үлдсэн хоёр нь мэргэчийн үүрэнд дайрагдсан тул бараг бусниулагдсан шинжтэй байсан юм. Гэвч тоногдсон хэдий ч зарим булшны хүнээ тавьсан байдал хөндөгдөлгүй үлдсэн зарим ясны байрлал зэргээс хүний тавьсан байдлыг тодруулж болохоор байна. ТХ-4 №1-р булшинд зүүн хойд зүгт хандуулан баруун хажуугаар хэвтүүлэн хоёр хөлийг өвдгөөр нь ихэд атийлган нугалж, хоёр гарыг өвдөгний тушаа чиглүүлэн тавьж оршуулжээ. ТХ-4 №2, 5 болон ТХ-5 №5, 7, 8-р булшинд нас барагчийг дээш харуулан гарыг их биеийн дагуу тавьж тэнэгэр байдлаар оршуулсан нь анхны тавилтаараа үлдэж хоцорсон зарим яснаас харахад тодорхой байна. ТХ-4 №3, 4, 6 булшны хүнийг тодорхойлох боломжгүй байв. ТХ-5 №1-р булш нь хоосон байсан бөгөөд эрт цагт бүрэн тоногдож хүний шарил болон дагалдуулсан эд өлгийн зүйлс алга болсон үү? эсвэл угасч хоосон булш үйлдсэн үү? гэсэн асуулт гарч ирж байна. Монгол улсын нутагт явуулсан дундад эртний нүүдэлчдийн булш оршуулгын судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд, “хоосон булш” цөөнгүй тохиолдож байсныг судлаачид тэмдэглэсэн²¹ байдаг.

Шарилыг модон авсанд хийсэн тохиолдол нэг тохиолдсон нь ТХ-5 №5 булш хавиргалан босгосон чулуун хашлага дотор модон австай байсан бөгөөд тоногдох явцад хэлбэр алдагдан толгой хэсгээс авсны таг бануны жижиг хэсэг, хөл, зүүн талын авсны хана байрандаа үлдэж хоцорсон байв. ТХ-4 №1, 4, 5 булшнууд нь нимгэн хавтгай том чулууг хавиргалан босгож үйлдсэн зууван хэлбэрийн чулуун хашлагатай байв. Үлдсэн зургаан тохиолдолд шарилыг булшны нүхэн доторхи хөрсөн дээр тавьж оршуулжээ. Нэг булшинд зөвхөн 1 бодгаль л тавьж ганцаарчилсан оршуулгыг үйлдсэн байна. Үүнээс ТХ-4 зургаан булшийг малтахад уг булшинд тавьсан бодгалиуд бүгд насанд хүрсэн хүмүүс байсан бөгөөд хүүхдийн булш одоогоор илрээгүй байна.

Зүг чигийн хувьд ихэвчлэн хойд зүг болон зүүн хойш, баруун хойш хандуулан тавьжээ. ТХ-4-1-р булш нь тоногдож сүйдсэн боловч цөөн тооны олдвор хэрэглэгдэхүүн үлджээ. Эдгээр нь бүгд чулуун хашлага дотроос олдсон бөгөөд *зэр зэвсгийн / нумны ясан наалт-3, хутга, төмөр зэв / хойлгын / бог малын нурууны яс-1 / зэрэг зүйлс* байна. Хүний хөлийн зүүн шилбэний ясан дээр төмөр хутга тавьсан нь байсан нь ихэд зэвэрч муудсан байлаа. ТХ-4 №6 булшнаас бог малын шагайт дагалдуулсан нь дундад зууны монголчуудын оршуулгын зан үйлийн тогтсон хэв маягтай адил байна. ТХ-5 №5 булшинд зүүн хөлийн тушаа авсны гадна талын хашлага чулуун дээр модон хуйтай төмөр хутга, сумны модон мөс (савх) зэрэгцүүлэн тавьсан байсан нь ТХ-4 №1 булшны зан үйлтэй ойролцоо байна. ТХ-5 №7, 8 булш эмэгтэй хүний булш байсан бөгөөд дундад зууны монголчуудын богтого малгай, гоёл чимэглэлийн зүйл

²¹ У.Эрдэнэбат. Монгол булшны судалгаа. Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага Газрын чулуу. тал-321 УБ., 2010

болох сувс, хүрэл чон хэлбэрийн чимэг зэрэг эд өлгийн зүйл илэрсэн юм. ТХ-5 №5, 8 булнаас нимгэн хавтгай хүрлийг дугуйлан хайчласан эдлэл илэрсэн нь зориулалт нь тодорхойгүй ч хүрэл толийг төлөөлүүлэн тавьсан байж болох юм хэмээн үзэв. ТХ-5 №5 булш нь хэдийгээр тоногдсон байсан боловч хамгийн баялаг эд өлгийн зүйлтэй булш байв. Эдгээр олдворууд нь дийлэнх нь хөлний орчимоос илэрсэн бөгөөд төмөр дөрөө, төмөр амгай, модон хуйтай төмөр хутга, модон хуйн дээр шигтгэсэн байсан бололтой хүрэл чимэг, нимгэн хавтгай хүрэл дугуй, авсны модны завсраас хувцасны алтан утас 1 ш зэрэг олдворууд илэрсэн юм.

Он цагийн хамаадал: Булшны гадаад, дотоод зохион байгуулалт, оршуулгын зан үйл, олдвор хэрэглэгдэхүүнд түшиглэн өмнө жил малтсан ТХ-4 №1, 2 болон ТХ-5 №1, 8-р дурсгалыг он цагийн радиокарбоны шинжилгээгээр XI-XIV зуун буюу Монголын үе, гэж үзсэн. Энэ онд малтан судласан ТХ-4 №4-6, ТХ-5 №5, 7 булнаас авсан дээжийг Япон улсын Нийгата Их Сургуулийн лабораторид илгээсэн юм. Он цагийг радиокарбоны (C14 AMS) ба нүүрстөрөгч болон азотын тогтвортой изотопын шинжилгээний аргаар тогтоолгохоор лабораторийн судалгаагаар хүний яс болон үйсний дээжний он цаг дараах байдлаар гарчээ. 2013, 2014 онд малтан судласан нийт булшны он цаг нь:

ТХ-4 №1 булш 1045-1095, 1120-1141, 1148-1159 он

ТХ-4 №2 булш 1290-1309, 1361-1386 он

ТХ-4 №3 булш 1304-1324, 1345-1365, 1384-1393 он

ТХ-4 №4 булш 1293-1307, 1363-1386 он

ТХ-4 №5 булш 1310-1360, 1387-1398 он

ТХ-4 №6 булш 1322-1348, 1393-1406 он

ТХ-5 №1 булш 1320-1350, 1391-1410 он

ТХ-5 №5 булш 1303-1324, 1346-1366, 1383-1393 он

ТХ-5 №7 булш 1406-1427 он

ТХ-5 №8 булш 1311-1359, 1387-1400 он хэмээн гарсан бөгөөд үнэмлэхүй он цаг нь МЭ 1297-1410 байна.

Товч дүгнэлт: Хэрлэнбаян Улаан уулын Таван Хайлаастын амны 4, 5-р оршуулгын газарт хийсэн малтлага судалгааг доорх байдлаар дүгнэж байна.

- Таван Хайлааст 4 болон 5-р оршуулгын газрын дурсгалууд нь 1297-1410 он буюу XIII зууны сүүл үеэс XV зууныг хамарч байгаа нь Аураг ордноос Хархорум хотруу шилжин суусанаас хойш үед үйлдэгдсэн булш хэмээн үзэж болохоор байна.

Радиокарбоны шинжилгээнээс гадна он цаг тогтоож болохуйц олдвор хоёр илэрсэн нь ТХ-4 №3, ТХ-5 №8 булнаас нанхиад бичигтэй зоос тус тус нэг илэрсэн юм. 开元通宝(kai yuan tong bao МЭ 621 он), 崇宁通宝 (chong ning tong bao МЭ 1102-1106 он) гэвч эдгээр зооснууд нь харьцангуй өмнөх үеийн зооснууд байгаа нь магадгүй эд баялагын төлөөлөл болгон хуучин зоос дагалдуулсан байж болох юм. Chongning tongbao хэмээх зоос нь ард болон урд талдаа нэмэх тэмдэгтэй ховил гаргаж өгсөн нь ямар нэгэн зүйлд хадаж хэрэглэж байсан бололтой.

- Малтлага судалгааны үр дүн нь XIII-XV зууны Монголчууд тэр дундаа Хөдөө Арал орчмын хүн зоны ахуй амьдрал, эдлэл хэрэглэл, ёс заншил зэрэг эдийн болон оюуны соёлыг нэхэн судлахад чухал эх хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй юм.

- Хэрлэнбаян Улаан уул түүний салбар ам, хөндий дэхь ноёлог өндөр газрууд нь Аваргын балгас, Хөдөө Арал орчимд амьдарч байсан ноёлог анги, тэдний үр

удмынхны нас барагчаа хөдөөлүүлж байсан оршуулгын газар хэмээн үзэж байна. Учир нь дээрх газрууд нь өмнө малтан судлагдаж байсан дундад эртний Монголчуудын булш оршуулгын дурсгалт газраас нилээд өвөрмөц шинжтэй бөгөөд өндөр уулын дунд биеэс дээшхи зүүн урд, урд, баруун урд зүгт хандсан хэсгийн тэгшивтэр ирмэг, дэвсгэг эсвэл орой хэсгийн жижиг хонд мэт нөмөр газарт нэг дор 2-20 орчим тоотой бүлэглэн байрлана. Эдгээр газрууд нь нөмөр дулаан, наран ээвэр, алсын бараа харагдахуйц өндөрлөг газар байхаас гадна тэнд хүрч очиход бэрх байгалийн бартаа саад ихтэй, хүний нүдэнд төдий л өртөмгүй нууц далд байдалтай оршино.

ТХ-4 бэсрэг оршуулгын газарт байрлах зургаан булшны он цагаас харахад XIII зууны сүүл үеэс XV зууны эхэн үе гэвэл ойролцоогоор 100 гаран жилийн хугацаанд үйлдэгдсэн хэмээн үзэж болох юм. Энэ хугацаа нь хэрэв нэгэн цусан төрлийнхөн гэж үзвэл хүний тав орчим үеийг илтгэх хугацаа бөгөөд цаашид хүний ясанд гений судалгаа хийж үзвэл сонирхолтой үр дүнд хүрч болох юм.



*ТХ 5-7-р булшны дараас
/өмнө талаас/*



*ТХ 4-4-р булшны дараас
/өмнө талаас/*



*ТХ 5-8-р булшны дараас
/зүүн урд талаас/*



*ТХ 4-2-р булины оршуулга
илэрсэн байдал*



*ТХ 5-1-р булины
оршуулгын нүх*



*ТХ 5-8-р булины оршуулга
илэрсэн байдал*



*ТХ 4-4-р булины оршуулга
илэрсэн байдал*



*ТХ 5-5-р булины оршуулгын
нүх*




*ТХ 4-3-р булины оршуулга
илэрсэн байдал*

БУЛГАН АЙМГИЙН ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ХАНТАЙ БАГИЙН НУТАГ ЭГИЙН ГОЛЫН ХӨНДИЙД ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН ДҮРСГАЛЫН АВРАН ХАМГААЛАХ МАЛТЛАГА СУДАЛГАА

*Ч. Амартүвшин, Г.Эрэгзэн, Б.Багма-Оюу, Д.Базаргүр, Г.Лхүндэв,
Г.Галдан, Б.Батгалай, Б.Ангарагдөлгөөн, Д.Мандах*

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг Эгийн голын хөндийд Усан цахилгаан станц шинээр барих болсонтой холбогдуулан тус бүс нутагт өмнө 1990-ээд онд хийсэн хайгуул судалгаагаар илэрсэн дурсгалуудыг нягтлан бүртгэх, мөн Эрдэнэт хотоос Эг, Сэлэнгийн бэлчир хүртэлх авто зам, өндөр хүчдэлийн шугамын дагуу хайгуул судалгааны ажлыг 2014 оны 5 дугаар сард ШУА-ийн Археологийн хүрээлэн, Улаанбаатарын Их сургууль, ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургууль гэсэн 3 байгууллага хамтран гүйцэтгэж 347 дурсгалд авран хамгаалах малтлага судалгаа хийх шаардлагатай болохыг тогтоосон билээ. Улмаар „Эгийн голын усан цахилгаан станц төслийн нэгж” болон ШУА-ийн Археологийн хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Улаанбаатарын Их сургууль, ШУТИС-ийн Нийгмийн Технологийн сургууль, Монголын үндэсний музей гэсэн Монгол улсын хэмжээнд археологийн судалгаа хийдэг үндсэн 5 байгууллага хамтран Эгийн голын хөндийд томоохон хэмжээтэй авран хамгаалах малтлага судалгааны төслийг хэрэгжүүлсэн билээ.



Эгийн голын хөндий болон Хужирын голын хөндийд буй археологийн дурсгалын тархалтыг харуулсан бүдүүвч зураг

Тус хүрээлэнгийн баг 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн „Эгийн голын усан цахилгаан станц төслийн нэгж”-тэй байгуулсан АГ/27/14 тоот гэрээний

дагуу авран хамгаалах малтлага судалгааны ажлыг гүйцэтгэж эхэлсэн билээ. Тус хүрээлэн нь авто зам, эрчим хүчний шугамын дагууд 9, Эгийн голын зүүн цутгал Баянголын хөндийгөөс Хужир нуга, Бэлсэгийн хөндий хүртэл 10 гаруй км үргэлжлэх талбайд орших далайн түвшнээс дээш 900 м өндөрт орших 28, нийт 37 дурсгалыг малтан судлахаар төлөвлөн ажилласан.

Тус хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Археологийн дурсгалыг авран хамгаалах судалгааны секторын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Батдалай, Музей-Лабораторийн эрхлэгч, доктор Г.Эрэгзэн, Чулуун зэвсгийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Д.Базаргүр, магистр Г.Лхүндэв, магистрант Г.Ангарагдөлгөөн, Дундад зууны судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, доктор Б.Бадма-Оюу, Палеоантропологи-палеозоологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Д.Мандах болон МУИС, МУБИС-ийн 15 оюутан ажиласнаас гадна 06 дугаар сарын 12-ноос 27-ны хооронд МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхимийн багш доктор, дэд профессор У.Эрдэнэбат, доктор, дэд профессор З.Батсайхан нараар удирдуулсан Археологийн 2-р дамжааны 37 оюутан 14 хоногийн хугацаатайгаар хээрийн дадлага гүйцэтгэсэн болно.

Тус хүрээлэнгээс томилон ажиллуулсан багнь энэ газарт нийт 44 дурсгалыг малтан шинжилсэн ба 3 хэсэг газарт археологийн нарийвчилсан хайгуул судалгаа зохион байгуулж, УЦС баригдах нийт талбайг хамруулсан замын сүлжээний зураг гаргах хайгуул, нутгийн иргэдийн нүүдлийн байршлыг тодруулах угсаатны зүйн судалгааны ажил зохион байгуулсан бөгөөд археологийн малтлага судалгаатай холбоотойгоор илрэн олдсон хүн, малын ясыг нарийвчлан бүртгэх, цэгцлэх, нас хүйсийг тогтоох палеоантропологи, палеозоологийн судалгаа зэрэг олон тал судалгааны ажил хийжээ. Эдгээр судалгаа шинжилгээний урьдчилсан үр дүнг дурсгалын холбогдох он цаг, дурсгалын хэв шинж, судалгааны чиглэл зэргийг харгалзан чулуун зэвсгийн үеийн дурсгал, хүрэл зэвсгийн үеийн дурсгал, Хүннүгийн үеийн дурсгал, Монголын үеийн дурсгалын малтлага судалгаа, Орон нутаг-угсаатны зүйн судалгаа, Палеоантропологи, палеозоологийн судалгаа хэмээн 6 хэсэгт хуваан товч байдлаар танилцууля.

Тус хээрийн шинжилгээний ангийн чулуун зэвсгийн үеийн дурсгал судлах баг нь Эмгэнт хошуу, Улаан эрэг зэрэг газарт хайгуул, сорилтын малтлага судалгаа хийсэн ба Дөрөлж, Баянгол зэрэг дурсгалын 6 хэсэгт малтлага судалгааны ажил хийсэн байна. Хайгуул судалгааны үр дүнд Эмгэнт хошуунаас палеолитын үед холбогдох олон олдвор илрүүлсэн бөгөөд Улаан эрэгт сорилтын малтлага хийж зөвхөн өнгөн хөрсөн дээр ил гарсан олдвортой ч газрын гүнд соёлт давхаргагүй болохыг тогтоожээ. Дөрөлжийн дурсгалт газарт нийт 4 хэсэгт малтлага хийснээр газрын гүнд 2 үе соёлт давхаргатай болохыг тогтоосон ба энэхүү давхарга нь Баянголын дурсгалд ч ижил ажиглагдаж буйг тухайн хэсэгт 2 газарт малтлага хийж тогтоосон байна. Маллагын үр дүнд Дөрөлжийн дурсгалаас 164 ш, Баянголоос 45 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлэн олжээ. Эдгээр олдвор хэрэглэгдэхүүн нь тухайн бүс нутагт 20-40.000 жилийн өмнө эртний хүмүүс амьдарч байсныг нотлоод зогсохгүй тэдний амьдарч байсан бууц, суурин харьцангуй өргөн хүрээнд тархсан байсныг тодруулж өгч байгаагаар онцлог юм. Энэ жилийн чулуун зэвсгийн судалгааны өөр нэг үр дүн нь Дөрөлж, Баянгол зэрэг дурсгалт газрын хөрсний бүтэц, соёлт давхарга зэргийг илүү тодруулж, орчин үеийн арга зүйн дагуу баримтжуулж авсанд байна.

Хүрэл зэвсгийн үеийн дурсгал судлах нь баг нь Хужирын голд 1 хиргисүүр, 8 чулуун овоолгот байгууламж, Эмгэнт хошууны өмнө талаар тархсан хүрэл зэвсгийн үеийн дурсгалаас 2 хиргисүүр, 2 дөрвөлжин булшийг сонгон маллага судалгаа хийсэн.

Хужирын голд маллага хийсэн дурсгалуудаас он цаг тогтоохуйц олдвор хэрэглэгдэхүүн илрээгүй ч дурсгалын бүтэц зохион байгуулалтыг тодруулсан нь энэ төрлийн дурсгалын судалгааны хэрэглэгдэхүүнийг баяжуулж өгснөөр ач холбогдолтой юм. Харин Эмгэнт хошуунд маллага хийсэн 2 хиргисүүрээс хүний оршуулга илэрсэн бөгөөд 1 хиргисүүрээс мөнгөөр хийсэн үсний боолт, цагаан өнгийн зуурмагаар хийсэн хүзүүний сувсан зүүт зэрэг сонирхол татахуйц чухал олдвор хэрэглэгдэхүүн илэрсэн. Үсний мөнгөн боолт нь карасукын соёлын хэв шинжийг хадгалсан байсан бөгөөд энэ нь хиргисүүрийн соёл, түүнийг үлдээгчдийн талаарх судалгаанд онцгой ач холбогдолтой юм. Эмгэнт хошуунд малтсан 2 дөрвөлжин булшны хувьд эрт цагт тоногдож сүйтгэгдсэн тул оршуулгын ул мөр үгүй болсон байсан. Эмгэнт хошуунд хийсэн хүрэл зэвсгийн үеийн дурсгалыг малтан шинжлэх явцад ажиглагдсан өөр нэг чухал зүйл нь тухайн газрын хөрсжих үзэгдэл юм. Энэ газарт буй хиргисүүрийн чулуун байгууламжууд 0.4-0.5 м зузаан шороонд булагдсан байсан бол дөрвөлжин булшнуудын чулуун байгууламж дээр харьцангуй гүехэн хөрс тогтсон байсан. Иймэрхүү хөрсжих үзэгдлийн ялгаа нь тухайн 2 дурсгалын хоорондын завсрын үед тухайн бүс нутагт цаг агаарын нилээд өөрчлөлт гарсныг илтгэж болох талтай. Тиймээс энд ажиглагдсан зүйлийг цаашид өөр дурсгалт газруудтай харьцуулан судлах шаардлагыг бий болгож байгаа юм.

Хээрийн шинжилгээний ангийн Хүннүгийн булш оршуулгын дурсгал судлах баг нь Баруун Бэлсэгийн дурсгалт газарт буй 40 орчим булшнаас 18 булшийг малтан шинжилсэн. Эдгээр булшнуудыг том талбайгаар цэвэрлэн гадаад чулуун байгууламжийг ил гарган малтсан бөгөөд ингэснээр оршуулгын газар дахь булшны байршилзүй, булш хоорондын холбоо зэргийг тодруулахад хэрэг болохуйц багагүй зүйлийг тодруулсан. Маллага хийсэн булшнууд нь хэд хэдээр бүлэг болсон байдалтай бөгөөд бүлэг тус бүрт 1 харьцангуй том хэмжээтэй булш, түүнийг тойрсон, эсвэл түүнтэй залгаа байдалтай харьцангуй жижиг булшнууд байрлаж байсан. Хэмжээгээр том булшнууд нь модон хашлага, модон австай нилээд нарийн бүтэцтэй бол жижиг булшнууд нь чулуун хашлагатай, эсвэл ямар нэгэн нэмэлт байгууламжгүй байв. Бүтэц зохион байгуулалтын энэхүү ялгаа нь олдвор эд өлгийн зүйлтэй ч шууд хамааралтай болох нь маллагын дүнд тодорхой мэдэгдсэн. Тухайлбал, нарийн бүтэцтэй булшнуудаас олон тооны малын яс, чий будагтай цар, аяга, төмөр сав суулга, олон тоотой шавар ваар зэрэг гарч байхад чулуун хашлагатай болон ямар нэгэн нэмэлт байгууламжгүй булшнаас нумын ясан наалт, сумын зэв зэрэг цөөн тоотой олдвор олдсон. Баруун Бэлсэгийн Хүннү булшнуудаас илэрсэн олдвор эд өлгийн дотроос ясан тоног бүхий бүсний хос ясан арал, Грек-Бактриас гаралтай хөх өнгийн чулуун зүүт зэргийг онцлон дурдууштай.

Эртний бууц, суурин судлах баг Эгийн голын хөндийд нарийвчилсан хайгуул судалгаа хийсний үр дүнд эртний бууц суурингийн ул мөрийг 5 газарт илрүүлж, 1 газарт Хүннүгийн үед холбогдох модон байгууламжтай барилгын ором илрүүлсэн. Энэ жил цаг хугацааны боломжоос шалтгаалан уг барилгын турийн бүтэц, зохион байгуулалтыг бүрэн тодруулж чадаагүй ч гэсэн өмнө нь манай нутгаас илрүүлж байгаагүй шинэ төрлийн дурсгал олж судласан тул судалгааны үр дүн, ач холбогдол нь өндөр юм.

Монголын үеийн дурсгалын судалгааны баг Мухдагийн аманд 4 булш малтан

шинжилсэн ба Эмгэнт хошуунд тоногдож сүйтгэгдсэн 1 хадны оршуулгыг илрүүлэн судласан. Мүхдагийн амны 4 булшны 3 нь оршуулгын нүх бүхий булш бол 1 нь хадны хөмөг ашиглан үйлдсэн оршуулга байв. Эдгээр булшнууд ихэд тоногдож сүйтгэгдсэн бөгөөд хүний зарим ясны үлдэгдэл л илэрсэн. Энэ удаагийн маллагын хэрэглэгдэхүүнд нь хэдийгээр шинэ баримт ажиглагдаагүй ч өмнө хийсэн маллагын хэрэглэгдэхүүнийг баяжуулж, Монголын үеийн судалгааны эх хэрэглэгдэхүүнийг нэмж буйгаар ач холбогдолтой юм.

Хээрийн судалгааны багийн хийсэн орон нутаг, угсаатны зүйн судалгаа нь өмнө нь төдий л өргөн хүрээнд хийгдэж байгаагүй шинэ чиглэлийн судалгаа билээ. Орон нутгийн замын сүлжээний бүдүүвч зураг гаргах нь эртний нүүдэлчдийн үлдээсэн бууц суурин, биет дурсгалтай эдгээр авто замууд хэрхэн уялдаж байгааг харуулахын зэрэгцээ эдгээр замуудын он цагийг тодорхойлох нэг боломж бий болгоход чиглэгдэж байв. Харин малчдын нүүдлийн байршлыг баримтжуулах судалгаа нь тухайн бүс нутгийн айл өрхийн улирлын чанартай өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршлыг тодорхойлох, түүгээр дамжуулан эртний бууц сууринг шинээр илрүүлэн олох, өнөөгийн болон өмнөх нүүдэлчдийн амьдралын хэв маягт үлдсэн уламжлал, өөрчлөлтийг тодорхойлоход чиглэгдсэн. Энэ судалгааг хийснээр Эгийн голын хөндийд 840 км зам туулж нийт 68 өвөлжөө хаваржаа, зуслангийн газрыг тэмдэглэсэн байна.

Палеоантропологийн судалгаанд нийт 26 хүний ясны хэрэглэгдэхүүнийг хамруулсан бол палеозоологийн судалгаанд 1852 ширхэг мал, амьтны яс хамрагджээ.

Хавсралт: Гэрэл зураг



Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүн



Хээрийн шинжилгээний ангийн отог

Чулуун зэвсгийн судалгаа



Баянголын амны чулуун зэвсгийн дурсгалт газар



Дөрөлжийн чулуун зэвсгийн дурсгалт газрын малтлагын явц

Хүрэл зэвсгийн судалгаа



Хиргисүүрийн малтлагын явц



Дөрвөлжин булины малтлагын явц

Бууц суурингийн судалгаа





Суурингийн малтлагын явц

Хүннү булшны судалгаа



Дурсгалт газрын ерөнхий байрлал



Нийт талбайгаар цэвэрлэсний дараах байдал



Булины гадаад дараас



Булины малтлагын явц



Булины ориуулгын хэсэг



Булины тахилын хэсэг

ТӨВ, УМАРД МОНГОЛЫН НУТАГТ ХИЙСЭН БЭСРЭГ
ХАЙГУУЛЫН АНГИЙН ЗАРИМ ҮР ДҮН

Г.Эрэгзэн, Ч.Амартүвшин, А.Энхтөр, Г.Батболд, Б.Батдалай

Тус хүрээлэнгээс мэдээ шалгах, зарим нэгэн дурсгалын талаар нэмэлт мэдээлэл цуглуулах зорилгоор зохиогчдын бүрэлдэхүүнтэй хайгуул судалгааны ангийг 2014 оны 5-р сард 7 хоногийн хугацаагаар томилон ажилуулсан юм. Энэхүү хайгуул судалгааны анги Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл, Архангай аймгийн нутаг аялан явж нийт 20 дурсгалт газартай танилцан, хэмжилт судалгаа, гэрэл зургийн баримтжуулалт хийн нэмэлт мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэв¹.

Хүснэгт: Хээрийн судалгааны маршрут, төлөвлөгөө

	Дурсгалт газрын нэр	Аймаг	Сум	
1	Цагаан толгой (Цант)-н турь	Дархан-Уул	Орхон	
2	Айргийн гозгорын дурсгал	Орхон	Жаргалант	
3	Булган аймгийн музей, Диваажингийн сүм,	Булган	Булган	
4	Гуртын гүүрний хүн чулуу		Хутаг-Өндөр	
5	Бийбулагийн балгас, Арслан толгой			
6	Сэлэнгийн хүннү булш			
7	Намнан уулын зүүн бэлийн монгол булш			
8	Бага Баяртын дурсгал			
9	Өгөөмөрийн голын дурсгал			Мөрөн
10	Худгийн халзангийн дурсгал			Хөвсгөл
11	Уушгийн өврийн цогцолбор дурсгал	Хөвсгөл		Бүрэнтогтох
12	Тариатын давааны хүн чулуу		Рашаант	
13	Салхитын хүннү булш			
14	Гол модны дурсгалт газар	Архангай	Хайрхан	
15	Шивээт улааны дурсгалт газар		Баян-Агт	
16	Могойн шинэ усны дурсгалт газар, шороон дов	Булган	Сайхан	
17	Дов дэрсний дурсгал		Дашинчилэн	
18	Цогтын гэрийн буйр хэмээх шороон дов			
19	Улаанхэрэм хотын турь			Баяннуур
20	Улаан хэрэм орчмын шороон дов			

Хайгуул судалгааны ангийн гол зорилго Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутагт орших Худгийн халзангийн дурсгалыг очиж үзэн дурсгалын гадаад хэлбэр, хэмжээ зэргийг тодруулах, цаашид судлах шаардлага болон боломжийн талаар дүгнэлт гаргах явдал байсан. Худгийн халзангийн дурсгал гэдэг нь 2002 онд нутгийн иргэн газар шорооны ажлын явцад санамсаргүй байдлаар илрүүлэн олсон эртний булш юм. Уг булшнаас гарсан эд өлгийн зүйлс дотор өвөрмөц хэлбэрийн төмөр дөрөө байсан нь судлаачдын сонирхолыг татжээ. Зохиогч уг төмөр дөрөөг хөрш бүс

¹ *Г.Эрэгзэн, Ч.Амартүвшин, А.Энхтөр, Г.Батболд, Б.Батдалай. Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгийн археологийн мэдээ шалгах хээрийн шинжилгээний ангийн тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар, 2014.*

нутгийн олдворуудтай харьцуулан Жужаны үед холбогдох боломжтой хэмээн үзсэн бөгөөд энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан тэрхүү дурсгалт газрыг дахин судлах шаардлага урган гарсан юм. Бид уг дурсгалын талаар анх мэдээлсэн нутгийн иргэн Манлайбаатар гуайнхыг сураглан очиход тэднийх Худгийн халзангийн дурсгалын дэргэд хаваржиж таарсан нь олзуурхууштай юм.

Худгийн халзангийн олдворууд илэрсэн нүхийг эргүүлэн булсан байсан бөгөөд нутгийн иргэдийн аман мэдээгээр уг дурсгал нь газар дээр ил мэдэгдэх чулуун байгууламжгүй, харин бага зэрэг хонхор байсан нь онцлог шинж ажээ. Бид тэрхүү дурсгал илэрсэн газарт тарж хайгуул хийж үзэхэд уулын зүүн бэлийн налуу дэвсгэт хүний гар хүрсэн буюу ямар нэгэн байдлаар хөндөгдсөн шинж тэмдэгтэй хэд хэдэн газар мэдэгдсэн. Эдгээр нь ерөнхийдөө 2-3 м орчим голчтой багахан хонхорууд бөгөөд ил мэдэгдэх чулуун дараас, чулуун байгууламж зэрэг нэмэлт байгууламж огт мэдэгдэхгүй байна. Хайгуулын явцад илрүүлсэн дээрх хонхорууд нь нутгийн иргэдийн олдвор илрүүлсэн дурсгалтай гадаад хэлбэрийн хувьд төстэй юм. Тиймээс энэ газарт цаашид маллага судалгаа хийх шаардлагатай ба маллага хийснээр гадаад шинж тэмдэггүй Жужаны үеийн дурсгалыг илрүүлэх магадлалтай хэмээн үзэж байна.

Хайгуул судалгааны явцад дээр өгүүлсэн Худгийн халзангийн дурсгалаас гадна хэд хэдэн дурсгалыг шинээр илрүүлэн тэмдэглэсэн ба зарим нэгэн дурсгалт газарт биечлэн очиж танилцсны үр дүнд багагүй нэмэлт мэдээлэл цуглуулж чадсан юм. Тухайлбал, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Намнан уулын өвөрт байрлах Бага Баяртын дурсгал, Хөвсгөл аймгийн Рашаант сумын Тариатын давааны хүн чулуун хөшөө, Булган аймгийн Сайхан сумын нутаг Могойн шинэ усны дурсгалын ойролцоо орших шороон довт булш зэргийг илрүүлсэн ба Булган аймгийн Баян-Агт сумын нутагт орших Шивээт улаан, Орхон аймгийн нутагт орших Айргийн гозгор, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын ойролцоох Өгөөмөрийн голын дурсгал, Булган аймгийн Сайхан сумын Могойн шинэ усны дурсгал, Булган аймгийн Дашинчилэн сумын Цогтын гэрийн буйр зэрэг дурсгалт газруудад биечлэн очиж танилцсны үр дүнд цаашдын судалгаанд ач холбогдолтой нэмэлт мэдээллийг цуглуулж чадлаа.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Намнан уулын өвөрт байрлах Бага Баяртын дурсгалын хувьд өмнө нь огт тэмдэглэгдэж байгаагүй ажээ. Бид газар дээр очиж хайгуул судалгаа хийсний үр дүнд уг дурсгал эртний булш биш, харин хүн олноор бөөгнөрөн амьдарч байсан олон сууц бүхий эртний тосгоны үлдэгдэл байж магадгүй хэмээн таамагласан юм. Энэ орчимд хайгуул хийж үзэхэд 50-60 орчим гонзгой дөрвөлжин хэлбэрийн сууцны үлдэгдэл байгаа нь мэдэгдсэн бөгөөд зарим сууцны ойр орчмоос төмрийн баас, шавар савны хагархай зэрэг аж ахуйн болон үйлдвэрлэлийн холбогдолтой түүвэр олдвор цуглуулсан. Мөн уг эртний тосгоноос өмнө тийш газрын нам хэсэгт хэд хэдэн газарт 30 гаруй м голчтой дугуй хэлбэрийн чулуун байгууламжийг илрүүлсэн бөгөөд эдгээрийг гадаад хэлбэрийг үндэслэн уулын ус хуримтлуулах байгууламж бололтой хэмээн таамагласан юм. Эндээс үзэхэд Намнан уулсын өвөрт байрлах энэхүү дурсгал нь олон хүн нэг дор бөөгнөрөн амьдарч байсан эртний тосгон болохын дээр төмөрлегийн үйлдвэрлэл эрхлэх дархчуудын хороолол байж болохоор байна. Архивын мэдээ баримтаас үзэхэд Намнан уулын өвөрт „Намнангийн хүрээ” гэх суурин газар байсан нь мэдэгдэнэ. Бидний үзсэн энэхүү дурсгал нь „Намнангийн хүрээ”-ний турь мөн эсэхийг дахин нягтлах шаардлагатай юм. Гэхдээ дурсгалын ерөнхий байдал нь нилээд эртний шинжтэй бөгөөд Уйгарын үеийн 2 дахь том хот „Байбалык” буюу „Баян балгас” хотоос холгүй орших тул он цагийн хувьд ойролцоо үеийнх болов уу хэмээн урьдчилсан байдлаар таамаглаж байна. Манай улсын нутгаас ийм төрлийн дурсгал өмнө илэрч



судалгдаж байгаагүй тул энэ дурсгалыг цаашид малтан шинжлэх шаардлагатай юм.

Тариатын давааны хүн чулуун хөшөө нь баруун гартаа хундага барьж, зүүн гараар бүсээ атган зогсож буй эр хүний дүрийг гаргасан бүхий л хэв шинжээр Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөдтэй ижил дурсгал болно. Нутгийн иргэд уг дурсгалын толгой болон эх бие хугарч салсан байсныг цементээр нааж эвлүүлсэн ба гадуур нь модон хайс хийж хамгаалсан байна. Түүнчлэн уг хүн чулуун хөшөө Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумаас Архангай аймгийн Өлзийт сумыг чиглэх гол авто замын ойролцоо орших тул өмнө нь олон судлаач үзэж танилцаж байсан нь дамжиггүй. Гэвч албан ёсны тайлан, ном зохиолд уг хөшөөг тодорхойлж оруулалгүй өдий хүрчээ. Тиймээс бид энэ тайланд Тариатын давааны хүн чулуун хөшөөний тодорхойлолт, гэрэл зураг зэргийг тусгайлан оруулав.

Булган аймгийн Сайхан сумын нутагт Могойн шинэ усны дурсгалын ойролцоо буюу чанх ар талд орших уулын оройд нэгэн шороон довт булш байна. Уг дурсгалын талаар эрдэм шинжилгээний ном зохиолд дурдсан зүйл байдаггүй ажээ. Биднийг очиж үзэхэд шороон довыг эксковатораар зүүн хойд талаас нь ухаж сүйтгэсэн байв. Нутгийнхны хэлэхээр социализмын үед нэгэн орос нөхөр ийнхүү сүйтгэсэн гэнэ. Шороон дов нь 5-7 м орчим өндөр, сууриар 30 орчим м голчтой, орой хэсгээр 2-3 м голчтой, шороо, шавар, чулууг үелүүлэн дэлдэж хийсэн байгууламж ажээ. Энэхүү дурсгалын ерөнхий хэв шинж нь сүүлийн жилүүдэд Булган аймгийн Баяннуур, Төв аймгийн Заамар зэрэг сумдын нутгаас илэрч судлагдсан „шороон бумбагар” хэмээн нэрлээд буй бунхант булшнуудтай төстэй байна. Маллага хийсэн „шороон бумбагар”-уудын газрын хөрсөн дээр ил мэдэгдэх шороон дов нь газрын гүнд байрлах бунхант хэсгийн таазыг нурахаас хамгаалах зориулалттай байгууламж болох нь мэдэгддэг. Бидний үзсэн энэхүү дурсгалын хувьд газрын хөрсөн дээр ил мэдэгдэх шороон довны зүүн хойд хэсгийг сүйтгэсэн боловч газрын гүнд байрлах бунханыг хөндөлгүй орхисон байх магадлалтай юм. Тиймээс цаашид энэ дурсгалыг малтан шинжилж газрын гүнд байрлах бунхант хэсгийг авран хамгаалах шаардлагатай хэмээн үзэж байна.

Булган аймгийн Баян-Агт сумын нутагт орших Шивээт улааны дурсгалыг судлаачид „тахилын байгууламж” хэмээн тодорхойлж ирсэн юм. Хайгуулын баг энэ дурсгалтай газар дээр нь очиж танилцсан бөгөөд уг дурсгал нь ерөнхийдөө Уйгарын үеийн хотын жижигрүүлсэн хувилбар маягтай маш их ажил болж байгуулсан нүсэр байгууламж болох нь мэдэгдэж байна. Дурсгалыг Ханүй, Хүнүй 2 гол уулзах бэлчирт байрлах өндөр уулын оройг эзлүүлэн байгуулжээ. Дурсгал нь дөрвөлжин хэлбэртэй чулуугаар байгуулсан гол хэрэмтэй, түүний өмнө талд залгуулан байгуулсан өөр нэгэн хэрэм буюу залгаа 2 хэрэмтэй, гол хэрмийн 4 булан, болон зүүн баруун талын ханын хэсэгт тус бүр 2 цонж, өмнө талын туслах хэрмийн урд талын 2 булан, хаалганы хэсэг зэрэгт цонжтой юм. Гол хэрмийн төв хэсгийг эзлэн том хэмжээтэй чулуун овоолго байх бөгөөд уг чулуун овоолго нь 8 талт суурь бүхий байгууламж болох нь мэдэгдэж байна. Туслах хэрмийн өмнө талын хаалганы гадна хүн чулуу, арслан, гэрэлт хөшөө зэргийг эгнүүлэн тавьжээ. Эдгээр чулуун дүрсүүдийг олон тийш зөөж авч явсан байсныг хожим дахин цуглуулж авч ирсэн ажээ. Тиймээс уг чулуун хөшөө дурсгалуудын анхны байрлалыг мэдэх боломжгүй болсон байна. Шивээт улааны дурсгалын ерөнхий хэв шинж, хэлбэр, бүтэц зэргийг ажиглахад Зүүн Азийн бүс нутагт VIII-X зууны үед нилээд өргөн тархсан хаад язгууртны булштай төстэй байна. Энэхүү дурсгалтай их ойролцоо хэлбэрийн дурсгал нь өдгөө БНСУ-ын Кёнжу хотын ойролцоо орших Нэгдсэн Шилла улсын үеийн хаадын бунхант булшнууд юм.

Хөвсгөл аймгийн Мөрөн хотын ойролцоох Өгөөмөрийн голын дурсгалыг 2012 онд „Northern Railways” ХХК-ны захиалгаар хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны явцад анх илрүүлэн олсон байдаг. Тухайн үед дурсгалын он цаг тодорхойлолгүй орхисон бөгөөд энэ удаагийн хайгуулын явцад дахин үзэж няглан, дурсгалын гадаад хэлбэрт тулгуурлан Өгөөмөрийн голын булшнуудыг хүрэл зэвсгийн эхэн үеийн Афанасьевын соёлын дурсгал байх боломжтой хэмээн тодорхойлсон. Хэрэв энэхүү дурсгал Афанасьевын соёлд холбогдох бол уг соёлын хүрээг тэлэхээс гадна Монголын төвийн бүс нутгийн хүрэл зэвсгийн судалгаанд чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болох боломжтой юм.

Дээр дурдсанчлан энэ удаагийн хайгуул судалгааны явцад нилээд олон дурсгалуудыг шинээр илрүүлэн олсон ба хэд хэдэн дурсгалт газарт нэмэлт судалгаа хийсний үндсэн дээр шинэ таамаглал дэвшүүлэх боломж бүрдсэн нь хээрийн судалгааны гол үр дүн юм. Түүнээс гадна хайгуул судалгаанд олон чиглэл, түүхийн өөр өөр цаг үеэр мэргэшсэн мэргэжилтнүүд оролцсон нь дурсгалт газрын талаарх өмнөх дүгнэлт таамаглалыг дахин авч хэлэлцэх, шинэ чиг хандлагаар тайлбарлах, мэдээлэл солилцох, шинжлэх ухаанч маргаан өрнүүлэх боломжийг олгосон бөгөөд энэ явдал нь судалгааны үр дүнд эерэгээр нөлөөлснийг тэмдэглэх хэрэгтэй.



2014 ОНД ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Ч.Амартүвшин, Б.Батгалай, Д.Бөхчулуун

Соёлын өв гэдэг бол аливаа улс үндэстний түүх, угсаа гарал, уламжлал, ёс заншил, итгэл бишрэл, эв нэгдэл цаашлаад үндэсний аюулгүй байдал гэх зэргийг тодорхойлон харуулах томоохон зүйл юм. Тиймээс ч улс орон болгон соёлын өвийн үнэ цэнийг ойлгож тэдгээрийг төрийн хамгаалалтанд авч хадгалан хамгаалах үйл ажиллагааг хуульчилсан байдаг.

Монгол оронд уул уурхай болон дэд бүтцийн салбар эрчимтэй хөгжиж байгаатай холбоотойгоор тус хүрээлэн нь байгуулагдсан цагаасаа хойш соёлын биет өвийг авран хамгаалах судалгааны ажлыг улсын хэмжээнд толгойлон явуулах болсон билээ. Тус хүрээлэн нь энэ онд Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн (шинэчлэн найруулсан) 5-р бүлгийн 27-р зүйлийн 8-т „Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах”, тус зүйлийн 9-т „Урьдчилсан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна” заалтын дагуу нийт 70 удаагийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгаа хийлээ.

Хайгуул судалгаа

2014 онд тус хүрээлэн нь нийт 65 тооны авран хамгаалах хайгуул судалгааны ажил хийнээс 40 талбайгаас 1361 тооны археологийн дурсгал шинээр илрүүлэн олж баримтжуулснаас чулуун зэвсгийн дурсгалт газар 4, хиргисүүр 367, дөрвөлжин булш 73, шоргоолжин булш 2, мөнгөн тайга хэлбэрийн булш 4, буган хөшөө 1, хөшөө чулуу 7, хадны зургийн дурсгалт газар 5, хүннү булш 80, түрэгийн хашлага 1, зэл чулуу 1, монгол булш 64, хийдийн турь 6, эртний суурин 5, чулуун байгууламж 147, түвд бичигтэй хөшөө 19, тээрмийн чулуу 3, он цагийг урьдчилан тогтоох боломжгүй булш оршуулгын дурсгал 557 тус тус багтаж байна.





График: Хайгуулаар илэрсэн дурсгалын тоон үзүүлэлт

Хайгуул судалгаагаар нэг талбайд хамгийн олон дурсгалыг Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт байгуулах Эгийн голын усан цахилгаан станцын талбайгаас нийт 347 дурсгал, Бугат сумын нутгаар дайран өнгөрөх замын трассын дагуу нийт 185, Ховд аймгийн Мянгад сумын нутаг дахь 14272.5 га талбайгаас нийт 142 дурсгал тус тус илрүүлэн олж баримтжуулжээ.

Тус хүрээлэн нь 2012 оноос эхлэн археологийн дурсгалын бүртгэлийн мэдээллийн сан хийж эхэлсэн юм. Уг мэдээллийн санд тулгуурлаж Өмнөговь аймгийн Ханбогд сумаас Говьсүмбэр аймгийн Чойр сум хүртэл тавигдах хатуу хучилттай замын трассын дагуу археологийн дурсгал буй эсэхийг газарзүйн ArcGIS програм ашиглан шалгалт хийн мэргэжлийн дүгнэлт гаргасан бөгөөд үүний үр дүнд зам барилгын ажилд нийт 8 дурсгал өртөж болзошгүйг тогтоосон байна. Түүнчлэн Оюу Толгой компанийн төслийн талбайгаас Гашуун сүхайтын хилийн боомт хүртэлх замын шинэчлэгдсэн трассын дагуу хичнээн дурсгал өртөж болзошгүй талаар бүртгэл мэдээллийн санд тулгуурлан тогтоов.



Газрын зураг 1: Авран хамгаалах хайгуул судалгаа хийсэн газрууд

А.Энхтөр, Г.Батболд нар Зам, Тээврийн Яамны захиалгаар Цахиур-Тосонцэнгэл чиглэлийн хатуу хучилттай замын трассын дагуу өртсөн дурсгалуудтай танилцаж нийт 8 дурсгалыг авран хамгаалах шаардлагатай гэсэн мэргэжлийн дүгнэлт гаргасан байна.

Малтлага судалгаа

Энэ онд уул уурхайн болон усан цахилгаан станцын талбай, өндөр хүчдэл дамжуулах шугам, хатуу хучилттай замын трассын дагууд нийт таван газарт малтлага судалгааны ажил зохион байгуулаж нийт 93 дурсгалыг авран хамгааллаа.





График: Авран хамгаалах судалгааны ажлын тоон үзүүлэлт (2003-2014 он)

Үүнд, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь „Жавхлант Орд“ ХХК-ийн ашиглалтын талбайд хүрэл зэвсгийн үеийн булш 5, чулуун байгууламж байгууламж 4 нийт 9 дурсгал, Ханбогд сумын сумын нутаг дахь „Оюу Толгой“ ХХК-ийн барих замын трассын дагуу дөрвөлжин булш 3, дундад зууны булш 1, он цаг тодорхойгүй булш 2, чулуун байгууламж 32 нийт 38, Булган аймгийн Хутаг-Өндөр, Бугат сумдын нутагт баригдах усан цахилгаан станцын талбай болон дэд бүтцийн трассын дагууд чулуун зэвсгийн дурсгалт газар 5, хиргисүүр 1, дөрвөлжин булш 1, хүннү булш 18, хүннү сүүрин 1, монгол булш 4, хадны оршуулга 1, чулуун байгууламж 9, он цаг тодорхойгүй булш 2, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутаг дахь „Хөтөл Цемент Шохой“ ХХК-ийн лицензит талбайд 1 булш болон Улаанбаатар хотын Налайх дүүрэгт „ННС“ ХХК-ийн барьж буй замд өртөж болзошгүй Тоньюкукийн хөшөө тус тус багтаж байна.



Газрын зураг 1: Авран хамгаалах малтлага судалгаа хийсэн газрууд

Дүгнэлт

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хүрээнд 70 удаагийн археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг амжилттай зохион байгуулан 18 аймгийн 41 сум, 3 дүүргийн нутаг дэвсгэрт хайгуул судалгаа явуулж 1361 тооны археологийн дурсгал шинээр илрүүлэн баримтжуулж мөн 4 аймгийн 4 сум, 1 дүүргийн нутагт малтлага судалгаа явуулж 2000 гаруй чулуун зэвсэг, 1856 мал амьтаны яс, 32 хүний ясны хэрэглэгдэхүүн, 100 орчим олдвор цуглуулсан байна.

Энэ жилийн авран хамгаалах судалгааны тоон үзүүлэлтээс харахад өмнөх жилээс 71.36 орчим хувиар буурсан нь Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал, гадаадын хөрөнгө оруулалт, хуулийн хэрэгжилт зэрэг хүчин зүйлтэй шууд холбоотой ажээ.




График: Авран хамгаалах судалгааны ажлын үзүүлэлт (2003-2014 он)

Энэ жил хайгуулаар илэрсэн дурсгалын тоогоор янз бүрийн гадаад хэлбэртэй чулуун дарааст булш (557) тэргүүлж, хиргисүүр (367) удаалсан байна. Мөн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт орших Тоньюкукийн гэрэлт хөшөөнд маллага судалгаа хийж байх явцад Бишрэлтийн даваа хэмээх газраас нийт 25 булштай хүннүгийн үед холбогдох оршуулгын газар илэрсэн нь Туулын сав нутаг дахь хүннүгийн дурсгалт газрын тоог нэгээр нэмсэн юм.

Тус сектор нь авран хамгаалах судалгааны нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажилаж байгаа бөгөөд энэ онд тус мэдээллийн санд тулгуурлан зайнаас тандан судлах аргачлалын дагуу хоёр газарт дүгнэлт гаргаж нийт 8 дурсгал зам, барилгын ажлын явцад сүйдэж болзошгүйг тогтоосон нь шинэлэг зүйл болов.

Маллага судалгаанд 93 дурсгал хамрагдсанаас чулуун зэвсгийн дурсгалт газар 5, хиргисүүр 1, дөрвөлжин булш 4, хүрлийн үеийн булш 5, хүннү булш 18, хүннү суурин 1, дундад зууны булш 5, хадны оршуулга 1, чулуун байгууламж 32, он цаг тодорхойгүй булш 5 тус тус хамрагдсан байна. Чулуун зэвсгийн маллагыг үр дүнд 2 үе соёлт давхарга илрүүлж 2000 гаруй чулуун зэвсэг олжээ.

Хүснэгт-1. 2014 онд явуулсан хайгуул судалгааны ажлын товч мэдээлэл

№	Аймаг (хот)	Сум, дүүрэг	ААН, байгууллага	Дурсг тоо	Тайлан бичсэн
1	Архангай	Ихтамир	„Пенинсула Майнинг“ ХХК	31	Н.Батболд, Н.Эрдэнэ-Очир Б.Дашдорж, Д.Бөхчулуун
2	Баянхонгор	Баян-Овоо	„Спейшл Майнз“ ХХК	30	Г.Галдан, Д.Бөхчулуун
3	Баянхонгор	Бөмбөгөр	„Эрдэнэминас“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд
4	Баянхонгор	Галуут	„Бест Коппер Гоулд Корпорейшн“ ХХК	-	Н.Батболд
5	Баянхонгор	Галуут	„Бест Коппер Гоулд Корпорейшн“ ХХК	-	Н.Батболд
6	Баянхонгор	Галуут	„Эс Кью Эс“ ХХК	45	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Дашдорж, Б.Батдалай
7	Булган	Бугат	„Эгийн Голын УЦС“ Төслийн нэгж	185	Б.Гүнчинсүрэн, Ч. Амартүвшин, Г.Эрэгзэн
8	Булган	Орхон	„Гөүлдэн Нэст“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд
9	Булган	Орхон	„Гөүлдэн Нэст“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд
10	Булган	Хутаг-Өндөр	„Эгийн Голын УЦС“ Төслийн нэгж	347	Б.Гүнчинсүрэн, Ч. Амартүвшин, Г.Эрэгзэн
11	Говь-Алтай	Алтай	„ЭфВиЭсПи“ ХХК	10	Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин, Г.Ангарагдөлгөөн, Д.Одсүрэн
12	Говьсүмбэр	Сүмбэр	„Тайшэнг Девелопмент“ ХХК	15	Ч.Амартүвшин, Д.Одсүрэн
13	Дархан-Уул	Шарын гол	Шарын Гол ХК	45	Я.Цэрэндагва, Ж.Гантулга
14	Дархан-Уул	Хонгор	„Очир-Ундраа“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Г.Лхүндэв
15	Дорноговь	Даланжаргалан	„Тайшэнг Девелопмент“ ХХК	1	Ч.Амартүвшин, Д.Одсүрэн
16	Дорноговь	Даланжаргалан	„Ловонко“ ХХК	-	Ц.Амгалантөгс, Л.Дэлгэрмаа
17	Дорноговь	Сайхандулаан	„Их Хүрэн Толгой“ ХХК	28	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Дашдорж, Б.Батдалай
18	Дорноговь	Сайхандулаан	„Их Хүрэн Толгой“ ХХК	3	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Дашдорж, Б.Батдалай
19	Дорноговь	Даланжаргалан	„Ловонко“ ХХК	14	Ц.Амгалантөгс, Л.Дэлгэрмаа

20	Дорноговь	Эрдэнэ	„Андхуйшан“ ХХК	62	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд, Л.Ишцэрэн, Д.Бөхчулуун
21	Дорноговь	Даланжаргалан	„Чингисийн Хар Алт“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Н.Эрдэнэ-Очир, Л.Ишцэрэн
22	Дорноговь	Даланжаргалан	„Блюскэй Харс“ ХХК	6	Б.Гүнчинсүрэн, Н.Эрдэнэ-Очир, Л.Ишцэрэн
23	Дорноговь	Даланжаргалан	„Зэт Ди Эл“ ХХК	9	Н.Батболд, Д.Бөхчулуун, Б.Дашдорж
24	Дорноговь	Сайншанд	„Натур Фрейндли“ ХХК	80	Ч.Амартүвшин, Б.Батдалай, Г.Ангарагдөлгөөн, Д.Молор
25	Дорноговь	Даланжаргалан	„Зэрэглэх Гэрэл“ ХХК	6	Д.Одсүрэн, Г.Лхүндэв, Х.Пүрэвжал
26	Дорнод	Матад	„Пи Эй Ар Эн“ ХХК	-	Ч.Амартүвшин, Б.Батдалай, Н.Батболд
27	Дорнод	Дашбалбар	„Центрвил“ ХХК	66	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд, Л.Ишцэрэн
28	Дорнод	Дашбалбар	„Трежур Эксплорэйшн“ ХХК	-	Н.Батболд, Г.Эрэгзэн, Б.Батдалай
29	Дорнод	Чойбалсан	„Империа Метал Групп“ ХХК	12	Н.Батболд, Г.Эрэгзэн, Б.Батдалай
30	Дорнод	Чойбалсан	„Уэлт Эксплорэйшн“ ХХК	-	Н.Батболд, Г.Эрэгзэн, Б.Батдалай
31	Дорнод	Дашбалбар	„Ирвэс Интэртрейд“ ХХК	-	Н.Батболд, Л.Ишцэрэн
32	Дундговь	Сайнцагаан	„Тэвшийн Нүүрс“ ХХК	-	Ц.Амгалантөгс, Л.Дэлгэрмаа
33	Дундговь	Говь-Угтаал	„Эй Юу Си“ ХХК	24	Г.Батболд, Ц.Буянхишиг
34	Дундговь	Гурвансайхан	„Букорп“ ХХК	13	Г.Батболд, Ц.Буянхишиг
35	Дундговь	Өндөршил	„Эй Юу Си“ ХХК	32	Г.Батболд, Ц.Буянхишиг
36	Завхан	Завханмандал	Шувуун Хар Уул	27	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Дашдорж, Б.Батдалай
37	Өвөрхангай	Хайрхандулаан	„Шаргал Болор“ ХХК	2	Я.Цэрэндагва, Ж.Гантулга
38	Өмнөговь	Далазадгад	„Оффсет Консалтинг“ ХХК	7	Н.Батболд
39	Өмнөговь	Гурвантэс	„Баатарван Транс“ ХХК	3	Н.Батболд, Д.Молор, Д.Бөхчулуун
40	Өмнөговь	Манлай	„Баяраам“ ХХК	21	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Дашдорж, Б.Батдалай
41	Өмнөговь	Мандал-Овоо	„Мушгиа Худаг Металс“ ХХК	8	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Батдалай, Б.Дашдорж
42	Өмнөговь	Мандал-Овоо	„Рэмет“ ХХК	7	Амартүвшин, Н.Батболд, Б.Батдалай, Б.Дашдорж
43	Өмнөговь	Ханбогд	„Гашуунсүхайт“ ХХК	8	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд, Л.Ишцэрэн
44	Сүхбаатар	Сүхбаатар	„Цэгээн Үүдэн“ ХХК	-	Н.Батболд, Л.Ишцэрэн
45	Сүхбаатар	Түвшинширээ	„Ихтүмэн Бээр“ ХХК	-	Н.Батболд, Д.Бөхчулуун
46	Сүхбаатар	Халзан	„Спрот“ ХХК	-	Ч.Амартүвшин, Ч.Ерөөл-Эрдэнэ, Н.Батболд, Г.Эрэгзэн
47	Сүхбаатар	Эрдэнэцагаан	„Товгор Хад“ ХХК	5	Ч.Амартүвшин, Ч.Ерөөл-Эрдэнэ, Г.Эрэгзэн, Н.Батболд
48	Сэлэнгэ	Ерөө	„Бест Коппер Гоулд Корпорейшн“ ХХК	-	Н.Батболд
49	Сэлэнгэ	Ерөө	„Бест Коппер Гоулд Корпорейшн“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Б.Батдалай
50	Сэлэнгэ	Ерөө	„Опен Пийт“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд
51	Сэлэнгэ	Мандал	„Нарны Өргөө“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Н.Батболд
52	Төв	Баян	„Баян Хурай“ ХХК	-	Н.Батболд, Б.Батдалай
53	Төв	Баян	„Эрдэнийн Цахирмаа Тал“ ХХК	-	Н.Батболд, Б.Батдалай
54	Төв	Лүн	„Лмо Майнинг“ ХХК	5	Ч.Ерөөл-Эрдэнэ, Н.Батболд
55	Увс	Түргэн	„Салхит Майнинг“ ХХК	26	Н.Батболд, Б.Дашдорж, Д.Бөхчулуун
56	Увс	Наранбулаг	„Наранбулаг Шим“ ХХК	5	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Дашдорж, Б.Батдалай

57	Улаанбаатар	Баянзүрх	„Натур Фрейндли“ ХХК	-	А.Энхтөр
58	Улаанбаатар	Налайх	„Ростов“ ХХК	27	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Т.Батбаяр, Т.Хантөгс
59	Улаанбаатар	Хан-Уул	„Очирням“ ХХК	-	Г.Лхүндэв
60	Ховд	Манхан	„ЭфВиЭсПи“ ХХК	-	Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин, Г.Ангарагдөлгөөн, Д.Одсүрэн
61	Ховд	Манхан	„ЭфВиЭсПи“ ХХК	4	Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин, Г.Ангарагдөлгөөн, Д.Одсүрэн
62	Ховд	Мянгад	„Дорнын Шим“ ХХК	142	Ч.Амартүвшин, Н.Батболд, Б.Дашдорж, Б.Батдалай

Хүснэгт 2. Мэргэжлийн дүгнэлт

№	Аймаг (хот)	Сум, дүүрэг	ААН, байгууллага	Дурсгалын тоо	Тайлан бичсэн
1	Өмнөговь	Ханбогд	„Оюу Толгой“ ХХК	-	Ч.Амартүвшин, Б.Батдалай
2	Өмнөговь/Говь сүмбэр	Хабогд/Чойр	„Оюу Толгой“ ХХК	8	Ч.Амартүвшин, Б.Батдалай
3	Завхан	Их уул	„Хурдны Зам“ ХХК	25	А.Энхтөр, Г.Батболд

Хүснэгт-3. Малтлага судалгаа

№	Аймаг (хот)	Сум, дүүрэг	АНН, байгууллага	Тайлан бичсэн	Дурсгалын тоо
1	Булган	Хутаг-Өндөр	“Эгийн Голын УЦС” Төслийн нэгж	Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Б.Бадма-Оюу, Б.Базаргүр, Д.Молор, Г.Лхүндэв, Б.Эрдэнэ, Д.Мандах, Г.Галдан, Б.Батдалай, Г.Ангарагдөлгөөн	44
2	Өмнөговь	Гурвантэс	“Жавхлант Орд” ХХК	Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин, Б.Батдалай	9
3	Өмнөговь	Ханбогд	“Оюу Толгой” ХХК	Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин, Н.Эрдэнэ-Очир, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ, Б.Батдалай	38
4	Сэлэнгэ	Сайхан	“Хөтөл Цемент Шохой” ХХК	Булш - 1	1
5	Улаанбаатар	Налайх	“ННС” ХХК	А.Энхтөр, Л.Мөнхбаяр, Т.Батбаяр, Т.Хантөгс	1

